

ХЭЗЭЭ Ч БУУЖ ӨГӨХГҮЙ БАЙХ ХҮЧ

МЯТРАШГҮЙ

ЖОН БИВЭЭР

САТАНЫ УРХИ БЕСТСЕЛЕР НОМЫН ЗОХИОЛЧ



DVD ДОТОР ДАРААХ МАТЕРИАЛУУД БИЙ

Эрхэм хүндэт найз минь,

Христ доторх аялалын маань бариа нь гараанаасаа илүү чухал юм. Та уралдааны тамирчин шиг замаа сайн дуусгах хэрэгтэй. Харамсалтай нь үй олон ах, эгч, дүүс маань замын бэрхшээл сорилд сөхөрч, эцэстээ бууж өгөхийг бид харсаар байна. Гэхдээ танд дуулгах сайхан мэдээ нь Бурханы нигүүлсэл биднийг нөхцөл байдлыг гартаа авахад шаардлагатай бүхнээр хангадаг. „Мятрашгүй” ном маань энэ тухай л өгүүлнэ.

Энэ ном өнөөгийн Чуулганы амин чухал хэрэгцээг онцлохоор онцгой эш үзүүлээр тослогдон төрсөн гэдэгт би итгэдэг. Номын маань ачаар амьдралдаа жинхэнэ эрх чөлөө, итгэл, тэсвэр тэвчээрийг олсон тухайгаа олон олон эрчүүд, эмэгтэйчүүд гэрчилдэг. Эзэний илчилсэн энэ үнэний үгийг бичиж байхдаа, миний сүнс ч сэргэн дүрэлзсэн билээ.

Эзэн надаар энэ үгийг бичүүлсэн нь ганц л зорилготой. Энэ үгийг танд болоод даян дэлхийн үйлчлэл нэгт удирдагч нарт хүргэх. Тиймээс хамаг л сэтгэл, хайраараа өлгийдөж хүргэсэн Бурханы энэ үгийг хүлээж аваарай. Энэ үг таныг болон таны халамж дор байгаа хүмүүсийг зорилго, эрх мэдэл, тэнгэрлэг хувь тавилангаар хуяглана гэдэгт итгэл төгс байна.

Найз минь, энэ бол миний өөрийн Бурханы төлөөх амьдрал, үйлчлэлийг оронгоор нь өөрчилсөн үг юм шүү. Та ч бас Бурханы танд аминчлан айлдсан энэ үгийг олборлох аваас, тэс өөр хүн болно. Би ч үүний төлөө залбирна. Энэ үг таныг болоод танд хайртай хүмүүсийг өөрчилсөн гэдэг амьд гэрчлэлийг тэсэн ядан хүлээнэм.

Христ доторх найз Жон Бивэр чинь.



John Bevere
JohnBevere@ymail.com



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org

УРМЫН ҮГС

“*Мятрашгүй*” ном таныг Бурханд хамаатай юмсын төлөө асааж, Бурханаас танд заяасан хувь тавилангаасаа зуурч, итгэл дотроо бэхжихэд чинь туслана.

— Жойс МЕЙЕР

Библийн багш, шилдэг борлуулалттай номын зохиолч.

Жон Бивэр бол Христийн биеийн төлөө л амьдрахаар төрсөн хүн. Тиймдээ ч түүний сургаал номлолоос итгэгч хүн бүрийг Бурханаас заяасан хувь тавилангаа олж, хөгжин цэцэглээсэй гэсэн чин хүслийг нь харж болно. Жоны Христийг хайрлах чин хайр, Бурханы үгийн гүн илчлэл нь таныг Христийн төлөө мятрашгүй амьдардаг болгоно.

— БРАЙН, БОББИ ХЬЮСТОН

Хиллсон чуулганы тэргүүн пастор.

Тодорхой нэг сэдвээр ном бичих амархан. Харин бичсэн шигээ амьдарна гэдэг тэс өөр зүйл шүү. Бурханы араас мятрашгүй мөрдөж мөшгихийн хүчирхэг нөлөөг Жоны үгээс ч, амьдралаас ч харж болно. Жон уншигч нараа сүнсний унтаа байдлаас сэргэж, Бурханы төлөө асахыг ятгажээ. Энэ бол тоглоом биш!

— ЖЭЙМС РОБИНСОН

Техасын Форт Уорт дахь LIFE Outreach International,
Ерөнхийлөгч

Хүн амьдралаа яаж өөрчилдгийг Жон Бивэр маш нарийн зааж өгчээ. Тэрбээр итгэгч хүн бүрийг зүгээр нэг тогтвортой сайхан амьдрах зорилгоосоо давж, Мятрашгүй нэгэн байхыг ятган сэнхрүүлжээ. Том амьдардаг хүмүүс чухамхүү мятрашгүй чанарынхаа улмаас л тэгж амьдарч чаддаг. Тиймээс энэ номыг үг бүрчлэн уншихыг урамшуулъя.

— Бишоп Ти. Ди ЖЭКС

Поттер Хаус чуулганы пастор

Чуулганд “нэг удаагийн” гайхамшиг бишгүй л өрнөдөг. Маш цөөхөн нь л итгэмжтэйгээр төгсгөдөг гэсэн үг. Гэхдээ заавал ийм байх албагүй юм. Христийн бие доторх энэ цагийн хамгийн хүчирхэг эрчүүдийн нэг болох Жон Бивэр “бидний амьдрал уг нь ийм мундаг байж болох байсан боловч, тийм тааруухан төгссөн” гэж яригдах албагүй гэдгийг сэнхэртэл тайлбарлажээ. Таны итгэл, гал заавал буурч унтрах албагүй юм. Та Мятрашгүй байж чадна.

— СТИВЕН ФУРТИК

Элевэйшн Чуулганы удирдах пастор

Нар зогссон нь номын зохиогч

Жон Бивэрийн ном бүр Христийн дотор бөгөөд Христийн төлөө бат бэх, эрүүл чийрэг, үр жимстэй амьдралыг сүндэрлүүлэхэд том хувь нэмэр болдог! Энэ мундаг тоосгыг нэмж өрсөнд баярлалаа!

— ЖЭК ДАБЛЮ. ХЭЙФОРД

Дайсан бидний Мятрашгүй зан чанарыг л онилдог. Тиймээс бид итгэлдээ ч, үйлдэлдээ ч улам л мятрашгүй байх цаг иржээ. Бурханы хүсэл биелэн биелтэл тайтгардаггүй мятрашгүй хүмүүсийг Бурхан гаргаж ирж байна. Яг ийм үед энэ ном шиг хэрэгтэй зэвсэг алга.

— КРИСТИН КЭЙН

Equip & Empower Ministries байгууллагын захирал,

The A21 Кампанит ажлын үндэслэгч

Хэдэн жилийн өмнө би “Мятрашгүй” гэсэн бичигтэй бугуйвч бэлгэнд авч билээ. Тэгээд Христийн араас, надад хандсан Түүний зорилгын араас явах ёстойгоо өөртөө өдөр бүр сануулахын тулд тэр бугуйвчаа байнга зүүдэг болсон юм. Манай мундаг Жон Бивэрийн бичсэн энэ ном ч Есүсийн араас тууштай, халуун сэтгэлээр явахыг, биднийг гэх Түүний аугаа хайрыг ахин нэг сануулж байна. Энэ сургаал таны зүрхэнд Бурханаар улам их өлсөж цангах зай гаргана гэдэгт итгэлтэй байна.

— ДАРЛИН ЗЭК

Магтаалын удирдагч, дуу зохиогч, дуучин

Мятрашгүй бол миний уншиж байсан номууд дундаас сүнснийг минь хамгийн их “өдсөн” номын нэг. Жон биднийг зүгээр нэг амьтай голтой яваад байх биш, харин амьдралынхаа тал бүр дээр Бурханы эрх мэдлээр ялан дийлэгч бол гэжээ. Энэ бол амьдралд чинь хандсан Бурханы дуудлага руу таныг угз татах, Христийн биеийг хүчирхэгжүүлэгч, цагийг эзлэсэн үг юм.

— **СТОВАЛ ВИИМС**

Сэрэлт номын зохиогч, Флорида мужийн Жэксонвиллийн
Селебрэйшн чуулганы удирдах пастор

Жоны Мятрашгүй хэмээх шинэ ном нь дайсантай халз тулсан хүмүүст яг хэрэгтэй ном юм. Бурхан биднийг хувь тавиланд маань хүргэхээр амьдралын шуурга, амар тайвнаар дамжуулан өсгөн боловсруулдаг. Өөдөө уруугаа энэ замд Мятрашгүй ном таны итгэлт зэвсэг болно. Бурхан биднийг хэзээ ч хөсөрдүүлдэггүй учраас бид ч Бурханыг яагаад ч хөсөрдүүлж болохгүйг Жон сануулжээ.

— **ЖЕНТСЕН ФРАНКЛИН**

Фрии Чапел чуулганы тэргүүн пастор, Нью Йорк Таймсын
шилдэг зохиолч

ХЭЗЭЭ Ч БУУЖ ӨГӨХГҮЙ БАЙХ ХҮЧ

МЯТРАШГҮЙ

ЖОН БИВЭЭР

САТАНЫ УРХИ БЕСТСЕЛЛЕР НОМЫН ЗОХИОЛЧ



DVD ДОТОР ДАРААХ МАТЕРИАЛУУД БИЙ

RELENTLESS (Mongolian)

by John Bevere

© 2017, Messenger International

www.MessengerInternational.org

Originally published in English as RELENTLESS

Additional resources in Mongolian by John & Lisa Bevere

Are available for free download at: www.CloudLibrary.org

To contact the author: JohnBevere@ymail.com

*This book is a gift from Messenger International,
the ministry of John and Lisa Bevere*

МЯТРАШГҮЙ

Жон Бивэр

© 2017, Мессенжер Интернэйшнл

www.MessengerInternational.org

Энэхүү номыг Христэч удирдагч нарт ҮНЭГҮЙ ТАРААХ зорилгоор хэвлэсэн бөгөөд худалдан борлуулахыг хориглоно. Номын зохиогч Жон Бивэр Монгол чуулганд бэлэг болгов.

Монгол хэл дээрх бусад материалыг www.CloudLibrary.org

цахим хуудаснаас үнэгүй татаж авах боломжтой.

Зохиогчтой холбогдох имэйл: JohnBevere@ymail.com

Библийн ишлэл: Ариун Библи

© 1995, 1996, 1997, 1998, 1999, 2000 Монголын Библийн Орчуулгын Хороо

© 2004, Ариун Бичээс Библийн нийгэмлэг

Энэхүү номоо

Хүү Алек Бивэртээ зориулав

Миний хүү бол бэрхийг даван туулж,
дайснаа дэвслэсэн ялагч.

Миний хүүгийн амьдрал тэр чигээрээ

Бурханы таалал хийгээд нигүүлслийн гэрчлэл.

Аав нь хүүгээ мөнхөд хайрлаж, хүүгээрээ мөнхөд бахархана.

АГУУЛГА

- Танилцуулга — 13
- 1 Мятрашгүй — 17
 - 2 Амьдралд захирах — 29
 - 3 Хүчний үүсгүүр — 43
 - 4 Есүс хэрхэн явсан бэ? — 55
 - 5 Онцгойрсон — 69
 - 6 Үзэх үү эсвэл орох уу? — 91
 - 7 Зовлонгийн ард хэн байна? — 111
 - 8 Бүрэн зэвсэглэ — 133
 - 9 Нигүүлсэл дотор хүчтэй — 151
 - 10 Даруу байдлын зэвсэг — 159
 - 11 Ачаагаа хая — 175
 - 12 Эрүүл ухаантай, сонор сэрэмжтэй бай — 193
 - 13 Диаволыг эсэргүүц — 207
 - 14 Хамгийн том эсэргүүцэл — 223
 - 15 Мятрашгүй залбирал — 239
 - 16 Шагналын төлөө гүй — 255
 - 17 Хаанд ойрхон — 271
 - 18 Хэзээ ч бүү бууж өг! — 281

Хавсралт А:

Бурханы хүүхэд болох залбирал — 291

Хавсралт Б:

Би яагаад олон янзын орчуулга хэрэглэдэг вэ? — 295

Дэлгэрүүлж бодох, ярилцах асуулт — 297

ТАНИЛЦУУЛГА

Номоо бичиж эхлээд удаагүй байхдаа миний бие хүн төрөлхтний мятрашгүй чанарыг бахдан гайхуулсан нэгэн кино үзсэн юм. Майкл Дуглас, Вал Килмер хоёрын тоглосон Сүнс, Харангуй хоёр гэдэг кинонд 1800 - гаад оны бодит түүхийг өгүүлдэг.

Ид гялалзаж яваа цэргийн инженер Паттерсон (жүжигчин Вал Килмер) Зүүн Африк дахь Британий төмөр замын сүлжээний өргөтгөлийн ажлын хүрээнд Угандагийн Цааво голын дээгүүр татах галт тэрэгний гүүрэн замын ажлын даамлаар томилогдон ирнэ. Паттерсоныг ирэх үед төслийн ажил нь хуваариасаа хол хоцорсон байлаа.

Энэ учир ч төдөлгүй тайлагдана. Шөнө бүр замын ажилчид учиг улгүй шалтгаанаар ор мөргүй алга болдог байв. Тэгтэл хүн иддэг хоёр арслан ажилчдын хуаранг самарч, хүмүүсийг авлаж байгааг Паттерсон олж мэднэ. Тэдний цуст авыг зогсоохын тулд Паттерсон янз бүрийн арга хэрэглэвч, хоёр араатан Паттерсоны үйл хөдлөлийг урьдаас таан, урхинаас нь бултаж байв.

Амиа алдсан хүний тоо гуч давмагц төмөр замынхан Чарльс Ремингтон (жүжигчин Майкл Дуглас) гэдэг Америк анчнаас тусламж гуйна. Тэрбээр алдартай анчин байсан ч, арслангуудыг зогсоож барсангүй. Араатнууд шөнө алгасалгүй авласаар, эцэстээ ажилчид нь арслангуудыг хэзээ ч дийлдэшгүй муу ёрын хүч гэдэгт итгэнэ. Үхсэн хүний тоо 130 давахад, айдаст нэрвэгдсэн замчид ажлаа хаяад, Цаавогоор дайрдаг галт тэргэнд дайгдаад, эргэж ч харалгүй зугтаж одохыг Паттерсон,

Ремингтон хоёр харуулдан зогсохоос өөр тусгүй байв.

Гэхдээ үүний дараа өрнөдөг үйл явдал намайг үнэхээр бишрүүлсэн юм. Хүмүүс хоёр тал болов. Нэг талд нь ажилчдыг айдсаар хутган үймүүлж, дуусгах ёстой гэрээт ажлаа хаяж явахыг хатгах хулчгар даамал. Нөгөө талд нь Ремингтон, Паттерсон хоёроос гадна айдаст залгиулж, ажил үүргээ хаяж зугтахтаас татгалзсан Паттерсоны туслах залуу гурав.

Тэр гурав мангастай нүүр тулахаар гурвуулханаа үлджээ. Хэд хэдэн удаа арсланг алахын даваан дээр бүтэлгүйтнэ. Тэдний өмнө үнэхээр “сүнс зайлмаар” аймшигтай даалгавар байв. Тэд амиа алдаж болох байсан ч, дайснаа дарж, гүүрээ дуусгахаар шулуудсан байлаа. Тэдний энэ зэвсэг нь айдсаас хавьгүй хүчтэй байв. Цэц ухаантай, сонор сэрэмжтэй, шийдэмгий байж, эс бууж өгвөөс гарцаагүй ялна гэдэгт Ремингтон, Паттерсон хоёр итгэл төгс байв.

Зайгаа бас цагаа хэмнэх үүднээс цааш нь юу болсныг би нэг бүрчлэн тоочихгүй. Ямар ч байсан хүн иддэг хоёр арслан эцэстээ алуулдаг. Гэхдээ энэ ялалт асар их үнээр ирнэ.

Ажилчид нь эргэж ирэхдээ, төслийнхээ инженер Паттерсоныг тэс өөр нүдээр харна. Тэрбээр үхэлтэй нүүр тулсан ч, бууж өгөөгүй учраас тэдний хувьд “баатар” болжээ. Ажилчид түүнийг гүнээ хүндэтгэн, үг дуугүй дагаж, бараг л боломжгүй гэмээр ажлыг хийж дуусгана. Гүүрийн ажил товлосон цагтаа дуусав!

Бурханы элчин сайдууд бид ч ялгаагүй гүүр босгож байна. Бидний гүүр голын хоёр эргийг бус, харин тэнгэр газрын хоорондох ангальг холбодог. Дээрх түүх шиг бид ч бас дайсантай нүүр тулах бөгөөд Бичээс бидний дайсныг цуслагч арслан гэдэг. Гэхдээ тэр дайсан Цаавогийн арслангуудтай адил зэвсэггүй бол, харин бидэнд зэвсэг бий. Дайсан зэвсгээ хураалгасан бол, бидэнд энэ дэлхийн хамгийн хүчирхэг зэвсэг бий.

Бидэнд ялах ёстой тулаан, эзлэх ёстой цайз хэрэм бий. Энэ тулаан нь голдуу хүн төрөлхтний дотор дайсны суулгасан сэтгэлгээ, үйл хөдлөлийн хэв маяг, загвар дотор өрнөдөг. Дайсагнал заавал ирнэ. Гэхдээ “Христийн дотор” бид хүч илүү гэдгээ бүү мартаарай.

Тэгэхээр бид маш чухал асуулттай тулаад байна: Бид

дайснаас айгаад, амиа авран шарвалдсан аймхай ажилчид шиг зугтах уу эсвэл мятрашгүй, хатан зоригтой байж, тэнгэрийн даалгавраа биелүүлэх үү? Энэ номын үнэн таныг мятрашгүй чанараар бэхлээд зогсохгүй, эерэг өөрчлөлт авчирдаг ялагч болгож өсгөх болтугай.

Энэ үнэнийг бат мэдэж, энэ үнэн дээр бат зогсоорой. Учир нь мэдлэггүйгээсээ болж Бурханы хүмүүс үй олон жил боолчлогдож, устаж үгүйрч явсан түүх бий (Исаиа 5:13; Хосеа 4:6). Зөв мэдлэгээр бид итгэлийн бат бөх суурийг цутгаж, харин бат итгэлээр бид төөрөлдсөн, харанхуй ертөнцийг өөрчилнө.

Та өөрийнхөө хүрээлэн буй нийгмийг өөрчлөхөөр төрсөн хүн. Тиймээс хэзээ ч бууж өгдөггүй тэр мятрашгүй хүчтэй танилцаж, түүгээр айсуй бэрхшээлтэй нүүр тулж сурцгаая.

1

МЯТРАШГҮЙ

Эхлэхээсээ илүү дуусгах нь дээр.

Номлогчийн үгс 7:8

Яаж “дуусгах” нь яаж “эхлүүлэхээсээ” чухал гэдэгтэй та санал нийлэх буй за. Христэд итгэгчид бид Эзэнээсээ “Сайн байна, Миний сайн, итгэмжтэй зарц!” гэдэг үгийг дуулсан цагт л итгэлийн амьдрал маань төгс өндөрлөнө.

Амьдралын маань хамаг зүйл болсон Эзэнээсээ энэ үнэт үгийг дуулахын төлөө амьдрахад ямар үнэ төлөөс шаардагдах бол?

Сайн дуусгахын тулд сайн амьдрах ёстой. Үүний тулд мэдээж “хэзээ ч бууж өгөхгүй” байх ёстой. Мятрашгүй сүнстэй байх ёстой гэсэн үг.

Гэхдээ үүнийг яаж хийх вэ? Энэ яагаад тийм чухал гэж?



Ний нуугүй хэлэхэд, итгэгч хүмүүс амьдралаа сайнгүй дуусгах вий гэдэгт миний бие зовниж явдаг. Нэгэн удаа Бурхан надад энэ номын сэдэвтэй шууд хамааралтай, үнэхээрийн түгшмээр үзэгдэл үзүүлсэн юм.

Нэгэн хүн голын хүчит урсгалыг сөрөн, шүд зуун сэлүүрдэх юм. Энэ нь мэдээж амаргүй боловч, огт боломжгүй хөдөлмөр бас биш ажээ.

Гэтэл үе үе түүний хажуугаар бөөн бөөн хүнтэй, том том завинууд урсгалд туугдан хөвж өнгөрнө. Завин дээрх хүмүүс тааваараа идэж ууж, инээж ханиасаар, урсгал сөрөн тэмцэх нөгөө эрийг хараад элэг доогь хийнэ. Тэр хүн хөлс баасаа асган байж, хуруу газар урагшилж байхад, том завин дээрх хүмүүс хуруугаа ч хөдөлгөхгүй “жаргах” мэт харагдана.

Хэсэг хугацааны дараа нөгөө хүний тэнхээ барагдав. Тамирдаж, сульдсан эр сэлүүрээ суллалаа. Эхлээд хэд хэд сэлүүрдэж байснаа, төдөлгүй таг зогсчихов. Тэгтэл тун харамсалтай юм болж, завь нь урсгал өөд харсан чигтээ урсаж эхлэх нь тэр.

Тэгж байтал мань эр өөр нэгэн цэнгэлтэй завьтай таарав. Тэр завь өмнөх завиудаас арай өөр байлаа. Юув гэхээр, тус завь яг мөнөөх эрийн завь шиг урсгал өөдөө харчихсан урсаж байв. Тиймээс сайхь эр тэр завины хүмүүстэй нийлэхээр шийдэн, завинд нь орж сууна. Өмнөх завиуд нь хамраа усны урсгал дагуу харуулчихсан урсаж явсан бол, тэр завь урсгал өөд харчихсан байжээ. Гэхдээ хамгийн харамсалтай нь тэр завь ч ялгаагүй урсгал даган урсана.

Энэ үзэгдлийн тайлал нь юу вэ? Тэр гол нь энэ дэлхий юм. Завь нь энэ дэлхий дээр хүн биднийг амьдарч, ажиллах чадвартай болгодог бие юм. Харин завин дээрх эр нь итгэгч хүн бөгөөд түүний гарт буй сэлүүр нь Бурханы харьшгүй нигүүлсэл юм. Цэнгэлтэй завиуд нь ижил төстэй зорилгоор нэгдсэн хүмүүсийг дүрслэж байгаа бол, голын урсгал нь муу ёрын нэгний зангаагаар хөдлөдөг дэлхийн урсгал юм.

Мөнөөх эр Бурханы хаанчлал дахь хувь тавиландаа хүрэхээр нигүүлслийн сэлүүрээр урсгал сөрөн сэлүүрджээ. Түүний бял бол түүний итгэл юм. Гэвч харамсалтай нь тэрбээр эцэстээ тамирдсан. Түүнд зорьсондоо хүрэх биеийн хүч нь байв ч, сэтгэлийн хүч нь цуцсан учраас өөрийгөө чадахгүй хэмээн бодож, бууж өгөөд тэмцлээ зогсоожээ.

Сэлүүрдэхээ зогсоомогц, завь нь өмнөх сэлүүрийнхээ эрчээр нэг хэсэгтээ (урсгал өөд) урагш харсан чигээрээ байна. Тэгээд яг энэ эгшинд хажуугаас заль шургана. Харахад амьдрал нь урагшилж, үр жимс ургуулсаар байх мэт үзэгдэвч, энэ бүхэн нь үнэндээ ямар ч амьгүй юм. Тэрбээр сонор сэрэмжээ алдаж, итгэлийн амьдралаар амар хялбар, амжилттай аж төрж чадаад байна хэмээн андуу сэтгэнэ.

Эцэстээ завь нь таг зогсож, ургалд туугдаж эхэлнэ - анхандаа алгуур боловч, адагтаа урсны хурдаар туугдана.

Харин одоо энэ үзэгдлийн гол үнэнийг тайлъя: сайхь эрийн завь нь урсгал өөд урагш харсан боловч, урсгалаараа хойш туугдаж яваа юм. Тэрбээр Христэд итгэгч хүний хэлээр ярьж, дууг дуулж, хаанчлалын зан аягийг харуулж, Христэд итгэх итгэлийн дүрийг үзүүлэвч, хэрэг дээрээ дэлхийн замаар замнаж яваа хүн ажээ (1Иохан 2:15-17).

Сүүлдээ манай “дайчин” өөрийнхөө адил “итгэгчдийн” баяр цэнгэлтэй завийг олж үзсэн. Тэд ч бас завиныхаа хамрыг урсгал өөд харуулсан учраас, өөрсдийгөө чуулганы нэг хэсэг гэж бодно. Тэд ч бас Христитгэлийн хэл, дуу, зан аягийг мэднэ. Гэвч тэр хүмүүс зовлогоо зовоолгүй, аясаараа хөвж яваа нь үнэндээ хэдийнээ дэлхийн урсгалыг дохидог ёрын муу нэгний удирдлага дор ямар ч үр жимсгүй “итгэлийн” амьдралаар цамнаж яваагийн царай ажээ.

Үл итгэгч дэлхий тэр “Христчин завьд” сууж яваа хүмүүсийг хавчиж, гоочлох нь бүү хэл, харин ч бүр өхөөрдөн хөөргөдөг. Тэр хүмүүс Филиппой 3:14 дээр элч Паулын Христэд итгэгч хүмүүст хандан: “Би Христ Есүс дотор Бурханы дээш чиглэсэн дуудлагын шагналыг авахын төлөө бариа руу урагшилдаг” хэмээн захисны дагуу урагшаа - зөвхөн урагшаа давшихаа байчихсан хүмүүс юм. Үнэндээ тэдгээр итгэгч нэртнүүд нь дэлхийн замыг барагтай - за шуудхан хэлэхэд огт эсэргүүцдэггүй билээ.

Элч Иоханы үгийг үзнэ үү:

Учир нь ертөнцөд байгаа бүхэн тухайлбал, махан биеийн хүсэл тачаал, нүдний хүсэл тачаал, амьдралын бардам

бахдал нь Ааваас бус, харин энэ ертөнцөөс ирдэг юм. Ертөнц хийгээд түүний хүсэл тачаал нь өнгөрнө. Харин Бурханы хүслийг үйлддэг нэгэн нь мөнхөд оршдог. (1Иохан 2:16-17)

Дээрх үзэгдэлд *итгэгчид*, *үл итгэгчид*, *мэхлэгдсэн хүмүүс* гэсэн 3 төрлийн хүн гарч байна.

- Зүгээр л аваад л, аваад л, аваад л байх хүсэлдээ улайран урсах *үл итгэгчид*.
- Бурханы хаанчлалыг дэлгэрүүлэхийн төлөө давшаад л, давшаад л, давшаад л байх ёстой *итгэгчид*.
- Аваад л, аваад л, аваад л байх хүслээ “Христчин дүрээрээ” нууж явдаг *мэхлэгдэгсэд*.

Өнөөгийн хүмүүсийн сэрдхийм дүр байдлыг төлөөлсөн энэхүү үзэгдлээс хүн бүр өөрөөсөө: “Би хэнтэй нь адилхан байна?” гэж асуух хэрэгтэй. Эцсийн эцэст Бурхан бидэнд...

Та нар итгэл дотор байгаа эсэхээ шалгаж, өөрсдийгөө батла.
... (2Коринт 13:5) хэмээн тушаасан буюу.

Ийм үзэгдэл үзэж, тайллыг нь ойлгосныхоо дараа би Еврей итгэгчдэд хандсан доорх үгийг яс махаараа ухаарсан юм:

Иймд цуцсан гар, сульдсан өвдгөө тэнхрүүлэгтүн. Доголон нь замаасаа хазайхгүй, харин эдгээгдэхийн тулд өөрсдийн хөлд зориулж шулуун зам тавь. ... Хэн чинь ч Бурханы нигүүлслээс салахгүйн тулд болон ямар ч гашуун үндэс урган хор учруулан, түүгээр олон хүн бузарлагдахгүйн тулд сэрэмжил. (Еврей 12:12-13,15)

Бурханы хүүхдүүд бид Аавынхаа алдрын төлөө амьдралаа сайн дуусгахын төлөө улайрч амьдрах ёстой. Та бид хоёр цуцаж, сэлүүрээ тавьж, энэ дэлхийн урсгалд туугдаж, Бурханы нигүүлслээс эргэх талаар санах ч учиргүй.

Сайн дуусгаагүй хүмүүс яадгийг Бичээсийн жишээнээс ахин дахин үз. Давидын хүү, үе үеийн хамгийн цэцэн билэг,

баян, хүчирхэг хаан болох Соломоныг л хар. Тэрбээр урьд хожид ямар ч аавын хүүгийн хүрэх нь бүү хэл, бараадаж очоогүй өндөрлөгт гарсан ч, жаргалдаа ташуурч, сэлүүрээ суллаж, хаанчлалынхаа адаг дээр дэлхийн системтэй сээр хүзүү холбон, сэтгэл зүрхээрээ Бурханаас урвасан байдаг.

Соломон хэдэн зуун гадаад эхнэртэй байсан болохоор, Иехова Бурхандаа л үнэнч дуулгавартай байх тал дээр байнгын хэрүүл уруул болдог байсан биз. Тэгээд тэр олон хүүхэнтэйгээ ам хэлээ олж, амар жимэр амьдрах гэсэндээ Соломон Иехова Бурханаасаа нүүр буруулж, эхнэр хүүхнүүдийнхээ харийн бурхдыг залаад зогсохгүй, өөрөө ч сүслэн мөргөдөг болжээ.

Энэ увайгүй үйлдлээс нь болж Соломоны үр удам өндийж босох аргагүй их гай зовлонд унасан тул Соломон хар толгойгоо мянга шаагаад ч нэмэр болоогүй юм. Соломон эцэг Давидынхаа итгэмжтэйгээр бөхлөсөн хүчирхэг хаанчлалыг хүлээж аваад, эхэндээ уламчиг батжуулсан ч, яваандаа туйлдааж, бутгаргаж, адагт нь мөхөөжээ. Соломон сайн дуусгаж чадаагүй учраас л тэр шүү дээ. Соломон мятрашгүй байсан бол, Израилийн түүх тэс өөрөөр эргэх байсан.

Тэгвэл Иохан баптистыг Соломонтой харьцуулья. Иохан үнэнийг хүчирхэг үгээрээ тунхаглан, нэр төртэй амьдралаараа батлан, шийдэмгий амьдарсан. Иохан ч ялгаагүй дайсагналд өртсөн. Гэхдээ Иүдейн хааны хатан юмуу хамсаатнууд нь биш, харин Иүдейн хаан нь өөрөө Иоханы тунхагласан үнэнийг дагаж амьдраагүйгээс болж, Иохан Соломоноос хавьгүй аймшигтай үр дагавар үзсэн юм. Соломонд гэр бүлийн асуудал нүүрлэсэн бол, Иохан шоронд орж, тамлуулж, эцэст нь алуулсан. Гэтэл ийм аймшиг, аюул, үхэл сэхлийн нүүрэн дээр ч Иохан үнэний төлөө үгээрээ ч, үйлдлээрээ ч бат зогссон учраас эцэстээ Соломонтой зүйрлэшгүй аугаа өв үлдээж чадсан юм.

Иохан, Соломон хоёрыг дайрсан зовлонгийн үер та бид хоёрыг ч дайрна. Бид хувхайрсан дэлхийн хоосон үнэлэмжтэй тэмцэлдэж байна. Энэ дэлхийн нөлөө нь хүчирхэг. Зальжин. Ховсдом. Тэнд хүн “Ядарч байна. Жаахан амраадхая” хэмээн сэрэмж алдан, бууж өгөөд, үерийн усанд хамуулах амархан. Та бид хоёрын хувьд амьдралаа сайн дуусгах цорын ганц зам нь

итгэлдээ мятрашгүй зогсох юм. Ингэж байж л бид харанхуйн хаанчлалд жинхэнэ аюул занал учруулж, тэдэнтэй нэгийгээ үзнэ.

МЯТРАШГҮЙ СҮНС

Мятрашгүй байх гэж юу гэсэн үг вэ? Энэ нь шийдэмгий, тууштай, бууж өгөхийг мэдэхгүй тэрс хандлага, эрс байдлыг дүрслэнэ. Товчхондоо няцдаггүй л гэсэн үг. “Няцамхай” гэдэг үг нь улам л хүлцэнгүй дорой болж, найр тавин буулт хийдэг шинжийг хэлнэ. Мятрашгүй гэдгийг өөрөөр “сөхрөшгүй, яс, хатуу, найраагүй, дийлдэшгүй, гүргэр, махруун тэгээд бүр “гөжүүд” гэж хэлж болно. Мөн “шийр заасан, тууштай, баригдашгүй, санаа шулуудсан, ган бат, зоргоороо, цөхрөшгүй, чадуу” гэж ч болно.

Мятрашгүй гэдэг үгээр муу ёрын, тавирашгүй хүчийг дүрслэж болох ч, бид энэ үгийг бурханлаг, эерэг утгаар хэрэглэн, хэрэг зоргодоо хүрэхээр шулуудсан хатан зоригт хүнийг дүрслэнэ. Тэрбээр хол ойрын ямарваа зорилгодоо хүрэхээс нааш сэтгэл амардаггүй бөгөөд түүнийг юу ч зогсоож дийлэхгүй.

Мятрашгүй итгэгч гэж бэрхшээл дунд Бурханд тавих итгэл, найдвар, дуулгавартай зангаа сулруулах нь бүү хэл, улам чангалдаг хүнийг л хэлээд байгаа юм. Амьдралаа бүх талаараа сайн төгсгөхийн төлөө бүх чадлаараа зүтгэсэн, мятрашгүй итгэгч хүн л энэ дэлхийн түүхийг туурвиад, ирээдүйд тэнгэрт очихдоо Эзэнээрээ “Сайн байна!” хэмээн сайшаалгасан нэгэн гэдгээрээ мөнхөрнө.

Нэгэн цагт “мятрашгүй” гэж нэрлэхийн аргагүй байсан нэг хүнийг би мэднэ. Тэр бол би! Үнэндээ би мятрашгүй гэх нь байтугай, хамгийн няцамхай хүн байв. Хатуухан хэлбэл шарваач л байлаа.

Би 1979 онд Пердю Их Сургуулийн оюутан байхдаа Бурханд итгэсэн юм. Семестрээ дуусгаад, гэртээ чавхдаж хариад, Католик аав ээж хоёртоо шинэ итгэл бишрэлийнхээ талаар шууд хэлтэл, ээж маань юу гэсэн гэж санана? “Хүү минь, энэ чиний ээлжит сонирхол. Удахгүй залхчихна!”

Ээжийн энэ үг намайг ян хийтэл хатгав. Гэхдээ гутранги муу үг байсандаа биш, харин ч хатуу боловч дэндүү үнэн үг

байсандаа тэр. Би ч үнэхээрийн л барьж авсан бараг бүх зүйлээ хаядаг байв.

Ганц бие байхдаа, ирээдүйд тогтвортой гэр бүлтэй болж чадахгүй байх вий хэмээн түгшдэг байлаа. Учир нь би нэг охинтой хоёр, гурав уулзаад л залхдаг байв. Тэд яриангүй хөөрхөн, мундаг, эелдэг охид байсан ч, миний уйдамхай зангаас л хамаг хэрэг болдог байв. Учир нь дараа нь тэд өөр залуустай маш сайхан үерхэж яваа харагддаг байлаа. Гэтэл би нэгийг нөгөөгөөр солихоос өөр ямар ч ахицгүй байв.

Би зөвхөн үерхэл нөхөрлөлдөө няцамхай байсангүй. Төгөлдөр хуур сурч эхэлсэн ч, зургаан сарын дараа л “болимоор байна” хэмээн үглэн дуулсан юм. Учир нь аав, ээж хоёр маань болиулахгүй байв.

Тэгэхээр нь тас хэдэрлэв. Миний энэ зангаас залхсан төгөлдрийн багш маань өөрөө аав, ээжээс хоёроос “хүүдээ төгөлдөр хуур битгий сургаач” гэж гуйсан юм. Багш маань амьдралдаа цорын ганц удаа цорын ганц хүнийг төгөлдөр хуур битгий сур гэж “урамшуулан дэмжсэн” нь би байв!

За тэгээд биеийн тамир спорт дээр ч ялгаагүй. Бэйсбоол тоглосон. Хэдэн жилийн дараа хаясан. Сагс тоглосон - гурван сар л тэссэн. Дараа нь гольф барьж авсан - мөн л гурван сар. Гүйлтээр хичээллэсэн ч ялгаагүй л төгсгөв.

Ингээд л тоочоод байвал, тоочоод л байна. Ном уншина - дуусгахгүй. Ахлах сургуульд би ганц ном л уншиж дуусгасан нь Эрнест Хемингуэйн “Өвгөн тэнгис хоёр” гэдэг зохиол байлаа. Дүнгээ гаргуулахын тулд унших шаардлагатай байсан бөгөөд бэсрэг зохиол учраас, дээрээс нь би загасчлах дуртай учраас, малийж байгаад л дуусгаж билээ.

Төрөл бүрийн клубт элсэнэ - төд удалгүй хаяна. Ховор зүйлс сонирхож, үнэтэй тоног төхөөрөмж авахуулсан ч, сүр дуулиантай эхэлсэн сонирхол маань төдөлгүй сарниж, үнэтэй тоног төхөөрөмж маань шүүгээний буланд зэврэв.

Товчхондоо ээж маань яг л үнэн хэлсэн юм. Би цаашдаа

■
**Мятрашгүй итгэгч
хүн л энэ дэлхийн
түүхийг туурвидаг.**
■

энэ л замаараа замнах уу? Бурханд итгэсэн шинэхэн итгэл, оргилуун хүслээсээ няцаж, Христэд итгэх итгэлээсээ ухрах уу? Библи тэргүүтэй номууд маань миний урьдын богино наст дур сонирхол шиг шүүгээний буланд шарлах уу?

Гэхдээ нэг сайхан мэдээ дуулгая. Тэр амархан залхдаг няцамхай этгээд чинь өдгөө гуч гаруй жил Есүс Христийн төлөө дүрэлзсээр л явна. Өнөөдөр би гэртээ ирээд, аав ээж хоёртоо шинэ итгэлээ хөөрөн байж дуулгасан шигээ л - магадгүй түүнээсээ ч хүчтэй дүрэлзэж явна. Аугаа хүчирхэг Бурхан Аав минь над шиг амархан няцдаг, нялздаг, туйлбаргүй этгээдийг өөрчилж, Ариун Сүнсээрээ мятрашгүй сүнслэг чанартай болгосон билээ.

Бурхан намайг *мятрашгүй итгэгч* болгосон.

Хэрэв та Есүс Христийг Эзэнээ болгон хүлээж авсан л бол, яг ийм чанартай болох бүрэн боломжтой. Гэхдээ мэдээж хөгжүүлэх хэрэгтэй. Энэ номын зорилго нь ерөөсөө л энэ. Амьдарсан шиг амьдарч, дуусгасан шиг дуусгахын төлөө Бурханаас зүгээр ирсэн энэ чадварыг хэрхэн өсгөж, хүчжүүлэхийг танд зааж өгнө.

БУРХАН ТАНЫ ТУХАЙ НОМ БИЧЖЭЭ

Газар дээр дэлгэрэх Бурханы үйл хэрэг дотор хувь тавилангаа биелүүлэхийн тулд та өөрийгөө хэн болохыг, Бурханд хичнээн хэрэгтэй болохыг ухаарав уу? Тэнгэрийн Аав тань танд найдаж байгаа гэхээр балмагдаж байна уу?

Бурхан танд зориулж амьдралын зам тавьжээ! Тэр зам чинь таныг төрөхөөс ч өмнө тэмдэглэгдсэн байж. Дуулал 139:16 дээр:

“Төрхөө олоогүй хөврөл байхад минь Таны нүд харж л байсан. Надад тогтоогдсон өдрүүд болоогүй байхад Бүгд номд тань бичигдсэн байжээ” гэдэг.

Аав ээжийнхээ бодолд ч мэндлээгүй, төрхөө ч олж амжаагүй хөврөл байхад чинь Бурхан таныг ажиглан харж, таны тухай ном бичиж байжээ. Тэгэхээр зөвхөн манлайлагч, алдартнууд л хөрөг намтраа бичүүлдэггүй аж. Бурхан таны талаар ном

бичихээр барахгүй, энэ номоо таныг мэндлэхээс ч өмнө Өөрийн мутраар үзэглэн туурвижээ.

Та “Жон, та миний талаар мэдэхгүй байна! Би чинь тэнэг сонголтоороо амьдралаа балласан усан толгой шүү дээ. Тэгээд тэр бүхнийг чинь Бурхан үзэглэсэн болж таарах нь ээ?” хэмээн хилэгнэж магадгүй.

Үгүй, мянгантаа үгүй! Бурхан бидний амьдралд зам тавьсан. Харин Түүний тавьсан ер бусын замаар явах үгүйгээ бид өөрсдөө шийддэг. Бид буруу сонголт хийж төөрөлддөг ч, жинхэнээсээ гэмшбэл, завиа зөв зам руу дахин залах боломжтой.

Эсвэл та: “Амьдрал надад хатуурхаж, би өөрийн буруугаас биш, өрөөлийн гайгаар аймшигтай хохирсон хүн. Тэгэхээр тэр их гутрал, зовлонг Бурхан зохиосон байх нь ээ?” хэмээн асч магадгүй.

Мөн л “Үгүй!” гэж хариулья. Хүн бид нүгэлт дэлхийд аж төрж байна. Есүс ч биднийг үлэмж их зовж, үй түмэн бэрхшээлтэй тулгарна гэсэн. Гэхдээ танд ямар гээчийн бэрхшээл тулгарахыг Бурхан төрөхөөс чинь ч өмнө мэдэж байсан учраас, үүнээс сэргийлж зугтах юмуу даван туулах замыг цэц ухаанаараа бэлтгэж өгчээ. Тиймээс л Бурхан Өөрийнх нь Үгд мятрашгүй ханддаг итгэгч хүмүүсийг “ялагч” гэсэн юм.

Еврей 12:1-р ишлэл хүн бүрийг “Тиймээс бид өөрсдийг минь хүрээлэн буй үүл мэт үлэмж их гэрч нартай тул аливаа саад тотгор ба амархан урхиддаг нүглийг хажуу тийш нь тавьж, өмнөө тавигдсан уралдаанд тэвчээртэйгээр гүйцгээе” хэмээн ятгадаг. Бурхан хүүхэд болгоноо уралдааны гараан дээр тавьдаг. Та мятрашгүйгээр гүйж байж л уралдаанаа дуусгана. Өөр арга байхгүй. Дээрх хэсэгт тэвчээр гэдэг чанарыг онцлон тэмдэглэсэн нь нэн сонирхолтой юм. Бичээч “жаргалтай юмуу зорилготой эсвэл бүр нухацтай гүйцгээе” гэж хэлээгүй. Намайг буруугаар бүү ойлгоорой. Аз жаргал, зорилго, нухацтай байдал нь бүгд Христэд итгэх итгэлийн замд зайлшгүй чухал чанар мөн. Гэхдээ энэ бүхнийг манлайлдаг амин чанар нь мятрашгүй чанар юм.

Хүн мятрашгүй сүнстэй байж л сайн дуусгана. Сайн дуусгахын тулд тууштай, тэвчээртэй байх ёстой. Еврей 12:1-р

ишлэлийг Мессеж Библи маш гоё хэлдэг: “Бэлтгэх байдлаа ав, гүй, тэгээд хэзээ ч бүү зогс!” Барияндаа орох эсэхээс маань бидний өөрийн амьдрал төдийгүй, бидний хайртай хүмүүсийн амьдрал ч шийдэгдэнэ. Та Бурханы хүүхэд мөн л бол, танд шаардлагатай бүхэн байгаа! Бурхан таны дотор таныг бүх талаар чадвартай болгодог хүчийг суулгасан. Тууштай байх аваас, та элч Паул шиг “Би сайн тэмцлээр тэмцсэн, замаа дуусгасан, итгэлээ сахисан” (2Тимот 4:7) гэж хэлэх л болно.

Та гэрлэлт, гэр бүл, ажил, бизнес, сургууль, санхүү, эрүүл мэнд зэрэг аль ч тал дээрээ бэрхшээлтэй тулж болно. Нөхцөл байдал чинь ямар ч гарцгүй - юу юугүй л хамаад явчихмаар зүрх үхүүлж, сэтгэл мохоом хүчтэй урсгал шиг л харагдаж байна уу? Тэгвэл танд нэгэн сайхан мэдээ дуулгая: “Энэ нь хүмүүст боломжгүй боловч Бурханы хувьд өөр. Учир нь Бурханд бүх юм боломжтой” (Марк 10:27). Таны нөхцөл байдал ямар аймшигтай байсан ч, Бурханы өмнө юу ч биш юм. Гэхдээ Есүс энэ амлалтаа маш чухал нэгэн шалгуур хавсаргажээ: “Итгэдэгт нь бүх юм боломжтой!” (Марк 9:23) Боломжгүй юм боломжтой болохыг харахын тулд мятрашгүй итгэл хэрэгтэй. Энэ ном маань ч “хүний чадвараас давсан зүйлтэй нүүр тулж, боломжгүй нь Бурханы хүч, нигүүлслээр боломжтой болохыг харах” тухай л өгүүлнэ.

Сонс! Бурхан таныг “Эзэний өмнө аугаа” (Лук 1:15) гэж дуудахыг хүсч байна. Бурхан шиг таны төлөө, таны амжилтын төлөө гараа гаргадаг хэн ч байхгүй. Тэр танд гайхамшигтай амьдрал зэхсэн бөгөөд амьдралаа гялалзтал төгсгөж, хойч үедээ итгэл, ач холбогдол, суутай амьдрал өвлүүлж үлдээхийг чинь хүсэн хүлээдэг. Тийм боловч мятрашгүй итгэгч байх эсэх нь танаас л бүрэн шалтгаална.

Та “Үнэнийг хэлэхэд би тийм ч хатуужилтай хүн биш. Хүнд байдалд орохоороо хаяад зугтана уу л гэхээс, гүрийгээд давсан тохиолдол над байхгүй” гэж бодож байж магадгүй.

Хэрэв та тийм хүн бол, танд дуулгах бүр ч чимэгтэй мэдээ байна.

Одоо таны өнгөрсөн баларсан хамаагүй. Есүс Христийн нигүүлслийн ачаар, өдгөө та хуучнаа давтах шаардлагагүй

болсон. Та жинхэнэ мятрашгүй итгэгч болж, амьдралаа сайн дуусгах бүрэн боломжтой. Та сайн төгсгөл хийх бүх болзлыг хангасан хүн гэдгийг баяртайгаар дуулгая. Бурхан таныг аугаа хувьтай хүн гэж хардаг!

Есүсийг дагаж буй хүн зам дээр отох дайсагналаас зугтахгүй. Энэ замаар явах төлөөс нь ч өндөр, шагнал нь ч өндөр. Таны хүч нөлөөг үгүй хийж, Бурханаас хүлээж авсан даалгаврыг чинь нураах санаатай атаат дайсан танд бий. Сатан таныг үтэр түргэн цааш нь харуулах шаардлагатай, аюултай этгээд гэж үздэг бөгөөд яг үнэндээ таныг алж байж л санаа амарна. Гэхдээ Есүсийн загалмайн үйлсийн ачаар Сатан хэдийнээ ялагдсан. Түүний эхлүүлж байгаа тулаан бүрт Сатан хэдийнээ ялагдаж, бид хэдийнээ ялсан! Гэхдээ энэ ялалтыг биелэл болгохын тулд бид Сатантай болоод Сатаны хамсаатнуудтай мятрашгүй тулалдах ёстой! Харин хэрхэн тулалдахыг одоо сурцгаая.

Та бол энэ дэлхийг өөрчлөхөөр бүтээгдсэн хүн. Та бол Бурханы төлөө захирах хувьтай Хааны хүүхэд. Та хаанчлалын түлхүүрийг өвөртлөсөн хүн! Бурхантай хамт мятрашгүй итгэлээр алхбал, Бурхан танд юу юугүй туугаад аваад явчих гэж буй хүчит урсгалыг сөрөн явах хүч, чиглүүлгийг өгнө.

Тэгэхээр Бурханы үгээр үргэлжлүүлэн аялахаасаа өмнө аян замаа Эзэнд даатгая:

*Дээдийн дээд Бурхан минь, энэ номыг уншиж байхад
Таны Ариун Сүнс намайг сургаж, гэгээрүүлэх болтугай.
Би зүгээр нэг мэдээлэл юмуу догь санаа олж авмааргүй
байна. Миний амьдралд суулгасан, Таны ер бусын баялаг
дуудлагыг би зүрхээрээ ойлгомоор байна. Хувь тавилангаа
биелүүлээрэй гэж Таны өгсөн хүчийг би мэдмээр байна.*

■
**Бурхан шиг таны
төлөө, таны
амжилтын төлөө
гараа гаргадаг хэн
ч байхгүй.**
■

Үгээрээ дамжуулан намайг ямар ч дайсны өмнө үнэн дотор мятрашигүй бат зогсож чаддаг болгооч. Та намайг энэ цагийн төлөө төрүүлсэн. Та намайг “Мятрашигүй” гэдэг энэ номын үгээрээ боловсруулан сургаж, Өөрийнхөө нэрд алдрыг, Өөрийнхөө зүрхэнд баяслыг авчраач. Есүсийн нэрээр залбирч байна. Амень.

АМЬДРАЛД ЗАХИРАХ

Учир нь Бурханы үг амьд бөгөөд идэвхитэй, хоёр талдаа иртэй ямар ч илдээс хурц бөгөөд сэтгэл хийгээд сүнсийг, үе мөч хийгээд нугас чөмгийг салтал нэвтрэн ордог агаад зүрхний бодол хийгээд санааг ч шүүх чадвартай юм.

Еврей 4:12

Бурханы үгийг үг чигээр нь хүлээж авдаг байсан бол, өнөөдөр хүмүүс тэс өөр байх байсан. Ер нь олон хүний хувьд нөхцөл байдлаа сэтлэн, Бурханы Үгд итгэх шиг хэцүү юм байдаггүй гэлтэй. Таны өнөөгийн нөхцөл байдал таагүй байгаа бол, үүнийг өөрчилж болно, амьдрал ингээд дуусчихгүй гэдгийг мэдээрэй. Юуг ч өөрчилж болно. Хэзээ ч өөрчлөгддөггүй нэг л зүйл байдаг. Тэр бол Бурханы Үг юм. Олон жилийн тэртээ Есүс Христ Өөрөө “Тэнгэр газар өнгөрөн одовч Миний үгс үгүй болохгүй” (Лук 21:33) хэмээн мэдэгдсэн. Дээшээ хараад, хүн төрөлхтөн бий болсон цагаас өнөөдрийг хүртэл дэлхийг гэрэлтүүлж бас дулаацуулсаар ирсэн нарыг хар даа. Бурханы Үг худлаа болж таарахаас тэр нар унтарч сүйрэх нь илүү амархан ажээ. Бурханы Үг үеийн үед, мөнхийн мөнхөд тогтоно!

Иеремиа 1:12 дээр Аугаа хүчирхэг Бурхан Аав маань “Чи сайн харлаа. Учир нь үг минь биелэхийг Би харж байна (Би

Үгээ гүйцэлдүүлэхэд бэлэн байна)” хэмээн мэдэгджээ. “Бэлэн байна” гэснийг анхаарна уу. Бурхан үгээ яг хэзээ биелүүлэх вэ? Хамгийн энгийнээр хэлбэл “хэн нэг хүн итгэх үед!” Марк 9:23 дээр Есүс “Итгэдэгт нь бүх юм боломжтой” хэмээн айлдахдаа, дээрх үгээ бататгажээ. Тиймээс аймшиггүйгээр итгэ!

АМЬДРАЛД ЗАХИРАХААР ТӨРСӨН

Дараагийн дөрвөн бүлгээр бид амин чухал нэг үнэнийг сурна. Энэ үнэн бидэнд итгэлийн амьдралаа сайн дуусгахын төлөө яаж мятрашгүйгээр тэмцэхийг зааж өгнө. Заримдаа яриа маань сэдвээсээ хазайх мэт санагдаж болно шүү. Гэхдээ надтай хамт байгаарай. Аялалын маань төгсгөл дээр бүх зүйл эвлэн нийлж, нэгэн цул болно.

Үүнийг санангаа, Шинэ гэрээний нэгэн чухал бичээсийг нягтлая:

...тэгэх тусмаа нигүүлслийн баялгийг болон зөвт байдлын бэлгийн дүүрэн хүртэгсэд нь Есүс Христ гэгч ганц Хүнээр дамжин амь дор ноёрхоно. (Ром 5:17)

“Амь дор ноёрхоно” буюу “амьдралд захирна” гэсэн хэллэгийг анхааралтай харна уу. Үүнийг Нью Интернэйшнэл Вержн Библи дээр “амьдралд ноёлох” гэдэг бол, Вэймот дээр “хаад мэт амьдралд хаанчлах” гэдэг. Бурханы хүүхдүүд болсон та бид хоёр хаад хатад шиг захирахаар төржээ! Үүнийг би хэлээгүй, Бичээс өөрөө хэлж байна. Харин “Бичээс бүр нь Бурханы амьсгалснаар...” байдаг юм (2Тимот 3:16). Тэгэхээр Бурхан биднийг Түүний Хүүгийн хүчээр амьдралд захирна гэжээ. Бурхан “Та нар хожим тэнгэрийн улсад захирна” эвсэл “хойд насандаа захирна” гэж хэлээгүй. Бурхан биднийг Христээр дамжин энэ амьдралд хаад хатад шиг захирна гэдгийг тодоос тод мэдэгджээ.

Миний толь бичиг дээр хаан, хатан гэдгийг “тодорхой давхаргадаа дээдийн дээд юмуу эрхмийн дээд байр суурь эзэлдэг хүмүүс” хэмээн тодорхойлсон байна. Харин захирах

гэдэг үгийг “ноёрхол буюу өргөн хүрээний нөлөө” хэмээн тодорхойлжээ. Тэгэхээр хаад хатад шиг захирна гэдэг нь тодорхой давхаргадаа дээдийн дээд ноёрхолтой байж, нөлөөлөхийг хэлдэг ажээ. Тэгвэл бид чухам ямар давхаргад дээдийн дээд байж, ноёрхох вэ? Амьдрал гэдэг давхарга дээр.

Өөрөөр хэлбэл бид амьдралд дээрэлхүүлэх биш, харин амьдралыг захирах ёстой ажээ. Энэ бол Бурханы Үг - танд өгсөн Түүний амлалт! Үүнийг зүрхэндээ бат суулгаарай.

ХУДАЛ МЭДЭГДЭЛ

Гэтэл бид өдий хүртэл нэгэн худал мэдэгдэлд бөмбөгдүүлсээр иржээ. Нөхцөл байдал хор хохиролтой, таагүй, хүнд - тэр бүү хэл аминд халтай болох үед нэжгээд хүмүүс: “Бурхан хянаж байгаа” гэсэн баталгаа дор маш хүлцэнгүйгээр амаа үддэг. Энэ нь угтаа “Бурхан бүхнийг хянадаг. Тиймээс бидэнд нүүрлэсэн бэрхшээлийг Бурхан хайраар дүүрэн, сайн мөн чанараараа яаж ийгээд эргүүлж дөнгөнө. Тиймээс бид өөрсдөө эсэргүүцэлтэй нүүр тулж, савсагнах хэрэггүй” гэсэн заль мэх юм.

Гэтэл үнэндээ Бурхан энэ мэдлийг бидний гарт өгсөн юм. За, номоо чулуудахаасаа өмнө миний үгийг сонсож хайрла.

Дуулал ном “Тэнгэрс бол ЭЗЭНий тэнгэрс, Харин дэлхийг Тэрээр хүний хөвгүүдэд өгчээ” гэдэг (Дуулал 115:16). Мессеж Библи үүнийг “Тэнгэрсийн тэнгэр нь БУРХАНЫХ бол, газрыг Тэр бидэнд хариуцуулсан” гэдэг.

Тэгэхээр газрыг хэн хариуцдаг байх нь? Бид!

Аугаа хүчирхэг Бурхан бол онц бөгөөд бүрэн эрхт Бүтээгч учраас энэ л бүрэн эрхийнхээ дагуу газрыг захирах мэдлийг, хэрхэн захирах мэдэлтэй нь хамт хүнд гардуулжээ. Олон хүний итгэдэгчлэн, хэрэв Бурхан дэлхийг хянан захирсан хэвээр байгаа юм бол, Адам хориотой жимсийг ам руугаа явуулах үед л Бурхан хажуугаас нь дэлсэж, жимсийг нь унагаад: “Адам гуай, яаж байгаа чинь энэ үү? Наадахаас чинь болж юу болохыг ойлгож байна уу? Чам дээр, чиний үр удам дээр ямар гээчийн зовиур, зовлон, өвчин, гамшиг, өлсгөлөн, ядуурал, аллага, хулгай буухыг мэдэж байна уу? Газар

хөдлөлт, хуй салхи, хар шуурга, хортон, ган гачиг, араатны аюулын талаар ярихын ч хэрэггүй. Байгаль дэлхий бүхлээрээ завхарна гэдгийг ойлгохгүй байна уу? Тэгээд хамгийн гол нь хүн төрөлхтнийг авран сэргээхийн тулд Би Өөрийнхөө ганц Хүүг аймшигтайгаар үхүүлэхээр дэлхий рүү илгээх ёстой болно!” хэмээн том дуугаар зандрах байсан бус уу?

Бурхан газар дэлхийг хүн төрөлхтөнд гэрээслэсэн учраас л Адамыг зогсоогоогүй юм. Бидний хайрын Бүтээгч Бурхан маань эрх мэдлийг өгчихөөд, хүссэнээр нь хэрэглэхгүй байвал, буцаагаад авчихдаг нэгэн биш юм. Бурхан ямар нэг зүйлийг өгсөн л бол, бүр мөсөн өгдөг. Үүнийгээ ч батлан хэлсэн: “Учир нь Бурханы бэлгүүд ба дуудлага нь буцалтгүй ажээ” (Ром 11: 29).

“Гэхдээ Бурхан “Газар хийгээд түүнийг дүүргэдэг бүхэн, дэлхий хийгээд түүнд оршигч бүгд ЭЗЭНийх юм” (Дуулал 24:1) гэдэг шүү дээ” гэж хэлэх хүн гарах байх. Үүнд би гэр

бүлдээ тохиолдсон нэгэн үйл явдлаар жишээлэн хариулья.

Бурхан ямар нэг зүйлийг өгсөн л бол, бүр мөсөн өгдөг.

Лизагийн маань дал гарсан ээж Ширли сүүлийн хэдэн жил биднээс хол, Флорида дахь байшиндаа ганцаараа амьдарсан тул Лиза бид хоёр ээжийгээ ойр байлгахыг хүсч байлаа. Тэгээд Лиза маань манайхаас 5 минутын зайтай,

тун аятайхан байшин зарагдаж байхыг олсон юм. Үнэхээр төгс байшин байв! Тиймээс бид хоёр тэр байшинг худалдаж аваад, ээжийгээ тэр байшинд амьдарч бас манай Мессенжер Интернэйшнэл байгууллагад ажиллаач гэж урьтал, ээж маань ч дуртайяа зөвшөөрлөө. Хэдийгээр тэр байшин бидний өмч байсан ч, ээж маань биднээс хамааралгүй гэдгээ мэдрээсэй гэсэндээ сар бүр нэр төдий түрээс авахаар тогтов. Ээж маань тэр байшинд олон жил амьдарч, амьдралынхаа тал бүр дээр цэцэглэсэн юм.

Тэр бүх хугацаанд хэдийгээр би сууцны эзэн хэвээрээ байсан боловч, орон байраа яаж тавилгажуулж, тохижуулахыг, гэр орондоо хэрхэн байх, яаж аж төрөхийг ээждээ нэг ч заагаагүй юм. Өглөө, өдөр, орой юу зооглох, ямар цахилгаан

бараагаар тоноглохыг ч ээжийнхээ мэдэлд үлдээв. Ээж маань ар гэрийнхээ ажлыг өдөр бүр өөрийнхөө дураар л зохицуулна. Тэр байшингийн албан ёсны эзэн нь би мөн. Гэхдээ би хадам ээждээ түрээслэсэн учраас хадам ээж маань тэр сууцны бүх хэргийг толгой мэдэн шийддэг байв. Ээж маань хүссэн үедээ надаас тусламж гуйж болно. Гэхдээ тэрбээр өөрөө л хүсэхгүй бол, би дур мэдэн оролцохгүй.

Яг үүнтэй адил газар дэлхий бол Эзэнийх. Тэр Эзэн нь мөн. Гэхдээ Эзэн маань газар дэлхийг хүн төрөлхтөнд түрээслэжээ. Эзэн маань биднийг бүтээгээд, газар дэлхий гэдэг “гэрийг” өгөхдөө, юу гэж айлдсныг үзнэ үү:

Бурхан тэднийг ерөөж — Үржиж, олширцгоог! Газар дэлхийг дүүргэж, түүнийг эзэмшицгээг! Далайн загас, огторгуйн шувууд хийгээд газар дээр хөлхөгч амьтан бүхнийг захирцгааг! гэв. (Эхлэл 1:27-28)

Бурхан Өөрийнхөө өргөө гэрийг бидний мэдэлд шилжүүлжээ. Тиймээс энэ дэлхийн эрх мэдэл, захиргаа нь өдгөө Бурханы мутарт биш, та бидний гарт байна.

ШИНЭ ЭЗЭН

Гэтэл Диавол могойн биеэр ирээд, Адам Ева хоёрыг мэхлэж, Бурханы Үгээс гаргаж, том асуудал дэгдээв. Хүн Диаволын үгэнд орохдоо, Сатан гэдэг шинэ эзний гарт шилжиж очсон юм. Сатаны мэдэлд хүн төдийгүй, хүний мэдэл дор байсан бүх юм очжээ. Ийнхүү байгаль дэлхий ч, хүн төрөлхтний удам угсаа ч бүхлээрээ ёрын нэгний гарт оржээ.

Энэ шилжилт нь хожим Есүс Сатан хоёрын дунд өрнөсөн яриаг тайлбарладаг. Диавол Есүсийг өндөр уулан дээр аваачаад, дэлхийн хаанчлалуудыг үзүүлээд: “Энэ бүх эзэмшил болон эдгээрийн сүр хүчийг (үлэмж гайхамшиг, онцсайн, эрхэм дээд чанар, эрхэмсэг хийгээд нигүүлсэнгүй байдлыг нь) би Чамд өгье. Учир нь энэ бүгд надад өгөгдсөн юм. Би хүсвэл хэнд ч үүнийг өгч чадна (Лук 4:6) гэдэг.

Тэгвэл дэлхийн бүх хаанчлал нь хэзээ диаволд “өгөгдсөн бэ?” Хэдэн мянган жилийн тэртээ Адам Бурханаас өгөгдсөн газар дэлхийг захирах эрх мэдлээ хөсөрдүүлэх үед диаволд өгөгджээ. Хүнд гардуулсан Бурханы юмс нь ийнхүү Бурханы мөнхийн дайсны гарт оржээ. Тиймээс Бичээс: “Бид Бурханых, харин бүх ертөнц нь ёрын нэгэн дор байдгийг мэднэ” (1Иохан 5:19) гэдэг.

БУЦААЖ АВАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гэтэл Бурхан Адамын хөсөрдүүлсэн бүхнийг хүн төрөлхтөнд эргүүлж өгөхийг хүсчээ. Гэхдээ Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр бууж ирээд, буцаагаад авчихаж болохгүй байв. Бурхан бүгдийг хэдийнээ Адамд хүлээлгээд өгчихсөн учраас Адам эрх үүргээ хөсөрдүүлсэн байсан ч, Бурхан хөндлөнгөөс нь булаагаад авчихаж болохгүй байсан. Энэ эрх үүргийг хүн л алдсан учраас Хүн л буцааж авах ёстой байв. Тиймээс л Есүс “Хүний Хүү” болж ирсэн юм. Есүс эмэгтэй хүнээс төрсөн учраас 100 хувь хүн, Түүний Аав нь Ариун Сүнс байсан учраас 100 хувь Бурхан байв (Тиймээс Есүс нүглийн хараалаас эрх чөлөөтэй байсан). Гэвч Есүс “...харин Өөрийгөө юу ч үгүй болгон, боолын дүрийг авч, хүнтэй адил болжээ” (Филиппой 2:7). Есүс Бурхан байсан ч, Бурханы дүр төрхөө тайлан, хүн болон газар дээр иржээ.

Есүс Аавынхаа үгээс нэг ч гараагүй юм. Есүс загалмайг даван туулах цагаан хүсэл, сэтгэлээрээ л Адамын хөсөрдүүлсэн бүхнийг цусаараа төлөн байж буцааж авсан юм. Колоссай 2:15 дээр Бичээс “Захирагчид болоод эрх баригчдыг зэвсэггүй болгоод, Тэр тэднийг загалмай дээр ялж, тэднийг нийтэд үзүүлэн болгов” гэдэг. Ийнхүү Адамын хөсөрдүүлсэн эрх мэдлийг Есүс ганцаараа эзэмших болжээ. Тиймээс л Есүс: “Тэнгэр газар дээрх бүх эрх мэдэл (захирах бүх эрх мэдэл) Надад өгөгдсөн (Матай 28:18) хэмээн шууд айлдсан юм.

Нэг л өдөр Есүс эргэж ирээд, байгаль дэлхий Адамыг нүгэл үйлдэхээс өмнө Еден цэцэрлэгт ямар байсан - яг тэр хэвэнд нь буцааж сэргээнэ. Ром 8:20-21 дээр Элч Паул:

“Учир нь бүтээл өөрийнхөө хүслээр бус, харин өөрийг нь захирсан Түүний улмаас хоосонд захирагдсан боловч, найдвар дор бүтээл өөрөө ч мөн ялзралын боолчлолоос чөлөөлөгдөж, Бурханы хүүхдүүдийн алдрын эрх чөлөөнд очих юм.”

Байгаль дэлхий одоо ч дорой хэвээрээ байна: хүний бие доройтож үхдэг хэвээрээ, биет ертөнц ялзардаг хэвээрээ, араатнууд сул дорой нэгнээ авладаг зэрлэг хэвээрээ, могой хорт хэлээрээ хатгаж алдаг хэвээрээ, тахал өвчин дэгддэг хэвээрээ, хар шуурга, хуй салхи залгиж сүйтгэдэг хэвээрээ л байна. Гэхдээ эдгээрийн дээр бүхнийг өөрчлөгч Нэгэн буюу Христ оршино.

ХРИСТ ГЭЖ ХЭН БЭ?

Тэгэхээр “Христ гэж хэн бэ?” гэсэн асуудал тавигдана. Яг энэ асуулт дээр хуучин оюун санаа маань Бурханы хүүхдүүд биднийг дөнгөж орхидог. Христ гэхээр хүмүүс зөвхөн Христ гэдэг овогтой Есүс гэдэг хүний талаар л боддог. Тэдгээр гэнэн цагаан хүмүүс загалмай дээр үхэж, үхлээс амилсан Аугаа Их Хааныг л санадаг. Тийм ээ, Христ гэдэг нэр нь яахын аргагүй бидний Эзэн, Аврагчийн нэр. Гэхдээ Бурханы Үг юу гэж айлддагийг харах уу?

1Коринт 12:27 дээр Паул “Эдүгээ та нар Христийн бие бөгөөд тус тусдаа эрхтнүүд нь юм” гэжээ. Итгэгчид бид нийлээд Христийн бие ажээ. Бид тус бүртээ Христийн биеийн “амин эрхтнүүд” юм. Есүс толгой нь, бид бие нь - ийм л энгийн аж!

Танд толгойноос гадна булчин, шуутай хоёр гар, гуя, өвдөг, булчинтай хоёр хөл, цээж, гэдэс, элэг, хоёр бөөр тэргүүтэй олон эд эрхтэн бий. Та өөрийнхөө талаар бодохдоо, дан ганц толгойгоо юмуу эсвэл дан ганц биеэ боддог уу? Та толгойгоо нэг нэрээр, биеэ өөр нэрээр дууддаг уу? Мэдээж үгүй. Та бол цулдаа нэг л хүн. Та миний толгойг хараад, Жон Бивэр байна л гэнэ. Толгой маань халхлагдчихсан, бие маань дангаараа харагдаж байсан ч, та намайг Жон Бивэр л гэнэ. Миний толгой, бие хоёр нийлээд Жон Бивэр гэдэг нэг хүн болдог.

Яг үүнтэй адилхан Христийн толгой хийгээд бие нь нэг юм. Есүс бол бидний толгой, харин бид Түүний биеийн эд эрхтнүүд юм. Тиймээс та Шинэ гэрээнд Христ гэдэг үгийг уншихдаа, зөвхөн загалмай дээр үхсэн Есүсийг биш, өөрийгөө бас харах хэрэгтэй. Тиймээс л Еврей 2:11 дээр Бичээс “Учир нь Ариусгагч болон ариусгагдсан бүгд нэг гаралтай юм” гэдэг. Есүс Өөрөө “Би зөвхөн тэдний төлөө бус, тэдний үгээр дамжуулан Надад итгэх хүмүүсийн төлөө мөн гуйж байна. Энэ нь Эцэг Та Миний дотор, Би Таны дотор байгаатай адил, тэд бүгд нэг байхын тулд бөгөөд мөн тэд Бидний дотор байж, Та Намайг илгээсэн гэдэгт ертөнцийг итгүүлэхийн тулд билээ” (Иохан 17:20-21) гэжээ.

Та Есүстэй нэг болсон. Яг бодитоор нэг болсон!

Би бичээсээс ганц, хоёр ишлэл тасдаж аваад, ийм юм яриагүй гэдгээ батлах үүднээс дахин хэд хэдэн ишлэлээр энэ гайхамшигтай зарчмыг танд батлан ойлгуулмаар байна. Дараах хэдэн ишлэлийг анхааралтай уншаад, урьд нь хэзээ ч уншиж, сонсож байгаагүй мэтээр тунгаан бодно уу:

- Петр биднийг “Түүний тэнгэрлэг мөн чанарыг хуваалцагч” болохын тулд Бурханы Үгээр төрсөн (1Петр 1:23; 2Петр1:4) гэжээ. Мөн чанар гэдгийг “хүний төрөлх чанар юмуу амин чанар; зан чанар” хэмээн тодорхойлж болно. Та бид хоёр яг Есүсийнхтэй ижил амин чанартай. Тухайлбал миний толгой гар хоёр саланги биш, холбоотой учраас толгойд минь байгаа генийн бүтэц гарт минь ч байдаг.
- Элч Иохан “Түүний дүүрнээс нь бид бүгдээрээ нигүүлсэл дээрээ нигүүлслийг хүлээн авсан” (Иохан 1:16) гэжээ. Дүүрэн гэдэг үгийг дуулав уу? Иоханы үгийг Петрийнхтэй нэгтгэвэл, бид Христийн амин чанарыг буюу сүнслэг генийн бүтцийг дүүрнээр хүлээж авснаа мэдэж болно.
- Хожим эхний захидалдаа Иохан “Учир нь бид энэ ертөнцөд Түүн шиг (Есүс шиг) байдаг (1Иохан 4:17) гэжээ. Иохан энд дараагийн амьдралын талаар яриагүй. Иохан одоо цаг дээр бичсэн байна: Христ энэ ертөнцөд

ямар байна - бид яг л тийм байна. Бид яг өнөөдөр одоо Есүстэй адилхан байна!

- Паул “Биес чинь Христийн эрхтнүүд гэдгийг та нар мэдэхгүй юу? (1Коринт 6:15) гэж асуужээ. Тэрбээр энэ үгээ маш мэдээжийн юмны талаар ярих мэт хэлжээ. Тэгвэл та ч бас энэ мэдээжийн үнэнийг орхигдуулаагүй биз? Чуулган бид энэ үгд үнэхээр итгэдэг үү?”

ХРИСТИЙН ЭРХ МЭДЭЛ

Тэгэхээр бид Христ гэдэг нэрэнд багтаж явдгаа мэдлээ. Тэгвэл Христийн бие болсон бид Христийн дотор бидэнд олгогдсон эрхийн дагуу хэр зэрэг эрх мэдэл, хүч эдлэх вэ? Ефес 1:19 дээр Паул Христийн дагалдагч бүр “Түүний үлэмж аугаа байдлаас хол давсан, хэмжээлшгүй, хязгааргүй хүчийг” ойлгож ухаарахын төлөө үнэн голоосоо залбирсан байдаг.

Ямар аймаар дүрслэл вэ! Ямар том хэмжүүр вэ! Сүр жавхлант Эзэн маань хэмжээлшгүй, энгүй хүчтэй гэдэгтэй та санал нийлэх үү? Түүний хүч нь ертөнц дээрх ямар ч аугаа хэмжээс, эрх мэдлээс хол тасархай гэдгийг үг дуугүй батлах уу?

Тэгвэл та өөрийнхөө талаар ингэж хэлж чадах уу? Эсвэл бүр өөрийгөө ийм хүчтэй гэдэгт итгэх үү? Чадахгүй байгаа бол, та санаандгүйгээр өөрийгөө Христээс таслачихжээ. Та өөр биеийн эрхтэн үү? Та Христийн тасархай, Түүний биеийн эд эрхтэн биш гэж үү? Та “Энэ Жон Бивэр арай л дэндэж байна!” гэж хэлж магадгүй. Тийм гэж үү? Тэгвэл би танд дэндээгүй гэдгээ батлахын тулд дээрх ишлэлийг бүтнээр нь уншиж өгье: “Итгэдэг бидний доторх хийгээд бидний төлөөх Түүний үлэмж аугаа байдлаас хол давсан, хэмжээлшгүй, хязгааргүй хүчийг...” (Ефес 1:19) гэсэн байна.

Паул бидний тухай л ярьж байна. Яагаад? Яагаад гэвэл Есүс Христэд итгэдэг хүнийхээ хувьд та бид Христийн тасархай юм. Тиймээс Христэд байдаг яг тэр хүч танд ч бий! “Христ энэ ертөнцөд ямар байна - бид яг л тийм байна.” Үүнийг зүрхээрээ хүлээн авч чадах уу?

Ефес дээрх Паулын залбирлыг үргэлжлүүлэн үзье:

“... Энэ нь Түүний хүч чадлынх нь хүчний үйлдэл билээ. Тэрээр Христ дотор энэ л хүчээр нөлөөлж, Түүнийг үхэгсдээс амилуулаад тэнгэрлэг оршихуйд баруун гартаа залж... (Ефес 1:19-20)

Эзэн Есүс Христ маань загалмайд цовдлогдож, үхэж, оршуулагдан, үхлээс амилаад, өдгөө дээдийн дээд эрх мэдлийн сэнтийд залран суугаа гэдэгт та итгэдэг үү? Хэрэв та жинхэнэ Христэд итгэгч мөн л бол, гарцаагүй итгэнэ. Тэгвэл өөрийнхөө талаар та ингэж итгэдэг үү? Үнэнийг хэлэхэд, ихэнх итгэгчид өөрийгөө ингэж харж зүрхлэдэггүй. Гэтэл Ром 6:3-4 дээр Паул:

“Христ Есүс рүү баптисм хүртсэн бид цөмөөрөө Түүний үхэл уруу баптисм хүртсэн гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тиймд бид үхэл уруу баптисм хүртсэнээрээ Түүнтэй хамт оршуулагдсан учраас Эцэгийн алдраар Христ үхэгсдээс амилуулагдсаны адил, бид мөн шинэ амийн дотор явах юм.”

Энэ хэсэгт усан баптисмын тухай биш, харин бид дахин төрөхдөө Бурханы Сүнсээр Христийн бие рүү булхдаг “булхлын” тухай ярьж байгааг анхаарна уу (1Коринт 12:13). Бид Христийн бие учраас Түүн рүү булхах яг тэр эгшинд бидний түүх өөрчлөгджээ. Түүнтэй үхэж, Түүнтэй оршуулагдаж, Түүнтэй үхлээс амилуулагдаж, өдгөө цоо шинэ бүтээл болсон бид яг Түүн шиг амьдарч байна! Дахин хэлэхэд “Христ энэ ертөнцөд ямар байна - бид яг л тийм байна!” Бид Христийн дотор байна! Бид Христ мөн! Бид Түүний бие! Бид Түүнтэй нэг!

Ефес 1:20 - иос үзбэл, Христийн тасархай болсон бид өдгөө захирагчийн суудалд суугаа ажээ. Үнэндээ тэр нь Бурхан Аавын сэнтийн дор орших ертөнцийн хамгийн дээд суудал юм. Матай 28:18 дээр Есүс “... Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн” хэмээн айлджээ. Паул цааш нь Ефес 1:21 дээр:

“...бүх засаглал, эрх мэдэл, хүч, ноёрхол түүнчлэн энэ

үед төдийгүй ирэх үед нэрлэгдэх аливаа нэрээс ч дээгүүр болгожээ.”

Есүс энэ дэлхий, ертөнц дээрх бүх захиргаа, эрх мэдэл, хүчний дээр залардаг гэдэгт та итгэдэг үү? Христэд итгэдэг хүнийхээ хувьд мэдээж итгэж байгаа. Тэгвэл би танаас: “Харин өөрийнхөө тухайд ингэж итгэж байна уу?” гэж асууя. Та бараг л итгэхгүй биз. Итгэхгүй байгаа бол, та дахиад л итгэлээрээ юмуу сэтгэлгээгээрээ өөрийгөө Христээс таслачихжээ. Та өөр биеийн хэсэг үү? Үгүй, та бол Христийн биеийн хэсэг! Бид бүгдээрээ Христийн биеийн хэсэг! Бид бол Христ! Бид Түүний бие! Паул үүнийг хэрхэн батласныг анхааралтай сонсоно уу:

Бурхан бүх юмсыг Түүний хөл дор захируулж, Түүнийг чуулганд бүх юмсын дээрх Тэргүүн болгож өгөв. Чуулган нь Түүний бие тухайлбал бүхний дотор бүгдийг Дүүргэгчийн дүүрэл болой. (Ефес 1:22-23)

Бид бол Есүс Христтэй төгс нэгдсэн, Түүний бүрэн дүүрэн байдал, Түүний бие мөн. Бүх юмс Түүний хөл дор тавигдсан гэж Паул хэлжээ. Тэгэхээр та бүр Христийн биеийн хөлийн хуруу байсан ч, энэ дэлхий доторх болоод дэлхийн доорх бүх захиргаа, хүч, ноёрхол танаас яльгүй доор биш, харин хавьгүй доор орших ажээ. Христийн дотор сэргээгдсэн эрх мэдэл чинь Адамын алдсан тэр эрх мэдлээс хавьгүй аугаа болоод танд эргэж иржээ.

■
**Христийн тасархай
болсон бид өдгөө
захирагчийн
суудалд суугаа**
■

Бид энэ үнэнд итгэж ядна гэдгийг Бурхан сайн мэдэж байсан байх. Тиймээс энэ тухай Паулаар дамжуулан Ефес хоёрдугаар бүлэгт ямар ч эргэлзээгүй баттай үг өгчээ. Бид нэг зүйлийг санах хэрэгтэй. Ефес ном нь анхандаа нэг л үргэлж бодлын хөврөл бүхий захидал байсан. Энэ бүх бүлэг, шүлгийн зүйчлэл нь бүр хожим хийгдсэн ажил юм.

Тэгэхээр Бурхан Есүс дотор биднийг Түүгээр амилуулж,
Түүнтэй хамт тэнгэрлэг оршихуйд суулгасан (Ефес 2:6).

Толгой, бие хоёр саланги явдаггүй. Бид бүгдээрээ тэнгэрлэг давхарга доторх захиргаа, эрх мэдэл, хүчний суудалд сууж байна. Өөрөөр хэлбэл бид энэ дэлхийн ямар ч хүчнээс дээр орших давхаргад байна - үнэндээ бол бүр хол дээр байна!

Бидний дээр ямар ч буг чөтгөр, нүгэлт тэнгэрэлч, тэр бүү хэл Сатан өөрөө ч эрх мэдэл, хүчгүй. Христ доторх байр суурь, эрх мэдлийнхээ ачаар бид төгс захирдаг!

Халлелүяа!

АМЬДРАЛД ЗАХИРАХ

Тэгэхээр сая сурсан зүйлээрээ дамжуулан бүлгийнхээ эхэнд тэмдэглэсэн бичээсийн ишлэлийг эргэж харъя.

Ганц хүний алдаа зөрчлөөс болж ганц хүнээр дамжин үхэл нь ноёрхсон юм бол, тэгэх тусмаа нигүүлслийн баялгийг болон зөвт байдлын бэлгийн дүүрэн хүртэгсэд нь Есүс Христ гэгч ганц Хүнээр дамжин амь дор ноёрхоно (Ром 5:17).

“Христ гэдэг ганц Хүнээр дамжин амь дор ноёрхоно” гэдэг үгийг дахин харна уу. Христийн биеийн эрхтнүүд бид алив саад тотгорыг үл харгалзан, амьдрал, бурханлаг мөн чанарын төлөө захирах эрхтэй болжээ. Бидэнд энэ газар дэлхийг захирах эрх мэдэл өгөгдсөн. Тиймээс хэрэв юмс болж бүтэхгүй, буруугаар эргэж байгаа бол, бид л эрх мэдлээ хэрэгжүүлж чадахгүй, хөсөрдүүлснээс болж байгаа юм.

Олон жилийн өмнө намайг номлолын үйлчлэлд хөл тавихад, пастор маань намайг чуулганы үй олон гишүүдийн өмнө тайзан дээр гаргаж байгаад энэ тухай минь зарлаж билээ. Гэтэл хэд хоногийн дараа нэгэн ахмад үйлчлэгч манай гэргийд: “Лиза, Бурхан танай нөхөрт нэг үг хэллээ” гэжээ.

Лиза бид хоёр ч сурч мэдэж, өсөхийн төлөө ангаж цангасан залуус байв (бид одоо ч тэр л хэвээрээ байгаа). Тэгээд Лиза: “Хэлээч ах минь? Би Жонд дамжуулж хэлье” гэжээ.

Тэгтэл тэр ахмад үйлчлэгч: “Хэрэв Жон Бурханаас олгогдсон эрх мэдэл дотроо алхахгүй бол, тэр эрх мэдлийг нь өөр хүн булааж аваад, түүний эсрэг ашиглана гэж Жонд хэлээрэй” гэсэн ажээ.

Лизагийн дамжуулсан энэ үг миний зүрхийг яг л гэрэлт илд шиг сүлбэв. Тэгээд энэ үг нь зөвхөн миний хувьд биш, Христ доторх хүн бүрийн хувьд хичнээн үнэн болохыг өдий хүртэл гэрчлэн харсаар байна. Бурханд үнэн голоосоо хайртай хүмүүс сөрөг хүч, нөхцөл байдалд захирагдан дарлуулсаар байгааг харах үнэхээр эмгэнэлтэй. Эзэн Есүс маань тэднийг чөлөөлөх гэж аймшигтай төлөөс төлчихөөд байхад, тэд хүлээстэй хэвээрээ л явдаг. Энэ амьдралд хаад хатад мэт захирах ёстой боловч, өөрийгөө Христ дотор хэн болохыг мэддэг ч үгүй, тоодог ч үгүй тэдгээр гэнэн хүмүүс цаг агаар, байгалийн гамшиг, өвчин, эмгэг, чөтгөрийн ажил, сөрөг нөхцөл байдал гэхчилэн үй түмэн муу ёрын хүчинд захирагдсаар, дарлуулсаар явна.

Гэхдээ хэрэв та захирах биш, захирагдаж яваа бол, танд нэг сайхан мэдээ дуулгая. Хэрэв та саяын бүлэгт заасан Бурханы Үгийг зүрхэндээ хүлээж авбал, амьдрал чинь өөрчлөгдөнө. Одоо та өөрт байгаа эрх мэдэл, хүчээ мэдэж авсан болохоор, энэ талаар юу ч мэдэхгүйгээсээ болж хаанчлал дотор гачигдан зүдэрч яваа хүмүүст туслаж, сайн сайхан амьдралыг түгээх мэдэлтэй боллоо.

Элч Иохан Христийн биеийн эрхтнүүд болсон бидэнд “Түүний дотор оршдог гэж яригч нь Түүний явсанчлан өөрөө бас тийн явах учиртай” (1Иохан 2:6) хэмээн хатуу хэлжээ.

Иохан 20:21 дээр Есүс “Амар амгалан та нарт байх болтугай. Эцэг Намайг илгээсний адил Би бас та нарыг илгээнэ” хэмээн айлдахдаа, үүнийг бататгасан юм. Есүс биднийг Өөр шиг нь захираасай гэж хүсдэг. Далайн шуурга Есүсийн болон дагалдагч нарынх нь аминд заналхийлэх үед Есүс салхинд болон тэнгист тушаахад, тэдгээр нь Есүсийн үгэнд орсон байдаг. Цөлд өлсөж цангасан үй олон хүнд хоол хэрэгтэй болох үед Есүс байгаа жаахан хүнсийг үржүүлэн, хэдэн мянган хүнийг цадтал хооллоход, цаана нь анх байснаас нь ч их хүнс үлдсэн байдаг. Завь байгаагүй тул Есүс шууд нуурын усан дээгүүр алхсан

байдаг. Хуримын дарс дуусахад, Есүс усыг дарс болгосон. Есүс инжрийн модыг тушаал үгээрээ хатааж, үхүүлсэн. Есүс чихээ цавчуулсан зарцыг буцааж чихтэй болгосон. Есүс өвчтэй хүмүүсийг эрүүл саруул, сохрыг хараатай, дүлийг сонсголтой, хөлгүйг хөлтэй болгосон. Амьдралд захирагч Есүсийн хувьд газрын иймэрхүү бэрхшээл нь юу ч биш байв.

Чөтгөрийн зарц нар Есүсийг сүрдүүлээгүй. Есүс тэдэнтэй нүүр тулах бүрийдээ, эсэргүү амыг нь Үгээрээ тагладаг байсан. Муу ёрын захирагч нар Есүсийг барьж дөнгөөгүй. Хилэгнэсэн хүмүүс Есүсийг хадан хавцал руу түлхэж чадаагүй - Есүс тэдний дундаас зүгээр л гараад явчихсан. Чөтгөр шүглэсэн хүмүүс Есүсийг айлгаагүй - Есүс тэднийг зүгээр л чөлөөлсөн. Ингээд л яриад байвал яриад л байна. Иохан Есүсийн амьдралын талаарх яриагаа өндөрлөхдөө “Мөн энэ номд бичээгүй өөр олон тэмдгийг Есүс шавь нарынхаа өмнө үйлдсэн юм. ... Есүсийн үйлдсэн бас өөр олон үйлс бий. Хэрэв тэдгээрийг нь нэгбүрчлэн бичсэн бол бичигдсэн номуудыг нь энэ ертөнц ч багтаахгүй байхсан гэж би боддог” хэмээн дүгнэн хэлсэн юм (Иохан 20:30; 21:25).

Есүс энэ амьдралд захирсан. Есүс эсэргүүцэл, дайсагналыг захирсан. Есүс газар дээр тэнгэрийг буулгасан. Есүс бидэнд жишиг тогтоож өгсөн. Тэгээд үүнээсээ ч илүүг биднээс хүсэн хүлээдэг: “Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Надад итгэдэг нь Миний хийдэг үйлсийг бас хийх бөгөөд эдгээрээс агуу ажлуудыг ч хийх болно...” (Иохан 14:12).

Энэ үгээс дараагийн асуулт ургана. Тэгвэл бид амьдралд хэрхэн захирах болж байна? Энэ их хүч хаанаас ирдэг вэ?

ХҮЧНИЙ ҮҮСГҮҮР

... нигүүлслийн баялгийг болон зөвт байдлын бэлгийн дүүрэн хүртэгсэд нь Есүс Христ гэгч ганц Хүнээр дамжин амь дор ноёрхоно.

Ром 5:17

Тэгэхээр бид энэ амьдралд хаад хатад шиг захирахаар төржээ. Бид дэлхийн амьдралд захирагдах биш, захирах ёстой.

Тэгвэл үүнээс “Надад үүнийг хийх хүч, чадвар нь байгаа юу?” гэсэн асуулт ургана.

Тэгэхээр чивава нохой, хүрэн баавгай хоёрыг харьцуулж үзье.

Чивава бол мятрашгүйгээрээ алдартай, адтай, бяцхан нохой. Ийм ааштай чиваатай таарч явсан уу? Дургүйг нь хүргэчихбэл хуцаж хоргоогоод сална гэж үгүй. Бүр шагайнаас хазаад ч авч мэднэ. Хөлөөрөө зөөлхөн түлхсэн ч, таныг дийлэх гэж мятрашгүйгээр дайрна. Гэхдээ энэ нохойг далд оруулахыг хүсбэл томоохон шиг дуугараад, хүчтэйхэн шиг өшиглөхөд л болно. Чивава нугадас хийн цохиж, айсандаа ичгүүртэйгээр зугтаж одно. Яагаад? Энэ жаахан нохойнд том хүнийг ялах хүч байхгүй.

Харин нөгөөтэйгүүр нас биед хүрсэн ойн хүрэн баавгайд

дайруулсан хүн иж бүрэн зэвсэггүй л бол, дуусаа гэсэн үг. Баавгай таныг ганц базаад л дуусгана.

Биднийг амьдралаа сайн сайхан дуусгаасай гэж хүсдэггүй хүчнүүд байдаг. Бид тэдгээртэй тулалдахдаа, ялна гэдгээ яаж мэдэх вэ? Бид тэдгээртэй чивава шиг нүүр тулдаг уу, хүрэн баавгай шиг нүүр тулдаг уу? Бид захирах хүчээ хаанаас авдаг вэ?

Үүнд мөн л Ром 5:17 хариулна. Бид Бурханы “нигүүлслийн баялгийн” ачаар л захирах чадвартай байдаг.

ТОМ ТАСАРХАЙ

Гэхдээ “нигүүлслийн баялаг” гэдэг яг энэ сэдэв дээр Америкийн Евангелийн Христэд итгэгчдийн дунд маш том тасархай үүсдэг.

2009 онд манай үйлчлэл Америк даяарх янз бүрийн урсгал чиглэл, бие даасан чуулгануудын дахин төрсөн, Библид итгэдэг, Бүтэн сайнд цуглаанд явдаг Христийн дагалдагч нарын дунд нэгэн судалгаа явуулж, “Бурханы нигүүлслийг гурав буюу түүнээс олон янзаар тодорхойлох юмуу дүрслэн хэлэхийг” хүссэн юм. Гэтэл хүмүүсийн дийлэнх олон нь Бурханы нигүүлслийг 1) Аврал, 2) Үнэ төлбөргүй өгөгдсөн бэлэг, 3) Нүглийн уучлал гэсэн байв.

Америкийн Христэд итгэгчид өөрсдийгөө нигүүлслээр бөгөөд зөвхөн нигүүлслээр аврагдснаа мэддэгт нь би баярлаад барахгүй. Аврал нь ус цацсанаар, цуглаанд явснаар, шашны хуулийг сахин биелүүлснээр юмуу нүглээ цайруулах гэж буян хийснээр ирэхгүй. Ефес 2:8-9 дээр “Нигүүлслийн учир итгэлээрээ аврагдсан нь та нараас бус, харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр чинь биш тул хэн ч үл сайрхах болно” хэмээн маш тодорхой хэлдэг. Евангелийн Христэд итгэгчид нь Бурханы нигүүлслийг буян гавьяагаар олж авах бус, харин Калвари толгод дээрх Есүс Христийн авралын ажилд итгэх итгэлээр л хүлээж авна гэдэг хөдлөшгүй мэдлэг дээр бат суурилсныг мэдэх нь сэтгэл уужрам сайхан мэдээ байлаа.

Гэнэн цайлган хүмүүс Бурханы тааллыг олох гэж хичээж байгааг харах нь үнэхээрийн эмгэнэл юм. Эрчүүд, эмэгтэйчүүд

өөрийнхөө үйлс, зан байдалд хамаг найдлагаа тавин, өөрийнхөө хүчээр Бурханы өмнө зөв болох гэж зүтгээд бүтэлгүйтсэн үй олон зүрх зүсэм жишээ бий. Нийгэм таныг тэнгэрт тулгал магтдаг байсан ч, хэн ч өөрийгөө айсуу шүүхээс аварч чадахгүй гэдгийг Ефес 2:8-9 дээр тодорхой хэлжээ. Авралыг зөвхөн нигүүлслээр хүлээн авна. Яагаад гэвэл аврал нь Хүүгийнхээ үхэл, амилалтаар дамжуулж бидэнд соёрхсон Бурханы бэлэг юм.

Түүнчлэн Бурханы мөнхийн авралыг итгэлээр хүлээж авсан атлаа яваандаа Бурханы нигүүлслийн цутгалыг ажил үйлсээрээ олж авч чадаад байгаа мэт амьдарч байгаа хүмүүс бас л эмгэнэлтэй. Тэд өөрсдийгөө илүү их залбирах ёстой, илүү их мацаг барих ёстой, илүү их буяны ажил юмуу Христигэлтэй холбоотой ажил үйлс хийх ёстой гэж боддог. Элч Паул Галатын чуулганыг яг энэ алдааных нь төлөө: “Хуулиар зөвтгөгдөхийг оролдож буй та нар Христээс арилан, нигүүлслээс салж унажээ” хэмээн хатуу зэмлэсэн байдаг (Галат 5:4). Өнөөдөр яг ийм урхинд олон сайхан итгэгчид орж байгаа нь нэн харамсалтай.

Мөн манай судалгаагаар Америк итгэгчид Бурханы нигүүлслээр нүглээ уучлуулснаа мэддэг болох нь харагдсан юм. Энэхүү ер бусын үнэнийг Ефес 1:7 ч батлан хэлдэг: “Түүний нигүүлслийн баялгаар бидэнд Түүний дотор цусных нь золилт, гэм нүглийн маань төлөөх уучлал бий.” Аврал нь бидний нүглийг мөнхөд уучилсан, Бурханы үнэгүй бэлэг юм. Бурхан минь үүнд тань баярлалаа!

Тэгэхээр Америк итгэгчдийн дийлэнх хувь нь Бурханы нигүүлсэл бол үнэ төлбөргүй өгөгдсөн аврал, бэлэг мөн нүглийн уучлал гэдгийг мэддэг ажээ. Сайн мэдээний үйлчлэгч нар ч энэ гурван чухал үнэнийг онцлон түгээхдээ мундаг ажилласан бөгөөд үүнд нь Бурхан ч баяртай байгаа гэдэгт итгэлтэй байна.

Гэхдээ манай судалгаа нэгэн эмгэнэлтэй үнэнийг бас олж илрүүлсэн юм. Судалгаанд оролцсон хүмүүсийн хоёрхон хувь нь л “Нигүүлсэл бол Бурханы хүч” гэдэгт итгэдэг байв. Гэтэл Бурхан Өөрийнхөө нигүүлслийг яг ингэж тодорхойлсон байдаг:

“Миний нигүүлсэл чамд хангалттай. Учир нь мөхөсдөлд [Миний] хүч бүрэн төгс болдог.” (2Коринт 12:9)

Хэрэв та Есүсийн хэлсэн үгийг улаанаар тэмдэглэсэн Библийг үзбэл, дээрх үгс нь хараар биш, улаанаар бичигдсэн байхыг харж болно. Хэдийгээр энэ үгсийг элч Паул бичсэн боловч, эдгээр нь Паулын үгс биш, харин Эзэний Өөрийнх нь үгс ажээ. Бурхан Өөрийнхөө нигүүлслийг Өөрийнхөө хүч гэжээ. Гэтэл Америк итгэгчдийн ердөө хоёрхон хувь нь буюу нарийндаа бол 1,9 хувь нь л үүнийг мэддэг болохыг манай судалгаа харуулсан юм. Энэ нь 100 итгэгч тутамд 2 ч хүрэхгүй хүн гэсэн үг! Бидний бүхнийг чадагч, Аугаа хүчирхэг Бурхан “Миний нигүүсэл бол Миний хүч” гэж хэлсэн байтал, 100 итгэгч тутамд хоёр ч хүрэхгүй хүн үүнийг мэдэж байдаг. Аймшигтай байгаа биз!

НИГҮҮЛСЭЛ БОЛ ХҮЧ

2Коринт 12:9 дээрх мөхөсдөл гэдэг үг нь “чадваргүй” гэсэн утгатай юм. Тэгэхээр Бурхан “Чи өөрийнхөө чадвараар хийх боломжгүй нөхцөл байдалтай тулах цагт Миний нигүүлсэл (хүч) дээд зэргээр ажиллана” гэжээ. Үүнийг Македонийн итгэгч нарт хандсан Паулын үгээс ч харж болно: “Ах дүү нар аа, Македонийн чуулгануудад өгсөн Бурханы нигүүлслийг та нарт мэдүүлэхийг бид хүсэж байна. ...Учир нь тэд хэр чадлаараа болон хэрээсээ ч илүү, сайн дураараа өгснийг би гэрчилнэ” (2Коринт 8:1,3). Энд мөн л нигүүлслийг Бурханы хүч гэжээ.

Өмнө нь Паул тэдэнд: “Тэгээд ч бид энэ хорвоод, ялангуяа та

■
**Бурханы тааллыг
 олох гэж хичээж
 байгааг харах
 нь үнэхээрийн
 эмгэнэл**
 ■

нарын дунд биеэ авч явахдаа Бурханы ариун чанар хийгээд чин сэтгэл дотор, махбодын мэргэн ухаанаар бус, харин Бурханы нигүүлсэлд (нигүүлслийн хүчинд) байв” (2Коринт 1:12) гэж бичсэн. Энд ч мөн нигүүлслийг Бурханы хүч гэжээ.

Петр ч Бурханы нигүүлслийг яг л ингэж тодорхойлсон. “Бурханыг болон бидний Эзэн Есүсийг мэдсэнээр та нарт нигүүлсэл ба амар амгалан улам арвижиг. Алдар ба давуу чанараараа

биднийг дуудсан Түүний жинхэнэ мэдлэгээр дамжин бурхан хүч (нигүүлсэл) нь бидэнд амь болоод итгэл сүсэгт хамаатай бүхнийг соёрхсон” (2Петр 1:2-3). Энд ч мөн нигүүлслийг “Түүний тэнгэрлэг хүч” гэжээ. Бурханы хүслээр амьдрахад шаардлагатай бүхэн бидний итгэлээрээ хүлээж авсан Бурханы нигүүлслийн хүчээр боломжтой болдог гэдгийг Петр хэлжээ.

Бүгдээрээ үүнийг Грек хэлнээс дэлгэрүүлж үзье. Шинэ гэрээнд нигүүлслийг гол төлөв карис гэдэг Грек үгээр хэлдэг. Энэ үгийг Жэймс Стронгийн алдарт Библийн бүрэн тайлбар тольд “бэлэг”, “ач тус”, “таалал”, “нигүүлсэнгүй”, “чөлөөлөлт” хэмээн тодорхойлжээ. Хэрэв эдгээр анхан шатны тодорхойлолтыг Ром, Галат, Ефес номын тодорхой ишлэлүүдээр зузаалж харбал, дийлэнх Америк итгэгчдийн мэддэг нигүүлслийн талыг харж болно. Гэхдээ Стронг цааш нь улам лавшруулан нигүүлсэл нь “зүрхэнд үзүүлэх тэнгэрлэг нөлөө; үүний амьдрал дээрх тусгал” хэмээн тодорхойлжээ.

Үүнээс зүрхэнд өрнөсөн үйл явцсын гадаад тусгал гэж байдаг бөгөөд энэ нь нигүүлслийн хүчийг тодруулдгийг харж болно. Үйлс 11:23 дээр Барнаб Антиохын чуулганд ирээд “Бурханы нигүүлслийг үзэж баярласан” гэдэг. Барнаб нигүүлслийн талаар сонсоогүй, харин гэрчлэн харжээ. Хүмүүсийн зүрхэн дэхь хүч амьдралаар нь харагдахыг Барнаб үзжээ.

Тиймээс л Иаков “Чи надад итгэлээ (нигүүлслээ) үйлсгүйгээр харуул. Би чамд итгэлээ (нигүүлслээ) үйлсээрээ харууля” гэж хэлж болох юм” (Иаков 2:18) гэжээ. Бид Бурханы нигүүлсэлд итгэлээр хүрдэг учраас л (Ром 5:2-ыг үзнэ үү) би итгэл гэдэг үгийг нигүүлсэл гэдэг үгээр орлууллаа. Иаков “Надад итгэлээр хүлээж авсан нигүүлслийг чинь гэрчлэх хүчээ харуулаач” гэж хэлжээ.

Зондерваны Библийн үгийн нэвтэрхий тольд карис гэдэг үгийн тухайд: “Нигүүлсэл нь биднийг Бурханы өмнө зөвтөд тооцуулахаас хавьгүй ихийг гүйцэлдүүлэгч эрчит хүч юм. Нигүүлсэл нь бидний амьдралд бодитой хэрэгждэг хүч. Нигүүлсэл нь биднийг сул дорой үед хэзээд авч гардаг Бурханы хүчирхэг үйлс мөн” гэжээ.

Нигүүлслийн талаарх Шинэ гэрээний ишлэл бүрийг анхааралтай уншиж, олдсон бүх Грек толь бичгээ олон арван

цаг судлаж, унаган Грек хэлтэй хүмүүсээс асууж лавласныхаа дараа би өөрөө *нигүүлслийг* дараах байдлаар тодорхойлсон юм:

Нигүүлсэл нь бидэнд төрөлх чадвараасаа давж гарах чадварыг өгдөг, Бурханы үнэгүй хүч юм.

ЮУТАЙ ЭМГЭНЭЛ ВЭ?

Америк итгэгчдийн хоёрхон хувь нь л Бурханы нигүүлслийн хүчийг мэдэж байгаа нь юутай эмгэнэл вэ? Үүнийг нэгэн жишээгээр дүрслэе.

Бид судалгааны ажлаар явж байгаад, экваторын бүсээс Африкийн ширэнгэнд амьдардаг нэгэн жижиг омгийг олж илрүүлжээ гэж бодъё. Тэд ундныхаа усыг авахын тулд хамгийн ойрхон булаг руу өдөр бүр гурван км алхана. Тэгээд тэр усаа нуруун дээрээ үүрээд буцаад гурван км алхана.

Ан амьтад нь өөрсдөө хүрч ирээд: “Оройн зоогтоо намайг зоогло” гэж хэлэхгүй учраас, гэдсээ тэжээхийн тулд омгийнхон маань анд гарна. Заримдаа зээр гөрөөс зэрэг том амьтан авлахаараа, түүнийгээ сууриндаа авчрах гэж арван хэдэн км газар үүрч дүүрч явна.

Хэрэгцээт бараагаа авахын тулд хамгийн ойрын тосгон хүртэл 60 км алхаад, юмаа аваад буцаад 60 км алхана.

Энэ зовлонг нь дуулсан бид тэр омгийнхонд бэлэг барихаар шийдэв. Тийм ээ, бид тэднийг таалан соёрхож, нигүүлсэнгүй хандан, чөлөөтэйгээр туслахаар шийднэ (Стронгийн толь бичиг дэхь бүх тодорхойлолт байгаа биз?) Тэгээд бид тэдэнд цоо шинэ Лэнд Ровер авч өгөв.

Бид машинаа захиалаад, Африкийн эрэг рүү усан онгоцоор явуулаад, дараа нь өөрсдийн биеэр сууринд нь хүргэж өгнө. Машинаа суурингийн ойролцоо байршуулаад, омгийнхныг ахлагчтай нь тэр чигээр нь шив шинэхэн Лэнд Ровер дээрээ дагуулж ирнэ. Тэгээд нүүр бардам инээмсэглээд: “Энэ бол та нарт өгч байгаа бидний бэлэг!” гэж зарлана.

Тэгснээ омгийн ахлагчийг жолоочийн хажуугийн суудалд суулгаж байгаад манай нэг хүн баяртайгаар тайлбарлаж

гарна: “Ахлагч аа, энийг гайхамшигт Лэнд Ровер гэдийн! Агаар хөргөгчтэй! Гадаа халуу шатаж байсан ч, хөргүүрээ асаачихбал, сэрүү татаад л явчихна!

Лэнд Ровер маань бас халаагууртай. Гадаа тачигнаж байсан ч, халаагуураа асаачихбал, пөн хийгээд л явчихна!

Тэгээд болоогүй ээ, энэ Лэнд Ровер маань хиймэл дагуулын радиотой. Юу гэсэн үг болохыг мэдэх үү? Энэ нь та машин дотроосоо даян дэлхийн мэдээг цаг алдалгүй сонсоно гэсэн үг.” Тэгээд Английн БиБиСи агентлагийн шууд нэвтрүүлгийг тавьтал, ахлагч мэл гайхав.

“Гэхдээ ахлагч аа, ингээд болоогүй ээ. Бид Лэнд Ровер дотроо DVD тоглуулагч суулгасан байгаа.” Тэгээд нэг DVD аваад, тоглуулагчдаа шургуулан товчийг дартал, ахлагч бүтэн өнгөт дэлгэц дээр гарч байгаа киног үзээд уулга алдав.

“Ахлагч аа, энэ юу ч биш! Энэ Лэнд Роверт бас CD тоглуулагч бий.” Тэгээд магтаалын CD тоглуултал, магтаалын дуу машинаар нэг хангинаж, ахлагч хэлэх үггүй толгой сэгсэрч сууна.

Тэгээд биднийг Лэнд Роверээс буух үед ахлагч: “Энэ сайхан бэлэгний чинь хариуд бид та нарт юу өгөх вэ?” гэв.

“Өө, юу ч өгөх хэрэггүй! Энэ чинь та бүхэнд зориулсан бэлэг учраас юу ч өгөх хэрэггүй. Бид та нарт хайртай учраас л өгч байгаа юм” хэмээн бид итгэл төгс хариулна.

Ахлагч омгийнхонтойгоо бөөн баяр болж, бид ч харих замдаа гарлаа. Тэгтэл хэдэн сарын дараа нөгөө омгийнхон чинь усаа авах гэж алхсан хэвээр, ан гөрөөгөө үүрсэн хэвээр, хэрэгцээт бараагаа авах гэж хамгийн ойрын тосгон руу 60 км алхсан хэвээр гэдгийг дуулав. Яагаад ийм явдал болов? Яагаад гэвэл бид тэдэнд Лэнд Роверийн хамгийн гол үйл ажиллагаа нь тээвэрлэлт гэдгийг хэлэхээ мартжээ. Бид омгийн ахлагчид Лэнд Ровер түүнийг хүссэн газарт нь хүргэж, хүнд ачааг нь тээвэрлэнэ гэдэг хамгийн чухал үүргээс бусдыг нь хэлж өгчээ.

Яг үүнтэй адилхан Бурханы нигүүлсэл бол Бурханы хүч гэдэг хамгийн гол үнэнийг Барууны чуулганы удирдагч нар итгэгч нартаа зааж өгдөггүй ажээ.

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ГЭЖ ЮУ ВЭ?

Та: “Нигүүлслийн хамгийн гол үйл ажиллагаа нь Бурханы хүч гэнэ ээ? Яаж ийм юм ярьж зүрхлэнэ вэ?” гэж хэлж магадгүй.

Саяхан намайг залбирч байтал Эзэн надад бодол болохоос өөр аргагүй нэгэн асуулт тавьсан юм: “Миний хө, Би Шинэ гэрээндээ нигүүлслийг юу гэж танилцуулсан бэ?” Хэдэн арван ном бичсэн хүний минь хувьд энэ асуулт тун чухал байв. Яагаад гэвэл би номдоо ямар нэгэн шинэ ойлголт танилцуулах бүрийдээ эхлээд үндсэн тодорхойлолтыг нь өгөөд, яваандаа илүү дэлгэрүүлэн хоёрдагч, гуравдагч тодорхойлолтыг нь хэлдэг. Гэхдээ мэдээж хамгийн түрүүнд үндсэн тодорхойлолтыг нь хэлж өгнө.

Жишээлбэл хэрэв би Лэнд Роверийн талаар захидал бичих гэж байсан бол ингэж бичнэ:

Ахлагч аа, бид танайд энэ Лэнд Ровер гэдэг цоо шинэ машиныг бэлэглэж байна. Энэ машины үндсэн үйл ажиллагаа нь тээвэрлэлт юм шүү. Одоо танай хүмүүс өдөр бүр нуруун дээрээ хүнд ус үүрч, хэдэн км газар алхаж, махаа идэх хэрэггүй болсон. Омгийн чинь нэг хүн булаг руу машинаараа сүнгэнэж очоод л, усаа аваад, хүнгэнээд хүрээд ирнэ. Одоо танай хүмүүс хүнд ангаа нуруун дээрээ үүрч, хол газрыг туулах хэрэггүй. Зүгээр хэн нэг нь хэрэгтэй газраа давхиж очоод, ангаа унагаж машиндаа чихээд л давхиад ирнэ. Түүнчлэн танай хүмүүс хэрэгцээт бараагаа хамгийн ойрын тосгоноос авах гэж 60 км алхах хэрэггүй. Зүгээр л давхиж очоод, хэрэгцээт бараагаа аваад, машиндаа шидээд л гүйцээ.

Ахлагч ба омгийнхон урьд нь хэзээ ч машин үзээгүй учраас бид нэн түрүүнд Лэнд Роверийн үндсэн үүргийг хэлж өгөх ёстой.

Захидлынхаа хоёрдугаар хэсэгт би тэр сайхан хөргүүр, халаагуурын тухай хэлнэ. Гуравдугаар хэсэгт хиймэл дагуулын радио, дөрөвдүгээр хэсэгт DVD, CD тоглуулагчийн талаар хэлж болох юм. Тэгээд захидлынхаа төгсгөлд энэ машин бол

бэлэг гэдгийг хэлнэ. Гэхдээ машиныхаа үндсэн үйл ажиллагааг заавал хамгийн түрүүнд хэлнэ.

Тэгэхээр надаас “Би Шинэ гэрээндээ нигүүлслийг юу гэж танилцуулсан бэ?” гэж асуусан Эзний асуулт дээр эргээд очъё.

Би ч “Мэдэхгүй!” л гэлээ. Тэгээд компьютерээ нээгээд, Библийнхээ конкордансыг дэлгээд, Бурхан Шинэ гэрээнд нигүүлслээ юу гэж тайлбарласан байдгийг олж мэдэв. Бурхан Иохан 1:16 дээр “Түүний (Есүсийн) дүүрнээс нь бид бүгдээрээ нигүүлсэл дээрээ нигүүлслийг хүлээн авсан” гэсэн байлаа.

Иохан “нигүүлсэл дээрээ нигүүлслийг” гэжээ. Үүнийг Афинд аж төрдөг, Грек хэлний мэргэжилтэн найз маань: “Иохан Бурхан бидэнд “нигүүлслийн дээдийг өгсөн” гэж хэлж байгаа юм” хэмээн тайлбарласан юм. Өөрөөр хэлбэл элч Иохан нигүүлслээс төрдөг бялхал хийгээд баялаг нь бидэнд Есүс Христийн бүрэн дүүрэн байдлыг авчирдаг гэжээ! Дуулав уу? Есүс Христийн Өөрийнх нь бүрэн дүүрэн байдлыг авчирдаг аж! Үүнд Есүс Христийн чадвар, хүч ч багтана.

Би үүнийг танд илүү бат ойлгуулмаар байна. Жишээлбэл, би нэг жирийн л дундаж теннисчин дээр очоод: “Бид чамд хамгийн сүүлийн үеийн шинжлэх ухааны аргаар Рожер Федерерийн бүрэн чадварыг эзэмшүүлж, чамайг түүн шиг тамирчин болгож чадна” гэж хэлжээ. Рожер Федерер бол газрын теннисний үе үеийн шилдэг тамирчдын нэг гэдгийг хэлэх хэрэгтэй байх. Тэгвэл тэр дундаж тамирчин юу гэх бол? Мэдээж: “Тэгье! Болгоод аль! Би яах ёстой вэ?” л гэнэ биз дээ. Тэгээд бид түүнд Рожер Федерерийн бүрэн чадварыг өгчихбөл, юу болох вэ? Тэр тамирчин клубынхаа аварга болж, Америкийн нээлттэй тэмцээнд шалгарч, дараа нь Уимбилдонд ялна.

■

**Бурханы нигүүсэл
бидэнд Есүс
Христийн Өөрийнх
нь бүрэн дүүрэн
байдлыг өгчээ!**

■

Мөн хэрэв би их сургуулийн уран барилгын ангийн шинэхэн оюутан дээр очоод: “Би чамд хамгийн сүүлийн үеийн шинжлэх ухааны аргаар Фрэнк Ллойд Врайтын бүрэн

чадварыг эзэмшүүлж, түүний дайтай уран барилгачин болгож чадна” гэвэл, тэр залуу оюутан яах бол? “Пөөх, одоохон болгоод аль!” гэх биз. Тэгээд болгоод өгмөгц, тэрбээр яах бол? Сургуулиа хаяад, дэлхийн дээд шагналуудыг түүсэн карьер эхлүүлнэ биз дээ.

Эсвэл хэрэв би хөлөө олохгүй яваа бизнесмэн дээр очоод: “Бид таныг хамгийн сүүлийн үеийн шинжлэх ухааны аргаар Биил Гэйтс шиг бизнесмэн болгож чадна” гэвэл, тэр тэвдэж яваа бизнесмэн юу гэх бол? “Тэгье тэгье!” л гэнэ. Тэгээд Биил Гэйтсийн чадвартай хүн чинь юу хийх вэ? Зүүдлэж ч яваагүй шинэ бүтээгдэхүүнээ гаргаж, төсөөлж ч яваагүй бизнесийн хөрөнгө оруулалтын талаар бодож эхэлнэ.

Тэгэхээр нигүүлсэл бидэнд Рожер Федерер, Фрэнк Ллойд Вraith, Биил Гэйтсийн бүрэн дүүрэн байдлыг өгөөгүй. Эдгээр нь Бурханы нигүүлсэлд дэндүү жулдана. Бурханы нигүүлсэл бидэнд Есүс Христийн Өөрийнх нь бүрэн дүүрэн байдлыг өгчээ! Үүнийг ойлгож байна уу? Нигүүлсэл бидэнд ийм л чадвар өгчээ!

Тэгэхээр Бурхан Шинэ гэрээнд нигүүлслээ “үнэ төлбөргүй бэлэг” гэж танилцуулаагүй ажээ. Тийм ээ, нигүүлсэл нь Бурханаас бидэнд үнэ төлбөргүй өгөгдсөн бэлэг мөнөөс мөн бөгөөд би үүнд хязгааргүй талархана. Бурхан бас нигүүлслийг нүглийн уучлал гэж танилцуулаагүй. Гэхдээ мэдээж Бурхан нигүүлслээрээ бидний нүглийг уучилдаг нь үнэн бөгөөд би үүнд ч мөнхөд талархана. Бурхан Шинэ гэрээнд Өөрийнхөө нигүүлслийг Есүс Христийн бүрэн дүүрэн байдлыг өгдөг хүч хэмээн танилцуулжээ.

Өмнөх бүлэгт Петр биднийг “...бурхан (мөн) чанарыг хуваалцагч” (2Петр 1:2-4) гэж хэлсэн. Мөн чанар гэдэг нь хувь хүний амин чанар, зан чанарыг хэлж байгаа юм. Тэгэхээр Бурханы нигүүлсэл бидэнд Есүсийн Өөрийнх нь амин чанар, зан занарын бүрэн дүүрэн байдлыг чөлөөтэй өгдөг ажээ. Тиймээс л Иохан “Учир нь бид энэ ертөнцөд Түүн шиг байдаг” (1Иохан 4:17) гэжээ. Та энэ үгийн хэмжээсийг ойлгож байна уу?

Бид энэ амьдралд ийм аугаа хүч, хүчин чадлаар захирахаар төржээ. Бурханы нигүүлсэл биднийг яг Есүс шиг болгохоор дахин бүтээжээ. Тиймээс бид яг Есүс шиг амьдрах хүчтэй.

Бид жинхэнээсээ Есүсийн дотор байна. Бид бол Түүний бие. Бид бол газар дээрх Христ. Бид бол Христэд итгэгч хүмүүс. Тийм учраас л Иохан тун эрэлхэгээр: “Түүний дотор оршдог гэж яригч нь Түүний явсанчлан өөрөө бас тийн явах учиртай (1Иохан 2:6) хэмээн хатуу хэлжээ.

Энэ үгийг зүрхэндээ шингээ. Бид энэ дэлхий дээр Есүс шиг явах буюу амьдрах учиртай хүмүүс. Энэ бол Библийн зөвлөгөө биш, харин тушаал мөн!

4

ЕСҮС ХЭРХЭН ЯВСАН БЭ?

Түүний дотор оршдог гэж яригч нь
Түүний явсанчлан өөрөө бас тийн явах учиртай.

Иохан 2:6

Бид Есүс шиг явах учиртай юм бол “Есүс хэрхэн явсан юм бэ?” гэдэг асуулт гарч ирнэ. Нэгдүгээрт - Тэр гайхмаар ариун хийгээд бурханлаг явсан. Энэ дэлхийн тачаал Түүнийг эзэмдээгүй; Тэр төрөлх бус, бурханлаг бус хүслийг захирч амьдарсан. Яг үүнтэй адилхан элч Паул бидэнд Бурханы таалалд нийцдэг арга замаар үйлчлэх тухай заажээ:

Хайртууд минь, эдгээр амлалт байгаа тул бид өөрсдийгөө махбодын ба сүнсний бүх л бохирос цэвэрлэе. Ингэхдээ Бурханаас эмээж, ариун чанарыг төгс болгоё. (2Коринт 7:1)

Паул “өөрсдийгөө цэвэрлэе” гэснийг харж байна уу? Тэр “Бурхан та нарыг цэвэрлэнэ” гэж хэлээгүй нь сонин шүү. Цаашаа явахаасаа өмнө нэг зүйлийг тодруулж хэлмээр байна. Есүсийн цус бидний нүглийг угаадаг - энэ бол авралын ач тус. Гэхдээ энд

элч Паул бидний ариуслын талаар ярьж байна. Өөрөөр хэлбэл бидний төлөө хэдийнээ үнэ төлбөргүй хийж өгсөн зүйлийг хэрэгжүүлэх талаар ярьж байна. Товчхондоо энэ нь Христэд итгэдэг хүнээс шаардагддаг зан байдал, үйлдэл юм.

Түүнчлэн дээрх ишлэл дэхь “бүх л” гэдэг үгийг анзаарав уу? Бид өөрийгөө бие, сэтгэлийг маань бузарлагч зарим нэг бохироосоо юмуу дийлэнх бохироосоо биш, харин бүхий л бохироосоо цэвэрлэх ёстой ажээ. Бид бүрэн төгс ариун болох ёстой. Петр ч үүнийг бататгадаг: “Харин та нарыг дуудсан Ариун Нэгэний адил өөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтун” (1Петр 1:15). Хэрэв бид энэ үгийг нөгөө чихээрээ гаргачилгүй (зарим хүн өөрөө ч ингэдэг, бусдад ч ингэж заадаг) нухацтай авч үзбэл, Есүс шиг бурханлаг зан байдлаар амьдарсан хүн л Бурханд таалагдах зан байдлаар үйлчилдгийг мэдэж авна. Үүнийг яаж хийх вэ? Бурханы нигүүлслээр.

Жишээлбэл би ахлах сургуульд байхдаа мундаг нүгэлтэн байлаа. Юу гэсэн үг вэ гэж үү? Би нүгэлт мөн чанартай байсан бөгөөд нүглээ ч мундаг хийдэг байсан гэсэн үг.

Өсвөр насанд байхад минь манай аав охин дүү бид хоёроос хот орж, кино театрт Чарльтон Хестоны тоглосон “Арван тушаал” гэдэг кино үзэх үү гэж асуусан юм. Бидний аж төрдөг гуравхан мянган хүнтэй суурингийн кино театр нь нэгэн зэрэг арван таван кино гаргах хүчин чадалгүй, нэг удаадаа ганц л кино гаргадаг жижиг кино театр байв. Тэр үед юуных нь Xbox (Эксбокс), Wii (Вии) тоглоом, хавтгай дэлгэцтэй зурагт тэргүүтэй медиа хэрэгсэл байхав. Жирийн л жижиг, цүдгэр зурагтаас өөр юм байхгүй. Тиймээс том дэлгэцээр кино үзэх тасалбар бэлгэнд авна гэдэг ёстой л тэнгэрийн хишиг байсан тул би ч уухайн тас зөвшөөрлөө.

Тэгээд бид театрт суугаад киногоо үзэж байтал, Мосег эсэргүүцсэн Датан тэргүүтэй ёрын хүмүүс газарт залгиулдаг үзэгдэл гарав. Тэднийг там шууд амьдаар нь залгичихдаг. Үүнийг аварга том дэлгэцээр үзсэн би гэдэг аугаа нүгэлтэн сүнсээ зайлтал айж, ухаан жолоогүйгээ гэмшиж гарлаа. Өөрийнхөө ёрын муухай, тачаангуй зан үйлдлийг нэгт нэгэнгүй тоочиж, Бурханаас өршөөл эрэн, ээ гэгээн минь ахиж

хэзээ ч үйлдэхгүй хэмээн ам тангараг өргөв. Би тэр киноноос цоо шинэ хүн болоод гарав! Гэтэл энэ шийдвэр маань долоо хоног л наслаж, мань хүн эргээд нүглийнхээ замд оров. Яагаад? Надад гэмшил байснаас, нигүүлсэл байгаагүй юм.

Хэдэн жилийн дараа оюутан болсон хойноо нэгэн хуурай ахаасаа Кампус Крусэйдийн Сүнсний дөрвөн хуулийг сонслоо. Тэр дөрвөн хуулийг уншаад, би Есүс Христийг Аврагч Эзэнээ болгов. Ингэж би Бурханы хүүхэд болов. Гэхдээ яг үнэндээ би Христийг мэддэггүй байхдаа амьдарч байсан тэр л нүгэлт амьдралаараа амьдарсаар байлаа. Надад Библийн мэдлэг, сургаал дутаж байв. Учир нь би эдүгээ ямар хүчтэй болсноо бас л мэдээгүй байлаа.

Хэдэн жил өнгөрөв. Тэгтэл нэгэн удаа миний сайн мэдэх нэгэн бичээс хуудаснаасаа огло үсрээд гараад ирэх нь тэр: "... ариуслыг мөшгөгтүн. Үүнгүйгээр хэн ч Эзэнийг үзэхгүй (Еврей 12:14). Энэ үг миний дээрээс яг л хүнд туухай шиг дарав. "Пөөх, би Бурханыг хармаар байна. Гэтэл Түүнийг харахын тулд ариун амьдрах хэрэгтэй!" гэж бодогдлоо. Харамсалтай нь би энэ үгийг зөвөөр ойлгоогүй учраас хуульчлагч болж хувирлаа. Тэгээд хавь ойрынхоо хүмүүсийг хуулийн зүйл заалтаар жанчдаг болов. Би тэдэнд "ариун амьдар!" гэж тушаах атлаа ариун амьдрах хүчийг нь өгч чаддаггүй байв. Би хүмүүст Бурханы хүчээр биш, харин өөрийнхөө чадвар, сэтгэлийн хатаар ариун амьдрахыг тулган шаардаж, үүнийхээ гайгаар гэргий, найз нөхөд, дотныхоо хүмүүсийг ихэд шархлуулсан юм.

Тэгтэл нэгэн удаа залбирч байтал Эзэн надад: "Хүү минь, ариун байдал бол чиний махан биеийн үйлс биш, Миний нигүүлслийн бүтээгдэхүүн юм" гэж айлдав. "Тийм байна! Би үүнийг л ойлгоогүй байж!" Тэгэхэд л би нигүүлсэл нь миний чадахгүй байсан юмсыг хийх чадвартай болгодог Бурханы оршихуй мөн бөгөөд үүний ачаар л би өөрийнхөө хүчээр хийж чадахгүй байсан юмсаа хийх чадвартай болж, бие, сэтгэлийг маань бохирлогч юмсаас цэвэршиж, бүрэн төгс ариун амьдрах хүчтэй болдгийг ухаарч эхэлсэн юм. Ингэж байж л Бурханд таалагдах арга замаар үйлчилнэ. Тиймээс л Еврей номын зохиогч:

“тааламжит үйлчлэлийг Бурханд өргөх нигүүлсэлтэй байцгаая.” (Еврей 12:28)

Бид нигүүлслийн ачаар л Бурханд таалагдах арга замаар үйлчилдэг. Өөрийнхөө хүчээр өөрийгөө цэвэрлэж чадахгүй байсан юмсаас нигүүлсэл л биднийг цэвэрлэх хүчтэй болгодог.

Өмнө ярьсан судалгаанаас үзбэл, Америк итгэгчдийн бараг 98 хувь нь өөрийнхөө хүчээр ариун амьдрах гэж зүтгэдэг аж! Хоёрхон хувь нь л нигүүлсэл бол Бурханы хүч гэдгийг мэднэ. Харин үлдсэн 98 хувь нь энэ тухай огт мэдэхгүй учраас энэ хүчийг огт ашигладаггүй гэсэн үг. Бид аливаа зүйлийг Бурханаас итгэлээр хүлээн авдаг. Харин мэдэхгүй зүйлдээ хүн итгэж чадахгүй. Паул “Тэгвэл Түүнд итгээгүй тэд яаж Түүнийг дуудах вэ? Түүнийг сонсоогүй тэд яаж Түүнд итгэх вэ? Тэд тунхаглагчидгүйгээр яаж сонсох вэ?” (Ром 10:14) гэсэн байдаг. Бид өөрт байгаа гэж мэддэг зүйлээсээ л ач тус хүртдэг.

Нөгөө Африк омгийнхоны тухай дахин авч үзье. Омгийнхон Лэнд Роверийн үндсэн үйл ажиллагаа нь тээвэрлэлт болохыг мэдээгүй учраас нэг ч жолоодоогүй. Тэд ээлж ээлжээрээ дотор нь суугаад, үсчин дэвхцэж, хөргүүр, халаагуурыг нь асааж, DVD, радио, CD - г нь тоглуулав ч, тэр унааг хөдөлгөх талаар санах ч үгүй.

Би нэг удаа жигтэйхэн гоё зургийн аппарат авбаа. Хайрцгийг нь задлаад, гаргаж ирээд, хуучин аппарат шигээ л хэрэглэв - чиглүүлж байгаад л хүссэн зургаа дарлаа. Үнэндээ шинэ аппарат авсан хүмүүс яг л ингэдэг.

Тэгээд хэдэн жил хэрэглэснийхээ дараа ялгаагүй аппараттай найз маань яаж тийм сайхан шөнийн, уран сайхны, үйл хөдлөлтэй, томруулсан зураг аваад байгааг гайхлаа. Тэгээд асуугаад учрыг нь мэдлээ: миний шинэ аппарат ч бас яг түүнийх шиг хүчин чадалтай ажээ. Би ч аппаратныхаа гарын авлагыг гаргаж ирээд, судлаж эхлэв. Удалгүй хавьгүй сайхан зураг дардаг ч боллоо. Надад юу байгааг мэдээгүй учраас, би үүний ач тусыг хүртэж чадаагүй ажээ.

Тэр золгүй 98 хувь хүмүүс ч ялгаагүй. Тэд нигүүлслийн ачаар юутай болсноо амьдралын гарын авлага болох Библиэс

судлаагүй ажээ. Тэд зүгээр л дийлэнх олны жишиг үйлдэл, сургаалыг даган дууриажээ. Тэд өөрт буй хүчин чадлаа мэдэхгүй учраас тушигджээ.

Бид өөрийнхөө хүчээр ариун юмуу ариусгагдсан амьдралаар амьдрах гэж оролдбол, юу болох бол? Хоёр зүйлийн нэг нь болно: бид нэг бол нэг зүйлийг ярьдаг ч, өөрөө өөрөөр амьдардаг хоёр нүүртэй хуульчлагч нар болно. Эсвэл “нигүүлсэл миний үйлдсэн, үйлдэж буй, үйлдэх бүх нүглийг шийдвэрлэсэн” гэдэг Библийн бус итгэлээр бамбай хийн, дур зоргоороо амьдарна. Тэгээд “Есүс шиг амьдрах” нь сайхан санаа боловч, амьдралгүй зүйл гэж үздэг болно.

Яг ингэж үздэг хэсэг итгэгчид болон багш нар маш солиотой доктрин зохион бүтээжээ. Тэд “Есүс Христийн аврал биднийг Бурханы хүүхдүүд болгодог. Гэхдээ бид хүн учраас нүглээсээ салах боломжгүй. Бид хүн учраас алдаж онож, нүгэл үйлдэлгүй яахав” хэмээх худал шалтгаар тачаангуй зан үйлдлээ хаацалж, өөрийгөө худлаа тайвшруулна.

Гэтэл Шинэ гэрээний сайн мэдээнд ийм юм огт байхгүй. Сайн мэдээ нь “Есүс биднийг нүглийн шийтгэлээс чөлөөлөхийн төлөө үнэ төлөөсийг нь төлөөд зогсохгүй мөн нүглийн хүчнээс чөлөөлөх үнэ төлөөсийг нь төлсөн!” гэдэг. Үүнийг Паул ч тодорхой хэлсэн: “Учир нь та нар хуулийн дор байгаа бус, харин нигүүлслийн дор байгаа тул нүгэл та нарыг захирахгүй” (Ром 6:14). Хууль нь хүмүүст зөвхөн хориг л тавьж чадна. Харин нигүүлсэл нь биднийг өөрийнхөө хүчээр хийж чадахгүй байсан зүйлээс буюу нүглээс эрх чөлөөтэй байх хүчийг өгдөг. Тиймээс л Паул Коринтын итгэгчдийг “Бурхантай хамтран ажиллагч бид та нараас хичээнгүйлэн гуйя. Бурханы нигүүлслийг дэмий хоосноор бүү аваарай” (2Коринт 6:1) хэмээн ятгажээ.

Гэхдээ Паул нигүүлслийг бүү цалгардуулаарай гэж анхааруулахдаа, Барууны дийлэнх чуулганы заадаг “нигүүлслийн” талаар яриагүй юм. Тэд нигүүлслийг ингэж заадаг: “Тийм ээ, би амьдрах ёстой шигээ амьдрахгүй байгаагаа мэднэ. Гэхдээ зүгээр. Яагаад гэвэл би Бурханы нигүүлслээр аврагдаж, уучлуулсан!” Үүгээр барахгүй: “Би өөрийнхөө

үйлсээр биш, Есүсийн үйлс дээр тулгуурлан аврагдсан учраас юу хүссэнээ л хийнэ. Учир нь нигүүлсэл намайг уучилсан” гэж дэмийрдэг. Ингэж ярьж байгаа хүнд бурханлаг амьдрах ямар ч итгэл үнэмшил байхгүй. Ийм нигүүлслийг цалгардуулна гэж байх уу? Байхгүй. Энэ бол Бурханы зорилго ба хүчийг ой гутмаар худлаа танилцуулж байгаа хэрэг юм.

Нигүүлсэл нь биднийг өөрийнхөө хүчээр барахгүй байсан зүйлээ хийх чадвартай болгодог - бие, сэтгэлийг маань бузарлагч бүхнээс өөрийгөө цэвэрлэж, бүрэн төгс цэвэр байх хүчтэй болгодог Бурханы хүчирхэгжүүлэгч оршихуй юм гэдгийг бид ойлгосон цагтаа л энэ нигүүлслийг хэзээ ч цалгардуулж болохгүй гэдгийг ухаарна.

Жишээлбэл арван жилийн дараа бид нөгөө Африк омгийнхноо эргэж очжээ. Тэгээд Лэнд Ровераа гардуулж өгсөн газраа иртэл машин маань яг л тэр газраа яг л тэр янзаараа байж байв. Бүр хог шороонд дарагдаж, өвс ургамалд баригдчихжээ. Хаалгыг нь хөшиж онгойлгоод, эргүүлж тойруулж хартал, заалт нь хүлээлгэж өгсөн яг л тэр хэвэндээ байв. Бид бие бие рүүгээ хараад: “Тэд бидний арван жилийн өмнө өгсөн бэлэгийг огт ашиглалгүй, цалгардуулжээ!” хэмээн дуу алдана.

Тэр омгийнхон бүр Лэнд Роверийн тухай “үнэгүй ирсэн үнэт бэлэг” гэдэг дуу зохиож, энэ тухай өөр хоорондоо ам уралдан ярьсан ч байж болох. Тэд бороо ороход машиндаа хорогдож, төмөр хүлгийнхээ ачаар айх аюулгүй амар жимэр амьдарч байгаагаа бахдан магтаж, үлгэр домог болтол нь ярьсан ч байж болох. Гэвч тэд машинаа унаагүй учраас хайран бэлэгийг дэмий цалгардуулжээ.

Тиймээс л Паул та биднийг Бурханы гайхамшигт нигүүлслийн хамгийн гол ерөөл, ач тусыг яг тэдэн шиг дэмий цалгардуулах вий хэмээн анхааруулжээ:

Бурханы нигүүлслийг дэмий хоосноор бүү аваарай.

Хайртууд минь, эдгээр амлалт байгаа тул бид өөрсдийгөө махбодын ба сүнсний бүх л бохироос цэвэрлэе. Ингэхдээ Бурханаас эмээж, ариун чанарыг төгс болгоё.

(2Коринт 6:1; 7:1)

Үүнээс илүү тодорхой хэлнэ гэж юу байхав? Тэгвэл чуулганууд яагаад “үүнийг юу юунаас илүү онцлож, энэ талаар илүү их заахгүй байна вэ?”

ЕСҮС ХҮН ТӨРӨЛХТНИЙ ХЭРЭГЦЭЭГ ШИЙДСЭН

Иоханы нэгдүгээр захидлаас бид “Есүсийн явсанчлан явах ёстойг” (1Иохан 2:6) сурсан.

Ёстой гэдэг үгийг анхаарна уу. Үүнээс бид уг ишлэл нь зөвлөгөө биш, харин тушаал болохыг мэдэж болно. Бурхан биднийг яг Есүс шиг амьдраасай гэж хүсэн хүлээдэг. Тиймээс бид “Тэгвэл Есүс өөрөөр бас яаж амьдарсан бэ? гэж асуух хэрэгтэй болно.

Есүс хүмүүсийн хэрэгцээг шийдвэрлэж байсныг Сайн мэдээнээс тодорхой харж болно. Тэр өвчтэйг эдгээж, хүмүүсийг хүлээсээс чөлөөлж, сохор, дүлий, хэлгүйг нээж, хөлгүйг хөл оруулж, өлсөж цангасан хүмүүсийг хооллож ундаалан, тэр бүү хэл үхсэнийг амилуулж байсан. Тэгээд дараа нь бидэнд: “Аав минь Намайг илгээсний адил Би бас та нарыг илгээнэ” (Иохан 20:21) гэж айлджээ.

Тэгвэл бид үүнийг нь яаж хийх вэ? Бурханы нигүүлслийн үнэгүй бэлэгээр дамжуулж хийнэ! Библи анхны чуулганы талаар “Элч нар Эзэн Есүсийн амилсныг агуу хүчээр гэрчилж байсан бөгөөд тэд бүгдийн дээр бялхам их нигүүлсэл байсан билээ” (Үйлс 4:33) гэдэг.

Бурхан яагаад аугаа хүчийг аугаа нигүүлсэлтэй хослуулав? Яагаад гэвэл нигүүлсэл нь Бурханы хүч болой!

Та “Жон минь, энэ чинь элчийн тухай ярьж байна. Харин би элч ч биш, пастор ч биш, жирийн л итгэгч” гэж хэлж магадгүй. Тэгвэл би танд нэгэн “жирийн” итгэгчийн талаар ярьж өгье. Иерусалимын чуулганы ресторанд Степан гэдэг нэгэн зөөгч залуу байжээ. Тэр залуу элч, эш үзүүлэгч, сайн мэдээ дэлгэрүүлэгч, пастор, багшийн аль нь ч биш, зүгээр л настай эмэгтэйчүүдийг хооллодог залуу байсан. Гэтэл Библи түүнийг “Бурханы нигүүлслээр дүүрэн Степан... хүмүүсийн дунд алмайруулам гайхамшиг, тэмдэг үйлдэв” (Үйлс 6:8) гэсэн байдаг.

Степан элч ч, пастор ч биш атлаа яаж алмайрам гайхамшиг үйлдэв? Бурханы нигүүлслийн хүчээр л тэр! Степан өөрт бэлэг болж ирсэн нигүүлслийн хүчээр яг Есүсийн хийснийг хийж, хүн төрөлхтний хэрэгцээг шийджээ.

Яг ийм бэлэг танд ч, надад ч - итгэгч хүн бүрт өгөгдсөн. Иймээс л Есүс бидэнд “Бүх ертөнцөөр явж, сайн мэдээг хамаг бүтээлд тунхаглагтун... Итгэгчдэд дагалдах тэмдгүүд нь: Миний нэрээр тэд чөтгөрүүдийг зайлуулж, шинэ хэлээр ярих болно. Тэд могойг барина. Бас үхүүлэх ямар ч юм тэд уусан, тэр нь тэдэнд хор болохгүй. Өвчтөнд тэд гар тавивал эдгэнэ (Марк 16:15,17-18) хэмээн тушаажээ. Есүс “Гайхамшиг үйлдэх хүч (нигүүлсэл) нь гагцхүү элч нарт өгөгдөнө” гэж айлдаагүй. Эсвэл “Бурханы нигүүлслийг (хүчийг) бултад биш, элч нарт л өгнө” гэж хэлээгүй. Бурханы Үгнээ: “Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрэнд итгэгчдэд Тэрээр Бурханы хүүхэд болох эрхийг (хүчийг) өглөө” (Иохан 1:12) хэмээн маш тодорхой хэлдэг. Үүнд итгэж ядах юмгүй. Энэ л Библи бидэнд биднийг Есүс шиг амьдруулах “гайхамшиг үйлдэх хүч (нигүүлслийн үнэгүй бэлэг) нь элч нарт төдийгүй, итгэгч нарт ч өгөгдсөн!” гэжээ. Хайртай бүхэн рүү маань халдах өвчин эмгэгийг бид Бурханы хүчээр захирч чадна.

ЦЭЦ УХААН, ОЙЛГОЛТ, ГЭГЭЭРЭЛ, УР, БҮТЭЭЛЧ УХААН

Есүс өөрөөр бас яаж амьдарсан бэ? Тэр гайхамшигтай цэц ухаан, ойлголт, гэгээрэл, ур, бүтээлч ухаантай байсан. Есүсийн цэц ухаан хамгийн цэцэн цэлмэг хүмүүсийг ч гайхшруулж байсан. Түүний тэр их цэц ухаан хаанаас гарсан бэ?

Хүүхэд өсөж, хүчирхэг болсон бөгөөд мэргэн ухаанд боловсорсоор байлаа. Бурханы нигүүлсэл Түүн дээр байсан юм. (Лук 2:40)

Нигүүлслийн ачаар л Есүс ер бусын цэц ухаантай байжээ. Үүнээс маш ухаалаг нэг асуулт ургана. Хэрэв Бурханы

нигүүлсэл нь (олон итгэгчдийн заалгадаг шиг) нүглээ уучлуулж, тэнгэрт ороход л хэрэг болдог юм бол, Есүст нигүүлсэл ямар хэрэгтэй гэж? Тэр ширхэг ч нүгэл үйлдээгүй учраас, Түүнд ямар ч нүглийн уучлал шаардлагагүй. Гэхдээ Есүс Бурханы Хүү байсан ч, энэ дэлхий дээр хүн шиг төрж, хүн шиг алхаж амьдарсан. Түүнийг Өөрийгөө юу ч үгүй болгон, боолын дүрийг авч, хүнтэй адил болсон гэж Филиппой 2:7 хэлдэг. Тиймээс Есүс Өөрийнх нь зан чанарыг үнэхээр цогцлоож байсан цэц ухаан, ойлголт, гэгээрэл, ур, бүтээлч ухаан дотор явахын тулд Түүнд нигүүлслийн хүч хэрэгтэй байжээ.

Би Есүсийн цэц ухаан, ур, бүтээлч чанарыг биширдэг. Есүс үүгээрээ нэгэн эмэгтэйн амийг ч аварсан удаатай. Иохан 8-р бүлэгт шашны фанатууд завхайрч байгаад үйлдэл дээрээ баригдсан нэгэн эмэгтэйг сүмийн талбайд чирч авчраад, Есүсийн өмнө хөсөр хаядаг. (Гэхдээ завхайрсан эрийг нь яагаад чирч авчаагүйг би гайхдаг юм). Тэд “Мосе ийм эмэгтэйг чулуугаар нүүлгэж ал гэж тушаасан. Харин та юу гэмээр байна?” гэжээ.

Ямар ч хүн ийм байдлаас чамгүй ухаан сийлж байж л гарна. Тэгтэл Есүс явган суугаад, газар дээр нэг юм бичдэг (Би Түүнийг тэр шашны удирдагч нарын нууц амрагуудынх нь нэрсийг жагсааж бичсэн болов уу гэж боддог юм. Ханна, Рахел, Изабел гэх мэтчилэн бичсэн байх). Тэр хүмүүс Есүсээс хариу сонсохоор тулган шаардсаар байсан учраас Эзэн маань бичгээ нэг хараад: “За хө, та нарын дундаас нүгэл үйлдээгүй нь хамгийн түрүүнд энэ эмэгтэй рүү чулуугаа шид дээ” гэж хэлчихээд, дахиад л нөгөөхөө бичээд унажээ.

Хоёр нүүртэй тэдгээр шашны удирдагч нар сая л нөхцдөг хүүхнүүдийнхээ нэрсийг олж харсан уу яасан эсвэл Есүс хэт эрс тэс болзол тавьснаас болсон уу яасан - ямар ч байсан атгасан чулуугаа хаяад, оргүй мөргүй арилцгаадаг. Библи “Үүнийг сонсоод, тэд ахмадуудаасаа эхлэн нэг нэгээрээ гарч явсаар ганц Есүс л үлджээ. Өнөөх эмэгтэй тэндээ зогсоор л байв” (Иохан 8:9) гэдэг.

Дараа нь Есүс өндийгөөд, эмэгтэйгээс “Тэд хаачив? Тэд хаана байна? Чамайг хэн ч шийтгэсэнгүй юу? гэсэнд тэр —

Эзэн, хэн ч шийтгэсэнгүй гэв. Есүс —Би ч чамайг шийтгэхгүй. Яв. Үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд (Иохан 8:10-11) гэжээ.

Есүс бүтээлч, цэц ухаанаараа тэр эмэгтэйн амийг аварчээ. Есүс тэр эмэгтэйг яллаагүй. Энэ бол өршөөл. Есүс цорын ганц нүгэлгүй нэгэн байсан бөгөөд яг тэр эгшинд Тэрбээр эмэгтэйд өршөөлөө үзүүлжээ. Есүс тэр эмэгтэйн хуулийн дагуу эдлэх зохистой ялыг нь уншаагүй. Гэхдээ “Яв, дахиж нүгэл бүү хий” гэсэн. Энэ бол нигүүлсэл. Учир нь нигүүлсэл бидэнд авах эрхгүй зүйлийг минь өгдөг бол, харин өршөөл биднийг авах ёстой ялаас минь хэлтрүүлдэг юм. Есүс тэр эмэгтэйг өршөөлөөрөө чөлөөлж, нигүүлслээрээ дахиж нүгэл үйлдэхгүй байх хүчийг өгчээ.

Есүсийн дээр байсан Бурханы нигүүлсэл тэр эмэгтэйг шашны фанатуудын ялаас авраад зогсохгүй, завхайрахгүй амьдрах хүчийг өгсөн юм. Нигүүлсэл ийм хүчтэй!

Өөр нэг удаа Есүс Галил далайн эргээр явж байгаад, байгуулагдсан цагаасаа хойш үзээгүй хар өдрөө үзэж байгаа нэгэн загас агнуурын компанитай таарчээ. Тэр өдөр тэд ширхэг ч загас бариагүй юмсанж. Жишээлбэл нэг өдөр Их дэлгүүрт ширхэг ч бараа борлогдохгүй бол яах уу? Их дэлгүүрийн хувьд хамгийн хар өдөр нь болно биз дээ. Гэхдээ Есүсийн ганц бүтээлч, цэц ухаан л тэр компаний түүхэн дэхь хамгийн хар өдрийг хамгийн ашиг орлоготой, амжилттай өдөр болгож

хувиргав! Есүс загасчин байгаагүй

- гэхдээ Есүст нигүүлсэл байсан!

Юутай цэц ухаан, хүч вэ!

■
Нигүүлсэл ийм хүчтэй!
■

Бас нэг удаа Есүс нигүүлслийнхээ цэц ухаанаар хаанаас илжиг олж болохыг мэдэж байсан. Есүс ИиБэйээс

юмуу Грегслистээс хайгаагүй. Тэрбээр санхүүгийн компаниас зөвлөгөө авалгүйгээр татвараа яаж төлөхөө мэддэг байсан. Есүс Петрээр загас бариултал, загасны аманд яг хэрэгтэй хэмжээний зоос нь байсан. Үүнийг нигүүлсэл л илчилсэн.

Есүсийн ухааныг үнэхээр биширмээр. Сатан Иудасаар дамжуулж ёрын ажлаа гүйцэлдүүлэхээс ч өмнө түүний дотор диавол ажиллаж байгааг Есүс мэдэж л байсан. Есүс

Натанаелтай уулзаа ч үгүй байхдаа, түүнийг жинхэнэ шударга хүн гэдгийг мэдэж л байсан.

ӨӨРЧЛӨГДӨЖ БУЙ НИЙГЭМ

Үндсэндээ Есүсийн амьдралд байсан Бурханы нигүүлсэл л Есүст хүрээлэн буй нийгмээ өөрчлөх чадвар өгчээ. Есүс Кана хотын хуримд оролцсон. Тухайн үед хурим гэдэг цомхон үйл явдал биш, бүхий л тосгоныг хамарсан их найр байжээ. Гэтэл Есүсийн оролцсон тэр найрын дарс яагаа ч үгүй дуусчихсан учраас, хурим будаа болохдоо тулжээ. Хуримлаж буй хосын хоёр талын гэр бүл юу юугүй насаараа хусаад ч арилахгүй ичгүүрт орохдоо тулаад байв. Гэтэл Есүсийн дээрх Бурханы нигүүлслийн ганц хүрэлт дампуурахын даваан дээр ирсэн хуримын нэр төрийг тэнгэрт тултал огцом өргөжээ.

Бас нэг удаа Найн гэдэг хотын нэгэн бэлбэсэн авгай ганц хүүгээсээ хагацжээ. Тиймээс хотын захиргаа түүнийг өөд болох хүртэл нь татвар төлөгчдийн мөнгөөр тэжээж, хувцаслаж, орон гэрээр хангахаар болсон байна. Есүсийн дээрх Бурханы нигүүлслийн ганц хүрэлтээр л өнчирсөн авгайд энэ бүх тусламж шаардлагагүй болж, амьдрал нь сэргээгдэж, үр удам нь үргэлжилжээ (Лук 7:11-15).

Өөр нэгэн хотод Есүс гэмт хэргийн бүлгийн толгойлогчтой уулзжээ. Одоогийнхоор бол синдикатын загалмайлсан эцэг юм. Гэтэл Есүсийн нигүүлслийн ганц хүрэлтээр л Заккай гэдэг тэр хүн нийгмээ хөгжингүй, аюулгүй газар болгоно хэмээн ам мөчгөө өгч, дахиж хүмүүсийг шулахгүй, түүгээр ч барахгүй өв хөрөнгийнхөө талыг нь ядууст өгнө гэж хашхирчээ. Тэр хотын ядуус ч гараад өгчээ! Түүнчлэн Заккай шулж мөлжсөн зүйлсээ эздэд нь эргүүлээд 400 хувь өсгөж өгнө гэсэн. Тэгэхээр тэр газрын эдийн засаг шууд сэргэжээ (Лук 19:1-8). Бурханы нигүүлслийн ганц хүрэлт л энэ бүхнийг үйлдсэн!

Бас нэгэн удаа Есүс галзуурснаасаа болоод амь тэмцэн тарчилж байгаа нэгэн залуутай уулздаг. Тэр үед ямар галзуугийн эмнэлэг гэж байх биш. Тиймээс ийм хүмүүсийг засаг захиргаа нь л халамжилж, татвар төлөгчдийн мөнгөөр

тэжээж, хувцаслаж, хамгаалдаг байж. Гэхдээ тэр залуу хувцсаа байнга урж тасчдаг байсан болохоор, байнга л шинэ хувцас хэрэгтэй болно. Гэтэл Есүс нигүүлслээрээ тэр залууд ганц хүрээд л шууд эдгээсэн учраас түүнийг цаашид татвар төлөгчдийн мөнгөөр тэжээж, үр ашиггүй зарлага гаргах шаардлагагүй болжээ. Халамж хамгаалалт ч шаардлагагүй болсон учраас, тэр мөнгийг нь нийгмийн өөр хэрэгтэй зүйлд зарцуулж болно. Үүнээс гадна Бурханы нигүүлсэлтэй учирсан тэр ганц залуугаар дамжин Декаполисийн арван хот Бурханы хаанчлалын талаар сонсжээ (Марк 5).

Есүсийн дээрх Бурханы нигүүлслээр эдгэрсэн тэр бүх дүлий, сохор, татанги, өвчтэй, тахир татуу хүмүүсийг засаг захиргаа нь цаашид халамжлах шаардлагагүй болсноос гадна тэд эргээд нийгэмдээ үр бүтээмжтэй иргэд болжээ. Энэ мэтчилэн Сайн мэдээний ийм түүхүүдийг тоочоод л байвал, тоочоод л байна. Үүнээс гадна Есүс газар дээрх үйлчлэлийнхээ гурван жилд Сайн мэдээний номуудад багтаахын аргагүй олон гайхамшиг үйлдснийг элч Иохан хэлсэн байдгийг мартаж болохгүй.

Есүс “Надад итгэдэг нь Миний хийдэг үйлсийг бас хийх бөгөөд эдгээрээс агуу ажлуудыг ч хийх болно” (Иохан 14:12) хэмээн амласан. Яаж тэр вэ? Зохисгүй бидэнд Бурханы зүгээр өгсөн нигүүлслийн бэлэгээр дамжуулж хийнэ! Есүс Бурханы үнэ төлбөргүй бэлэг болж ирсэн нигүүлслээр дамжуулж хүрээлэн буй нийгмээ өөрчилсөн шиг бид ч бас өөрчлөх ёстой.

ХАЙГУУЛ

Энэ харанхуй дэлхийн захирагч нар болон хүчнүүд энэ үнэнийг л бидэнд мэдүүлэхгүйн төлөө хүчин зүтгэдэг гэдэгт би нэг ч эргэлзэхгүй. Америк итгэгчдийн 98 хувь нь нигүүлслийн ер бусын хүчийг мэдэхгүй, зүгээр өгөгдсөн үнэгүй бэлэг, нүглийн уучлал гэхээс цаашгүй байгаад дайсан сэтгэл амардаг биз. Тэгэхээр Америк итгэгчдийн ердөө хоёр хувь нь л дайсанд жинхэнэ аюул занал болж байна гэсэн үг юм.

Бид өөрт байгаа энэ ер бусын хүчийг л мэдэхгүй байвал, чуулганы тансаг байртай байна уу, олон гоё номтой байна уу,

том цуглаантай байна уу, зурагтын нэвтрүүлэгтэй байна уу, хиймэл дагуулын сувагтай байна уу - дайсанд ер падгүй. Дайсан нэг л зүйлээс айдаг - биднийг энэхүү нигүүлслийн хүчээ олж мэдээд, энэ нийгмийг Есүс шиг эр зоригтойгоо өөрчлөөд унах вий гэхээс л айна. Дайсан биднийг энэ амьдралыг захирах эрх мэдлийнхээ суудалд суучих вий гэхээс л айдаг.

1517 оны 10-р сарын 31-ний өдөр Мартин Лютер Германы Виттенбергийн Бүх Гэгээнтнүүдийн Сүмийн хаалган дээр Ерэн таван тезисээ хадаж байхдаа, хайгуул хийж явжээ. Энэ үйлдэл нь Сэргэн мандлыг өдөөж, тэр цагаас чуулган эрс шинэчлэгдсэн юм. Энэ бол хүнээр дамжуулж хийсэн Бурханы үйлс байв. Мартин Лютерийн тезисийн гол утга санаа нь зөвт хүн итгэлээр амьдарна л гэсэн үг юм. Тэрбээр хүмүүсийг дарлаж байсан сүмийн дарангуйлалтай нүүр тулжээ.

Би ч бас хайгуул хийж явна. Яг ингэж хайгуул хийж яваа олон хүн байгаа гэдэгт эргэлзэх юм алга. Та ч бас бидэнтэй нэгдээрэй. Бид модон хаалган дээр ерэн таван тезис хадахгүй. Бид нэг л үгийг итгэгчдийн зүрхэн дээр хадна. Тэр үг бол: “Нигүүлсэл нь Бурханаас өгөгдсөн нүглийн уучлал төдийхөн биш, харин биднийг яг Есүс шиг амьдруулж - нөлөөллийнхөө ертөнцөд тэнгэрийн эрх мэдэл, хүчийг үзүүлэн, амьдралд захирах хүчтэй болгодог.”

Дээрх судалгааны хоёр хувийг өсгөхийн төлөө явцгаая. Нигүүлсэл гэдэг үгийг сонсохоороо итгэгчид тэр даруй “хүний чадвараас давсан хүч” гэж боддог болог ээ.

ОНЦГОЙРСОН

Ганц хүний алдаа зөрчлөөс болж ганц хүнээр дамжин үхэл нь ноёрхсон юм бол, тэгэх тусмаа нигүүлслийн баялгийг болон зөвт байдлын бэлгийн дүүрэн хүртэгсэд нь Есүс Христ гэгч ганц Хүнээр дамжин амь дор ноёрхоно.

Ром 5:17

Ром 5:17 дээрх энэ хүч нь үнэмшихийн аргагүй хүч юм. Энэ ишлэлийн утга нь ч зог тусгамаар. Магадгүй иймээс л олон хүн энэ ишлэлийг анхаардаггүй байх.

Есүсийг Эзэнээ болгосон хүн бүр амьдралд захирах хувьтай. Бурханы нигүүлслийг үнэ төлбөргүй, зүгээр хүлээж авсан хүн бүр энэ дэлхийн ямар ч дайсагналыг чигчий хуруугаараа л зайлуулах хүчтэй. Энэ дэлхийн амьдрал биднийг захирах биш, бид энэ дэлхийн амьдралыг захирах ёстой. Бурханы нигүүлслийн хүчээр Есүс нийгмээ өөрчилсөн шиг, бид ч нийгмээ өөрчлөх ёстой. Энэ бол бидний эрх үүрэг.

АМЬДРАЛ ДЭЭР БУУЛГАБАЛ

Тэгэхээр Бурханы нигүүлслээр амьдралд захирах гэдэг нь юу гэсэн үг болохыг цааш нь ухаж үзье. Бид хэвийн хэмжээнээс давж, статус квог эвдэх ёстой гэсэн үг. Энэ нь бид амьдралыг долоо хоногийн дөчин цаг ажиллаад, сарын эцсээр төлбөр

тооцоогоо барагдуулсаар, эцэстээ тэтгэвэртээ гараад, адагт нь нас бараад диваажиндаа очно доо гэж бодохоос арай томоор харах ёстой гэсэн үг юм. Амьдралыг ингэж харна гэдэг үнэнхүү эмгэнэлтэй! Бурхан биднийг ингэж амьдраасай гэж хэзээ ч хүсэхгүй. Бид үүнээс хавьгүй том зүйлийг хийхээр төрсөн!

Бурхан биднийг сүүл биш толгой, доор биш дээр байлгахаар дуудсан (Дэд хууль 28:13) гэдгийг мэдбэл, бид “нөлөө өгөгч” нар болцгооно. Бид амьдралын саад бэрхшээлийг цөм цохиж гараад, Бурхантай гэрээ тогтоогоогүй хүмүүсээс ч тод гялалзана. Бид харанхуй дэлхийн дундах гэрэл гэгээ нь болно. Толгой чиглэл, явц, чиг хандлагыг тогтоодог бол, сүүл дагадаг. Бид нийгмийнхээ талбар бүрт аялдан дагалдагч биш, харин удирдан толгойлогч байх ёстой.

Хэрэв та багш хүн бол, оюутан сурагчиддаа цэц ухаан, эрдэм олгохын төлөө нигүүлслийн бэлгээрээ дамжуулан өөр ямар ч багш, ямар ч боловсролын системийн бодож олоогүй шинэлэг бүтээлч арга ухааныг санаачил. Та өндөр жишиг тогтоож, бусдыг ангай алмайртал оюутнуудаа өрд. Хамтран зүтгэгч нар чинь өөр хоорондоо: “Тэр хаанаас ийм санаа аваад байна аа?” хэмээн шивэр авир хийцгээг.

Хэрэв та анагаахын талбарт ажилладаг бол, нигүүлслийн бэлгээрээ аливаа өвчин эмгэгийг эдгээх үр нөлөөтэй нээлт хий. Хамтран зүтгэгч нар чинь ангайж алмайраад: “Тэр хаанаас энэ их санаагаа авдаг байна аа?” хэмээн хуйхаа маажиг.

Хэрэв та дизайнер бол, Бурханы нигүүлслийн бэлэг танд бусдын санаанд ч ороогүй анхдагч шинэлэг ур хийцийг төрүүлэг. Таны зохион бүтээсэн хэв маяг, чиг хандлага нийгмийг араасаа хуйлруулаг. Та ажил үйлсээрээ тодорч, чиг хандлагыг тодорхойлогч гэдгээрээ танигдаг. Ийнхүү та сүргийнхээ манлайд явдаг учраас, бусад чинь хуйхаа маажиад бие биедээ: “Тэр хаанаасаа ийм бүтээлч санаа олдог байна аа?” хэмээн шагшицгааг.

Хэрэв та улс төрийн талбарт яваа бол, нигүүлслийн бэлэг болох цэц ухаанаараа бусдын гарцгүй гэж харж байгаа нийгмийн асуудлыг шийд. Та хууль цааз боловсруулж, хамтран зүтгэгч нараасаа хавьгүй хурдан сонгогдож дэвшиг.

Таны гярхай, ухаалаг чанарыг үзсэн бусад чинь хөлсөө арчин өөр хоорондоо: “Тэр хаанаас энэ их цэц ухаан, гоц санаагаа аваад байна аа?” гэгцгээг.

Хэрэв та хууль хэрэгжүүлэх байгууллагад ажилладаг бол, нигүүлслийнхээ бэлгээр бусдын зөрчилдөж буй асуудал дээр амар тайван тогтоодог бай. Есүс хаанаас илжиг олохыг мэдэж байсан шиг, гэмт хэрэгтнүүд хаана бүгэж та мэддэг байг. Аливаа гэмт хэргийн нотлох баримтыг ямар ч мөрдөн байцаагчаас илүү хурдан, чадварлагаар эвлүүлэн илрүүл. Таны хосгүй цэц ухаан, чадвар, гэгээрлийг үзсэн талбарынхан чинь толгой сэгсрээд бие биедээ: “Тэр энэ их гоц ухаанаа хаанаас авдаг байна аа?” гэгцгээг.

Бизнесмэнүүд нь Бурханы нигүүлслийн бэлгээр дамжуулан нийгэмд ашигтай шинэлэг бүтээгдэхүүн, худалдаа арилжааны арга ухааныг боловсруулаг. Юу нь ашигтай, юу нь ашиггүйг та л мэддэг байг. Бусад бизнесмэнүүд таны амжилтын нууцыг олж мэдэх гэж тархиа гашилгаг.

Энэ бүхэн нь амьдралгүй, мөрөөдөл төдий жишээ биш шүү. Эдгээр нь бидний эрх үүргийн үлгэр загвар юм. Бид нийгмийн өөр өөр талбарт дуудагдсан боловч, аль ч талбар дээр манлайлж, толгойлж, мэргэших ёстой юм. Бусад нь тэвдэж байхад, бидний бизнес цэцэглэх ёстой. Бидний аж төрж буй нийгэм хөгжин цэцэглэсэн, аюулгүй, таатай газар байх ёстой. Бидний ажлын орчин дэвжин дээшлэх ёстой. Христийнхэн нийгмийн дуу хөгжмийг биширч дууриах биш, үргэлж давтагдашгүй, шинэлэг байдаг Христийнхэний дуу хөгжмийг нийгэм хуулбарлан дууриадаг байх ёстой.

График, видео, архитектурын дизайны хувьд ч ялгаагүй. Бурханы гэр бүлийн бүтээлч ухааны араас бүх талбар, төвшнийхэн гүйлддэг байг. Спорт, энтертэймент, урлаг, хэвлэл мэдээлэл тэргүүтэй бүх талбарт бид жишиг тогтоодог байя. Зөвт хүмүүс засаглахад улс, хот, аймаг, дүүрэг маань цэцэглэнэ.

Итгэгчид хэзээ, хаана байна - тэр газар уран бүтээл, үр бүтээл, амар амгалан, торгон ухаан, хосгүй чадвар цалгих ёстой. Бид чинь харанхуйг гийгүүлэх гэрэл шүү дээ. Бидэнд өгөгдсөн Бурханы ер бусын нигүүлслээр дамжуулан бид энэ харанхуй нийгэмд өөрсдийгөө онцгойруулах ёстой.

ӨӨРИЙГӨӨ ОНЦГОЙРУУЛАХ

Бурханы нигүүлслээр хүчирхэгжсэн хүмүүс бид амьдрал дээр гоцлох ёстой юм. Даниелийн доорх гэрчлэлийг анхааралтай уншина уу:

Тэгэхэд өнөөх Даниел ер бусын сүнстэй тул сайд, аймгийн захирагчдаас тодорч (өөрийгөө онцгойруулан), улмаар хаан түүгээр бүхэл хаанчлалыг захируулахаар төлөвлөж байв. (Даниел 6:3)

Ёстой гайхмаар. Даниел өөрийгөө онцгойруулсан. “Бурхан Даниелийг онцгойруулсан” гэж хэлээгүйг анхаарна уу. Энэ хосгүй залуу өөрийгөө онцгойруулсан гэдгийг Библийн томоохон орчуулга бүр хэлдэг. Мессеж Библи яг орчин цагийн үг хэрэглэн: Даниел “бусад удирдагч нараасаа тасран онцгойров” гэдэг.

Даниел яаж ингэв? Тэр Бурхантай холбоотой байсан учраас Түүнд ер бусын чанар байсан. Даниел Бүтээгчтэйгээ цаг үргэлж ойр байх сахилга батад суралцжээ. Тэгэхээр өнөөдөр Бурхантай гэрээ байгуулсан хэн ч ялгаагүй ийм л байх ёстой.

Нью Американ Стандарт Библи дээр “Даниел ер бусын сүнстэй нэгэн байсан учраас... өөрийгөө онцгойруулж эхлэв” гэдэг. Ер бусын гэдэг нь “хэвийн хэмжээг давах, статус квог эвдэх, нийтлэг хэмжүүрээс хэтрэх” гэсэн үг юм. Заримдаа аливаа үгийн нарийн утгыг гаргахын тулд эсрэг утгатай үгийг нь судлах хэрэгтэй байдаг. Харин ер бусын гэдэг үгийн эсрэг утгатай үг нь - нийтлэг, жирийн, хэвийн болно. Тиймээс ер бусын сүнс тээдэг хүн жирийн амьдарч чадахгүй.

Даниелийн бие юмуу санаа нь биш, харин сүнс нь ер бусын байсан гэдгийг бичээс хэлжээ. Сүнс нь ер бусын бол, оюун санаа, бие, бүтээлч чанар, ур чадвар, мэдлэг тэргүүтэй амьдралын бусад тал нь дагаад л явчихна. Бидний амьдралыг цогцлоогч нь сүнс юм. Хэрэв бид өөрт өгөгдсөн нигүүлслийг үнэхээр мэддэг бол, бидэнд ямар ч хязгаар байхгүй - учир нь бид “Түүнд итгэдэг хүний хувьд бүх зүйл боломжтой” (Марк 9:23) гэдгийг мэдэх

болно. Даниел Бурхантай тогтоох харилцааныхаа бүх боломж бололцоог л эдлэжээ. Тэрбээр Аугаа хүчирхэг Бурхантай тогтоосон гэрээнийхээ улмаас өөрийгөө нөхцөл байдлын боол биш эзэн, сүүл биш толгой гэдгээ мэддэг байжээ.

Үүнийг илүү ухаж үзье л дээ. Даниел ба түүний гурван найз Израиль гэдэг жижиг үндэстнээс Вавилон хэмээх дэлхийн хамгийн хүчирхэг гүрэнд олзлогдон иржээ. Америкчууд бид өөрсдийгөө өнгөрсөн хагас зууны хамгийн хүчирхэг улс гэж боддог. Гэхдээ Вавилоны дэргэд Америк юу ч биш гэдгийг шулуухан л хэлье. Вавилончууд даян дэлхийг захирч байсан! Тэд эдийн засаг, улс төр, цэрэг, нийгэм, шинжлэх ухаан, боловсрол, соёл урлаг - бүх тал дээр манлайлж байсан! Гэхдээ “хаан ямар ч асуулт асуусан бай, ямар ч асуудал гаргаж тавьсан бай - Даниел ба түүний гурван найз хаанчлал дахь бусад удирдагч нараас арав дахин илүү байжээ (Даниел 1:20). Зарим орчуулга тэднийг “арав дахин илүү, арав дахин цэцэн, арав дахин ихийг ойлгодог байсан” гэдэг. Тэд Вавилоны эрдэмтэн мэргэдийн санаагүйг санаж, бодоогүйг бодож олоод хэрэгжүүлэхэд, энэ санаа нь бүтдэг байсан юм.

ДАНИЕЛЭЭС Ч АУГАА, ИОХАНААС Ч АУГАА

Яг үүнийг бодонгоо Лук 7:28 дээр хэлсэн Есүсийн үгийг уншина уу: “Эмэгтэйгээс төрөгсдийн дунд Иоханаас аугаа нэгэн байхгүй.” Энэ нь Иохан баптист Даниелээс аугаа байсан гэсэн үг юм. Тэднийг үйлсээр нь бүү харьцуул. Учир нь Иохан үйлчлэгч байсан бол, Даниел төр нийгмийн зүтгэлтэн байсан. Гэхдээ Иохан Даниелээс “аугаа” болохыг Есүс маш тодорхой хэлжээ. Үүнийхээ дараа Есүс: “Харин Бурханы хаанчлалын хамгийн бага нэгэн нь ч түүнээс аугаа билээ” (Лук 7:28) гэсэн юм.

Яагаад Бурханы хаанчлалын хамгийн бага нь Даниелээс юмуу Иоханаас аугаа байж таарах билээ? Тэр үед Есүс хүн төрөлхтнийг чөлөөлөхөөр загалмай дээр хараахан хадагдаагүй байсан учраас, Иоханд дахин төрсөн сүнс байгаагүй юм. Иоханы талаар “учир нь Иохан энэ ертөнцөд Есүс шиг

байдаг” гэж хэлэх боломжгүй байжээ. Иохан Есүстэй хамт амилуулагдаж, Христтэй хамт тэнгэрлэг суудалд залагдаагүй. Гэтэл бидний талаар яг ингэж хэлсэн байдаг. Тиймээс л хаанчлалын хамгийн бага нь Иоханаас аугаа ажээ.

Есүсийн амилалтаас өнөөдрийг хүртэл энэ дэлхий дээр ойролцоогоор хоёр тэрбум итгэгчид амьдарсан гэж үздэг. Гэтэл та тэр хүмүүсийн дунд хамгийн өчүүхэн нь байлаа гэж бодсон ч, та Иохан баптистаас аугаа бөгөөд энэ нь та Даниелээс ч аугаа гэсэн үг! Тэгэхээр та өөрийгөө онцгойруулж байна уу? гэсэн асуулт ургана.

Та Есүс Христээр дамжин Бурхантай гэрээний харилцаанд ороогүй хамтран зүтгэгч нараасаа арав дахин дээр, ухаантай, цэцэн, бүтээлч, шинийг санаачлагч байж чаддаг уу? Чаддаггүй бол, яагаад? Яагаад дахин төрсөн итгэгчдийн дийлэнх нь дэлхийгээс арав дахин үр дүнтэй байж чадахгүй байна? Магадгүй бидний хоёрхон хувь нь л Бурханы нигүүлсэл биднийг Даниел шиг өөрийгөө онцгойруулж, амьдралд захирахын төлөө төрөлх чадвараасаа давж гарах Бурханы хүч болдог гэдгийг мэддэг учраас тэр бус уу? (Биднийг чуулган дахь сул дорой нэгнийхээ ачааг үүрээрэй гэсэн. Гэхдээ Библи тэднийг насан турш сул дорой чигээрээ үлдээрэй гэж хэлээгүй. Тэд ч бас нөлөөллийнхөө ертөнцөд өөрсдийгөө онцгойруулах харааг өвлөх ёстой).

Матай 5:14 дээр Есүс биднийг “дэлхийн гэрэл” гэж мэдэгдсэн. Ер нь Шинэ гэрээнд Есүс хүүхдүүдээ харанхуйг гийгүүлэх гэрэл гэж нэг бус удаа айлдсан байдаг. Тухайлбал Матай 5:14-16; Лук 12:3; Иохан 8:12; Үйлс 13:47; Ром 13:12; Ефес 5:8, 14; Колоссай 1:12; Филиппой 2:15; 1Тесалоник 5:5; 1Иохан 1:7; 2:9-10 дээр хэлжээ. Тэгэхээр энэ харанхуй дэлхийг гэрэлтүүлэх нь Христ доторх бидний амьдралын нэг гол үүрэг юм.

Дэлхийн гэрэл байна гэж юу гэсэн үг болохыг та бодож үзэж байсан уу? Харамсалтай нь “гэрэл” байх гэдгийг олон хүн Библиэ тэвэрч, Иохан 3:16-г ишлэсэн, нэг л их сайхан ааштай наалинхай хүн байх гэж боддог. Даниел “гэрэл байхыг” ингэж ойлгосон бол, яах байсан бол? Тэрбээр Вавилоны төр захиргааны байраар явахдаа, таарсан хүн бүртгээ нахилзаж бөхөлзөөд л: “Вавилоны

удирдагч нар аа, Дуулал 23 дээр “Эзэн бол миний хоньчин. Надад дутах зүйл нэг ч үгүй...” гэдэг!” гэх байсан байх.

Даниелийг өдөр залбирахаар явсан хойгуур Вавилоны захирагч, удирдагч нар юу гэх байсан бол? “Ашгүй нөгөө фанат чинь далд орлоо. Өдөржин залбираасай билээ. Үнэхээр хачин этгээд шүү!” гэх байсан биз.

Гэтэл тэд Даниелийг залбирахыг хориглосон хууль гаргасан (Даниел 6:6-8). Яагаад? Даниел өөрсдөөс нь арав дахин ухаантай, цэцэн, шинийг санаачлагч, бүтээлч байсан учраас тэр биш үү? Даниел өөрсдөөс нь илүү тушаал дэвшиж, бүх удирдагч нарын тэргүүн болсон учраас атаархаж үхсэндээ тэр биш үү? Тэд гайхшаа баран, өөр хоорондоо: “Ойлгохгүй юм. Бид чинь энэ дэлхийн сор болсон мэдлэгтэй, бэлэгтэй, ухаантай багш, эрдэмтэн, удирдагч нараас суралцсан. Гэтэл энэ муу жижиг улсаас гаралтай Даниел хаанаасаа ийм их санаа авдаг байна? Яахаараа тэр биднээс илүү байдаг билээ? Магадгүй өдөрт гурван удаа залбирснаас тэр байх! Түүнийг өөрсдөөсөө дээш гаргахгүйн тулд залбирахыг нь хориглосон хууль санаачилъя!” гэсэн байх.

Даниел үнэхээр ер бусын хүн байгаад, тэр харанхуй соёлыг гийгүүлсэнд үеийнхэн нь атаархаж үхжээ. Гэхдээ хаан тэргүүтэй олон хүн Даниелийн чадвараас амьд Бурханыг олж харахдаа, сэтгэл татагдаж, тэр Бурханыг дээдлэсэн юм.

Даниел хүмүүсийг Бичээсийн талаарх мэдлэг, хөөрхөн ааш, өдрийн гурван удаагийн залбирлаараа бус, харин онцгой чадвар, бурханлаг чанараараа татжээ. Даниел ажлынхаа талбарт бусдаас онцгойрч байсан нь хөдлөшгүй баримт билээ.

Яг үүнийг санангаа, биднийг гэрэл гэж дуудсан Есүсийн үгийг одоо сонсоно уу: “Хүмүүс та нарын сайн үйлсийг хараад, тэнгэр дэх Эцэгийг чинь алдаршуулахын тулд та нарын гэрэл тэдний өмнө тийнхүү гэрэлтэг” (Матай 5:16). Есүс биднийг ажил үйлсээрээ үл итгэгч хүмүүсээс онцгойрох тухай онцлон хэлжээ. Гэтэл бид үүнийг нь сайхан, хөөрхөн ааштай байх гэж ойлгож л явдаг.

ОРЧИН ЦАГИЙН ЖИШЭЭ

Надад Бен гэдэг нэг найз бий. Тэрбээр дэлхийн хамгийн том авто машин үйлдвэрлэгч компанид ажилладаг. Нэг удаа оройн зоог дээр Бен надад компанийхаа дэд ерөнхийлөгч болохоосоо өмнө өрсөлдөгч компанийхаа шилмэл инженерүүдийн багт ажиллаж байснаа ярьсан юм. “Жон, би Даниел номыг уншиж байгаад, Даниел болон түүний гурван найз хамтран зүтгэгч нараасаа арав дахин илүү байсныг үзээд: “Эзэн минь, Даниел болон түүний нөхөд Хуучин гэрээн дор байсан атлаа хамтран зүтгэгч нараасаа арав дахин илүү байсан юм бол, Шинэ гэрээний нигүүлсэл дор байгаа хүн би хамтран зүтгэгч нараасаа хамгийн багадаа л арав дахин илүү байх ёстой бус уу?” гэж залбирсан юм.

Манай тэр корпораци жил бүр ахлах дизайнеруудынхаа багийн гишүүн нэг бүрийг хэр хэмжээний хэмнэлт болон үр бүтээмж гаргасан талаар дүн шинжилгээ байсан юм. Өөрөөр хэлбэл багийн гишүүн бүрийн зохион бүтээл, санаа, бүтээмжийн үр өгөөжийг шалгадаг байлаа. Тэгээд тэр жил манай багийн хоёр дахь шилдэг хүн гучин таван сая долларын хэмнэлт, үр бүтээмж гаргасан байсан. Харин би яасан гээч?”

Би ч Бений хэлэх үгийг сонсохоор тэсэн ядан инээмсэглээд “Яасан?” гэж асуулаа.

Гэтэл Бен: “Би гурван зуун тавин сая долларын хэмнэлт, үр бүтээмжтэй ажилласан. Би миний дараа орсон хүнээс арав дахин илүү байж чадсан” гэж хэлсэн юм. Ийм л учраас манай Бен Америкийн хамгийн том нэгэн корпорацийн шилдэг гүйцэтгэх захирал болтлоо дэвшиж чаджээ.

Манай Мессенжер Интернэйшнэл байгууллагад ажилладаг байсан гэр бүлийн хоёр бий. Тэр хоёр нэг зун хоёр хүүгээ миний семинарт суулгатал, би яг энэ зарчмыг зааж таарчээ. Цуглааны дараа тэдний 11 настай отгон хүү Тайлер аавдаа: “Аав аа, надад Бурханы нигүүлсэл байгаа юм чинь би хотынхоо лигийн бусад хүүхдээс илүү сайн тоглох ёстой, тээ?” гэж хэлжээ.

Энэ түүхийг би ярьснаас аав, ээжийнх нь захидлыг шууд толилуулсан нь дээр байх:

Жон,

Энэ бол Тайлорын энэ улирлын Плэй- офф болон аваргын төлөөх тоглолтын үзүүлэлт. Энэ нь Колорадо Спрингсийн 11-12 настай хүүхдүүдийн бүх хотын лиги юм.

Хүү маань 166 см өндөр, 48 кг жинтэй, 11 настай хүүхэд. Багаараа авахуулсан зургийг нь харвал, миний хүү бусдаасаа ялгарах юмгүй, жирийн л нэг жаал.

Улирлын эхэнд хөл бөмбөгийн талбай дээрээ жил бүрийн бэлтгэлээ хийж байгаа хүүг маань харсан лигийн тэргүүн нь: “Манай Тайлер өнгөрсөн жилийнхээсээ арав дахин хурдан харагдаж байх чинь!” гэж хэлсэн юм.

Тайлер 78 удаагийн дамжуулалтаар 817 метр газар гүйсэн. Түүний араас орсон хүүхэд нь 70 удаагийн дамжуулалтаар 474 метр газар гүйсэн байв. Гэхдээ дасгалжуулагч нь ганц тоглогчийг гоцлуулаад байх нь спортын эв нэгдэлд нийцэхгүй гэж үзсэн учраас, хүүг маань тэмцээнд бүтэн тоглуулалгүй, аль нэг хагаст л тоглуулдаг байсан юм. Тэйлор 78 дамжуулалтаар нийт 17 тачдаун хийсэн бол, хоёрдугаарт орсон тамирчин нь 70 дамжуулалтаар 7 тачдаун хийжээ.

Тайлерийн гүйхийг харсан өрсөлдөгч багийнх нь дасгалжуулагч нар улирлын тоглолт дундаас хамгаалалтаа зузаатгаж эхэлсэн юм. Тоглолтын дундуур дасгалжуулагч нарын “68 - ыг анхаар!” “68 - ыг зогсоогооч ээ!” “Юугаа хийгээд байгаа юм бэ! Наадах чинь чамайг дуусгалаа иш дээ!” гэж орилолдох нь дуулна. Тэр 68 нь манай Тайлер юм.

Тоглолтын дараа Тайлер дээр танихгүй хүмүүс хурч ирээд: “Сайн уу” гээд л яриа дэлгэдэг болсон. Хүү маань үүнд дасаагүй учраас жаахан биеэ барьдаг боловч, аавдаа “Бурханы нигүүлсэл түүнийг бусдад нөлөөлөгч болгож байгаа учраас, цаашид ч гэсэн Бурханы нигүүлсэлд итгэсээр байна” гэдгээ хэлсэн шүү. Бид ч бас энэ их нөлөөг зөвөөр залаарай гэж захисан.

Хүндэтгэсэн Жим, Келли.

Үй олон залуус Бурханы Үгийг хүлээж аваад, үгийн дагуу үйлдэж байгаа нь гайхамшигтай. Бяцхан Тайлер бол бидний үлгэр дууриал юм.

БИДЭН ДОТОРХ НИГҮҮЛСЭЛ

Бид яагаад Бурханы хэлсэн Үгт зүгээр л итгэчихэж болдоггүй юм бэ? Тэр бидэнтэй “...дотор маань ажилладаг хүчний (нигүүлслийн) дагуу гуйх буюу бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар үйлдэх чадвартай Түүнд...” (Ефес 3:20) гэдэг гэрээ байгуулсан шүү дээ. Энэ нь тэнгэрээс үе үе ирдэг хүчний дагуу бус; энэ нь үйлчлэлийн онцгой бэлэгтэй эрэгтэй, эмэгтэй хүнээс ирдэг хүчний дагуу бус. Энэ нь бидний дотор ажилладаг хүчний дагуу юм.

Энэ ишлэл дэхь “үйлдэх чадвартай Түүнд” гэсэн хоёр дахь хэсгийг онцлон анхаарна уу. Дэлхийн аль нэг хэсэгт аймшигтай гамшиг болжээ гэж төсөөлье. Гэтэл дэлхийн өөр өнцөгт байдаг маш өгөөмөр, өглөгч нэгэн улс гамшгийн голомт руу цэргүүдээ, дээрээс нь ачааны усан онгоцоор чингэлэг дүүрэн шинэ жимс, ногоо, буудай, мах, цэвэр ус зэрэг хоол хүнс илгээжээ. Тэгээд генерал нь гамшигт нэрвэгдсэн улсын иргэдэд: “Бид та нарт авч чадах хэмжээгээр чинь л хоол хүнс өгнө” гэж мэдэгджээ. Эхний хүн дэрсэн сагс барьсаар гарч ирээд, хоёр хүний хоёр өдрийн л хүнс авав. Дараагийн хүн томоохон үүргэвчтэй ирээд, гэр бүлээ таван өдөр тэжээчих хангалттай хүнс аваад явжээ. Гэтэл гурав дахь хүн нь ачааны машинтай ирээд, өлсгөлөн гэр бүл, хөршүүдээ бүтэн сар тэжээж хүрэхүйц хоол хүнс дүүргээд явав.

Ачааны машинтай хүн тонн тонн хүнстэй харьж явааг харсан сагстай хүн эгдүүцэж хилэгнэн, энэ талаар хөршүүддээ бас замдаа таарсан хүн бүрт гомдоллосоор явсан тул түүний гомдол генералын сонорт хүрчээ. Генерал ч түүнийг дуудаад: “За залуу, бид та нарт авч чадах хэмжээгээр чинь л хүнс өгнө гээгүй билүү. Чи өөрөө л умайсан сав авчирсан. Яагаад олигтойхон сав авчраагүй юм бэ? Яагаад ачааныхаа машиныг авчраагүй юм бэ?” гэжээ.

Тэгвэл Бурханы нигүүлслийг хүртэхдээ Христэд итгэгчид ямар сав барьж ирдэг бол? Ефес 3:20 - иос үзбэл, нигүүлсэл бидэнд бидний гуйх буюу бодох хэмжээгээр минь өгөгдөх ажээ. Бурхан: “Миний нигүүлсэл чиний авчирсан саваас хол илүү шүү!” гэж байна. Өөрөөр хэлбэл Бурханы энгүй, яндашгүй, ёроолгүй хангамжаас аль зэрэг утгахыг бидний сав л шийдэх ажээ. Үнэндээ бол Бурханыг хязгаарладаг цорын ганц зүйл нь бидний барьж байгаа сав юм. Бурхан та биднээс “Чи яагаад дандаа аргацаасан юм боддог юм бэ? Чи яагаад ганцхан өөрийгөө юмуу гэр бүлээ л боддог юм бэ? Чи яагаад чиний дотор суулгасан бүрэн хүчин чадалд хөл тавьж, эргэн тойрондоо байгаа хүн бүрт Даниел шиг хүчирхэг нөлөө үзүүлдэггүй юм бэ?” гэж асууж байна.


Иймээс л Паул биднийг “Итгэдэг бидний доторх хийгээд бидний төлөөх Түүний үлэмж аугаа байдлаас хол давсан, хэмжээлшгүй, хязгааргүй хүчийг...” ойлгож мэдэхийн төлөө үнэн голоосоо залбирчээ (Ефес 1:19).

Паулын үгсийн сонголтыг харна уу: аугаа байдлаас хол давсан, хэмжээлшгүй, хязгааргүй.

Эдгээр үг таны амьдрал дээр ямар нэг утга илэрхийлж байна уу? Паул Бурхан сайхан зантай байвал, хэн нэг үйлчлэгчээрээ дамжуулан хааяа нэг хаяж өгдөг хүчний тухай биш, харин “бидний доторх хүчний” тухай ярьж байгааг анхаарна уу. Энэ хүч нь бусдад Есүс Христийн амилалтын хүчийг батлан харуулахын тулд биднийг бусдаас онцгойруулахын төлөө, биднийг энэ бүүдгэр ертөнцийг гэрэлтүүлэх гэрэл болгохын төлөө өгөгдсөн хүч юм!

Тэгэхээр бид өөрөөсөө “Есүс дэндүү өндөр өртөг төлчихөөд байхад, бид үүнээс нь дорой амьдраад байгаа юм биш биз?” гэж асуух хэрэгтэй. Өөртөө

шударга ханддаг хүн “Тийм” л гэж хариулна. Өөрөөсөө өөрийг сэтгэдэггүй дундаж чанараасаа болоод бид хаанчлалын төлөө


**Үнэндээ бол
 Бурханыг
 хязгаарладаг
 цорын ганц зүйл
 нь бидний барьж
 байгаа сав юм.**



энэ дэлхийд нөлөөлөх хүчин чадлаа ашиглаж чадахгүй байна.

Яагаад бид дандаа энэ дэлхийн итгэлгүй замаар салгалдаг юм бэ? Жишээлбэл эдийн засаг хямрахаар итгэгчид яагаад бусдыгаа дагаад сандардаг юм бэ? Надад заримдаа Филиппой 4:19 - ийг: “Миний Бурхан Уол Стриитийн банкны систем, эдийн засгийн үйл явцын дагуу хэрэгтэй бүхнээр чинь хангана” гэж бичих хэрэгтэй болчихсон юм шиг санагддаг. Саяхны дэлхийн эдийн засгийн хямралаар бид яаж хөгөө чирэв? Гэхдээ Бурханы Үгийн үнэнээс үзбэл, чухамхүү хүнд бэрх цагт л бид хэзээ хэзээнээс хурц гэрэлтэх ёстой! Эдийн засаг хямарлаа гээд Бурханы баялаг дэлхийгээс харьчихгүй. Шинэ санаа, бүтээлч байдал, нээлт ололт, хичээнгүй хөдөлмөр байж л байна. Цөвүүн цагт л Бурханы хүмүүс өндийж босоод, Бурханаас өгөгдсөн дотоод хүчээрээ хүмүүст ач тусаа өгөх сая сая, тэрбум тэрбум санааг сэдэж олох ёстой. Эдийн засгийн хямрал гэдэг нь санхүүгийн хэвийн урсгалд саад гарсан учраас, үүнийг саадгүй урсгах бүтээлч шинэ санаа шаардлагатай болсны дохио юм. Бүтээлч хүчний ундарга хэзээ ч хатдаггүй. Тиймээс Бурханы хүмүүс болсон та бид л үүнийг шийдвэрлэх хүчин байх ёстой!

1920 онд нэгэн хүн Эйми Семпл Мкферсонд: “Ийм эрин үед дээрээс нь Их хямралын дундуур Лос Анжелесийн төвд эмэгтэй хүн таван мянган хүний суудалтай байшин барьдаггүй юм” гэдгийг хэлэх хэрэгтэй байж. За барьчихлаа гэхэд тийм аймшигтай хямралын цагаар тийм том байшинг ажиллуулах ямар ч боломжгүй гэдгийг хэлэх хэрэгтэй байж. Гэтэл тэр эмэгтэй барьчихсан. Өнөөдөр би тэр байшинд гайхамшигтай цуглаан хийж номлолоо. Эймигийн байшингийн заслаас санаа авахын тулд Холливүүдийн продюсерүүд түүний Бүтэн сайны оройн номлол дээр нууцаар суудаг байсан гэж ярьцгаадаг. Дараа нь тэд харсан санаагаа Холливүүдийн тайз засалд хэрэглэдэг байж. Эйми тэдний хувьд жинхэнэ гэрэл байжээ.

Гэтэл би саяхан нэг нэвтрүүлэг үзсэн юм. Нэг залуу баахан үзэгчийн өмнө зогсоод, “Гайхамшигт хайрыг” дуулав. Үзэгчдийн урдуур шүүгч нар суужээ. Нөгөө хүн дуулж дуусахад, шүүгч нар түүний дуулах чадварыг өөр

өөрийнхөөрөө үнэлэв. Тэгээд: “Чи яахав дээ л дууллаа; илүү сайн дуулж болох байсан; өнгөө өндөр авчихлаа...” гэж дүгнэхийг нь сонсоод би үнэхээр сочирдсон юм.

Би хөл дээрээ ч тогтож ядаж байлаа. Тэгээд Эзэн рүү: “Эзэн минь, Та энэ ертөнцийг бүтээсэн. Та мананцар, шинэ оддыг бас гайхамшигт Роки нуруудыг, тэнгис далайг хосгүй амьд амьтадтай нь бүтээсэн. Та бидний дотор амьдардаг. Гэтэл бид авъяасаа нээх гэж Америкийн шүтээн рүү явж байна!” гэж орь дуу тавилаа. Бодоод үз: Эйми бүтээлч байдлаараа Холливүүдийг хуйлруулсан байхад, бид нигүүлслийг хөсөрдүүлж хаячихаад, жаахан онгодын араас Холливүүд рүү шогшдог болжээ.

Тэгээд би гүн гунигт автаж, олон өдөр шаналахдаа: “Нигүүлсэл бол бидний нүглийн уучлал, тэнгэрт орох тасалбар” гэдэг сургаалаар бойжиж байгаа хүмүүс яаж ч энэ дэлхийн гэрэл байх билээ” гэдгийг ухаарсан юм. Энэ нь Бурхан биднийг энэ дэлхийн нүдэнд элэг доогь болгож байгаатай л адил юм. Мятрашгүй итгэлээр тэмцэхийг шаардахгүй, амар хялбар, зовлонгүй сайн мэдээг бүтээх гэсэн хүсэл маань Бурханыг “Та нар хүссэн юм хүзүү орооно гэгч болох бий” гэж хэлтэл нь гашуудуулж байх бий.

Бид яагаад зүгээр л Бурханы амлалт, нөхцөл болзолд итгэчихэж болдоггүй юм бэ? Яагаад бид Бурханы үнэнээр амьдрахад гардаг эрс өөрчлөлтийг хайхын оронд, Түүний цэц ухааныг өөрийнхөө амьдралын хэв маягт нийцүүлэх гэж оролдоно вэ?

НИГҮҮЛСЭЛТЭЙ УЧИРСАН ТҮҮХ

Дунд сургуульд байхдаа би Англи хэл дээрээ - нарийндаа бол зохион бичлэг дээрээ ёстой нойлын ногоон тэг байлаа. Зохион бичлэгийн шинжтэй өчүүхэн даалгавар ч миний үстэй толгойг арзайлгадаг байв. Ганц хоёр хуудас юм бичих гэж гурваас дөрвөн цаг зууралдана. Эхнийхээ өгүүлбэрээ яаж бичихээ мэдэхгүй, хэдэн цагаар хоосон цаасаа гөлийж сууна. (Тийм ээ, тэр үед ямар юмных нь компьютер, iPad байхав). Тэгж тэгж

нэг өгүүлбэр бичнэ - тэгснээ тэрийгээ хараад, шал тэнэг юм гэж бодоод, базаад шидчихнэ. Дараагийн удаа нь овоо ахиц гаргаж - хоёр өгүүлбэр бичнэ. Тэгэнгүүтээ бүр ч тэнэг юм гэж бодоод ураад шидчихнэ. Ийм маягаар хичнээн ч цаг, хичнээн ч цаас гарзадсныг ёстой бүү мэд. Ийнхүү цаг гаруйн дараа овоо жаахан утга төгөлдөр нэг параграфтай болж авна. Эцэстээ миний хувьд бараг л мэргэжлийн төвшинд хийгдсэн тэр ажил маань тун ч тааруухан дүн авснаар өндөрлөнө.

Заримдаа би манай Англи хэлний багш нар дараагийн жил нь надтай ахиж зууралдахыг хүсээгүйдээ л “алтан гурав” зурж өгөөд, төгсгөдөг байсан байх гэж боддог юм. Та намайг жаахан хэтрүүлээд байна гэж бодож байгаа байх. Тэгвэл би ямар муу байснаа баримтаар нотлоод өгье. Үнэндээ би Англи хэлний улсын шалгалт дээрээ 800 оноо авахаас 370 оноо л авч байлаа. Энэ нь 46 хувь бөгөөд наддаа л “дээд амжилт” байв. Гэхдээ золоор би тоо болон шинжлэх ухааны хичээл дээрээ авъяастай байсан учраас Пердю Их Сургуулийн инженерийн ангид элсэж чадсан юм.

Тиймээс 1991 онд намайг залбирч байхад Бурхан “Хүү минь, Би чамаар ном бичүүлмээр байна” гэж хэлэх үед нь би Бурханыг “Намайг энэ дэлхий дээрх хар мянган хүүхдийнхээ нэгэнтэй эндүүрчлээ!” л гэж бодов.

Одоо хэлэхэд ичмээр байгаа ч, тухайн үед Бурханы тэр үг миний хөх инээдийг хүргэсэн тул би юу ч хийгээгүй юм. Тэр үед би яг одоо тантай хуваалцаж буй Бурханы нигүүлслийн гайхамшигтай, хүчирхэгжүүлэгч мөн чанарын талаар огт мэддэггүй байлаа.

Гэтэл арван сарын дараа хоёр долоо хоногийн зайтай Техас, Флорида гэдэг хоёр өөр мужид байхад минь хоёр өөр эмэгтэй надад яг адилхан үг хэлэв: Жон Бивэр, хэрэв чи Бурханы өгч буй үгийг бичихгүй бол, Бурхан үгээ өөр хүнд өгнө. Харин чи дуулгаваргүй байдлынхаа төлөө буруутай болно.

Хоёрдахь эмэгтэйгээс хоёр долоо хоногийн өмнө дуулсантайгаа яг адилхан үг сонсохдоо би Бурханаас үнэхээр эмээж: “Ээ, Бурхан минь, бушуухан шиг л үгэнд нь орж, номыг нь бичье!” гэж бодсон ч, “Бурхан том алдаа гаргаж байна даа” бодсон хэвээрээ л

байлаа. Би чинь ном байтугай, арван нүүр ч бичиж чаддаггүй хүн шүү дээ! Тэгээд цөхрөнгөө бараад, цаас аваад Бурхантай гэрээ үзэглэв. “Бурхан минь, би үүнийг Таны чадваргүйгээр ёстой хийж чадахгүй. Надад үнэхээр нигүүсэл хэрэгтэй байна!” гэж бичээд он сараа тавиад, гарын үсгээ зурчихлаа.

Тэгээд дараа нь суугаад номоо бичлээ. Ерөнхий төлөвлөгөө энээ тэрээ ч байхгүй. Учир нь би ийм гаргаж байж ном хөвөрдгийг ч мэдсэнгүй. Цээжинд минь ганц өгүүлбэр төдий үндсэн сэдэв маань л явж байлаа. Гэтэл гэнэт л өмнө нь хэзээ ч, хэнээс ч сонсож, заалгаж, бодож байгаагүй санаанууд тархинд минь ундарч эхлэв. Би тэрийг нь бичээд л, бичээд л байлаа. Эцэстээ бүтэн номын дайтай гар бичмэлтэй болчихсон сууж байв. Хожим нь хоёр дахь номоо, дараа нь гурав дахь номоо бичлээ. Өнөөдрийг хүртэл миний бие арван тав гаруй ном бичсэн нь дэлхий даяр жар гаруй хэлээр орчуулагдаж, хэдэн сая хувиар борлуулагдаад байна. Drawing Near гэдэг ном маань 2004 онд “Уншигчдын сонголт” шагнал хүртсэн бол, хэд хэдэн ном маань Америкт болон дэлхийд бестселлер болсон билээ.

Хэрэв би өөрийнхөө чадварт найдсан бол, ийм амжилтанд хэзээ ч хүрэхгүй байсан. Энэ бол зөвхөн Бурханы нигүүлсэл билээ.

Би Европт найман мянга гаруй Христэд итгэгч удирдагч нар цугласан хоккейн талбай дээр зогсож байхдаа, миний аль нэг номыг уншсан хүн байгаа эсэхийг асууснаа, бараг бүгдээрээ гараа өргөсөнд нь эргээд өөрөө гайхаж билээ. Зүүн Европт олон улсын конференцт оролцож байсан 60 гаруй орны 6000 удирдагчаас миний аль нэг номыг төрөлх хэл дээрээ уншсан хүн байгаа эсэхийг асуутал, тэдний бараг 90 хувь нь гараа өргөсөнд бас л мэл гайхаж билээ. Иранд манай номыг эрхлэн гаргадаг хүмүүс надад: “Та манай улс дахь хамгийн алдартай Христчин зохиолч” гэж хэлсэн юм. (Үүнийг бичиж байхад миний долоон ном Иран улсын албан ёсны хэл - Фарси хэл дээр орчуулагдаад байна) Ийм мэдээ газар бүрээс ирсээр л байна. Гэхдээ хамгийн гол нь “Энэ бол нигүүлсэл!” гэдгийг л би хэлэх гэсэн юм.

Би тантай нэгэн мөрөөдлөө хуваалцмаар байна: Би ахлах сургуулийнхаа Англи хэлний багш нартай уулзаад, Бурханы нигүүлслээр бичсэн арван таван номоо уншуулж, ухаан

алдуулж унагаад, дараа нь сэргээгээд Христ рүү дагуулмаар байдаг. Энэ үр жимсээрээ би багш нарынхаа нүдэнд онцгойрч, Эзэн Есүс Христийнхээ гайхамшигт нигүүлслийг тодоос тод гэрчилнэ!

Иймээс л Паул “Бурханы нигүүлслээр би одоогийн би болсон” (1Коринт 15:10) хэмээн зоригтой мэдэгдсэн юм. Эрхэм уншигч та, намайг одоо анхааралтай сонсоно уу: Та төрүүлсэн аав ээж, өссөн ахуй орчин, яс үндэс, хүйс, эзэмшсэн боловсролынхоо ачаар өдий зэрэгт хүрээгүй юм шүү. Өнөөдөр та Бурханы нигүүлслээр л өдий зэрэгт хүрсэн!

Би бас залуу байхдаа хэл яриандаа таг байлаа. Лиза надтай гэрлэхээд, анх миний номлолыг арван минут сонсоод л унтчихаж билээ. Зэрэгцээд сууж байсан дотны найз Эми нь шүлсээ асгартал бөх унтаж байсныг би одоо ч санадаг. Тэр хоёр намайг номлож дуустал сэрээгүй юм.

Хэдэн жилийн өмнө Лиза миний 1984 оны бичлэгийг олоод тоглуулсан юм. Хэдхэн секунд явуулаад л би: “Лиза, наадахаа хая!” гэж орилсон юм. Гэтэл Лиза тэр бичлэгийг аваад, хоёр гараараа атган цээжиндээ наагаад: “Яалаа гэж хаяхав! Чамайг барьцаалах баримттай боллоо!” хэмээн тас тас хөхөрч билээ.

Өнөөдөр миний бие дэлхийн том том тайзан дээр тав, арав, хорин мянган хүний өмнө номлож байгаа минь гагцхүү Бурханы нигүүлсэл юм. Надаас хүмүүс: “Та заахаасаа өмнө айдаг уу?” гэж асуудаг.

Би өөдөөс нь: “Үгүй ээ, айдаггүй!” гэж хариулдаг.

Тэд үүнийг дуулаад: “Яаж ийм олон хүний өмнө гараад сандардаггүй байна аа?” гэж ирээд л гайхдаг.

Хариуд нь би инээгээд: “Би хэл яриандаа таг хүн. Бурхан нигүүлслээ үзүүлэхгүй л бол, би дуусаа! Гэхдээ Бурханы нигүүлсэл намайг хэзээ ч хөсөрдүүлдэггүй, дандаа хамт байдаг!” гэж хэлдэг юм.

Тиймээс л 1Коринт 1:26 дээр Паул “Ах дүү нар аа, та нар дуудлагаа санагтун. Тэгэхэд махбод талаасаа мэргэн хүн олонгүй, хүчирхэг хүмүүс олонгүй, язгууртнууд ч олонгүй байлаа” гэж хэлсэн юм. Яагаад? Яагаад гэвэл ухаантай, хүчтэй, язгууртан хүмүүс нигүүлсэлд биш, өөрийнхөө чадварт найддаг.

Паул эхлээд яг тийм цэц ухаантай, язгууртны нэг байжээ. Филиппой 3:4 дээр тэрбээр “Гэсэн ч би махбодод түшиглэж болох юм. Хэн нэгэн нь махбодод түшиглэх гэдэг бол би бүр ч илүү” хэмээн хүлээн зөвшөөрсөн байдаг. Гэхдээ Паул нигүүлсэлд найдахыг сонгосон юм. Филиппой 3:7 дээр: “Гэвч миний хувьд ололт байсан болгоныг би Христийн төлөө хохирол болгон тооцов” гэжээ. Яагаад Паул тэрхүү хүний ололт амжилтаа хэрэгцээгүйд тооцсон бэ? Яагаад гэвэл Паул “Түүнийг болон амилалтынх нь хүчийг... таньж мэдэхийн төлөө” (10-ришлэл) төрөлх чадвар дотроо бус, харинамилалтын хязгааргүй хүч дотор амьдрахыг хүсчээ. Энэ нь Паул гэдсээ илээд хэвтэж байсан гэсэн үг биш юм. Паул өөрийнхөө талаас хийх ёстой зүйлээ хийж, хичээнгүй суралцаж, Бурханы бүхий л хүсэл, цэц ухаан, сүнслэг ойлголтоор дүүрэхийн төлөө чин зүрхнээсээ залбирдаг байжээ. Паул өөрийнхөө талаас хийх ёстой бүхнээ хичээнгүйлэн хийсэн шиг бид ч бас хийх ёстой. Гэхдээ Паул төрөлх чадвараа тэнгэрлэг хүчний талбарт амилуулахын тулд Бурханаас нигүүлслийг нь хүсдэг байжээ.

Хэрэв та оюутан бол, шамдан суралцахынхаа сацуу өөрийн ойлголтоор олж чадахгүй сэтгэлгээ, ололт амжилт өөд ахихын төлөө Бурханы нигүүлсэлд найдах хэрэгтэй. Хэрэв та эмч бол, орчин үеийн анагаахын хөгжилтэй хөл зэрэгцүүлэв ч, төрөлх чадвар, боловсролдоо найдаж болохгүй. Та мэдлэгийн үзүүрээс халин, цаашаа явахын төлөө Бурханы нигүүлслийн ер бусын цэц ухаан, бүтээлч чанарт найдах ёстой. Та тамирчин бол бэлтгэл сургуулиа уйгагүй, хичээнгүй хийнгээ үл итгэгч тамирчдаас онцгойрохын тулд бүх итгэл найдвараа Бурханы нигүүлсэлд тавь.

Бидний хайртай Бүтээгч Бурхан маань биднийг энэ дэлхий дээр сураггүй байхад, амьдралыг маань ном болгож бичсэн тухай ярьсныг санаж байна уу? Дуулал 139:6 дээр “Төрхөө олоогүй хөврөл байхад минь Таны нүд харж л байсан. Надад тогтоогдсон өдрүүд болоогүй байхад Бүгд номд тань бичигдсэн байжээ” хэмээн Давид бишрэн магтсан байхыг ч бид үзсэн.

Би танд намтрыг чинь ярьж өгье. Бурханы бичсэн намтрыг хүний чадвараар гүйцэлдүүлж чадах ч үгүй, боломж ч үгүй.

Бурхан танд зориулж хүнийхээ хүчээр биелүүлчих боломжтой намтар бичсэн бол, Тэрбээр алдраа тантай хуваалцах ёстой болно. Харин Бурхан ингэдэггүй! Үүнийгээ ч Исаиа 42:8 дээр тодорхой айлдсан: “Би ЭЗЭН. Нэр минь Тэр билээ. Би алдраа бусдад, магтаалаа сийлмэл хөргүүдэд өгөхгүй.” Тиймээс Бурхан таныг Өөрийнхөө нигүүлсэлд найдуулахын тулд хүний чадвараас хол давсан намтар бичиж өгчээ. Ийнхүү бүх алдар нь гагцхүү Бурханд л очно.

Гэтэл бодит байдал дээр Америк итгэгчдийн хоёрхон хувь нь л өөрсдийг нь энэхүү урьдаас бичигдсэн намтраа биелүүлэх чадвартай болгодог нигүүлслийн хүчийг мэддэг ажээ. Харин 98 хувь нь өөрийнхөө хүчээр дуудлагаа биелүүлэх гэж зүтгэвч, харамсалтай нь чадахгүй. Магадгүй иймээс л бид нийгэмдээ дорвитой нөлөөлж чаддаггүй байх.

НЭВТРЭХ ЭРХ

Үнэ төлбөргүй бэлэг!

Бурханы нигүүлслийг та хүний хүчин зүтгэл, гавьяа буянаар хүртэхгүй. Нигүүлслийг зөвхөн итгэлээр хүлээж авдгийг Паул батлан хэлсэн: “Нигүүлслийн учир итгэлээрээ аврагдсан нь та нараас бус, харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр чинь биш тул хэн ч үл сайрхах болно” (Ефес 2:8-9). Паул Ромын итгэгчдэд хандан: “Мөн дотор нь зогсдог энэхүү нигүүлсэл уруу бид Түүгээр дамжин итгэлээр орох боломжтой болсон бөгөөд бид Бурханы алдрын найдварт баярладаг” гэжээ (Ром 5:2). Тэгэхээр нигүүлслийг хуруу хумсаа хуйхлатал ажиллаж, өөгүй сайхан амьдарч, өдөрт хоёр цаг залбирч, сард хоёр удаа мацаг барьж байж хүлээж авдаггүй ажээ. Нигүүлсэлд зөвхөн итгэлээр л нэвтэрнэ!

Тэгвэл бид яагаад ийм амархан юмд итгэдэггүй вэ? Ингэж үзье л дээ. Танай цэвэр усны нөөц дуусвал жинхэнэ асуудал дэгдэнэ. Цэвэр ус байхгүй бол гэрийнхэн чинь хэдхэн өдрийн дотор л үхнэ. Гэтэл танай гудмын доох нь сая сая тонн цэвэр усны нөөцтэй хотын цэвэр усны сан байдаг бөгөөд нэг гол

хоолой нь танай гэрийн урдуур явдаг ажээ. Ийм нөхцөлд та яах уу? Та хотын захиргаан дээр очоод зөвшөөрөл аваад, барилгын дэлгүүрээс сангийн хоолой худалдаж аваад, гэртээ ирээд, гэрийнхээ сангийн хоолойг хотын цэвэр усны сангийн гол хоолойтой холбоно. Ийнхүү танай гэр хотын цэвэр усны сая сая тонн уснаас хүссэнээрээ хүртэх эрхтэй болно. Тэгэхээр итгэл нь нигүүлслийн хоолой юм. Одоо бүгдээрээ яг энэ ойлголтоороо Ром 5:2-ыг уншиж үзье: “Бид итгэлийн хоолойгоор хэрэгцээтэй бүх нигүүлслийнхээ уснаас хүртэнэ.” Тиймээс л Еврей номын бичээч: “Учир нь сайн мэдээ бидэнд тунхаглагдсны адил тэдэнд ч бас тунхаглагдсан. Гэтэл тэдний сонссон үг нь тэдэнд тус болсонгүй. Яагаад гэвэл сонсогчдын дотор үг нь итгэлээр холбогдоогүй ажээ” (Еврей 4:2) гэж хэлсэн юм.

Бичээч энд Бурханы амлалтын өвлөгчид болох Абрахамын үр удмын тухай ярьжээ. Зүйрлэх юм бол, тэнгэрийн бүх хүч, хангамж нь тэдний гэр, майхны урдуур урсаж байтал, тэд Үгийн амлалтын сантай “итгэлийн хоолойгоор” холбогдоогүй учраас Бурханы үнэ төлбөргүй зүгээр өгсөн хангамжийг эдлэж хэрэглэж чадаагүй юм.

Яг үүнтэй адилхан нигүүсэл нь биднийг төрөлх чадвараасаа давж гаран, гайхамшгийг үйлдэж, харанхуй ертөнцийг гэрэлтүүлэх чадвартай болгодог Бурханы үнэ төлбөргүй хүч гэдгийг Америк итгэгчдийн хоёр хүрэхтэй үгүйтэй хувь нь л мэдэж байхад, яаж ч чуулган бүхлээрээ итгэж, хөдлөх билээ? Паул: “Тэгвэл Түүнд итгээгүй тэд яаж Түүнийг дуудах вэ? Түүнийг сонсоогүй тэд яаж Түүнд итгэх вэ? Тэд тунхаглагчидгүйгээр яаж сонсох вэ?” (Ром 10:14) гэсэн бус уу?

Христэд итгэгчид
бид хүчирхэгжүүлэгч
нигүүлслийнхээ талаар хэлсэн

Бурханы үгийг тоохгүй байвал, үүнд яаж итгэх билээ? Бид мэдэхгүй зүйлдээ итгэж чадахгүй. Бурханы нигүүлсэлтэй итгэлийн хоолойгоор холбогдохгүйгээр Бурхан амлалтыг хүртэж чадахгүй.

■
**Бид мэдэхгүй
зүйлдээ итгэж
чадахгүй.**
■

Бидний энэ байдал Бурханы зүрхийг эмтэлдэг байх. Есүс биднийг Өөрийнхөө бүрэн дүүрэн амьдралын амьд гэрч болгож, Даниел, Иохан Баптист тэргүүтэй аугаа зарц нараасаа ч хол явуулахын төлөө аймшигтай өндөр төлөөс төлсөн. Гэтэл бид энэ аугаа үнэнийг нь тамын галаас сэргийлэх уучлалын даатгал төдийхнөөр ойлгож, дэмий цалгардуулсаар. Хэдийгээр энэ бүхэн нь үнэн боловч, хамгийн гол нь бид яг өнөөдөр, яг энэ амьдралдаа Бурханы нигүүлслийн хүчийг тунхаглаж, хэрэгжүүлэхээ мартсанд л бидний гол алдаа оршино. Тиймээс л бид энэ харанхуй дэлхий дээр Бурханы ажлыг хийж, Бурханы алдрын төлөө мятрашгүй амьдарч чадахгүй байгаа юм.

Есүсийн дагалдагч нар эцэстээ: “Бид Бурханы ажлыг гүйцэтгэхийн тулд юу хийх ёстой вэ?” гэж хашхиралдсан байдаг (Иохан 6:28). Тэд гонсойсон. Тэд зовж зүдэрч байгаа хүмүүст Бурханы чадвараар туслахыг хүссэн. Есүс тэднийг Өөрийг нь үлгэрлэн дагаарай гэсэн. Тиймээс тэд цөхрөнгөө бараад: “Бид яаж Тан шиг үйлдэх юм бэ?” гэж хашхиралджээ. Тэгтэл Есүс юу гэж хариулсан гээч? Есүс тэдэнд “Итгэлтэй бай” (Иохан 6:29) гэсэн.

Тийм ээ. Итгэл! Зүгээр л Бурханы “нигүүлслийн үгд итгэх” нь үүнийг хэрэгжүүлэх ганц арга юм. Паул Ефесийн итгэгчдийг яг л ингэж урамшуулсан: “Эдүгээ та нарыг босгон, ариусгагдсан бүхний дунд өв өгөх чадалтай Бурханд ба Түүний нигүүлслийн үгэнд би та нарыг даатгаж байна” (Үйлс 20:32).

Паулын явах цаг ирсэн учраас энэ бол түүний хайртай хүмүүстээ хандсан сүүлийн үг гэдгийг тэрбээр мэдэж байв. Энэ үед хүн хамгийн чухал үгээ л хэлнэ. Тиймээс Паул хайртай хүмүүсээ Бурханд төдийгүй, Бурханы “нигүүлслийн үгд” даатгажээ.

Өнөөдөр Христэд итгэгчид гэнэн цагаанаар өөр хоорондоо: “Бурханд итгээрэй”, “Бурхан байхад бүх юм болно”, “Бурханд улам ойртоорой” гэж ярьцгаадаг. Энэ зөвлөгөө нь хэдийгээр хүмүүсийг зөв чиглүүлж байгаа ч, арай л дутуу дулимаг юм. Паул итгэл нэгт нөхдөө Бурханд төдийгүй, “Бурханы нигүүлслийн үгд” даатгажээ. Бурханы нигүүлсэл биднийг босгон байгуулж, бидэнд өвлөж авах өв өгдөг. Таны өв юу вэ?

Энэ бол таныг төрөхөөс ч өмнө Бурханы бичсэн намтар юм.

Нигүүлслийн талаарх энэхүү дутуу дулимаг сургаалаас болж, үй олон итгэгчид (нарийндаа 98 хувь нь) “хангалттай сайн залбирсан, мацаг барьсан, хичээнгүй үйлчилсэн, ариун амьдарсан хүмүүс л Бурханы ер бусын хүчийг хүртэнэ” гэж бодох болжээ. Тэгвэл би танаас асууя - яг ямар хэмжээг хангалтайд тооцох вэ? Яг энэ асуудлаар Паул Галатын итгэгчидтэй нүүрэлдсэн байдаг:

... та нарыг Сүнсээр хангаж, та нарын дунд гайхамшгийг үйлддэг Тэрээр үүнийг хуулийн үйлсээр үйлддэг үү эсвэл сонссондоо итгэснээр чинь үйлддэг үү? (Галат 3:5)

“Хуулийн үйлс” нь хүний хүч чадал, хүчин зүтгэл дээр л төвлөрдөг учраас Бурхантай тогтоосон харилцааг маань юунд ч хүргэхгүй. Тэгэхээр Бурханы үнэ төлбөргүй өгсөн хүчирхэгжүүлэгч нигүүлслийг хүртэх гол хүчин зүйл нь Бурханы нигүүлсэлд итгэж, найдаж, хэрэгжүүлэх гэдгийг бид энэ бүлгээс сурлаа.

Яг л Есүст анх итгэхтэй л адил юм. Паул ингэж хэлжээ: “Та нар Сүнсийг хэрхэн хүлээн авсан юм бэ? Хуулийн үйлсээр үү? Эсвэл сонссондоо итгэснээр үү? Зөвхөн үүнийг л та нараас мэдэхийг би хүсэж байна” (Галат 3:2).

Та анх Есүст зүгээр л итгэж нигүүлслээр аврагдсан шигээ л цаашид нигүүлслээр амьдарч, нөлөөллийнхөө ертөнцөд гайхамшгийг үйлдэнэ.

ЧИВАВА ЮУ, ХҮРЭН БААВГАЙ ЮУ?

Тэгэхээр 3-р бүлэгт асуусан асуултаа дахин асууя. Бидэнд итгэл, замналдаа мятрашгүй байх хүч, чадвар байна уу? Бид чивава юу, хүрэн баавгай юу?

Сая сурсан зүйлсээ тунгаан бодсоныхоо эцэст та өөрийгөө хүрэн баавгай гэдгээ итгэл төгс батлана гэдэгт найдаж байна. Энэ итгэлээ толгойдоо ч, цээжиндээ ч тээгээд, мятрашгүй амьдралын талаар цаашаа сурцгаая!

6

ҮЗЭХ ҮҮ ЭСВЭЛ ОРОХ УУ?

... нигүүлслийн баялгийг болон зөвт байдлын бэлгийн
дүүрэн хүртэгсэд нь Есүс Христ гэгч ганц
Хүнээр дамжин амь дор ноёрхоно.

Ром 5:17

Би таныг Иохан 3:16 - г цээжээр хэлдэг шигээ Ром 5:17-
г ч бас цээжээр мэддэг болтол чинь давтмаар байна.
Тийнхүү та Бурхан таныг энэ амьдралд захируулахаар
төрүүлсэн гэдгийг яс махнаасаа мэддэг болж, нойрондоо ч
хүртэл тунхаглаж чаддаг болно. Ийм бат бөх итгэлтэй хүн л
мятрашгүй итгэгч буюу “ялагч” болно.

Цаашаа явахаасаа өмнө судлаж байгаа гол үнэнээ дахин
давтаж хэлмээр байна: Бурханы нигүүлслийг үнэ төлбөргүй
зүгээр хүлээж авсан хүн бүр энэ амьдралд захирах хүчтэй.
Бид сүүл биш толгой, нөхцөл байдлынхаа доор биш дээр
байна. Бид Бурханы арга замыг газар дээр буулгадаг, үлгэрлэн
харуулж, нөлөөлдөг хүмүүс байхаар төрсөн.

ТЭГВЭЛ ЯАГААД ИХЭНХ ИТГЭГЧИД АМЬДРАЛЫГ ЗАХИРДАГГҮЙ ВЭ?

Яагаад итгэгчид ингэж амьдарч чадахгүй байна? Яагаад дийлэнх олон нь амьдралыг захирах биш, амьдралд захирагддаг вэ?

Бид үүний хамгийн гол учир шалтгааныг үзсэн. Тухайлбал Америк итгэгчдийн 98 хувь нь Бурханы нигүүлсэл бол Бурханы хүч гэдгийг огт мэддэггүйг 2009 оны үндэсний судалгаа харуулсан. Энэ судалгаа нь Америкийн төдийгүй Барууны чуулганы ч ерөнхий дүр байдлыг харуулж байгаа гэдэгт би эргэлзэхгүй. Нигүүлслээр дамжиж ирдэг Бурханы ер бусын хүчийг мэдэхгүй, хүртэж чадахгүй учраас дийлэнх итгэгчид Бурханы хүссэнээр амьдарч чаддаггүй. Тэд хүчирхэг Лэнд Ровертой атлаа үүнийгээ унаж ч чаддаггүй, хэрэглэж ч мэддэггүй Африк омгийнхон шиг явган гүйсээр, ачаагаа үүрсээр явдаг.

Харин одоо бүгдээрээ итгэгчдийн амьдралд захирч чадахгүй байгаагийн хоёр дахь гол шалтгааныг үзнэ. Бүгдээрээ Эзэнтэй уулзахаар нууцаар ирсэн Иүдей удирдагч Никодемд хэлсэн Есүсийн үгийг үзье:

“Үнэнээр үнэнээр Би чамд хэлье. Хэн дээрээс эс төрнө, тэр Бурханы хаанчлалыг үзэж үл чадна.” (Иохан 3:3)

Есүс Никодемд хаанчлалыг үзэх тухай хэлжээ. Тэгснээ дараа нь Есүс тэс өөр зүйлийн тухай ярьдаг: “Үнэнээр үнэнээр Би чамд хэлье. Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр Бурханы хаанчлалд орж үл чадна” (Иохан 3:5). Есүс яагаад ярианыхаа голыг хаанчлалыг үзэхээс (3-р ишлэл) хаанчлалд орох руу (5-р ишлэл) шилжүүлэв? Бид дан Англи хэлнийхээ мэдлэгээр Библийг хөрвүүлэх гэж оролдохдоо, тухайн агуулгын жинхэнэ утга санааг гээх тохиолдол гардаг. Тиймээс тухайн хэсгийг эх хэлээс нь харбал, нарийн утга санааг нь ойлгож болно.

Есүс Бурханы хаанчлалын талаар ярихдаа, үнэндээ “Бурханы захиргааны” тухай өгүүлжээ. Сайн мэдээнд Бурханы хаанчлалыг базилеиа тоу Теос гэсэн Грек нэрээр голчлон ярьдаг. Теос нь Бурханыг хэлж байгаа бол, базилеиа нь “хаанчлал, захиргаа,

ээгнэл” гэсэн утгатай юм. Басилеиа нь “суурь” буюу “бааз” гэсэн язгуураас үүсэлтэй үг ажээ. Зарим эртэмдэд басилеиа тоу Теос гэдгийг “Бурханы эзэнт захиргаа” юмуу “Бурханы ноёрхол” гэвэл оновчтой болно гэдэг. Би эзэнт гэдэг үг дуртай. Эзэнт гэдэг нь “хэмжээлшгүй хүчийг” илэрхийлдэг.

Жишээлбэл Есүс бидэнд хэрхэн залбирахыг зааж өгөхдөө: “Аав аа, Таны нэр ариунаар дуурсагдах болтугай. Таны хаанчлал иртүгэй. Хүсэл тань тэнгэрт шигээ газар дээр биелэгдэх болтугай” (Лук 11:2) гэсэн. Есүс яг л: “Тэнгэрт байгаа бидний Аав аа, Та бол Аугаа хүчирхэг Бурхан. Таны хэмжээлшгүй хүчит, хүчирхэг захиргаа ирэх болтугай. Таны хүсэл тэнгэрт биелдэг шигээ газар дээр биелнэ” гэж хэлжээ. Гэхдээ гол асуудал нь олон хүмүүс үүнийг зөвхөн ирээдүй цаг дээр ойлгодог. Гэтэл үнэндээ Бурханы хаанчлал хэдийнээ ирчихсэн! Биет байдлаар ирээгүй ч, Сатаны нөлөө зайлуулагдаж, Есүс мөнхийн мөнхөд захирч эхлэхийн цагт Бурханы хаанчлал ирнэ гэдгийг Исаиа зөгнөсөн буюу. Бурханы хаанчлал нь хэдийнээ сүнслэг байдлаар ирчихсэн юм. Энэ нь Бурханы гэрээний хүмүүс болох бидний дотор байна. Учир нь Бурханы хаанчлал хэзээ ирэхийг асуусан фарисайчуудад Есүс “—Бурханы хаанчлал ажиглагдахуйцаар ирэхгүй. Хэн ч “Хараач, тэнд байна” гэх юмуу эсвэл “Хараач, энд байна” гэж хэлэхгүй. Харагтун, Бурханы хаанчлал нь та нарын дунд байна” (Лук 17:20-21) хэмээн айлдсан юм.

Калвари толгод дээрх Есүсийн үйлсийн ачаар өдгөө Бурханы хаанчлал нь Христийн дагалдагч бүрийн дотор оршиж байна. Бид хаашаа ч явсан, хаана ч байсан энэ ноёрхлыг түгээн дэлгэрүүлэх ёстой. Бид Есүс Христээр дамжин бидэнд үнэ төлбөргүй, зүгээр өгөгдсөн Бурханы нигүүлслийн хүчирхэг бэлэгээр дамжин амьдралд захирах ёстой.

Бүгдээрээ Есүсийн “Бурханы хаанчлал” гэсэн үг бүрийг “Бурханы хэмжээлшгүй хүчит захиргаа” гэдэг үгээр орлуулж уншъя. Ингэмэгц тэр үг нь өнөөгийн бидний хувьд илүү утга төгөлдөр, ач холбогдолтой болж ирэхийг хараад та гайхна даа.

Жишээлбэл Матай 12:28 дээрх Есүсийн үг нь: “Тэвч Би Бурханы Сүнсээр чөтгөрүүдийг зайлуулсан. Тиймд Бурханы

хэмжээлшгүй хүчит захиргаа та нарт ирчихээд байна” гэж уншигдана. Есүс Бурханы Гурвалын нэг гишүүн, бидэнд буй Бурханы нигүүлслийг (хүчийг) хангадаг Ариун Сүнсийг Бурханы Сүнс гэжээ. Түүнийг Шинэ гэрээнд “нигүүлслийн Сүнс” гэдэг (Еврей 10:29 - ийг үзнэ үү).

Матай 19:24 дээр Есүс мөн л: “Би та нарт дахин хэлье. Баян хүн Бурханы хэмжээлшгүй хүчит захиргаанд орохоос тэмээ тэвнийн сүвэгчээр нэвтрэх нь илүү хялбар” гэдэг.

Нэгэн баян хүн “Надад амжилтанд хүрэх бүхий л чадвар чадавхи, хүчин чадал нь бий” хэмээн сайрхжээ. Тэрбээр мэдлэг оюун, санхүү, биеийн хүч, хурц ухаан, холбоо харилцаа, эх үүсвэрийнхээ улмаас өөртөө итгэл төгс байв. Гэтэл Есүс түүнийг нэвтлэн харжээ. “Ядуус та нар ерөөлтэй еэ! Бурханы хэмжээлшгүй хүчит захиргаа та нарынх юм” (Лук 6:20).

Есүс санхүүгээр ядуу хүмүүсийн тухай биш, харин Бурханы нигүүлсэлд найддаг хүмүүсийн тухай ярьжээ. Есүс Өөрийнхөө талаар ярихдаа, Түүнд ядууст сайн мэдээг номлох Бурханы Сүнс байна хэмээн мэдэгдсэн байдаг. Гэхдээ Есүс хэзээд зорьж очсон газрынхаа бэл бэнчинтэй хүмүүстэй зориуд уулздаг байсан юм. Нөгөө зүүний сүвэгчинд багтдаггүй тэмээний тухай яриа ч Бурханд итгэхийг бус, эд мөнгөндөө найдахыг сонгосон баян залуу захирагчтай өрнөсөн ярианы дараа болдог.

Бурханы хаанчлалын талаар хэлсэн Есүсийн өөр нэгэн үгийг авч үзье: “Бурханы хэмжээлшгүй хүчит захиргааны нууц та нарт өгөгдсөн. Харин гадна байгсдад бүх юмс сургаалт зүйрлэлээр ирдэг” (Марк 4:11). Бурханы нигүүлслээр бидэнд олдсон эрх мэдэл, хүч нь гагцхүү Ариун Сүнсээр л илчлэгддэг тамгалагдсан нууц юм. Гэтэл “Нүд үзээгүй, чих сонсоогүй, Хүний зүрх сэтгэлд ороогүй юмсыг Бурхан Өөрийг нь хайрладаг хүмүүст бэлджээ” гэсэн үг ёсоор болж, үүнийг Бурхан бидэнд Сүнсээрээ илчилжээ. Учир нь Сүнс бүх юмсыг - тэр бүү хэл Бурханы гүн юмсыг ч гэсэн нягтладаг ажгуу (1Коринт 2:9-10). Та бидэн Бурханы нигүүлслээр дамжин амьдралд захирна гэдэг үнэнийг Ариун Сүнс бидэнд элч нараараа дамжуулан илчилж өгөх хүртэл нь энэ нь нууцлагдсан байжээ. Харин одоо бид үүнийг хэрэгжүүлэхийн тулд итгэхэд л болно.

Марк 9:1 дээр Есүс Бурханы хаанчлалын талаар өөр нэгэн баталгаа өгээ: “Үнэнээр Би та нарт хэлье. Энд зогсогсдын зарим нь, Бурханы хэмжээлшгүй хүчит захиргаа сүр хүчтэй ирэхийг үзэх хүртлээ үхлийг амсахгүй.” Аврагчийн энэхүү мэдэгдэл нь Бурханы хаанчлал нь ирээдүйд ч ирнэ, одоо ч энд ирчихсэн гэдгийг батлаж байна. Бурханы хэмжээлшгүй хүчит захиргаа нь Пентекост өдөр нигүүлслийн Сүнс ирсэн цагаас Есүсийн дагалдагч бүрийн дотор ирдэг болсон юм. Есүс Өөрт нь тун ухаалаг хариулсан бичээчид: “Чи Бурханы хэмжээлшгүй хүчит захиргаанаас холгүй байна” гэж хариулсан байдаг (Марк 12:34).

Эх Грек хэлээс нь үзбэл, Бурханы хаанчлал нь хавьгүй ач холбогдолтой, хүчтэй тусч байгааг дээрх хэдэн жишээнээс та харсан болов уу гэж найдаж байна. Шинэ гэрээн дээр Бурханы хаанчлал гэдэг үгийг унших бүрийдээ Бурханы хэмжээлшгүй хүчит захиргаа гэж ойлгобол, энэ ойлголт танд хавьгүй жинтэй бууна.

Гэхдээ бид Бурханы хэмжээлшгүй хүчит захиргааны талаарх маш чухал нэгэн зүйлийг мартаж болохгүй. Бурхан тэр захиргаагаа бидэнд даалгасан! “Тэнгэрс бол ЭЗЭНий тэнгэрс, Харин дэлхийг Тэрээр хүний хөвгүүдэд өгчээ (Дуулал 115:16). Адамын хөсөрдүүлсэн зүйлийг Хүний Хүү Есүс эргүүлж аваад: “Тэнгэр газар дахь бүх эрх мэдэл (захирах бүх хүч) Надад өгөгдсөн” (Матай 28:18) хэмээн тунхаглажээ. Гэхдээ Эзэн маань одоо газар дээр байхгүй учраас, Христийн бие болох та бид хоёр Бурханы хэмжээлшгүй хүчит захиргааг хэрэгжүүлэх үүрэгтэй юм. Бид хэрэгжүүлж чадахгүй бол, энэ захиргаа маань дэлхийн хүчний талбартаа үлдэж, харин бид амьдралд захирагдана. Бурхан ийм юм төлөвлөөгүй! Бид Христээр дамжин амьдралд захирахаар нигүүлслээр хүчирхэгжсэн хүмүүс билээ.

ҮЗЭХ БА ОРОХ

Одоо Никодемд хандсан Есүсийн үгийг үргэлжлүүлэн үзье. Эзэн эхлээд “Үнэнээр үнэнээр Би чамд хэлье. Хэн дээрээс эс төрнө, тэр Бурханы хаанчлалыг үзэж үл чадна” (Иохан 3:3)

гэж хэлснээ, араас нь “Үнэнээр үнэнээр Би чамд хэлье. Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр Бурханы хаанчлалд орж үл чадна” (Иохан 3:5) гэжээ.

Есүс яагаад хаанчлалд орохыг хаанчлалыг харахаас ялгаж өгснийг ойлгоход Бурханы хаанчлалын талаарх Грек хэлний судалгаа маань тус болох байх. Хэрэв бид Бурханы хаанчлалыг тэнгэр шиг биет газар гэж үзбэл, 3-р ишлэлд дахин төрсөн хүн тэнгэрт орох биш, зөвхөн харж чадна гэж байгаа юм шиг харагдана. Гэхдээ үнэндээ тийм биш юм. Есүс Бурханы хэмжээлшгүй хүчит захиргаа эсвэл хаант засаглалын тухай ярьж байгааг ойлговол, эдгээр ишлэл нь тэс өөр утга илэрхийлж, хялбархан ойлгогдоно.

Үзэх гэдгийг Грекээр эйдо гэжээ. “Харах, хүлээж авах, ухаарах, таньж мэдэх” гэсэн утгатай. Есүс үндсэндээ дахин төрсөн хүн нь Бурханы хэмжээлшгүй хүчит засаглалтай хаанчлалыг харж, хүлээн авч, ухаарч, таньж мэдэж чадна гэдгийг л хэлжээ.

Үүнийхээ дараа Есүс Бурханы захиргааны тухай өгүүлэхдээ эйдо буюу үзэх гэдэг үгийг хэрэглэлгүй, харин орох гэсэн утгатай эйсеркоммай гэдэг Грек үг хэрэглэжээ. Энэ нь “босоод, дотор нь орох” юмуу “босч орох” гэсэн утгатай. Тэгэхээр энэ хоёр мэдэгдлээрээ Есүс Бурханы хэмжээлшгүй хүчит захиргааг мэддэг байх мэдлэгийн хэмжээнээс босч дотогш орох үйлдлийн хэмжээнд хүртэл нүүдэл хийж байна. Ялгааг нь харж байна уу?

Тухайлбал би онгоцонд суухдаа онгоц газрын татах хүчийг сөрөн, хөөрөн нисч, намайг зорьсон газарт минь хүргэнэ гэдгийг мэддэг. Зорчигч хүнийхээ хувьд би онгоцоор нисэхийн ашиг тусыг мэддэг бас эдлэдэг.

Тэгтэл манай нэг найз намайг нисгэгчийн сургалтанд суулгалаа гэж бодъё. Ерөнхий мэдлэгтэй болмогц, багш намайг ганц мотортой онгоцонд суулгаж, юу хийхийг зааж өгөв. Тийнхүү би араагаа татан хөөрлөө. Ниснэ гэдэг үлгэрийн мэдрэмж. Ийнхүү би анх удаа нисэхдээ: “Одоо би энэ онгоцоор хүссэн зүгтээ хүрнэ. Замд ч баригдахгүй. Би өөрөө замаа гаргаад ниснэ” гэж бодно. Урьд нь би онгоцны хүчин чадлын

талаар зорчигчийн хэмжээнд мэддэг байсан бол, одоо өөрөө онгоцоо хүссэнээрээ жолоодож чаддаг болов. Би нислэгийн эрх чөлөөнд хөл тавин оржээ.

Есүсийн үгээс хоёр төрлийн итгэгч байдгийг мэдэж болно. Эхний бүлгийг нь онгоцонд суугаад, нисэхийн ашиг тусыг хардаг, хүлээж авдаг, эдлэдэг зорчигчидтой адилтгаж болно. Гэтэл нисгэгчийн бүхээгт явж ороод, ямар өндөр, хурдаар хаашаа нисэхийг шийдэн, нислэгийг гүйцэтгэдэг нисгэгч гэж байна. Зорчигчид хэдийгээр онгоцны ашиг тусыг хүртэж чадах ч, тэд яаж нисэхийг мэддэг нисгэгчийн эрхэнд л байна.

Бурханы хаанчлалыг үзэх хийгээд хаанчлалд орохын нарийн ялгааг тодорхой дүрслэн харуулахын тулд арал дээр амь гарсан хүмүүсээр жишээлж үзье. Тэр арал бол хүн иддэг зэрлэг махчин араатан, хорт могой, хилэнт аалз, хилэнцэт хорхойгоор дүүрэн аймшигт газар аж. Дээрээс нь тэнд хүний махаар хооллодог махчин омгийнхон ч байна. Тэгэхээр тэр амь гарсан хүмүүс маш хүнд байдалд оржээ. Гэхдээ удалгүй тэд маш сайхан мэдээтэй золгоно: тэд арал дээрээс банк дүүрэн шатахуунтай, нислэгийн зурвас дээр нисэхэд бэлэн зогсож байгаа онгоц олджээ. Тэр онгоц тэднийг бүгдийг нь зорьсон газарт нь аюулгүй хүргэж чадна. Гэхдээ нэг том асуудал тулгарав - тэдний дунд онгоц жолооддог хүн байхгүй! Бүгдээрээ л онгоцоор зорчиж явснаас биш, жолоодож мэдэхгүй. Тиймээс онгоц биднийг аюулгүй байдал, эрх чөлөөнд хүргэх хүчин чадалтай боловч, онгоцоо арлаас хөөргөх нь бүү хэл асааж ч мэдэхгүй бол, ямар ч ашиггүй болно.

Энэ дүрслэл нь Бурханы хэмжээлшгүй хүчит захиргааг зөвхөн нүдээр үзсэн юмуу мэдэрсэн итгэгчид хийгээд Бурханы хэмжээлшгүй хүчит захиргаа руу босоод орсон итгэгчдийн ялгааг харуулж байгаа юм.

Том ялгаа байгаа биз? Та аль төрөл нь баймаар байна?

ЗАХИРГААНД ОРОХ

Тэгэхээр мэдээж үүнээс үүдээд: “Тэгвэл Бурханы хүүхэд яаж Бурханы захиргааг үзэхээс Бурханы захиргаа руу орох вэ?”

гэдэг асуулт ургана. Өөрөөр хэлбэл бид яаж сүнслэг зорчигчоос сүнслэг нисгэгч болох вэ? Элч Паул яг үүнийг бидэнд хэлжээ.

Үйлс 13:1-4 дээр Паул, Барнаб хоёр Ариун Сүнсний заавраар төрөлх чуулганаа орхиод, элчийн анхныхаа аянд гарсан байдаг. Тэд урт удаан замыг туулан, Азийн олон хотоор аялаад, буцаад харих замдаа шинэ чуулган эхлүүлсэн газруудаа дахин эргэжээ. Тэр үед мэдээж аялна гэдэг асар явдалтай зүйл байв. Өнөөдөр би онгоцонд суугаад л, хорин дөрөвхөн цагийн дотор хүссэн газартаа хүрнэ. Би аль нэг газраас явахдаа “Аялна гэдэг амаргүй даваа болохоор, би энэ хүмүүсийг дахиж бараг тэнгэрт л харах байх даа” гэж боддоггүй. Гэтэл Паулын үед яг л тэгж бодмоор байжээ. Паул чуулгануудаа орхиж явахдаа, хаанчлалд төрүүлсэн тэдгээр хайртай хүмүүстэйгээ дахиж бараг газар дээр биш, тэнгэрт л уулзана гэдгийг мэддэг байв. Тиймээс Паул тэдгээр шинэ итгэгч нарт маш нарийн няхуур бодож байж, үгээ хэлдэг байжээ. Тэгээд түүний үг бидэнд яаж хаанчлалыг харахаас хаанчлалд орохыг зааж өгчээ.

Тэр хотод тэд сайн мэдээг тунхаглан, олон хүнийг дагалдагч болгоод Лустр, Икониум болон Антиох уруу буцахдаа дагалдагчдын сэтгэлийг хүчирхэгжүүлж, итгэлдээ байнга байгаарай гэж урамшуулан —Бид олон зовлон туулж байж Бурханы хаанчлалд орох ёстой гэлээ (Үйлс 14:21-22).

Паул тэр гурван хотод сүрхий сүрхий санхүүгийн семинар, чуулган өсгөх конференц, удирдлагын сургалт юмуу найдварын талаарх өөдрөг сургаал хийгээгүй. Мэдээж энэ бүх сэдэв нь бүгд Паулын сургаалд зохих байр сууриа яриангүй эзлэдэг байсан. Гэхдээ Паул тэдгээр шинэ итгэгчдийг мятрашгүйгээр амьдарч, сайн дуусгах үгээр хүчирхэгжүүлж өгөөд явжээ.

Паулын энэ үг өнөөдөр ч хүчин төгөлдөр байна. Бид энэ үгийг зүрх сэтгэлдээ сийлэх ёстой: Бурханы хаанчлалд орохын тулд бид олон зовлонг туулах ёстой. Надтай хамт байгаарай - учир нь энэ бол зовлонгийн үг биш, харин ч итгэл, найдварын үг юм. Ингэж бодъё: Гай зовлон ирдэг! Энэ бол зайлшгүй зүйл. Өөрийг нь дагадаг хүмүүсийн хувьд гай зовлон заавал байна гэдгийг

Есүс тодорхой хэлсэн: “Ертөнцөд та нар зовлонтой байна” гээд, “Тэхдээ зоригтой бай. Би ертөнцийг ялсан” (Иохан 16:33) гэжээ. Тэр ялчихсан учраас та бид хоёр энэ дэлхийгээс үсэрч ирсэн юуг ч ялан дийлэх эрх мэдэлтэй гэсэн үг юм. Бид бол Түүний бие, бид газар дээр буй Христ юм. Христийн дотор бид энэ дэлхийг ялсан!

Гай зовлон гэдэг үг нь “хүнд бэрх нөхцөл юмуу үлэмж их бэрхшээл” гэсэн утгатай юм. Үүнийг Грекээр тлипсис гэдэг. Тлипсис гэдэг үгийг Библийн үгийн нэвтэрхий тольд “Энэ нь дотоод болон гадаад дарамт шахалт үүсгэхүйц сэтгэл мэдрэмж, сүнслэг дарамт гэсэн ойлголт юм. Шинэ гэрээнд тлипсисийн тухай 55 удаа ярьснаас 53 удаад нь зүйрлэлээр илэрхийлсэн байдаг. Дайснаас дарамт шахалт ирж болох ч, дайсагналт нөхцөл байдал, буруу шийдэл, буруу шунал хүсэл нь адагтаа заавал алга болдог” хэмээн тайлбарлажээ.

Жэймс Стронг тлипсисийг (үгчилсэн болоод зүйрлэсэн утгаараа) “дарамт: золгүй байдал, шаналал, ачаа дарамт, хавчлага хяхалт, гай зовлон, бэрхшээл” гэж тодорхойлсон бол, Даблю. Ий. Вайн зүгээр л “бидний сэтгэл юмуу сүнсийг шаналган зовоож байгаа зүйл” гэж хэлжээ.

Харин би тлипсис буюу гай зовлонг хамгийн энгийнээр “цөл” гэж хэлнэ.

Орчин цагийн Библийн хувилбар дээр Үйлс 14:22-р ишлэлийг “Бурханы хаанчлалд орохын тулд бид олон бэрхшээл дундуур туулах ёстой” гэдэг. Үүнийг нэгэн жишээгээр дүрслэж үзье. Та нэгэн улсыг эзэлсэн аугаа хааны дайчин ажээ. Танай хаан тэр улсын нийслэл хотод нь нэвтрээд, хар санаат хааныг нь суудлаас авч хаяжээ. Хар санаат удирдагч ард түмнээ танай шударга үнэн хааны замаас гажуулахын төлөө харгислаж, худал суртал ухуулгаар тархийг нь бузарлаж, сайн сайхан бүхнийг эсрэг тухиран, саар муу бүхнээр цутгадаг байжээ.

Сайн хаан үнэнч дайчиддаа тэр улсын өнцөг булан бүрт ялалтын мэдээг түгээж, дайсны мэдэл дор байсаар байгаа нутаг дэвсгэр, цайз хэрмийг эзлэх тушаал өгнө. Учир нь хар санаат хааны зарим шадар туслахууд бууж өгөлгүй, цайз хэрэмдээ бүгсээр, хар санаат хааныхаа үйл хэргийг үргэлжлүүлсээр байгаа тул хар санаат хааны систем дор маш олон хүн үлдэж

хоцорчээ. Хэдийгээр манай тал ялалт байгуулсан ч, ялалтыг бүрэн тогтоохын тулд хийх ажил маш их үлджээ.

Тэгэхээр та бол дайсны мэдэлд байгаа цайз хэрмийг эзлэхээр явж буй дайчин юм. Замд чинь үй олон аюул тулгарна. Дайснууд таны даалгаврыг таслан зогсоохын тулд зам дээр чинь урхи занга тавина. Харин та энэ бүх бэрхшээлийг нэг нэгээр нь давсаар явна. Ингэж явсаар дайсны цайз хэрмийг устгах хамгийн гол, хэцүү даалгавартаа тулж ирнэ. Гэхдээ та замдаа дайсны урхи занга, тулаан, анги салааг ялсаар яваад асар их тулааны эрдэмтэй болжээ. Та дайсны цайзыг эзлэж чадбал, тэр газарт эрх мэдлээ тогтооно. Үүгээр барахгүй та эзэн хааныхаа төлөө тэр цайзыг эзэгнэн захирах итгэл даасан, чадварлаг удирдагч болно.

Энэ түүхийн сайн хаан нь Есүс Христ юм. Есүс биднийг үнэнч дайчдаараа томилон, энэ дэлхий дээр хорон ажлаа хийсээр байгаа харанхуйн хүчний дээр Өөрийнхөө ялалтыг тогтоолгохоор илгээжээ. Замдаа бид олон бэрхшээлтэй тулгаравч, эцсийн эцэст дайсны арга барил, арга зам, суртал ухуулгын хоригдол болсон эрчүүд, эмэгтэйчүүдийг чөлөөлөхдөө л нэг чөлөөлнө.

Энэ захиргаанд орохын тулд та бид хоёр олон гай зовлонг туулах ёстой. Гэхдээ Есүсийн хэлснээр, Эзэн маань дэлхийг ялсан учраас бид галтай цогтой байх ёстой. Бурханы нигүүлсэл биднийг энэ дэлхийн ямар ч сорилыг даваад гарах хүч, эрх мэдэлтэй болгосон юм.

Аврагч Эзэн Есүс Христэд итгэдэг бидэнд Бурханы нигүүлсийн хүч байгаа төдийгүй, мөн бид Бурханы нигүүсэл дотор маш чухал байр суурь эзэлдэг билээ. Ромын Христэд итгэгчдэд бичсэн Паулын үгийг баяртайгаар уншина уу:

Биднийг Бурханы хүүхдүүд гэдгийг Сүнс Өөрөө бидний сүнстэй хамт гэрчилдэг. Хэрэв бид хүүхдүүд нь юм бол, өв залгамжлагчид нь ч бас мөн. Христтэй хамт алдаршуулагдахын тулд хэрэв бид үнэхээр Түүнтэй хамт зовдог юм бол, бид Бурханы өв залгамжлагчид бөгөөд Христийн хамтран залгамжлагчид юм. Энэ цагийн зовлонгууд

бидэнд илчлэгдэх тэрхүү алдрын дэргэд юу ч биш гэж бид боддог. (Ром 8:16-18)

Итгэгч бид Бурханы өв залгамжлагчид мөн! Бид Бурханы өв залгамжлагчид, Есүс Христийн хамтран залгамжлагч. Өв залгамжлагч буюу клерономос гэдэг Грек үг нь “эзэмшил хүлээж авдаг эсвэл өвлөдөг нэгэн” гэсэн утгатай. Энд өв залгамжлагчийн зээмших эрхийг онцлосон байна. Миний толь бичигт өв залгамжлагчийг “өв залгамжлан авч байгаа бөгөөд эцэг өвгөөсөө хүлээж авсан өвөө үргэлжлүүлэгч хүн” гэж тайлбарлажээ. Түүнчлэн “хэн нэгнийг залгамжлах хууль ёсны эрхтэй хүн” гэж бас тодорхойлсон байна. Ёстой догь! Та үүнийг ойлгож байна уу? Бурхан биднийг Өөрийнхөө ололт амжилт, эзэмшил бүхнийхээ өв залгамжлагч болгожээ! Түүнд байгаа бүхэн биднийх юм. Тэр захирдаг шиг бид ч захирах ёстой.

■

**Тэгэхээр та бол
дайсны мэдэлд
байгаа цайз
хэрмийг эзлэхээр
явж буй дайчин юм.**

■

Бүх зүйл Бурханых учраас бүх зүйл биднийх юм. “Бүх юм та нарынх тул хэн ч хүмүүсээр бүү сайрхаг” (1Коринт 3:21). Бүх юм! Та бид хоёр жинхэнээсээ Бурханы өв залгамжлагчид! Орчин цагийн Англи Библи дээр “Дэлхий, амь, үхэл, одоо үе, ирээдүй - бүгд та нарынх юм. Бүгд та нарынх болсон” гэдэг. Энэ үгийг ганц хоёр өдөр тунгаан бод. Христийн дотор та бид хоёр энэ дэлхийн хамгийн баян хүнээс ч баян ажээ.

Гэхдээ нэг чухал сэрэмжлүүлэг байна аа. Ром 8 - ын дээрх хэсэгт хэрэв хэмээн маш тодорхой хэлснээс үзбэл, бидний өв залгамжлах эрх нь нөхцөл болзолтой ажээ. Өөрөөр хэлбэл тэр өв залгамжлалын эрх нь Христэд итгэдэг хүний гар дээр автоматаар ирдэггүй ажээ. Тэгвэл тэр болзол нь юу вэ? Бид Түүнтэй хамт зовох ёстой. Энэ хэсгийг дахиад уншина уу. Есүс Христтэй бодитоор хамтран захирахын тулд бид яг Есүс шиг Түүнд хамаатай бүхний замд тээглэсэн юмсыг угтаж очоод,

барьж аваад, ялан дийлэх ёстой. Түүнтэй хамт зовох гэдэг үгийг анхаарна уу. Дайснаа дарна гэдэг цэцэрлэгээр зугаалж, цэцгийн мандлаар бүжих явдал биш юм. Энэ бол дайн учраас дайныг зовлон дагадаг.

Гэхдээ бид ялах эсэхээ мэдэхгүй дайнд байлдаагүй. Ром 8:18 дээр Паул зовлонтой нүүр тулах нь найдвар дүүрэн, сайн зүйл хэмээн батлан хэлжээ:

“Энэ цагийн зовлонгууд бидэнд илчлэгдэх тэрхүү алдрын дэргэд юу ч биш гэж би боддог.” Та дараах зарчмыг сайн ойлгож аваад, насан турш сахиж амьдраарай: Танд ямар ч тлипсис ирсэн бай, энэ нь ялсны дараа таны хөл тавин орох захиргааны дэргэд юу ч биш юм.

Хэрэв бид зөв Христитгэлээр амьдарч байгаа л бол гарцаагүй зовно. Гэхдээ ялалт бүрийг даган, бидний дотор бүр аугаа алдар, хүч ирнэ. Паул хожим тэнгэрт шүүлтийн сэнтийн өмнө бидэнд бууж ирэх алдрын тухай яриагүй, харин энэ амьдралд ирэх ач тусын талаар ярьжээ. Бид гай зовлонг давж гарахдаа, хавьгүй өндөр төвшний бодит захиргаанд хөл тавин ордог.

ТҮҮНТЭЙ ХАМТ ЗОВОХ

Түүнтэй хамт зовох гэдэг үгийг харсан хүн Есүс яаж зовсон бэ? гэж асууна. Үүн дээр л олон хүн манардаг. Учир нь хоёр төрлийн зовлон бий. Нэг нь зөвт хүмүүст зориулагдсан зовлон бол, нөгөө нь дэлхийд зориулагдсан зовлон юм. Одоо үүнийг тайлбарлая.

Дэлхийн систем тэр чигээрээ ёрын муу нэгний дохио зангаагаар хөдөлж байгаа учраас дээрх хоёр төрлийн зовлонгийн хоёр дахь нь ирдэг (1Иохан 5:19). Үүнээс болж өдөр бүр хүмүүстэй муу ёрын, харгис юмс тохиолддог. Хүүхдийг хэвэлдээ байхад нь алж, нялх байхад нь хүчирхийлж, охидын биеийг борлуулж, өвчнөөр амиа алдаж, өлсгөлөн гуйланчлалд нэрвэгдэж, хэрүүл уруулаар салж сарниж, донтолтын боол болсоор үхэж үрэгдэж байгаа нь энэ хар жагсаалтын “дээжис” нь гэж хэлж болно. Энэ бүх зовлонд ширхэг ч сайн сайхан, ашигтай юм байхгүй. Эдгээр нь

аймшигтай, эмгэнэлтэй бөгөөд бүгд эрх мэдлээ ёрын муу эзэнд шилжүүлсэн Адамын нүглийн үр дагавар юм.

Харин одоо бүгдээрээ Паул, Петр хоёрын өгүүлсэн, зөвт хүмүүст тохиолддог эхний зовлон дээр төвлөрөн ярья. Зөвт хүмүүст ирдэг зовлонг Бурханы хүчээр давж чадсан тохиолдолд бидэнд алдар авчирч, захирах дуудлагыг маань бэхжүүлдэг бөгөөд өөрөөр хэлбэл асар их ашиг тустай юм.

Есүс үйлчилж байхдаа үүнийг л бидэнд харуулсан. Бид Түүнтэй хамт захирах гэж байгаа л бол, Түүнтэй хамт зовох хувьтай гэдгийг бүү мартаарай. Тэгвэл Есүс яаж зовсон бэ? Есүс гучин жил үйлчлэлд бэлтгэгдээд, Иордан голд Иоханаар баптисм хийлгэсэн.

Есүсийг баптисм хийлгэсний дараа тэнгэр нээгдэж, Ариун Сүнс Түүн дээр тагтаа мэт биетээр бууж ирсэн. Тэр үед Бурхан Аав нь тэнгэрээс бүгдэд сонсогдохоор: “Чи Миний тааллыг олсон Миний хайртай Хүү” (Лук 3:22) хэмээн айлдсан. Есүсийн тэнгэрийн энэ гайхамшигт батламжийг улс төрийн болоод засаг захиргааны удирдагч нар тэргүүтэй маш олон хүн гэрчлэн харсан байдаг.

Тэгэхээр хэрэв бид Есүс байсан бол “Миний цаг ирлээ! Яг одоо энэ олон түмний дунд анхныхаа номлолыг хэлдэг хэрэг. Энэ цагийн төлөө л бүтэн гучин жил бэлтгэгдлээ шүү дээ. Ер нь энэ үйл явдлыг ашиглаж чадах маркетинг, суртчилгааны баг хөлслөх хэрэгтэй байх. Энд байгаа хүмүүс бүгдээрээ л Намайг Бурханы Хүн гэдгийг мэддэг боллоо шүү дээ” гэх ухааны юм бодох байсан биз.

Энэ нь ч логиктой, ашигтай, ирээдүйтэй үйлдэл биз дээ? Гэтэл үүний оронд “Есүс Ариун Сүнсээр дүүрч Иорданаас буцаж цөлд Сүнсээр хөтлөгдөн, дөчин өдрийн турш диаволд соригджээ. Тэр өдрүүдэд юу ч идээгүй ба тэдгээрийг гүйцэхэд Тэрээр ихэд өлсжээ” (Лук 4:1-2). Олон итгэгчид Есүсийг цөлд

■

**Илүү аугаа ялалтын
төлөө биднийг
илүү хүчтэй
болгохын тулд
Бурхан биднийг
дасгалжуулдаг.**

■

өнгөрөөсөн дөч хоногийнхоо адаг дээр л соригдсон мэтээр боддогийг би мэднэ. Гэхдээ үгүй юм. Сайн мэдээ Есүсийн давсан гурван сорилтыг л онцлон бичсэнээс биш, Есүс бүтэн дөч хоногийн турш соригдсныг энд тодорхой хэлжээ.

Түүнийг хэн цөл рүү дагуулсныг хар даа. Диавол биш, харин Аав нь Ариун Сүнсээрээ дагуулан явжээ. Зарим нь Яахаараа Бурхан Хүүгээ зовлон, дайсагналтай тулгарна гэдгийг нь мэдсээр байж, цөл рүү дагуулдаг байна аа? гэж бодож болох юм. Гэхдээ нэг зүйлд баталгаатай байж болно - Бурхан бидэнд ялах хүчийг нь өгөлгүйгээр хэзээ ч шуурган дундуур дагуулахгүй. (Энэ зарчмын талаар би дараагийн бүлэгтээ ярина) Ямартаа ч Бурхан тлиписийн буюу гай зовлонгийн зохиогч биш гэдгийг мэдэхэд л болно. Бурхан биднийг нүгэлт дэлхийд аж төрж байгаа учраас дэлхийг байлдан дагуулж, захирахын тулд ёрын муу хүчний дайралтад өртөнө гэдгийг мэддэг. Тийм учраас, илүү аугаа ялалтын төлөө биднийг илүү хүчтэй болгохын тулд Бурхан биднийг дасгалжуулдаг.

Есүс баптисм хийлгэснийхээ дараа даруй Ариун Сүнсээр дүүрч цөл рүү яваад, дөч хоногийн турш тлиписистэй тулсан. Тэр бидний дунд нигүүлслээр дүүрэн хүн болж амьдрахын тулд бүхий л тэнгэрлэг эрх ямбаа тайлсан (Филиппой 2:7, Лук 2:40) гэдгийг бүү мартаарай. Тэр чөтгөрийн нэг ч сорилтод бууж өгөлгүй тулалдаад, дайсныг ялаад гарсан. Тэгээд дөч хоногийн дараа “Есүс Сүнсний хүч дотор Галилд буцаж ирэв. Түүний тухай зар эргэн тойрон дахь газар тархсан байжээ” (Лук 4:14).

Есүс цөл рүү явахдаа Бурханы Сүнсээр дүүрээд явсан бол, хүнд сорилтыг ялсныхаа дараа Сүнсний хүч дотор эргэж иржээ. Ром 8:18 дээрх Паулын үгийг санацгаая: “Энэ цагийн зовлонгууд бидэнд илчлэгдэх тэрхүү алдрын дэргэд юу ч биш гэж би боддог.” Есүс тлиписийг амжилттай давж гарсныхаа дараа захиргааны илүү өндөр төвшинд хөл тавин оржээ.

Энэ тухай элч Иаков “Сорилтыг тэсвэрлэдэг хүн ерөөлтэй е! Учир нь тэр шалгуулчихаад, Өөрийг нь хайрлагсдад Эзэний амласан амийн титмийг хүлээн авна” (Иаков 1:12) гэж хэлсэн байдаг.

Есүс цөлд дөч хоногийн сорилтоо ялж гарсан шиг, та ч бас ялж гарахдаа “амийн титмийг” хүлээж авна. Та “Тэр титмийг чинь хожим тэнгэрт шүүлтийн суудлын өмнө хүлээж авна биз дээ?”

гэж хэлэх гэж байна уу? Тийм ээ, тэр үнэн. Гэхдээ Иаков тэнгэрт авах бодит титмийн тухай яриагүй, харин одоо энэ амьдралдаа илүү өндөр төвшний захиргаанд хөл тавин орох тухай хэлсэн гэдэгт би итгэдэг. Титэм нь эрх мэдлийг илтгэдэг юм. Эрх мэдлийг юу дагадаг билээ? Хүч. Есүс цөл рүү дүүрээд явсан бол, ирэхдээ хүчтэй болоод ирсэн. Есүстэй хамт зовсон нөхцөлд л бид захирах хэмжээнд хүрнэ гэдгийг бүү мартаарай. Тиймээс бидний өөдөөс там тэр аяараа уяанаасаа тавигдан асч байсан ч, Бурханы үгийг мятрашгүйгээр даган, бууж өгөлгүйгээр ялж гарвал, бид тэр даруй ашиг тусыг нь хүртэж, ялалт байгуулсан талбартаа илүү өндөр эрх мэдлийг хүлээж авна.

ХАДАМ ЭЭЖИЙН МИНЬ ГЭРЧЛЭЛ

Энэ амлалтын амьд жишээ нь Манай Лизагийн ээж Ширли юм. 1979 онд өрхийн эмч нь Ширлид хөхний хорт хавдар туссаныг нь хэлжээ. Эрт оношилж чадаагүйн улмаас, хавдар нь тунгалагийн зангилаагаар нь тархчихсан байв. Тэгээд эмч хөхийг нь тунгалагийн зангилааных нь 30 хувьтай нь тайрч авсан ч, амьд гарах баталгаа өгч чадахгүй гэжээ.

Ширли оношоо баталгаажуулахын тулд хавдар судлалын талаар мэргэшсэн Америкийн хамгийн алдартай эмнэлгийн нэг болох Техасын Хьюстон хотын ЭмДи Эндерсоны эмнэлэгт ханджээ. Ширлиг үзсэн эмч нь тэр эмнэлгийн хавдар судлалын хэлтсийн тэргүүн байв. Гэтэл тэр эмч ч Ширлид таатай мэдээлэл өгсөнгүй. Тэрбээр эхний эмчтэй адилхан онош тавьсныхаа дараа: “Амьдрал хатуу юм аа” гэж хэлжээ. Тэгээд яг түүний хэлсэн эмчилгээг хийлгэх юм бол, дээд тал нь хоёр гурван жил л амьдарна гэжээ. Анагаахын шинжлэх ухаанд тэр хавдрыг эмчлэх арга байсангүй.

Тэгээд Ширлид туяаны эмчилгээ хийлгээд, дараа нь Индиана дахь гэртээ харьж хоёр гурван долоо хоног амраад, дахин Хьюстонд ирж химийн эмчилгээгээ үргэлжүүлэх заавар бичиж өгчээ.

Хьюстонд байхдаа Ширли залбируулахаар Америкийн нэгэн алдартай телевизийн үйлчлэлд ханджээ. Гэтэл тохиолдлоор дуудлагыг нь хүлээж авсан хүн нь ЭмДи

Эндерсоны эмнэлгийн амбулаторын тасгийг хариуцдаг гэр бүлийн хоёртой танил болж таарав. Тэгээд тэр хүн нөгөө хоёрт Ширлийг харж хандаж байхыг захижээ. Тэр хос ч Ширлитэй холбогдон цуглаанд, тэмцээнд, оройн зоогт дагуулж явахдаа байнга итгэл байгуулдаг Бурханы амлалт Үгийг ярьдаг байжээ.

Ширли шинэхэн итгэгч байлаа. Тэрбээр хорт хавдартай гэдгээ олж мэдэхийнхээ өмнөхөн Бурханд үйлчилдэг нэгэн гэр бүлийн хоёрын эхнэрээс нь итгэлийн үндсэн зарчмыг сурсан байв. Тэгээд Индианад эргэж ирээд, нөгөө эмэгтэйтэйгээ уулзан өдрийн хоол иджээ. Гэтэл тэр зөвлөх эмэгтэй нь: “Бурхан хүн болгоныг эдгээнэ гэж байхгүй” гэж хэлээд, хүнд өвчнөөсөө эдгэрч чадаагүй итгэгчдийн талаар жишээ татан ярьжээ. Ширли Хьюстоны гэр бүлийн хоёрын хуваалцсан итгэл найдварын бичээсийн талаар хэлтэл, зөвлөх эмэгтэй нь Ширлийг өөрийг нь сонссонгүй хэмээн дургүйцжээ.

Ширли учраа олохоо болив. Тэгээд химийн эмчилгээгээ хийлгэхээр Хьюстонд эргэж ирэхэд нь мөнөөх хос түүнтэй өдөр бүр уулзан, Бурханы үгээр урамшуулсаар байв. Эцэстээ Ширли эдгээнэ гэж амласан Бурханы үгд чин зүрхнээсээ итгэж, өөрийгөө эдгэнэ гэдэгт хатуу итгэжээ.

Ширли химийн эмчилгээгээ зогсоохоор шийдсэнээ эмчдээ хэлэхэд, эмч нь түүнийг солиорчихож гэж үзэн, цахилгаан шат хүртэл дагалдан, аминд аюултай алдаа хийж байгааг нь анхааруулжээ. Гэхдээ Ширли шийдчихсэн байлаа. Тэгээд гарч яваад, ЭмДи Эндерсоны эмнэлэгт эргэж хэзээ ч очоогүй юм. Ширли гэртээ хариад, өдөр бүр ном, аудио сургаал, Библи судлалаар дамжуулан Бурханы Үг дотор булхаж эхэлжээ.

Гучин таван жилийн дараа өнөөдөр ээж маань манайхаас хэдхэн айлын цаана эрүүл саруул аж төрөн сууж байна. Үнэндээ далан тавтай хадам ээж маань манай байгууллагын холбоо харилцааны хэлтэст өөр долоон хүнтэй хамтран үйлчилж, Америк даяарх хорь гаруй мянган чуулганы үй олон пастор, үйлчлэгч нарт манайхаас гаргасан ном, сургалтын материалаас өөрт хэрэгтэйгээ сонгоход нь туслаж, илгээх үйлчлэл хийж байна.

Түүнчлэн үйлчлэлийн минь амьдралд манай хадам ээж шиг амархан эдгэрдэг хүн надтай цөөхөн таарч байсан шүү. Би

Лизатайгаа гэрлээд удаагүй байхдаа, нэгэн орой харьж иртэл хадам ээж маань нилээд хүнд ханиад тусчихсан сууж байлаа. Үнэндээ тэрбээр явах ч тэнхэлгүй байсан учраас намайг орж ирэх үед орондоо орохоор шатаар мацаж байсан юм. Тэгээд намайг харуутаа: “Жон, энэ ханиаднаас салмаар байна, миний хүү залбираад өгөөч” гэж хэлэв.

Түүний төлөө залбиртал, Бурханы хүч пал хийтэл бууж, хадам ээж маань шалан дээр ухаан алдаж унаснаа огло харайж босоод, үүгээр түүгээр жирийлгэн: “Ээж нь та нарт хоол хийж өгнө өө!” гэж хөгжив. Тэгээд бидэнд маш амттай оройн хоол хийж өгсөн юм. Миний инээд хүрэн: Пөөх Петргэй яг л ийм явдал болсон ш дээ гэж бодож билээ. Петрийн өвчтэй хадам ээжийг Есүс эдгээхэд, ээж нь босоод тэдэнд хоол хийж өгсөн байдаг (Матай 8:14-15-ыг үзнэ үү).

Ширли өөрөө залбирлыг амархан хүлээж аваад зогсохгүй, бусдын эдгэрлийн төлөө ч маш хүчтэй залбирдаг. Өвчтэй юмуу гэмтэлтэй хүнтэй уулзахаараа Бурханы Үг, эдгэрлийн залбирлаар гал буутал залбирна!

Ширли дахиж хавдраар өвдөлгүй, гучин таван жил эв эрүүл сав саруул амьдарсаар байгаа төдийгүй, цаашид ч өнө удаан жил амьдарна! Аймшигт тлипистэй Бурханы Үгээр мятрашгүйгээр тэмцсэнээрээ Ширли маань эдгэрлийн талбар дээр амийн титмийг хүлээн авчээ. Тэр дайсагналыг тэвчин ялсан бөгөөд өдгөө ялалт байгуулсан талбар дээрээ захирч байна.

ЯЛАГЧИД

Ийм гэрчлэл олон хүнд бий. Өдгөө өөрөө тэнгэрийн улсад байгаа ч амьдрал, өв залгамжлал нь газар дээр үргэлжилсээр буй Орал Робертс ахыг сана. Тэрбээр арван долоон настайдаа сүрьегээр амиа алдахаа дөхсөн ч, эмчээс “эдгэрсэн” гэдэг үгийг дуулан дуултлаа энэ өвчний эсрэг Бурханы Үг, залбирлаар мятрашгүйгээр тэмцжээ. Ширлитэй адилхан Орал ч эдгэрлийн талбар дээр амийн титмийг хүлээн авч, хожим түүний амьдрал үйлчлэлээр дамжин сая сая хүн хүчирхэгжин эдгэрсэн юм.

Пасторынхаа үйлчлэлээр олон хүний амьдралд нөлөөлсөн Жимми гэдэг найз надад бий. Жимми маань хүүхэд байхдаа аюултай өвчин тусч, “найдваргүй” гэсэн оноштойгоор Орал Робертсын цуглаан дээр хүргэгдэн иржээ. Орал Робертсоор залбируулсныхаа дараа Жимми маань гайхамшгаар эдгэрсэн юм.

Хэрэв Орал залуу байхдаа өвчнөө ялж чадаагүй бол яах байсан бол? Жимми гэдэг пастор найз маань төдийгүй, Орал Робертсын үйлчлэлээр эдгэсэн сая сая хүн хаана байх байсан бол? Түүгээр барахгүй пастор Жиммигийн мөнхөд нөлөөлсөн хүмүүс хаана байх байсан бол? Орал Робертс захиргаанд хөл тавин орж чаджээ. Түүний мятрашгүй итгэлийн бүтэн үр дүнг бид шүүлтийн сэнтийн өмнө л бүрэн гүйцэт харах байх.

Мөн 1917 онд Техасын Мккиннид зүрхний гажигтай төрөөд, хожим цусны эдгэшгүй, ховор өвчин туссан Кеннет Ий. Хэгинийг аваад үз. Тэрбээр арван зургаахан насандаа хэвтэрт орж, үхлээ хүлээж байжээ. 1933 оны 4-р сард тэрбээр гурван удаа үхэхдээ тамыг харсан бөгөөд тухай бүр гайхамшгаар буцаж амилсан байдаг. Кеннет Эзэн Есүст амьдралаа өгчээ. Тэрбээр Бурханы Үгээр энэ өвчинтэй мятрашгүйгээр тэмцсэн. Түүнийг эргэж тойрч, тайвшруулдаг байсан пастор нь: “Хүү минь, хэдхэн өдөр л тэвчих. Энэ байдал тун удахгүй дуусна” гэж хэлжээ. Жилийн дараа Кеннет үхлийн хэвтрээсээ босч, төдөлгүй номлож эхэлсэн юм.

Кеннет Хэгин дэлхийн хэмжээний үйлчлэл хийж, жаран тав орчим сая ном хэвлэж, Библийн сургалтын төвөөрөө гуч гаруй мянган эрчүүд, эмэгтэйчүүдийг сургасны дийлэнх хувь нь бүтэн цагаар үйлчилдэг болжээ. Кеннет жаран таван жил үйлчлээд өдгөө Эзэн дээрээ очсон ч, өв залгамжлал нь амьдарсаар байна. Тэрбээр эдгэрлийн талбар дээр амийн титмийг хүлээж авсан учраас түүний итгэмжтэй үйлчлэлээр дамжин тоолж тоочихын аргагүй олон хүн эдгэрч, амьдрал нь өөрчлөгдсөн юм.

Кеннет тэвчээгүй бол яана? Түүний үйлчилсэн сая сая хүн яах байсан бол?

Миний саяын ярьсан гурван хүн хоорондоо нэг зүйлээрээ адилхан юм. Тэд бүгд дайралтад өртөж, худлаа мэдээ, муу

ёрын үг сонссон. Ширлиг “Бурхан намайг эдгээнэ!” гэдэгт итгэх шийдвэр гаргамагц, багынх нь найзын нөхөр Ширлитэй тангараг тасарчээ. Орал Робертсийг ч, Кеннет Хэгинийг ч амьдрахын төлөө Бурханд итгэснийх нь төлөө гаж, тэрс, буруу, тэр бүү хэл чөтгөрийнх хэмээн яллаж байжээ. Есүс ийм зүйлийн талаар юу гэж хэлсэн бэ? “Бүгд та нарын тухай сайнаар ярих цагт та нар золгүй еэ! Тэдний эцэг өвгөд хуурамч эш үзүүлэгчдэд ч тэгж хандсан юм” (Лук 6:26).

Хамгийн хачирхалтай нь хаанчлалын мэдээг бүгдэд таатай болгон хөнгөвчилж дэлгэрүүлдэг үйлчлэл, итгэгчид байдаг. Тэд хэн нэгнийг гомдоохоос юмуу “тэвчишгүй”, “тэрс” гэдэг нэр зүүхээс айсандаа, итгэлийн сайн тэмцлээр тэмцэхээс тагталзсан хүмүүс юм. Тэд “Хүний амьдралд юу ч тохиолдсон бай - үг дуугүй хүлээн зөвшөөрч, хүлцэн тэвч. Ингэх нь Бурханы хүсэл” гэж заадаг. Тэд Сайн мэдээний “хатуу” үгсийг түүж хаядаг. Сайн мэдээний бичээс Есүсийг “гомдлын хад”, “бүдрүүлэх чулуу” гэсэн байтал, тэдгээр хүмүүс Есүсийг хэнд ч гэм хоргүй хайрга болтол нь дордуулжээ.

Тэдгээр пастор, үйлчлэгч, итгэгчид хэнээр ч тэрс, гаж, чөтгөрийнх гэж дуудуулахыг хүсдэггүй, бүгдэд таалагдахыг л хүсдэг. Гэтэл Есүс яг ийм үгсээр дуудуулдаг байсан. Есүс үнэн дотор мятрашгүй зогссон. Тэр сайнаар хэлүүлэхийг хүсдэг хүмүүсийн залиг илчилсэн. “Хүний Хүүгээс болж хүмүүс та нарыг үзэн ядаж, гадуурхан, доромжилж, нэрийг чинь ёрын муу мэтээр үзэж үл ойшоох цагт та нар ерөөлтэй еэ!” (Лук 6:22) Сайнаар хэлүүлэхээс тэс өөр юм ярьсан байгаа биз? Дараа нь Есүс: “Учир нь үнэн таагүй байх тул хүн эвгүйцэж, дургүйцдэг юм” хэмээн тайлбарлажээ.

Үнэндээ, хэрэв та мятрашгүй итгэгч байхаар - амьдралд захирдаг нэгэн байхаар шийдсэн бол, Есүсийг дагадаг нэртэй боловч, аятай тухтай амьдралдаа цадсан хүмүүсийн гүтгэлгэ, худлын бай болж, үл ойлгогдож, үл ойшоогдож болно. Өөрсдийнхөө арчаагүй арга замыг зөвтгөхийн тулд тэд таныг бүхий л арга чаргаар дорд үзнэ. Тэд Хуучин гэрээний жинхэнэ эш үзүүлэгч нарт ч, Иохан баптистад ч, Шинэ гэрээний удирдагч нарт ч тэгж л хандсан. Тэд өнөөдөр ч ингэж л ханддаг. Заримдаа

Бурханыг мэддэг гэх хүмүүсээс л хамгийн хүчтэй эсэргүүцэл ирдэг. Тэд таны талаар худал ярьж, гүтгэж, гадуурхаж, Есүсийн хэлснийг ч хийж мэднэ: “Тэд та нарыг синагогоос хөөнө. Харин та нарыг алах хүн бүр өөрийгөө Бурханд үйлчилж байна гэж бодох цаг ирж байна” (Иохан 16:2).

Та Бурханы алдрын төлөө амьдралд захирахыг хүсч байна уу? Та Бурханы хаанчлалын төлөө мөнхөд өөрчлөх нөлөө авчирдаг хүн байхыг хүсч байна уу? Тэр аугаа өдөр Эзэнээсээ: “Сайн байна, миний итгэмжит сайн зарц” гэдэг үг сонсохыг хүсч байна уу? Хүсч байгаа бол: “Глипсистэй үхэх сэхэхдээ тултлаа үзэлцсэн хамаагүй тэмцээд, тэсээд, ялна” гэж яг одоо шийд.

Хэрэв та үнэхээр л захирахыг хүсч байгаа бөгөөд тэсч гарахад бэлэн байгаа бол, цааш нь үргэлжлүүлэн унш. Хамгийн сайн нь хараахан болоогүй байна.

Зовлонгийн ард хэн байна?

Учир нь Христийн төлөө Түүнд зөвхөн итгэх бус, Түүний
төлөө бас зовох нь та нарт соёрхогджээ.

Филиппой 1:29

Та нарт соёрхогджээ - гэдэг үнэхээр чимэгтэй үг ажээ. Ишлэлийн эхэн хэсгийг сонсолгүй, зөвхөн энэ үгийг сонссон хүн: “Надад юу соёрхогдсон юм бол? Намайг ямар амлалт хүлээнэ вэ?” гэж сонирхох нь гарцаагүй.

Тэгвэл хэлье: “Түүний төлөө зовох нь та нарт соёрхогджээ.”

Юу? “Зовлон, соёрхол” гэдэг хоёр үг хоорондоо ер авцалдахгүй баймаар. Гэхдээ Бурхан худлаа ярьдаггүй. Худал ярих нь бүү хэл, худалтай ойрхон ч байж чадахгүй. Өнгөц харахад энэ нь жаахан аргатай ишлэл мэт боловч, ухаарсан нэгнийх нь хувьд үнэхээрийн баясмаар амлалт юм. Христийн дотор алхаж амьдарч буй хүн зүрхнийхээ гүнд: тулаан том байх тусам, том ялалт ирдгийг мэднэ.

Тухайлбал тулаанд бэлтгэж буй цэрэг эр байна. Тэрбээр тулаан ямар чухал байдгийг, тулаан бүр байлдан дагуулах боломж гэдгийг сайн мэднэ. Тэрбээр хааныхаа төлөө амь биеэ хайрлалгүй зүтгэдэг, жинхэнэ дайчин юм. Ээлжит тулаан товлогдмогц, үүнийг дайчин эр маань эзэн хаанаа ахин нэг

алдаршуулах, ард олондоо ашиг олз авчрах завшаан хэмээн үзэж тогтож ядна. Тэрбээр энэ тулаанд эзэн хаан, төр түмнийхээ төлөө зовох нь баталгаатай бөгөөд үүнийгээ өөрөө ч мэднэ. Филиппой 1:29 дээрх ишлэлтэй таарч байгааг харж байна уу?

Та “Гэхдээ би ямар цэрэг биш. Надад байлдан дагуулагчийн хараа байхгүй” хэмээн сөргөлдөж магадгүй. Гэхдээ та хэрэв Христийн дотор байгаа л бол, таны сүнс дотор Христийн үр суулгагдсан учраас, та яалт ч үгүй цэрэг мөн. Есүс бол үеийн үед байсан хамгийн аугаа аймшиггүй чин зоригт дайчин юм. Библи Түүний тухай: “Би тэнгэр нээгдсэнийг харлаа. Харагтун, тэнд цагаан морь байлаа. Түүнийг унасан нь “Итгэмжит агаад Үнэн” гэсэн нэртэй бөгөөд зөв шударгаар шүүж дайтдаг. Түүний мэлмий нь галын дөл шиг, тэргүүн дээр нь олон титэм байна. Тэр өөрөөс нь өөр хэн ч эс мэдэх, бичигдсэн нэгэн нэртэй байлаа. ...Түүний амнаас хурц сэлэм гарсан байх агаад түүгээр Тэр үндэстнүүдийг цохих юм (Илчлэлт 19:11-12,15) гэдэг. Та Есүсийн дүр төрхөөр бүтээгдсэн учраас танд Түүний мөн чанар бий. Христ дайчин учраас, та ч бас дайчин мөн. Тиймээс л Шинэ гэрээ бидэнд ахин дахин тулааны талаар ярьдаг.

Ефес 6:12 дээр Паул: “Учир нь бидний тэмцэл бол мах цусны эсрэг биш, харин энэхүү харанхуй ертөнцийн захирагчид, эрх мэдэл, хүчнүүд, тэнгэрлэг оршихуй дахь ёрын муу сүнслэг хүчний эсрэг билээ” гэжээ.

Паулын өгсөн үүрэг даалгаврыг Мессеж Библи үнэхээр гайхалтай дүрслэн харуулсан. “Бид эцсээ хүртэл үхэх сэхэхээ үзэлцэх тулаан дунд, зайлах аргагүй дайн дунд байна.” Паул яг ийм утгатай үгийг Коринтын чуулганд бичсэн: “Учир нь бид махбодод алхдаг ч, махбодын дагуу дайтдаггүй. Бидний байлдааны зэвсэг нь махбодынх бус, харин ялагдашгүйг ч ялж чадах Бурханы хүчит зэвсгүүд юм” (2Коринт 10:3-4). Тэгэхээр бид байлдаж буй сүнслэг цэргүүд мөн! Та энэ тулааны төлөө төрсөн. Та дайчин байхаар төрсөн. Паул биднийг “Христ Есүсийн сайн цэрэг адил надтай хамт зов. Ямар ч цэрэг цэрэгт татагчдаа таалагдахын тулд аж амьдралын явдалд хутгалддаггүй” (2Тимот 2:3-4) хэмээн сэнхрүүлжээ. Тиймээс өөрийгөө цэрэг гэдгийг тархиараа ч, зүрхээрээ ч мэдэж ав.

Та тулаанаас амиа авран арчаагүй амьтан шиг зугтаж болно. Эсвэл дайны улаан гал руу дайран ороод, баатар шиг ялаад гарч болно. Эхний замыг сонгобол, үеийн үед урвагч нэрийг зүүнэ. Эр зоригийн замыг сонгобол, хааныхаа өмнө баатар шиг зогсоно.

Христ доторх эрхэм найз минь, танд Хаандаа таалагдаж, Түүнийг алдаршуулж, Түүний төлөө амьдрах чин хүсэл байгааг чинь би мэднэ. Гагцхүү махан биедээ буугаад өгчихбөл, махан бие чинь таныг Христийн зовлонг хуваалцах завшаанаас чинь хорих болно.

Есүс Христтэй хамт зовсон хүн Түүнтэй хамт хаанчилна гэдгийг бид Ром номоос сурсан. Бид эсэргүүцэл, гай зовлонд орох нь тодорхой байна. Гэхдээ хэрэв бид зовлонг аймшиг биш, харин соёрхол гэж үзбэл, ямар ч зовлонг баяр хөөртэй хүсэл найдлагаар даван туулна. Тулаан том байх тусам, том ялалт ирж, эцсийн эцэст бүр ч том алдар хүлээж авна. Би танд нэгэн баяртай мэдээ дуулгая: Та энэ дайнд хэзээ ч ялагдахгүй байх боломжтой! Учир нь 2Коринт 2:14 дээр “Биднийг Христ дотор ямагт ялуулдаг бөгөөд Түүний тухай мэдлэгийн анхилуун үнэрийг хаа сайгүй биднээр түгээдэг Бурханд харин талархал нь байг” хэмээн амлажээ.

БУРХАН ХАТУУ ААВ БИШ

Есүсийг баптисм хийлгэсний дараа өрнөсөн үйл явдлыг бид үзсэн. Ариун Сүнс Есүсийг цөл рүү дагуулж, Есүс тэнд дөч хоногийн турш өдөр, шөнөгүй соригджээ. Есүсийг диавол биш, Бурхан Өөрөө цөл рүү дагуулсан юм. Хүү нь хүнд бэрх соригдоно гэдгийг Бурхан мэдэж байсан. Гэхдээ Бурханд зорилго байсан болоод л хүүгээ тийш нь аваачжээ. Үүнээс бид Бурхан бидэнд ялах хүчийг нь өгөлгүйгээр шуурган дунд оруулдаггүй гэдгийг сурсан. Үүнийг зүрхэндээ хадгалж яваарай. Учир нь дайсантай тулах цагт чинь энэ үг л таныг хүчирхэгжүүлнэ.

Есүс Аавынхаа хэлсэн зүйлийг л хийдэг байжээ. Тэр Бурханы Сүнсээр төгс удирдуулсан. “Та нар Хүний Хүүг

өргөвөл, Би байгаа гэдгийг мөн Би юуг ч Өөрөөсөө хийдэггүй, харин Эцэгийн Надад зааснаар Би эдгээрийг ярьдаг гэдгийг мэдэх болно” (Иохан 8:28).

Хожим Есүс үй олон хүнд өдөржин номлож, үйлчлээд ядарсан байдаг. Түүнд ямар байсныг төсөөлж үзье. Миний бие хэд хэдэн удаа өдөржин номлоод, орой нь зочид буудалдаа хүргүүлэх замдаа хүлээж авсан хүмүүстэйгээ ч үг солих тэнхэлгүй, нам унтчихаж билээ.

Есүс ч бас тэгсэн л байх. Үдэш болж, Түүнийг хажуулах гэж байтал, Ариун Сүнс Түүнд дагалдагч нараа дагуулаад завиар эргийн нөгөө талд гар гэж зааварчилжээ. Нөгөө эрэг дээр нь даруйхан үйлчлэх шаардлагатай, чөтгөр шүглэсэн хүн байв. Есүс завин дээр гараад, нам унтаж орхижээ.

Гэтэл тэр хооронд аймшигтай далайн шуурга дэгдэв. Есүсийн ажилчдын дунд насаараа усан дээр амьдарсан, хашир туршлагатай мэргэжлийн дөрвөн загасчин байлаа. Тиймээс тэд далайн шуурга дэгдэх үед хэрхэх ёстойг мэддэг байсан ч, тэр шуурга жирийн шуурга байсангүй. Юу юугүй давалгаанд бяц цохиулахын даваан дээр мөнөөх мэргэжлийн далайчид чинь Есүсийг сэгсчин: “Үхлээ ш дээ, авраач ээ!” хэмээн бархиралдав. Тэд тэр аймшигтай тлиписисээс аврагдах гарцгүй болжээ.

■
**Ариун Сүнс
эхлэлийг ч,
төгсгөлийг ч
мэддэг Бурхан.**
■

Тэр шуурган дунд Аав, Ариун Сүнс хоёр тэвдсэн болов уу? Хар хөлс нь асган: “За ёстой баларлаа! Ийм шуурга муурга болно гэж бодсонгүй! Одоо яадаг билээ? Яах гэж Есүсийг эргийн нөгөө тал руу яв гэж хэлэв ээ? Ингэж балрах гэж!” хэмээн өөр хоорондоо үглэлдсэн болов уу?

Инээд чинь хүрч байна уу? Мэдээж Аав, Ариун Сүнс хоёрын дунд ийм яриа болоогүй. Шуурга дэгдэнэ гэдгийг Ариун Сүнс мэдэж л байсан. Учир нь Тэр эхлэлийг ч, төгсгөлийг ч мэддэг Бурхан. Исаиа 46:10 дээр Бурхан “...Би эхлэлээс авахуулан төгсгөлийг, хийгдээгүй байгааг ч өнө эртнээс мэдүүлсэн” гэжээ. Бурхан хөнөөлт шуурга дэгдэнэ гэдгийг мэдэхийн

дээдээр мэдэн, Есүсийг завинд суулгасан. Бурхан бидэнд ялах хүчийг нь өгөлгүйгээр шуурган дунд оруулдаггүй. Тэгээд Есүс сэрээд завины толгой руу очоод, шуурганд намжихыг тушаагаад, эргэж хараад дагалдагч нараасаа: “Та нар юунд айгаав? Юунд итгэлгүй байна вэ?” (Марк 4:40) гэж асуужээ.

Аймшигт аюулаас амьд мэнд үлдсэн мэргэжлийн далайчдыг Есүс яагаад тийм хатуу үгээр засах болов? “Итгэлгүй байдлыг нь” яагаад түс тас хэлэв? Завинд суухаасаа өмнө Есүс тэдэнд “Нөгөө эрэг рүү очъё” (35-р ишлэл) гэж хэлсэн. Есүс тэдэнд “замдаа живцгээе” гэж хэлээгүй. Есүс хэлсэн л бол, нөгөө эрэг дээр амьд мэнд гаргана гэдгийг тэд мэдэж байх учиртай байжээ. Тэд завиныхаа толгой дээр зогсоод: “Шуурга, чи биднийг алах нь бүү хэл зогсоож ч чадахгүй! Эзэн маань нөгөө эрэг дээр гаръя гэж хэлсэн. Тиймээс бид нөгөө эрэг дээр гарахдаа л гарна, за! Тиймээс замаас зайл!” гэж хашхирч байх ёстой хүмүүс байжээ.

Шуурга дэгдэнэ гэдгийг Бурхан мэдэлгүй яахав. Бурхан Өөрөө тэднийг шуурга руу дагуулсан. Гэхдээ Бурхан бас Есүсийн дагалдагч нарт шуургыг захирах эрх мэдлийг өгсөн. Гол оньс нь үүнд л бий. Амьдралд захирдаг хүмүүс зайлшгүй ирэх зовлонгийн дээр эрх мэдлээ тогтоодог бол, амьдралд захирагддаг хүмүүс энэ эрхээ эдлэх нь бүү хэл, мэддэг ч үгүй. Тиймээс бид тулаанд ялан ялтлаа мятрашгүйгээр тэмцэх ёстой. 2Коринт 2:14 дээрх үнэн таны эд эс бүрт амьдрах болтугай: “Биднийг Христ дотор ямагт ялуулдаг бөгөөд Түүний тухай мэдлэгийн анхилуун үнэрийг хаа сайгүй биднээр түгээдэг Бурханд харин талархал нь байг.”

Хэрэв энэ явдлыг умайсан сэтгэхүйтэй дагалдагч нарын мэдэлд үлдээчихсэн бол, бүгдээрээ живээд үхчих байсан биз. Гэтэл Есүсийн шуургыг захирах эрх мэдэл бүхий дуулгавартай зангийн ачаар тэд өөрсдөө аврагдаад зогсохгүй, нөгөө эрэг дээр чөтгөрийн гарт тарчилж байсан хүнийг ч чөлөөлж чаджээ.

Үүгээр барахгүй, тэр эдгэрсэн хүн Декополисийн арван хотод Бурханы хаанчлалыг тунхаглаж, олон хүнд хаанчлалын үр нөлөөг хүргэжээ. Ариун Сүнс Есүсийг дагалдагч нартай нь шуурган дунд оруулахад, тэд мэдээж аймшигтай зовсон. Гэхдээ Бурхан тэднийг ялагдуулах гэсэндээ биш, харин

шуурганы цаана хүлээж буй ялалтад хүргэх гэсэндээ энэ бүгдийг зөвшөөрчээ.

Хэрэв өнөөдөр бид элч нараас: “Тэр ганц хүнийг чөлөөлөхийн төлөө тэр шуурганд тэгж зовох шаардлага байсан гэж үү?” гэж асуубал, тэд нэгэн дуугаар: “Байсан!” гэж хариулах байв.

Өөр нэгэн үйл явдлыг харцгаая. Паул Ариун Сүнсний хөтөлгөөгөөр Иерусалим руу аялдаг. Гэтэл түүнийг тэнд юу хүлээж байв?

Үзтүгэй, эдүгээ би Иерусалим уруу Сүнсээр хүлүүлэн явж байхдаа ч надад тэнд юу тохиолдохыг мэдэхгүй. Зөвхөн хүлээс болон зовлон намайг хот бүрд хүлээж байгаа гэдгийг Ариун Сүнс надад гэрчилдэг (Үйлс 20:22-23).

Зовлон гэдэг нь мөнөөх тлипис гэдэг Грек үг юм. Тэгэхээр Ариун Сүнс Паулыг аймшигтай гай зовлон хүлээж буй газар руу дагуулжээ. Гэхдээ Бурхан биднийг Өөрийнхөө замаар дагуулахдаа, зам дээр отох ямар ч тлиписийг ялаад гарах нигүүлслийг өгдөг болохыг бүү мартаарай.

Паул тэр их зовлонг мятрашгүйгээр туулаад гарсны ачаар юу болсон? Сайн мэдээ Иерусалимын Иүдейчүүд, харийнханд хүрээд зогсохгүй, Ромын эзэнт гүрний иргэдэд - тэр дундаа цэргүүд, шүүгчид, хавийн хаад ноёд, тэр бүү хэл Цезарьт хүрчээ! Ариун Сүнсээр хөтлөгдөн, шуурга руу харайж орсон ганц хүний ачаар шүү дээ. Паулын амьдрал дахь энэ их зовлонгийн шуургыг Бурхан зохиогоогүй ч, Паул нүгэлт дэлхийн эсэргүүцлээс болж асар их зовно гэдгийг Бурхан мэдэж байжээ. Христ Паулд хайртайдаа, Ариун Сүнсээрээ хөтлөн, зовлон бүрийг ялан гарах нигүүлслээ хайрласан юм. Паул энэ тухайгаа “...Антиох, Икониум, Лустрт надад тохиолдсон ямар хавчлагуудыг би тэссэн билээ. Эзэн намайг тэр бүгдээс аварсан юм” (2Тимот 3:11) хэмээн дүгнэсэн байдаг. Паул яг Дуулал номын бичээчтэй адилхан хэлжээ: “Тэр намайг зовлон шаналан бүгдээс аварсан бөгөөд Би дайснуудаа нүдээрээ харсан” (Дуулал 54:7). Зарим нэг юмуу ихэнх зовлонгоос биш,

харин “бүх” зовлонгоос аварчээ. 100 хувь гэсэн үг!

Яг энэ амлалт та бид хоёрт хамаатай.

ААВЫН ЗӨВЛӨГӨӨ

Ууган хүү Аддисон маань нэгдүгээр ангид байхдаа, хэсэг дээрэлхүү жаалуудтай учирсан юм. Тоглоомын талбай дээр тэдэнд дээрэлхүүлснээсээ болоод нилээд хэдэн удаа уйлсаар гэртээ ирэв. Ийм үед аав хүнд ямар байдгийг та мэднэ байх. Би тэр тоглоомын талбай дээр нь үсэрч очоод, муусайн нусан журнуудыг нэг сайн тоншиж аваад: “Дахиад миний хүүд хүрбэл үү!” гээд сургаад өгмөөр байлаа. Гэхдээ ингэбэл гурван асуудал үүснэ. Нэгдүгээрт - энэ тийм бурханлаг үйлдэл биш. Хоёрдугаарт - энэ үйлдэл маань Аддисоны зан чанарт сөргөөр нөлөөлнө. Гуравдугаарт - энэ нь хуулиар хориотой үйлдэл. Хүүхдийн тоглоомын талбай дээр хүүхдүүд л эрх үүргээ эдлэх ёстой болохоос, томчууд эрх үүргээ хэрэгжүүлж болохгүй.

Тэгээд би жаахан тайвширч, Лизатайгаа ярилцсаны эцэст Аддисонд өөрийнхөө амьдралд тохиолдсон тлиписийг өөрийн биеэр шийдэхийг зааж өгөх нь л зөв юм байна гэсэн шийдэлд хүрсэн юм. Тэгээд Лиза бид хоёр орой болгон ээлжлэн хүүдээ тэдгээр жаалуудын учруулж байгаа тлиписийг яаж амжилттай шийдвэрлэхийг зааж зөвлөөд, өглөө бүр хүүгээ тухайн өдөр тулгарч болзошгүй асуудлыг гардан шийдэх арга ухаанаар хуяглаж өгөөд явуулдаг болов. (Гэхдээ мэдээж хүүгээ ноцтой аюулд ороод байгааг мэдэрбэл, багш захиралтай нь холбоо барьж мэдэгддэг байв)

Аддисон маань багадаа тохиолдсон энэ явдлыг болоод өөр хэд хэдэн удаагийн хэрэг явдлыг ялж гарсныхаа ачаар өдгөө хүмүүстэй харилцах арга ухааныг төгс эзэмшсэн юм. Хүү маань 2004 онд манай үйлчлэлийн багт орж, хамгийн бага үйлчлэлээс ажлын гараагаа эхлэж билээ. Тэр үед байгууллага маань өсвөр наснаас жаран насны дөч гаруй ажилтантай байлаа. Тэгэхэд би менежментийн багтаа: “Аддисон миний хүү ч гэлээ, ямар ч онцгой эрх эдлэхгүй!” гэж хатуу хэлсэн юм. Зургаан сарын дараа чуулганы маань удирдагч надад: “Аддисонд Чуулганы

харилцааны хэлтсийг хариуцуулмаар байна” гэж хэллээ. Чуулганы харилцаа нь үйлчлэлийн амин чухал үйл явц учраас, би түүнээс: “Яагаад Аддисонд гэж?” гэж асуутал, тэрбээр: “Яагаад гэвэл танай хүү чинь удирдагч!” гэж хариулсан юм.

Аддисон тэр хэлтсийг хариуцан удирдснаас хойш тус хэлтэс улам л хөгжин цэцэглэв. Хүү маань аливаа зөрчил асуудлыг шийдэх ур чадвар, цэц ухаанаа батлан харуулахдаа, хамт олныхоо болоод хүмүүсийн итгэлийг олжээ. Өнөөдөр 25-тай хүү маань Мессенжер Интернэйшнэлийн ерөнхий гүйцэтгэх захирлын үүргийг гялалзтал гүйцэтгэж явна. Тэрбээр нас насны хамт олныхоо хайрыг дааж, хамт олон нь ч түүнд итгэдэг учраас, дагадаг болжээ.

Тэгэхээр би Аддисоныг нэгдүгээр ангид байхад нь тэр дүрсгүй жаалуудаас болж сургуулиас нь гаргаад, гэрээр сургах ёстой байсан уу? Нялх хүү маань өдөр бүр өөдгүй хүүхдүүдэд дээрэлхүүлэхийг нь мэдсээр байж, сургуульд нь явуулж л байдаг, хатуу сэтгэлтэй хүн юм даа энэ Жон гэж та бодож байна уу? Дийлэнх нь тэгж бодохгүй байх аа. Яг үүнтэй адилхан Бурхан биднийг хаанчлалын төлөө дайрч ороод, ялаад гарах ёстой газраар дагуулж байгаа нь харгис хатуу явдал огт биш юм. Энэ бүхэн нь бидний л сайн сайхны төлөө бөгөөд эцэстээ Түүнийг алдаршуулна гэдгийг Бурхан мэддэг. Түүнчлэн хэрэв бид бэрхшээлийг Бурханы нигүүлслийн хүчээр ялж гарбал, энэ нь бидэнд ашиг тустай болохыг Бурхан мэддэг.

ГАЙ ЗОВЛОНГИЙН ЭХ ҮҮСВЭР

Тэгэхээр эхлээд тлиписийн эх үүсвэр юу болох, Бурхан үүгээр бидэнд юу сургахыг хүсдгийг тодорхой мэдэх ёстой. Учир нь үүнийг мэдэхгүйгээсээ болж олон хүн амьдралын гурван талбар дээр бүдэрдэг. Тиймээс үүнийг тодруулах нь маш чухал. Бүр дэндүү чухал учраас би энэ бүлгээ дуусан дуустал энэ тухай л ярина. Үүнийг тодорхой мэдэж байж л судлалаа цааш нь үргэлжлүүлэх боломжтой.

Бурхан тлиписийг бүтээгээгүй болохыг бид янз бүрийн жишээгээр үзсэн. Харин ч тлиписис буюу үлэмж зөрчил,

эсэргүүцэл, гай зовлон нь нүгэлт дэлхийн хар хүчээс ирдэг. Гэхдээ та үүнд яг итгэж байна уу? Надад ингэж асуухаас өөр арга алга. Учир нь тархинд чинь “Надад ирсэн энэ гай зовлонгийн зохиогч нь, бүтээгч нь, санаачлагч нь Бурхан биш үү?” гэх хумсын чинээ санаа төрөхөд л та зэвсгээ буулган, тэмцлээсээ ухарч, ялах нь бүү хэл амьд гарах эсэх чинь ч эргэлзээтэй болж мэдэх юм.

Дайнд явж байгаа цэрэг хэнтэй байлдахаа мэддэг. Арай туршлагатай цэрэг бол, дайсны байлдах арга барилыг ч гадарлана. Цэрэг хүний толгойд: “Би хэнтэй байлдах билээ?” гэсэн дэмий явган бодол хэзээ ч гүйхгүй. Гэтэл маш олон итгэгч амьдралд нь тулгарсан гай зовлонгийн ард чухам хэн байгааг мэдэхгүй явдгийг би гучин таван үйлчлэхдээ харсан. Паул бидэнд: “Ингэсэн нь биднийг Сатан мэхэлж далимдуулах вий гэсэндээ юм. Түүний санааг бид ямар мэдэхгүй биш” (2Коринт 2:11) хэмээн ухаантайхан шиг байгаарай гээд захиад байхад, харамсалтай нь тэр хүмүүс дайсныхаа арга барил, үйл ажиллагааг мэдэх нь бүү хэл, дайснаа ч таньдаггүй.

Сатаны арга барилыг яаж мэдэх вэ? Есүс бидэнд заасан! Есүс “Хулгайч зөвхөн хулгайлж, алж, сүйтгэхээр ирдэг. Харин Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн билээ” (Иохан 10:10) гэжээ.

Тэр “хулгайч” нь Сатан болоод түүний хамсаатнууд болохыг Иохан 10-р бүлэгт Есүс айлдсан. Хожим нь Есүс Сатаныг “энэ дэлхийн захирагч” (Иохан 16:11) гэж нэрлэсэн. Паул Сатаныг “энэ үеийн бурхан” (2Коринт 4:4), “...энэ ертөнцийн замнал ба агаарын хүчний ноёрхогч, дуулгаваргүй хөвгүүдийн дотор ажиллагч тэр сүнс” (Ефес 2:2) гэсэн. Сатан бол энэ дэлхийн системийн тохиргоог өөрийн гараар удирддаг нэгэн юм. Сатан бол бидний бүх гай зовлон, зөрчлийн эх үүсвэр мөн. Ефес 6:12 дээр Паул:

“Учир нь бидний тэмцэл бол мах цусны эсрэг биш, харин энэхүү харанхуй ертөнцийн захирагчид, эрх мэдэл, хүчнүүд, тэнгэрлэг оршихуй дахь ёрын муу сүнслэг хүчний эсрэг билээ”

Тэгэхээр хулгай, аллага, утсгалын (сүйрлийн) ангилалд багтах бүх зовлон нь Ефес 6:12-р ишлэлд дүрслэсэн янз бүрийн харанхуй хүчний ажил болохыг Иохан 10:10-аар ишлэл дээр хэлсэн Эзэний үг болоод Ефест хандаж бичсэн Паулын үг ямар ч эргэлзээгүй, тодорхой болгож байна. Нөгөөтэйгүүр Аавынхаа хүслийг илэрхийлэх нь Есүсийн зорилго мөн. Тиймээс Бурхан танд бүрэн дүүрэн, амь шиг амь өгөхийг л хүсдэг. Тиймээс дарамт, бэрхшээл, зовлонд орохдоо үүний цаана Бурхан байна уу, дайсан байна уу гэдгийг Иохан 10:10-аар ишлэлээр шүүгээрэй. Харин үүнийг яаж хийхийг жишээгээр тайлбарлаж өгье.

ИЧГҮҮР, ЯЛ, БУРУУТГАЛ

Танд ичгүүр, ял, буруутгалын мэдрэмж төржээ. Үүнийг Иохан 10:10-аар шүүн тунгааж үзбэл, эдгээр нь Бурханаас ирсэн биш, харин хулгай гэсэн ангилалд гарцаагүй багтана.

Гэхдээ бүрэн баталгаатай байхын тулд илүү нарийн ухаж үзье. Дууллын бичээч: “Сэтгэл минь ээ, ЭЗЭНийг магтаж, Ач тусыг нь ч бүү март. Тэрээр бүх хилэнцийг чинь уучилж, Бүх өвчнийг чинь илааршуулдаг” (Дуулал 103:2-3) гэсэн.

Өөрийнхөө мэдэх хамгийн найдвартай хүнийг сана даа. Таны хань ижил, аав ээж, өвөө эмээ эсвэл эмч чинь үү? Тэр хүн танд хэзээ ч худлаа яриагүй, таныг хэзээ ч мэхлэж яваагүй ажээ. Таны амьдралд ийм хүн байсан юмуу байгаа гэдэгт найдаж байна. Тэгээд тэр хүн чинь таны саяын уншсан амлалтыг нүд рүү чинь харж байгаад хэлж байна гэж төсөөл. Бүр хэлэхээр барахгүй, тэрбээр энэ амлалтаа бүрэн биелүүлэх чадвартай ажээ.

Тэгвэл Бурхан тэр хүнээс чинь ч найдвартай. Бурхан бидэнд Өөрийнх нь ач тусын нэгийг нь ч бүү мартаарай гэж заасан. Нэгийг нь ч! Бурханы нэн тэргүүний ач тус бол Тэр бидний нүглийг бүгдийг нь уучилсан явдал юм. Гайхмаар аа! Ямар өр зөөлөн, өршөөнгүй хайр вэ! Та үүнийг сайн мэдэхгүй явсан бол, яг одоо мэдэж ав: Та Христ Есүсийн дотор уучлагдсан. Түүний урсгасан цусаар угаагдаагүй ширхэг ч нүгэл танд байхгүй. Тиймээс өнгөрсөнд бодсон, хэлсэн, үйлдсэн боловч,

Бурханаас уучлал гуйсан ямар нэг зүйлийн чинь талаар сэтгэлд чинь ичгүүр, ял, буруутгал төрж байвал, энэ муухай мэдрэмжийн ард Бурхан байхгүй гэдгийг мэдээрэй. Энэ талаар Ром 8:33-34 дээр хэлсэн Паулын үгийг үз:

Хэн Бурханы сонгосон хүмүүсийг буруутгах (буруутгаж зүрхлэх) вэ? Бурхан бол зөвтгөгч Нэгэн мөн. Ялладаг нь хэн юм бэ? Христ Есүс нь үхээд, амилуулагдсан, Бурханы баруун талд буй, бидний төлөө зуучлан гуйдаг Нэгэн юм.

Маш тодорхой хэлжээ. “Хэн буруутгаж зүрхлэх вэ?” Бурхан уу? Мэдээж үгүй! Тэгвэл хэн биднийг яллах вэ? Есүс Христ үү? Үгүй! Бодоод үз: Таныг Өөрийнх нь дайсан байх үед Бурхан таны төлөө Өөрийнхөө хүү Есүс Христийг үхүүлэхээр илгээсэн. Есүс ч үүнийг зөвшөөрч, Ариун Сүнс ч үүнийг гүйцэтгэсэн. Тэгвэл одоо Өөрийнх нь дайсан биш, хүүхэд нь болсон таныг юу гэж Бурхан Аав, Хүү, Ариун Сүнс гурав яллах билээ? Бурхан Өөрийнхөө тахилын хурга дээр хэдийнээ буулгасан ялаа одоо юу гэж тан дээр буулгах билээ? Есүсийн тахил хангалтгүй байсан гэж үү? Мөнхийн төгс тахил биш байсан гэж үү?

Еврей номын бичээч бидэнд ийм баталгаа өгчээ:

Тэгэх тусмаа мөнх Сүнсээр өө сэвгүй Өөрийгөө Бурханд өргөсөн Христийн цус нь мөс чанарыг маань үхлийн үйлсээс цэвэрлэн, амьд Бурханд үйлчлүүлнэ шүү дээ! (Еврей 9:14)

Христийн тахил Бурханы өмнө бидний нүглийг устгаад зогсохгүй, мөс чанарыг маань нүглийн ял, буруутгал, ичгүүрээс цэвэрлэжээ. Тиймээс хэрэв та Бурханы төлөө амьдарч, Бурханы хүслийг дагаж байгаа ч, ичгүүр, ял, буруутгалын бодол мэдрэмжинд нэрвэгдэж байгаа бол, эдгээр нь таныг мөхөөх гэсэн дайснаас гаралтай юмс гэдгийг мэдээрэй. Тэгэхээр дайсантай л хатуу үзэх хэрэгтэй. Яаж? Яг л цөлд дайсантай үзэлцсэн Есүс шиг Бурханы Үгээр үзэлц! (энэ талаар дараа дараагийн бүлэгт дэлгэрэнүй ярина).

Гэхдээ хэрэв та (хэрэв гэж байгааг минь анхаарна уу) Бурханд дуулгаваргүй амьдарч байгаа бол, мөс чанар чинь таныг зэмлэснээс болж, зэмийн мэдрэмж төрж байж болох. Иохан “Хайртууд минь, зүрх маань биднийг яллахгүй бол бид Бурханы өмнө зоригтой байж, гуйсан болгоноо Түүнээс хүлээн авна. Учир нь бид Түүний тушаалуудыг сахиж, Түүнд тааламжтайг үйлддэг билээ” (1Иохан 3:20-21) гэсэн. Хэдийгээр яллах гэдэг үг нь “шүүхийн шийдвэр унших” гэсэн утгатай боловч, энэ өгүүлбэрт ийм утгаар хэрэглэгдээгүй юм. Катагиноско хэмээх энэхүү Грек үгийн утга нь “аливаа юмны талаар анхааруулах” буюу “алдааг нь олох”, “буруу” гэсэн утгатай ажээ.

Мөс чанар маань л биднийг Бурхантай тогтоох нөхөрлөлөөс алдуурч одохоос хамгаалан сахидаг. Хэрэв бид гэм буруутайгаа зууралдсаар байвал, Ариун Сүнс бидэнд хайртай Аав минь учраас засахаас өөр аргагүй болно: “Та нарт хөвгүүд шигээ хандсан тэрхүү сэнхрүүллийг та нар мартжээ. “Эзэний сахилгажууллыг бүү хөнгөн үз, хүү минь, Тэр чамайг зэмлэх үед сэтгэлээр бүү уна” (Еврей 12:5). Ариун Сүнс биднийг хулгайж, алж талахын тулд биш, харин Бурхантай тогтоох нөхөрлөлийг маань сэргээн босгож, Аавтай маань улам адилхан болгохын төлөө л засдаг.

Ял ч тэр, засал ч тэр - аль аль нь тун таагүй, зовиуртай мэдрэмж! “Бүх сахилгажуулалт нь тухайн үедээ баяр хөөр бус, харин уй гашуу мэт санагдавч, дараа нь энэ нь түүгээр дасгалжсанд нь зөвт байдлын амар амгалан бүхий үр жимсийг гаргаж өгдөг” (Еврей 12:11). Гэхдээ энэ хоёрт маш том нэг ялгаа бий. Ял таныг ямар ч гарцгүй болгож, зөвхөн ичгүүр буруутгалаар л зогсоо зайгүй тамладаг. Харин Бурханы засал нь танд гарц зааж өгдөг бөгөөд үүнийг гэмшил гэнэ.

Дүгнэж хэлэхэд, таны буруу замаар яваад байгааг мөс чанар чинь мэдэж байгаа бол, Бурхан ч бас мэдэж л байгаа. Учир нь Бурхан таны мөс чанараас аугаа. Буруугаа Бурханы өмнө дор нь шийдэж, дор нь гэмшиж, дор нь хая. Бурхан таныг уучилна. Ийм л амархан.

Иохан “Бяцхан хүүхдүүд минь, та нарыг нүгэл бүү үйлдээсэй хэмээн би эдгээрийг та нарт бичиж байна. Хэн нэг

нь нүгэл үйлдвээс Эцэгийн өмнө бид Өмгөөлөгчтэй агаад тэр бол зөвт Есүс Христ мөн” (1Иохан 2:1) гэж хэлжээ.

Иохан “Хүүхдүүд ээ, та нар нүгэл үйлдсэн ч, Өмгөөлөгчтэй шүү” гэж хэлээгүй. Тиймээс бид нүгэл хийхгүй байхыг зорих ёстой. Нүгэлт чанар биднийг нүгэл рүү л түлхдэг бол, Бурханы чанартай эгнэсэн хүн нүглийг бат сөрнө. Үүнийг ухаарсан хүн түүний амьдрал дээрх нүглийн хүч тас үсэрсэн бөгөөд гаднаа ч, дотроо ч ширхэг ч нүгэлгүй, эрх чөлөөтэй амьдрах нигүүлслийн хүчтэй болсноо мэднэ. Учир нь биднийг “... нигүүлслийн дор байгааг...” (Ром 6:14) Паул батлан хэлжээ.

Тэгэхээр нүгэл хийхгүй байх нь бидний зорилго юм. Бурханы нигүүлслээр бид үүнийг хийж чадна. Гэхдээ хэрэв (дахиад л хэрэв гэж байгааг минь анхаарна уу) бид нүгэл хийчихбэл, үүнийг газар дээр нь шийдвэрлэхдээ, Бурханы амлалт үгд итгээрэй: Бид нүглээ улайвал итгэмжит, зөвт Тэрээр нүглийг маань уучилж, бүхий л зүй бусаас биднийг цэвэрлэнэ” (1Иохан 1:9). Бурхан итгэмжит гэдэг нь таныг хэдэн удаа ч алдсан - тэр бүрт чинь уучилна гэсэн үг юм. Бурхан зөвт гэдэг нь та хэн ч бай, юу ч хийсэн бай - Бурхан уучилна гэсэн үг юм. Мөн Бурхан таныг буруу бүрээс чинь цэвэрлэнэ гэдэг нь бүхий л буруугаас чинь гэсэн үг юм. Тэр цагт та Бурханы өмнө хэзээ ч нүгэл хийгээгүй мэт цэвэр болно. Есүсийн цус тэр нүглийг чинь зүүн баруун зүг нийлдэггүйтэй адил холуу зайлуулна!

Итгэгч хүнийг амьдралд захирахад садаа болдог нэг том саад нь нүглийн талаарх мэдрэмж юм. Бид Бурханы өмнө улайж гэмшсэн нүглийнхээ төлөө ахин дахин ичгүүр, ял, буруутгалд хэмлүүлээд байхаараа адагтаа туйлдаж цөхөрдөг. Үй олон хүн Бурханаас биш, дайснаас илгээсэн ял, ичгүүрт тамлуулснаасаа болоод итгэлээсээ няцахыг би харсан. Тэд өөрсдийгөө уучлуулахын аргагүй олон юмуу хүнд нүгэл үйлдсэн гэж боддог. Тиймээс Бурхан хэдий уучилсан байсан ч, шинэчлэгдээгүй оюун ухаан дээр нь Сатан ажиллан, улам их ял, ичгүүр, найдваргүй байдлын цөхрөлд живүүлдэг. Үүнээс болж тэд нэг бол итгэлээ хаяж явдаг эсвэл итгэлийн ямар ч үр жимсгүй, байнгын ялтай, үхмэл амьдралын замыг сонгодог. Тэд амьдралд захирах биш, амьдралын эрхшээл дор явдаг юм.

Тиймээс та хийсэн нүглээ Эзэний өмнө чин сэтгэлээсээ гэмшиж, улайсан л бол, Бурхан таныг хэзээ ч нүгэл үйлдээгүйд тооцсон гэдгийг мэдэж ав. Бурхан Өөрийнхөө гайхамшигт нигүүлслээр ийм хялбар болгож өгчээ. Үүнд итгэж болно!

Гэхдээ нэг зүйлийг дуугүй өнгөрч болохгүй. Та үнэхээр л Бурханы хүүхэд мөн бол, дотор чинь Бурхан Аавын чинь үр байгаа учраас Аавдаа таалагдаж амьдрах нь таны эрхмийн дээд хүсэл байх ёстой. Харин Бурханы үгэнд ордоггүй хүн нь үнэндээ Бурханаар төрөөгүй ажээ. Хэрэв та нүгэл үйлдэх боломж хайсаар яваа бол, маш аюултай нөхцөлд байна. Шулуухан хэлэхэд - та жинхэнээсээ аврагдаагүй ажээ. “Нүгэл үйлддэг нь диаволынх юм” (1Иохан 3:6-8) хэмээн Библи маш тодорхой хэлсэн буюу.

ӨВЧИН, ЭМГЭГ, БИЕЙН ДОРОЙТОЛ

Нигүүлсэл бидэнд эдгээрийг захирах ямар хүч өгдөг вэ? Дуулал номын зохиогчийн бичсэн үнэнийг харцгаая:

Сэтгэл минь ээ, ЭЗЭНийг магтаж, Ач тусыг нь ч бүү март.
Тэрээр бүх хилэнцийг чинь уучилж, Бүх өвчнийг чинь илааршуулдаг (Дуулал 103:2-3).

Дахиад л амьдралдаа учирсан хамгийн найдвартай хүнээ санаад, дараа нь Бурхан түүнээс хавьгүй найдвартай гэдгийг хүлээн зөвшөөр. Бурхан хэзээ ч амлалтаасаа буцдаггүй. Бурханы бидэнд үзүүлсэн хамгийн эхний ач тус нь бидний нүгэл бүрийг итгэмжтэйгээр уучилдаг явдал гэдгийг бид Дуулал номоос үзсэн. Тэгвэл яг үүнийг тушаасан тэр л амьсгал Бурханы өөр нэгэн ерөөлийг хэзээ ч мартахгүй байхыг бас тушаажээ: Хэзээ ч худлаа ярьдаггүй тэр Бурхан: “Би та нарын бүх өвчнийг нэг бүрчлэн эдгээдэг” гэж айлджээ. Бурхан дийлэнх өвчнийг чинь юмуу өвчний чинь 98 хувийг биш, харин 100 хувь эдгээдэг гэжээ. Эдгэрэл нь нүглийн уучлалтай л адил Есүсийн авран сэргээх үйлсийн чухал хэсэг байсан юм. Бидний сүнслэг болоод биеийн эрх чөлөөний төлөө Есүс ямар аймшгийг хүлцэж гарахыг Исаиа зөгнөн хэлсэн байдаг:

Үнэхээр Тэр бидний сул дорой байдлыг тээж Өвчин зовлонг маань үүрчээ, Гэтэл бид Түүнийг Бурханд зодуулж, цохиулж, зовсон гэж л тооцжээ. Гэвч гэмт үйлдлийн маань улмаас Тэр хатгагдан Хилэнцийн маань улмаас Тэр бяцарч авай. Амар тайвны маань төлөө Түүн дээр гэсгээл байж, шархаар нь бид эдгэрчээ (Исаиа 53:4-5).

Исаиагийн дээрх бичээст сул дорой гэж хөрвүүлсэн үг нь угтаа коли гэдэг Еврей үг юм. Үүнийг Стронгийн тайлбар тольд “өвчин, доройтол, эмгэг” гэж тодорхойлдог. Библийн нэрт эрдэмтэн, зохиолч Хенри Тэйер үүнийг “гай, өвчин, доройтол, эмгэг” хэмээн тодорхойлсон. Энэ нэр томъёо нь Хуучин гэрээнд хорин дөрвөн удаа гардгийн хорин нэгт нь чухам өвчин юмуу эмгэгийн талаар ярьсан байдаг. Тиймээс миний бодлоор дээрх ишлэл дэхь коли гэдэг үгийг зүгээр л “өвчин, эмгэг” гэж орчуулахад болно.

Дуулал номын бичээч ч, Исаиа ч нүглийн уучлал, өвний эдгэрэл хоёрыг нэг өгүүлбэрт дурьдсан нь тохиолдол биш юм. Учир нь эдгээр нь хоёулаа Есүсийн Калвари дээр үнэ төлбөргүй хангаж өгсөн авралд багтжээ.

Есүс дээр өвчнөө эдгээлгэхээр ирсэн нэг ч хүн Есүсээс татгалзсан хариу сонсоогүйг Сайн мэдээнээс харж болно. Есүс нэг ч удаа: “Наад өвчнөө хүлцээд амьдар. Наадахаар чинь дамжуулж Аав минь чамд сургамж өгч байна” гэж хэлээгүй. Тийм ээ, ингэж хэлдэг итгэгчид, тэр бүү багш нар ч бий. Гэхдээ жаахан бодлоготой байцгаая: Тэр Есүс одоо өөрчлөгдчихсөн үү? Тэр өчигдөр ч, өнөөдөр ч, өнө мөнхөд хэвээрээ гэдэг шүү дээ (Еврей 13:8). Тэр газар дээр байхдаа хэзээ ч хэнээс ч нүүр буруулаагүй бол, биднээс ч нүүр буруулахгүй. Цаашилбал, хэрэв та Бурхан өвчнөөр дамжуулж сургамж өгдөг гэж итгэдэг юм бол, яах гэж эмч рүү гүйдэг юм бэ? Бурханы зааж өгөх гэж байгаа зүйлтэй тэмцээд дэмий биш үү? Тэгэхээр энэ бүхэн чинь ямар ч авцалдаагүй байгааг харж байна уу?

■

**Бурхан хэзээ
ч амлалтаасаа
буцдаггүй.**

■

Түүнчлэн Бурханы эдгэрэлд итгэж найдсан нэг ч хүн таталзсан хариулт аваагүйг Үйлс ном ч хэлдэг. Элч нар тэдэнд нэг ч удаа: “Бурхан таныг эдгээх хүсэлтэй байгаа эсэх нь бүрхэг байна. Тиймээс эдгээнэ гэж горьдохоос өөр арга алга” гэж хэлээгүй. Харин ч Исаиа 53, Дуулал 103-ын дагуу биеийн эдгэрэл нь нүглийн уучлалтай л адил Есүсийн авран сэргээх ажлын зайлшгүй хэсэг байсан учраас эдгэрэл эрсэн хүн баталгаатай эдгэрдэг байжээ. Эдгэрлийг хүчингүй болгож байгаа бол, нүглийн уучлалыг ч хүчингүй болгох ёстой болно!

Өнөөдөр ч бүх төрлийн өвчин, эмгэг, биеийн доройтол нь хулгай, аллага, сүйрэл гэсэн ангилалд хамрагдана. Бид эдгээрийг Калвари дээрх Есүсийн тахилын эрх чөлөөгөөр сөрж зогсох ёстой. Эдгээр нь бидэнд хандсан Бурханы хүсэл яавч биш юм. Есүсийн авралын багц урьдын адил бүрэн эхээрээ хүчинтэй байна! Тиймээс л Паул “Амар амгалангийн Бурхан Өөрөө та нарыг бүрэн ариусгатугай. Сүнс, сэтгэл, бие тань бүхлээрээ бидний Эзэн Есүс Христийг ирэхэд гэм зэмгүй хэвээр байх болтугай” (1Тесалоник 5:23) гэж бичжээ. Паул биеийг маань сэтгэл, сүнстэй минь нэгтгэж бичсэн нь Бурхан таны сүнс, сэтгэлийг бүрэн бүтэн байлгахыг хүсдэг шигээ биеийг чинь ч бас яг л Түүний анх бүтээсэн арга замаар ажиллаж, бүрэн бүтэн байгаасай гэж хүсдгийг илтгэж байна.

Та: “Гэхдээ Бурханы эдгэрэлд найдсан ч, эдгэж чадаагүй, нас барчихсан хүнийг би мэднэ” гэж хэлэх гэж байгаа байх. Тэгвэл би танаас: “Бурханд итгэх бидний итгэл хэн нэг хүний амьдралын туршлага дээр суурилах ёстой юу эсвэл Бурханы мөнхийн Үгийн тунхаглал дээр суурилах ёстой юу?” гэж асуумаар байна. Яг одоо тархи, зүрхэндээ нэг мөр шийд. Ром 3:3-4 дээр Паул: “Зарим нь итгэмжгүй бол яах вэ? Тэдний итгэмжгүй нь Бурханы итгэмжийг хүчингүй болгох уу? Тийм биш ээ. Хүн бүр худалч байсан ч Бурхан үнэн. Энэ нь «Та үгсээрээ зөвтгөгдөж Та шүүгдэхдээ ялна» гэж бичигджээ” гэсэн байдаг.

Шууд хэлэхэд, тэр нас барсан хүн зүрхэндээ яг юу гэж итгэж байсныг та бид мэдэхгүй шүү дээ. Бурханы эдгэрэлийг зогсоо зайгүй тунхаглаж байсан ч, эдгэхгүй байх вий гэсэн

айдсаа нуун дарагдуулахын тулд ингэдэг байсан ч байж мэдэх. Жинхэнэ итгэл нь Бурханы амлалтад эргэлздэггүй. Хүн тархиараа зөв гэж бодсон зүйлээ хэлж болох ч, зүрхэндээ өөрөөр итгэж болдог.

Тиймээс Бичээсийн үнэнээс зөрж байгаа амьдралын туршлагыг шүүж яллахгүйгээр яаж хүлээж авах ёстой вэ? Жишээлбэл гэр бүлийн чинь гишүүн юмуу найз чинь өвчнөөс болж залуудаа хорвоог орхибол яах вэ? Миний л хувьд ийм нөхцөлд дараах байдлаар хандахыг сурсан: Бичээс биднийг уралдаж байна гэсэн. Гүйлтийн уралдаанд тамирчин бүр өөрийнхөө зурвас замаар л гүйдэг. Тэгэхээр хэрэв хэн нэгний амьдралд тохиолдсон үйл явдал нь Бичээсийн үнэнтэй эгнэхгүй байвал, тэр явдлыг тухайн хүний л зурвас зам дээр үлдээх ёстой болохоос, өөрийнхөө зам дээр гаргаж ирэх шаардлагагүй. Тэр явдал нь нигүүлсэнгүй бөгөөд шударга Шүүгч болох Бурхан тэр хүн хоёрын хоорондын хэрэг юм. Ийм аргаар л та өөрөө итгэлийн барьц алдалгүй, үргэлжлүүлэн гүйнэ. Харин хэн нэг хүний гэрчлэл нь Бурханы Мөнхийн Үгтэй эгнэж байвал, өөрийнхөө итгэлийн гүйлтийг бэхжүүлэхийн тулд зам дээрээ авчирч болно.

Бурханы Үгийн мэдэгдлийг эд эсдээ тулгал шингээж байж л, дараа нь тэр мэдэгдэл дэхь амлалтыг хүлээж авна. Ингэж чадсан хүн л Бартимай шиг мятрашгүй итгэлтэй байна.

Есүс дагалдагч нартайгаа бөөн бөөн хүмүүсээр бүчүүлсээр Иерохо хотоос гарч явжээ. Гэтэл замын хажууд сууж байсан Бартимай гэдэг нүдгүй хүн Есүсийг явж байгааг дуулаад, Эзэнийг дуудан хашхирав. Хажууд нь байсан хэдэн хүн Бартимайг “Багшид төвөг удахаа боль!” хэмээн зандарсан ч, Бартимай бүр чанга бархирав! Бартимай тархиараа биш, зүрхээрээ итгэжээ. Бурхан түүнийг эдгээх хүсэлтэй гэдэгт Бартимай хамаг зүрхээрээ итгээгүй байсан бол, юу гэж амьтанд адлагдан байж, зүтгэх билээ? Бартимайд тийм итгэл байгаагүй бол, тэрбээр “Есүс над дээр ирж, намайг эдгээгээгүй юм чинь, намайг сохор чигээрээ үлдээсэй л гэж хүсч байгаа хэрэг” гэсэн худал бодолдоо хууртагдаад л дуугаа хураачих байсан. Гэтэл Бартимай ийм худал хуурмагт автаагүй. Тэр шийдчихсэн байснаа нууж хаалгүй, ил чангаар илэрхийлсэн. Тэгтэл юу болсныг хар:

Есүс зог тусав (Марк 10:49).

Гайхмаар аа! Есүс тэнгэрээс томилгоотой гол даалгавраа биелүүлэхээр Иерусалим руу эргэлт буцалтгүй шулуудсан байв. Есүсийн ухаан санаанд тэр даалгавраас өөр юу ч байгаагүй. Түүнийг үй олон хүн бүчин хоргоож байсны дунд янз бүрийн эмгэг өвчтэй хүмүүс байсан л байгаа. Тийм боловч тэдний нэг нь ч Есүсийг амин чухал даалгавраасаа түр сатааран, зог тусан зогсоход хүргээгүй юм. Гэтэл тээр тэндээс “Есүс ээ!” хэмээн зогсоо зайгүй хадах нэгэн дуу! Тэр дууг юу ч барьж хорьж дийлэх янзгүй болтой. Өөрийг нь шавж байсан хүмүүсийн сэтгэл доторх чимээгүй итгэл биш, харин тэртээ буй Бартимайн чанга хашхираа Есүсийг зог тусахад хүргэжээ. Тэгээд Есүс: “Түүнийг хүрээд ир гээч” гэж хэлэхэд, дагалдагч нар нь сохор Бартимайг: “Эзэн дуудаж байна. Алив, хүрээд ир!” (Марк 10:49) хэмээн дууджээ.

Мэдээж Бартимайн эргэн тойронд байсан хүмүүс энэ явдлыг сайшаагаагүй. Сайшаах нь бүү хэл, харин ч дургүйлхсэн байдаг. Гэхдээ энэ байдал Бартимайн урмыг хугалаагүй. Учир нь түүнд итгэл байсан. Бартимай нөмөрч байсан адсагаа шулуудчихаад, год хийн босоод, дагалдагч нараар хөтлүүлэн Есүс дээр ирэв.

Эзэн түүнээс: “Чи Надаар юу хийлгүүлмээр байна?” гэж асуулаа.

Даапаалаад байна уу? Юу гээчийн асуулт вэ? Сохор хүнээс юу хэрэгтэйв гэж асууж байдаг. Хараажийн хэрэг байтал, Есүс яах гэж ийм дэмий юм асууна вэ? Ядарсан хүний хэрэгцээнд арай л мэдрэмжгүй байгаа юм биш үү? Доромжлоод байгаам уу?

Яалаа гэж! Эзэн Бартимайн итгэлийн нотолгоог харахыг хүсчээ.

Бартимай “Нүд гуйна гэхээр арай л даварчихсан хэрэг болох байх. Гэхдээ Та ядаж сүүлийн хэдэн өдөр намайг зовоож байгаа толгойг минь эдгээгээд өгөөч?” гэж хэлсэн бол, Есүс тэрийг л нь хийж өгөх байлаа. Үүнийг ч Бартимайг нүдтэй болсны дараа хэлсэн Есүсийн үг батладаг. Есүс: “Яв даа. Итгэл чинь чамайг эдгээлээ” гэсэн юм.

Маркэдгэрч чадаагүй түм буман хүний тухай бичээгүй, харин эдгэрсэн ганц хүний тухай бичжээ. Тиймээс эдгэж чадаагүй хэн нэгний түүхээр хөдлөшгүй баримт нотолгоо хийн, итгэлээ бүү ганхуулаарай. Би дахин хэлье: Бурханаас ямар нэг юм хүлээж авч чадаагүй хүмүүсийг шүүмжилж, шүүж болохгүй. Гэхдээ тэдний түүхийг зүрхэндээ нотлох баримт болгон бүү хадгал. Ром 3:3-4 дээр Паул “Зарим нь итгэмжгүй бол яах вэ? Тэдний итгэмжгүй нь Бурханы итгэмжийг хүчингүй болгох уу? Тийм биш!” гэсэн. Бид Бурханы Үгтэй эгнэсэн гэрчлэлийг л зүрхэндээ баримт болгож хадгалах ёстой.

ГАЧИГДАЛ БА ЯДУУРАЛ

Нигүүлсэл бидэнд гачигдал ба ядуурлын дээр хүч өгөөгүй гэж үү?

Яагаад гэдгийг нь мэдэхгүй, гэхдээ зарим хүн ядуу зүдүү байдал нь бурханлаг чанарын үлгэр жишээ гэж итгэдэг. Зарим нь бүр Бурханд насаараа ядуу зүдүү үйлчилнэ гэж ам өчиг өргөж туйлширдаг. Гэхдээ энэ сэтгэлгээг Филиппой 4:19 дээрх баталгаа бут цохидог: “Миний Бурхан алдар дахь баялгаараа Христ Есүс дотор та нарыг хэрэгтэй бүхнээр чинь хангана. ”

Паулын энэ үг нь чухамхүү санхүүгийн талаар итгэгчдэд хэлсэн үг болохыг захидлын агуулгаас нь мэдэж болно. Бидний хэрэгцээ эдийн засгаар юмуу хувьцааны зах зээлээр биш, харин Бурханы алдар дахь баялгаар хангагдах болно. Янзтай. Яагаад гэвэл Бурханд асар их баялаг бий - үнэндээ бүр ёроолгүй их! Энэ амлалт дээр тулгуурлан, Бурхан таныг ямар ч сайн зүйлээр дутаахгүй гэдэгт бид итгэл төгс байж болно. Дуулал номын бичээч: “Залуу арслан ч гачигдан өлсөж байдаг. Харин ЭЗЭНийг хайгчид (асуудаг, хүсдэг хүмүүс) ямар ч сайн юмаар гачигдахгүй” (Дуулал 34:10) гэдэг. Гачигдал ба ядуурал нь бүрэн дүүрэн амьдрал яавч биш учраас, танд хандсан Бурханы хүсэл байж таарахгүй.

Сайн нэр нь үлэмж баялаг юмуу тэр бүү хэл Бурханы үнэт тосолгооноос ч дээр гэдэг (Сургаалт үгс 22:1; Номлогчийн үгс 7:1-ийг үзнэ үү). Бид өр төлбөрөө барагдуулахгүй бол, муу нэр зүүнэ. Та түрээсээ цагт нь төлдөггүй байж, байрныхаа

менежерт Есүсийн тухай яриад яах юм. Таныг хэлсэн үгдээ хүрдэггүй хүн гэдгийг амьдрал чинь гэрчлээд байхад, тэр хүн юу гэж таныг сонсохов. Гэхдээ Бурхан таныг хангасаар, эцэстээ та байр худалдаж авах чадалтай болоод, түрээсийн байрнаасаа нүүхийг чинь танай байрны чинь менежер харвал, үл итгэгч хүнд үүнээс илүү нотолгоо олдохгүй. Дэд хууль 28:12 дээр Бурханы үг "...Олон үндэстэн чамаас зээлнэ. Харин чи зээлэхгүй" гэсэн. Өөрөө өр лизинггүйгээр барахгүй, баялгаа бусадтай хуваалцаж, сайн мэдээний үйлсэд өгч "үндэстнүүдэд зээлүүлнэ" гэдэг ямар аугаа гэрчлэл вэ!

Тэгэхээр Бурхан биднийг хувийнхаа хэрэгцээг хангах төдий байдлаас өндөрт төвшинд аваачихыг хүсдэг нь эдгээр бичээст тодорхой байна. Бурхан биднийг хөгжин цэцэглээсэй гэж хүсдэг. Элч Иохан юу гэж залбирсныг хараач: "Хайрт минь, сэтгэл тань амар тайван байгаагийн адил бүх зүйл тань сайн сайхан байж (юу юуны түрүүнд хөгжин цэцэглэж), эрүүл энх байгаасай хэмээн би залбирч байна" (3Иохан 1:2).

Би юу юуны түрүүнд хөгжин цэцэглэж гэдэг үгийг тодруулсан байгаа биз? Бурхан юу юунаас илүүтэй Өөрийнхөө хүүхдийг хөгжин цэцэглэж, эрүүл саруул байгаасай гэж хүсдэг. Би дахиад хэлье: "Юу юунаас илүүтэй! Бүхний түрүүнд!" Элчийн залбирал Бурханы хүсэл биш юм бол, Бичээст юу гэж бичигдэх билээ. Бурхан хэзээ ч давсладаггүй бас хэтрүүлдэггүй. Бурхан тэгж чадахгүй. Учир нь тэгвэл энэ нь худал болно. Харин Бурхан худлаа ярьж чадахгүй. Тиймээс найз минь Бурхан биднийг юу юунаас илүүтэй хөгжин цэцэглүүлж, эрүүл саруул байлгахыг хүсдэг гэдэгт баталгаатай байж болно. Биширмээр!

Тэгвэл хөгжил цэцэглэл гэж юу вэ? Энэ нь өөрийнхөө хэрэгцээг хангаад, дээрээс нь нөлөөллийнхөө хүрээнд байгаа хүмүүсийн хэрэгцээг хангаж чадахыг л хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл та мөнгөний гачаалаас болж Бурханы Өөрийг нь мэдүүлээрэй гэсэн хүмүүст хүрч очиж чадахгүйд хүрэх ёсгүй гэсэн үг юм. Магадгүй иймээс л Бурхан "Харин эцэг өвгөдөд чинь тангарагласан Өөрийнхөө гэрээг өнөөдрийнх шиг батлахын тулд Тэр чамд хөрөнгө чинээ олох хүч чадал өгдөг учраас чи өөрийн Бурхан ЭЗЭНийг санагтун" (Дэд хууль 8:18) гэж хэлсийм биш байгаа?

Бурхан биднийг мөнгөтэй байхыг эсэргүүцдэггүй. Бурхан биднийг мөнгөнд эзэмдүүлэхийг эсэргүүцдэг. Мөнгө нь бүх бузар муугийн үндэс биш; мөнгийг хайрлах хайр нь бузар муугийн үндэс юм. Амьдарлынхаа талбар бүр дээр - тэр дундаа санхүүгээр хөгжин цэцэглэх нь танд хандсан Бурханы хүсэл мөн.



Сая бидний ярьсан амьдралын талбарууд дээр маш олон төлөвшөөгүй, шинэ итгэгчид зөрчилддөг. Гэхдээ ичгүүр, ял, буруутгал, өвчин, эмгэг, биеийн доройтол, гачигдал, ядуурлын зохиогч нь Бурхан биш гэдгийг мэдвэл, дайсны довтолдог бусад талбарыг ялгаж мэдэх хавьгүй амархан болно. Тэгэхээр бидний өмнө хаанчлалын төлөө байлдан дагуулах ёстой газар нутаг, хийх ёстой тулаан хүлээж байна.

Галын шугам руу ойртох тусмаа замд чинь тулгарсан саад чинь хулгай, үхэл, сүйрэл гэсэн ангилалд багтаж байвал, Бурхан үүнд ямар ч хамаагүй гэдгийг мэдээрэй. Энэ бол таныг мохоож, ялагдуулж, мөхөөх гэсэн Сатанаас ирж байгаа юм. Бурханы хаанчлал тэнгэрт шигээ газар дээр илэрхийлэгдэхийн төлөө та бид хоёр мятрашгүйгээр тулалдах ёстой.

БҮРЭН ЗЭВСЭГЛЭ

Иймээс Христ нэгэнтээ махбодоороо зовсон тул та нар ч гэсэн ижил санаагаар өөрсдийгөө зэвсэглэ. Учир нь махбодоороо зовсон нь нүглийг дуусгасан.

1Петр 4:1

Цэргүүдээ ширхэг ч сум, буу, их буу, бөмбөг, танк, онгоц бүү хэл хутга ч бариулалгүй дайнд илгээдэг улс байдаг уу? Тэр улс дайнд яах бол? Ялж чадах уу? Тулалдаж чадах уу? Ялж гийгүүлдэггүй юмаа гэхэд, ядаж амь гарах болов уу? Миний бодлоор хайран сайхан залуусын дийлэнх нь алагдаж, үлдсэн нь дайсандаа олзлуулах байх.

Энэ бол зүгээр л төсөөлөл. Яагаад гэвэл миний л мэдэхийн ийм юм хэзээ ч болдоггүй. Инээдтэй санагдаж болох ч, “зовлонд ямар зэвсэггүй яваа” итгэгчид үүнээс ялгаа юун? Харамсалтай нь бидний дийлэнх нь ямар ч зэвсэггүй, гар хоосон явж байдаг. Тэгээд гэнэтийн тлипсис дайрахад, гар хоосон явж байсан хүмүүс гүн цочрол, самуурал, гайхшралд орно. Үүнээсээ болж хариу үйлдэл хийх биш, хариу мэдрэмж л илэрхийлээд байдаг.

Петр эхний захидалдаа Ариун Сүнсний чиглүүлгээр бидэнд Христийн адил зовохын тулд өөрсдийгөө бүрэн зэвсэглээрэй гэж захисан байдаг. Есүс яаж зовсон билээ? Гэм нүгэлдээ баригдсандаа зовсон уу? Үгүй, Есүс гэм нүглийг эсэргүүцсэн. Есүс өвчин эмгэгт баригдсандаа зовсон уу? Үгүй, Есүс

өвчин эмгэгийг эсэргүүцсэн байх. Есүс өр төлбөрт баригдаж, даалгавраа биелүүлэх мөнгөгүй болсондоо зовсон уу? Үгүй! Гэхдээ Есүс санхүүгийн хангамжийн төлөө Бурханд ямагт найдах ёстой байсан гэдэгт би итгэдэг. Есүс бүх талаараа соригдсон боловч, дайсны ширхэг ч довтолгоонд унаагүй юм. Тэгвэл биднийг яг Түүн шиг амьдраарай гэсэн. Бид ч бас диаволын ширхэг ч дайралтад унах ёсгүй юм.

Петрийн захидлыг цааш нь уншбал, Есүс мөн хүмүүсийн шударга бус хандлагаас болж - тодруулбал тухайн үеийн төр, шашны удирдагч нараас болж багагүй зовжээ. Би л хувьдаа үүнийг хамгийн өндөр төвшний захиргаанд хөл тавьж орох хүний зайлшгүй давж гарах ёстой хамгийн том зовлон гэдэгт итгэдэг.

Паулыг ч бас яг ийм шударга бус хандлага хамгийн их зовоосон байдаг. Түүнийг чулуугаар нүүлгэж, таван удаа ташуурдаж,

гурван удаа саваагаар жанчиж, нутгийнхан нь ч, харийнхан ч, хуурамч итгэгчид ч байнга аюул занал учруулдаг байсан. Паулыг гүтгэж, зохион ярьж, элэглэж, хүншгүй хандаж, доромжилж, хуурамч ял тулгаж байсан. Тэгвэл Паул өөрөө бидэнд яг адилхан сэрэмжлүүлэг өгчээ: “Үнэндээ,

■

**Та дэлхийн
замаар амьдарбал ...
Үндсэндээ та дайны
хоригдол болно.**

■

Христ Есүс дотор сүсэг бишрэлтэй амьдрахыг хүсэгч бүх хүн хавчигдах болно” (2Тимот 3:12).

Та дэлхийн замаар амьдарбал, тэд таныг хавчиж оролдохгүй. Үндсэндээ та дайны хоригдол болно. Та дайсны “ДХ” (Дайны Хоригдол) гэдэг шоронд хоригдоно. Та хаанчлалын төлөө давшин эзлэж, Бурханд алдрыг авчрах чадваргүй болсон. Галын шугаманд байлдаж яваа цэргүүд л дайсны газар нутгийг эзлэхээр давшиж яваа, эрх чөлөөтэй хүмүүс юм.

Бид Бурханы хаанчлалаас тэс өөр, Бурханы хаанчлалтай дайсагнадаг дэлхий дээр амьдарч байна. Энэ дэлхийн системийн урсгал нь Бурханы Сүнсний урсгалыг сөрж урсдаг. Тиймээс хэрэв та үнэхээр Эзэний төлөө амьдарч байгаа л бол гай зовлон, дайсагнал, хавчлага үзнэ. Энэ бол бидний ажлын нэг хэсэг.

Эрхэм найз минь, та өмнөх бүлэгт гарсан зовлонгуудаас болж эсвэл байгаль дэлхийн нөхцлөөс болж эсвэл энэ дэлхийн системийн нэгж, байгууллага, хүмүүсээс болж Христийн дотор эсэргүүцэгдэж зовно. Тиймээс л Петр таныг үүнд бэлэн байж, “бүрэн зэвсэглэ” гэсэн юм.

ЗЭВСЭГТЭЙ БА ЗЭВСЭГГҮЙ

Тэгэхээр үүнийг гэнэтийн аюулд өртсөн зэвсэгтэй, зэвсэггүй хоёр хүнээр дүрслэн ярьбал тустай болов уу гэж санана. Тухайлбал арилжааны нисэх онгоцны жолооч нар 6-12 сар тутамд тогтмол бэлтгэл сургуульд хамрагддаг. Ингэхдээ нисгэгчид яг жинхэнэ онгоц шиг бүтэц, дэлгэц, жолоодлоготой, маш нарийн компьютерийн систем бүхий тусгай төхөөрөмжтэй өндөр технологийн дасгал сургуулийн хиймэл онгоцонд бэлтгэлээ хийнэ. Энэ хиймэл онгоц нь нисгэгчийн удирдлага, гадаад орчны хүчин зүйлээс хамааран үйл хөдлөл хийдэг хөдөлгөөнт тавцан дээр суурилна. Товчхондоо нисгэгч жинхэнэ онгоцонд байна уу, хиймэл онгоцонд байна уу гэдэг нь ялгагдахгүй.

Хиймэл онгоц нь жинхэнэ нислэгийн бүхий л нөхцөл, доголдлыг бүрэн даган дууриах хүчин чадалтай учраас симуляторыг удирдаж байгаа зааварлагч нь нисгэгчийг янз бүрийн асуудалд (глипсист) оруулна. Нисгэгч симулятораа хүчтэй чичиргээ, салхины зүслэг, цаг агаарын эрс тэс үзэгдэл, мотор унтрах, эвдрэх, газардах араа доголдох зэрэг нисгэгч хүнд тулгарч болох үй олон асуудлын заримаар жолоодож гарна. Тийнхүү нисгэгч маань сургалтын явцад гэнэтийн бэрхшээл бүрийг удаа дараа амжилттай гардан шийдвэрлэж, давж чадбал, жинхэнэ амьдрал дээрх хямралыг шийдэхэд бэлэн болно гэсэн үг юм. Ийм бэлтгэл сургуулийн ачаар нисгэгчид олон тооны аюул ослоос урьдчилан сэргийлж чаддаг байна.

2001 оны 9 сарын 11-ний өмнөхөн болсон нэгэн онгоцны ослыг би мэднэ. Тэр бага оврын арилжааны онгоц нь жолоочийг зорчигчдоос тусгаарладаг бүхээгийн хаалгагүй онгоц байжээ. Тэгээд ослын дараа онгоцны хар хайрцгийг олоод

унштал, бүхээгийн хаалга байхгүй учраас мэргэжилтнүүд нисгэгчдийн яриаг ч, зорчигдын дуу чимээг ч аль алийг нь тодорхой сонсжээ. Тэгсэн онгоц унаж эхэлмэгц зорчигчид аймшигтай айж бархиралдаж эхлэсэн бол, харин нисгэгчид нь тэр аюул дунд тайван байж, хяналтыг гартаа аван, доголдлыг тодорхойлон ажилласаар байжээ. Тэд айдас бачимдлаар биш, харин бэлтгэл сургуулийнхаа дагуу үйлджээ. Ахмад нь заавар өгч, туслах нисгэгч нь заавар бүрийг гүйцэтгэж байв. Хоёр нисгэгч эцэс хүртлээ яг ингэж үйлджээ. Нисгэгчид гэнэтийн аюулд бэлтгэгдсэн байсан бол, ямар ч бэлтгэлгүй зорчигчид тэс өөрөөр авирлажээ. Нисгэгч нь зорилготой хөдлөсөн бол, зорчигчид нь хоосон айдас л мэдэрчээ.

Нэг удаа намайг хувийн жет онгоцоор бараг 12,000 метрийн өндөрт нисч явтал, онгоцны хаалгынх нь лац эвдэрчихсэн юм. Бүхээгээс даралттай агаар эрчтэй гадагшлах нь яг л хоолойгоор хүчит шуурга исгэрэх мэт чанга байв. Онгоцны бүхээг доторх агаарын даралт тэр дороо унав. Би ч яах учраа олохгүй тэвдэж байлаа. Үнэнийг хэлэхэд би цээжийг минь самардах айдастай амь тэмцэн, бүхий л чадлаараа залбирч байлаа. Тэгсэн онгоцны ахмад маань хэдэн арван мянган цагийн нислэгийн туршлагатай, үй олон удаагийн ослын газардалт хийж явсан, Усан цэргийн нисэх хүчний турших нисгэгч байж таарсан юм. Лац эвдрэх үед тэрбээр туслах нисгэгчийнхээ хамт шууд ажилдаа оров. Тэд тэр даруй асуудлыг тодорхойлон, хүчил төрөгчийн багаа зүүгээд, дараа нь надад баг өгсөн юм. Хүчил төрөгч байхгүй бол тэд даалгавраа дуусгаж чадахгүй.

Ахмад маань туслах нисгэгчдээ шуурхай заавар өгөнгөө, өөрөө ослын газардалт хийхээр доошилж эхлэв. Энэ гамшиг дунд ахмад маш тайван, итгэлтэй, баталгаатай алхам хийж байлаа. Бэлтгэл сургуулийнхаа ачаар тэрбээр даган биелүүлэх ёстой нарийн үйл явцсыг эзэмшжээ. Миний хувьд хэдийгээр ноцтой аюулд орсон байж магадгүй гэдгээ гадарлаж байсан ч, тийм итгэлтэй ахмадыг харсан хүн чухам ямар аюулд орсноо мэддэггүй юм билээ. Би ахмадын үйл хөдлөлөөс ширхэг ч айдас олж хараагүй юм. Ахмад үнэхээрийн ул суурьтай, түргэн шуурхай, хурц шулуун үйлдэж, бүгдийг хяналтандаа авсан байлаа.

Ахмад онгоцоо секундэд 1800-2400 метрийн хурдтай шумбуулан, тавхан минутын дотор 3700 метрийн өндөрт буулгаж, төдөлгүй аюул осолгүй газардуулав. Аюул өнгөрсний дараа би нэг зүйлийг ухаарсан юм: Ахмад гэнэтийн глипсист “бүрэн зэвсэглэсэн” байсан бол, харин би гар хоосон байжээ.

1Петр 4:1-р ишлэл бидэнд яг үүнийг л заадаг. Усан цэргийн нисэх хүчний турших нисгэгч гэнэтийн аюулд зэвсэглэсэн байсан шиг, бид ч бас сүнслэг тулаанд зэвсэглэсэн байх ёстой. Мятрашгүй ном маань таныг Христ доторх хувь тавиландаа хүрч, амьдралд захирах замд тань зайлшгүй тулгарах бэрхшээлд бэлтгэх дасгалын төхөөрөмж байх болтугай.

ГАЙ ЗОВЛОН ТОХИОЛДОНО

Зэвсэглэсэн байхын тулд нэн тэргүүнд бид зовно гэдгээ мэдэх ёстой. Иохан 16:33 дээр Есүс “Ертөнцөд та нар зовлонтой байна” хэмээн айлдсан. “Байж магадгүй” биш, харин “байна.” Паул “Бид олон зовлон туулж байж Бурханы хаанчлалд орно” (Үйлс 14:22) хэмээн анхааруулсан. Мөн “Тэгснээр хэн ч эдгээр зовлонд ганхахгүй. Учир нь бид үүний тулд л заяагдсан гэдгийг та нар өөрсдөө мэднэ” (1Тесалоник 3:3) гэж бичжээ.

Дайнд явж байгаа цэрэг хүний адил “бид зовохоор томилогдсон.” Цэрэг хүн ялагдах гэж байлддаггүй. Жинхэнэ цэрэг хүн байгуулах ялалтаа харж, түүнийхээ төлөө ямар ч бэрхшээлийг (зовлонг) цөм дайраад гардаг. Тэрбээр тулаанд бэлтгэн, өөрийгөө зэвсэглэдэг. Та бид хоёр байлдаж байна. Аврагдсны дараа амьдрал чинь амар жимэр болчихно гэж бодсон уу?

Хүмүүс шинээр төрсөн Христэд итгэгч нарт “асуудалгүй, төгс амьдралд тавтай морил” гэж хэлэхийг сонсохоор миний дургүй хүрдэг. Энэ бол үл гүйцэлдэх амьдрал. Шинэ итгэгчдэд ийм утгагүй юм ярьж байгаа үйлчлэгч, итгэгч нар нь шинээр төрсөн сүнслийн сайн сайхны төлөө санаа тавьсандаа биш, харин “аврах ажиллагаагаа дуусгасандаа” л баярлаж байгаа юм шиг л санагддаг. Тариачны тухай сургаалт үлгэртээ Есүс “Үг таригдмагц, үгнээс болж хавчлага зовлон ирдэг” (Марк

4:17) хэмээн айлдсныг тэдгээр багш нар санадаггүй болтой. Нью Ливинг Транслэйшн Библи дээр “Тэд үгд итгэсэн учраас асуудалд орж, хавчигддаг” гэдэг. Шуудхан хэлэхэд, та Христийн нэгэн адил Бурханы Үгд итгэхдээ сайн дураараа асуудал, бэрхшээл, хавчлага дор орлоо гэсэн үг юм. Үүнд баталгаатай байж болно.

Хэрэв та энэ талаар огт мэдээгүй явсан шинэ итгэгч бол, би танд үүнийг анхлан дуулгая: “Та Христэд итгэхдээ, амьдралдаа хэзээ ч үзээгүй их тулаанд хөл тавьжээ!” Гэхдээ өөр нэгэн гайхамшигтай мэдээ байна аа - та энэ тулаанд ялагдах албагүй! Бүр ширхэг ч тулаанд ялагдах албагүй. Аврагдахаасаа өмнө та амьдралынхаа бүх тал дээр ялагдсан байж болно. Гэхдээ одоо та Ариун Сүнсний оршихуй, Бурханы эгнэшгүй нигүүлслийн ачаар амьдралын бүх талбарт захирч чадна.

ТА ЦОО ШИНЭ ЮМТАЙ ТУЛГАРААГҮЙ

Тулаанд “зэвсэглэхийн” хоёрдугаар зарчим нь “энэ наран дор шинэ юм гэж байдаггүйг” мэдэх. Та хэзээ ч хэний ч - ялангуяа Есүсийн туулж гараагүй бэрхшээлийг үзээгүй. Есүс бүх талаараа соригдсон. 1Коринт 10:13 дээр Паул:

Та нарт учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл. Бурхан итгэмжтэй, Тэр та нарыг хэр чинь хэтэртэл соригдохыг зөвшөөрдөггүй, харин дааж гарахын тань тулд сорилттой хамт мөн гарцыг ч буй болгоно гэж бичжээ.

Танд тулгарсан бэрхшээл нь хэн нэгэнд хэдийнээ тулгарсан, хэн нэгний хэдийнээ ялсан зүйл! Үүнд итгэж болно! Түүнчлэн бид дааж дийлэх хэмжээнээсээ давсан дайсагнал, хавчлагатай тулгарахгүй гэдгийг дээрх ишлэл амлаж байна. Тиймээс тулж зогсоод, ялж чадахгүй эсэргүүцэл, бэрхшээлтэй тулгарах вий гэдэг айдсаа хая. Тэнгэрлэг Аав чинь ийм зүйл болохыг хэзээ ч зөвшөөрөхгүй, шууд л хаана.

Орчин цагийн Англи Библи дээр “Бурхан амлалтаа биелүүлдэг бөгөөд таныг бат зогсох хүчээс чинь хэтэрсэн юмсаар соригдохыг зөвшөөрөхгүй. Чөтгөр танд дураараа хүрч чадахгүй гэдэг. Гайхамшигтай баталгаатай үнэн ажээ. Аугаа хүчирхэг Бурхан

зөвшөөрөөгүй л бол, дайсан бидэнд хүрч чадахгүй. Эдгээр сорил зовлонг Тэнгэрлэг Аав маань сэдэж зохиогоогүй боловч, Тэрбээр таныг дайснаа дарж, Өөрт нь алдрыг авчирч, Өөрийнх нь хаанчлалыг тэлсэн мундаг баатар болоосой гэсэндээ заримдаа зовлон дундуур дагуулдаг. МЭ 160- 230 онд аж төрж байсан анхан үеийн чуулганы хүндэт удирдагч Тертуллиан үүнийг яг онож хэлсэн байдаг:

Бурхан Сатаны арга загварыг ажиллуулахыг зөвшөөрөхдөө, давхар Өөрийнхөө сайны зорилгыг хэрэгжүүлсээр ирсэн юм. Бурхан хүний сэргэлтийг хойшлуулсан яг тэр шалгаанаараа диаволын сүйрлийг хойшлуулжээ. Учир нь урьд нь хүн Сатанд сайн дураараа ялагдсан шигээ одоо Сатаныг сайн дураараа няц дарах орон зайг Бурхан хүнд гаргаж өгсөн юм. ... (Тийнхүү энэ нь хүмүүнд) ялалтаараа авралаа нэр төртэйгээр сэргээх боломж олгоно. Ийнхүү диавол өмнө нь хорлож чадсан хүндээ ялагдахдаа, уламчиг хатуу шийтгэл хүлээнэ. Үүнийг ухаарсан хүн Бурханы сайн сайхныг улам л бахдан бишрэх нь тодорхой буюу.”

Бурхан бидэнд аврагдахаасаа өмнө дарлуулж байсан дайснаа одоо бут цохиж, “адилтай болох” болох боломж олгожээ. Бүх алдар нь Бурханд байг. Дайсан одоо Бурханы гарын бүтээл болсон хүн төрөлхтнийг дарлаж чадахгүй. Дайсан Еден цэцэрлэгт Адамын алдаанд дөрөөлөн үүнийг хийж чадсан ч, хожим Есүс Өөрийн биеэр ирээд дайсныг гүйлтийн замаас гаргаж хаяад, өдгөө бидэнд диаволыг нэг мөр болгох завшаан олгожээ.

1Колоссай 1:24 дээр Паул “Одоо би та нарын төлөө зовоходоо баяртай байна. Түүний бие болох чуулганы төлөө Христийн зовлонд юу дутаж буйг нь би махбоддоо нөхдөг” гэжээ. Паулын энэ үг нь мэдэхгүй хүнд бол: “Биднийг бүрэн гүйцэт аврахад Есүсийн зовлон хангалтгүй байсан” гэж ойлгогдмоор байдаг учраас олон итгэгчид энэ бичээсээс нүүр улайх юмуу зайлсхийдэг. (Гэхдээ үнэндээ ийм бичээс байдгийг жирийн итгэгчид байтугай, номыг нь сурсан үйлчлэгч нар ч бараг мэддэггүй).

■

**Танд тулгарсан
бэрхшээл нь хэн
нэгэнд хэдийнээ
тулгарсан, хэн
нэгний хэдийнээ
ялсан зүйл!**

■

Гэхдээ Паул ингэж хэлээгүй. Паул харин ч хаанчлалыг дэлхийн хязгаар хүртэл тэлэхийн тулд шаардлагатай ажлаа тултал нь хийх бидний боломжийг л цохон тэмдэглээд байх шиг харагддаг. Есүс бидэнд Өөрийнхөө төгс гүйцэтгэсэн ажлыг дэлхийн хязгаарт хүргэх завшаан олгосон. Дайсан өшөө авахаар амь тэмцэн эсэргүүцэхдээ маш их гай зовлон учруулж байгаа ч, бидний хувьд энэ нь ялгуусан зовлон юм. Есүс чуулганыхаа талаар: “Үүнийг тамын хаалга тогтоож дийлэхгүй” гэж айлдсан (Матай 16:18). Энэ бол дайн. Бид Бурханы нигүүлслийн хүчээр жагсан давшсаар, газар нутгийг байлдан дагуулсаар явах бөгөөд биднийг там ч өөрөө тогтоож дийлж чадахгүй. Бурхан үүнийг амласан!

Танд ирж буй дайсагналыг өмнө хэн нэгэн итгэгч, тэр бүү хэл Христ Өөрөө ч хэдийнээ туулаад, даваад гарсан гэдгийг бүү март. Петр биднийг “Харин та нар баг итгэлээрээ түүнийг эсэргүүц. Дэлхийд буй ах дүү нар чинь адилхан зовлон эдэлж байгааг та нар мэднэ” (1Петр 5:9) хэмээн урамшуулсан. Бурханы хүслээр амьдрахад зовлон зэрэгцэж алхдаг нь үнэн боловч, Бурханы нигүүлслийн хүч дотор баг зогссон хүн үүнийг заавал ялна.

ЯЛАГДАХ ЯМАР Ч НӨХЦӨЛГҮЙ

Ийнхүү бид “зэвсэглэх” гурав дахь чухал зарчим дээр ирлээ. Энэ нь “хэзээ ч ялагдах албагүй” гэдгээ мэдэх. Есүсийн үгийг гөлрөөд л зогсоод байлгүй, харин гуд хийтэл залгилаад, сайтар эргэцүүлэн бод:

Харагтун! Могой ба хилэнцэт хорхойнуудад халдах, дайсны хамаг хүчээс дээгүүрх эрх мэдлийг Би та нарт өгсөн. Та нарт юу ч хор учруулахгүй. (Лук 10:19)

Айхтар мэдэгдэл байгаа биз! Нэгдүгээрт - харагтун гэдэг үгийг чухалчлан, анхаарлын тэмдэг тавьсан байгааг анхаарна уу. Хэрэв орчуулагч нар Есүсийн мэдэгдлийн ард анхаарлын тэмдэг тавьсан бол, энэ нь юу юунаас чухал учраас энэ үгийг юу юунаас илүү анхаарч хүлээж авах ёстой гэсэн үг юм.

Есүс Би та нарт зарим юмуу дийлэнх хүчээс дээгүүрх эр мэдлийг өгсөн гэж хэлээгүй, харин хамаг буюу бүх хүчээс дээгүүрх эрх мэдлийг өгсөн гэж айлджээ. Энэ бол 100 хувь. Та дайсны хүчний дээр зуун хувийн эрх мэдэл тогтоосон төдийгүй, Сатаны тэдгээр ёрын муу хүчээс хол давуу хүчтэй юм. Кинг Жэймс Вержн Библи дээр “Би та нарт дайсны бүх хүчийн дээгүүрх хүчийг өгч байна” гэдэг. Энэ нь Паулын “бас итгэдэг бидэнд хандсан Түүний хүч чадлын яндашгүй аугааг мэдэх болтугай. Тэр хүч нь ... бүх засаглал, эрх мэдэл, хүч, ноёрхол түүнчлэн энэ үед төдийгүй ирэх үед нэрлэгдэх аливаа нэрээс ч дээгүүр болгожээ” хэмээн залбирсантай (Ефес 1:19-21) таарч байна. Бидэнд зүгээр нэг илүү биш, харин хол илүү хүч өгөгджээ.

Бид дайсны бүх хүчээс дээгүүр эрх мэдэл, хүчтэй. Гэхдээ үүнээс гадна бас нэгэн гайхамшигтай үнэн бидний нэмэлт хүч болдог. 1Иохан 4:4 дээр бидэнд “Бяцхан хүүхдүүд ээ, та нар Бурханых бөгөөд тэднийг дийлсэн. Учир нь та нарын дотор байгаа Тэр бол дэлхийд байгчаас аугаа” гэдэг. Ёрын муу сүнснүүд нь Христийг эсэргүүцэгч сүнс бөгөөд бүх гай зовлонгийн үндэс мөн. Гэхдээ бидний дотор амьдарч, биднийг хүчирхэгжүүлж байдаг Нэгэн нь дайсныг хэдийнээ бут цохичихсон учраас бид ч бас дайснаа хэдийнээ ялсан юм.

Лук 10:19 дээр Есүс бидэнд “Та нарыг юу ч гэмтээхгүй” гэсэн. Таныг гэмтээж чадах ширхэг ч муу ёрын хүч байхгүй. Танд тулгарсан ямар ч тэмцэлд та ялагдах хувьгүй. Та Бурханы өгсөн зэвсгээр мятрашгүйгээр тулалдах аваас хэзээд ялаад л гарна. Энэ тал дээр ч Эзэн бидэнд амлалтаа өгсөн: “Биднийг Христ дотор ямагт ялуулдаг бөгөөд Түүний тухай мэдлэгийн анхилуун үнэрийг хаа сайгүй биднээр түгээдэг Бурханд харин талархал нь байг” (2Коринт 2:14).

Түүнийг анхааралтай сонсбол, Эзэн биднийг нөхцөл бүрт, тулаан бүрт ялалт руу дагуулна. Есүсийн амлалтыг Иохан ч баталдаг:

Бурханаар төрсөн бүхэн ертөнцийг ялдаг. Ертөнцийг ялсан ялалт нь бидний итгэл болой. (1Иохан 5:4)

Дэлхий бидэн рүү юу ч нүүлгэсэн бай - бид түүнийг нь итгэлээрээ ялаад л гарна. Сатан бол “энэ дэлхийн бурхан” гэдгийг бүү мартаарай. Сатан бидэн рүү юу ч нүүлгэсэн бай, түүнийг нь бид ялна. Учир нь бидний Бурхан хэдийнээ ялалтад хүргэх замыг тавьсан.

Иоханы үгээс үзбэл, энэ дэлхийг сөхрүүлдэг нь бидний итгэл ажээ. Яагаад итгэл гэж? Яагаад гэвэл итгэл бидэнд ялалтад хүргэх нигүүлсэлд (хүчинд) хүрэх эрхийг олгодог. Бид Бурханы нигүүлслээр амьдралд захирах тухай ярьж байна. Бурханы нигүүлсэл бидэнд үнэ төлбөргүй олгогдсон. Гэхдээ аливаа нөхцөл байдал дунд бидний амьдралд Бурханы нигүүлслийг (хүчийг) цутгах хоолой нь итгэл учраас, итгэж чадахгүй бол (итгэлтэй байхгүй бол), энэ бүхэн бүтэхгүй. Учир нь Ром 5:2 дээр Паул “Эдүгээ та нарыг босгон, ариусгагдсан бүхний дунд өв өгөх чадалтай Бурханд ба Түүний нигүүлслийн үгэнд би та нарыг даатгаж байна (Үйлс 20:32) гэсэн юм. Паул тэднийг Бурханы алдрын төлөө амьдруулах өвтэй байлгахын тулд Бурханы нигүүлсэл рүү харуулжээ.

ТУЛААН БҮРТ ЯЛУУЛАХ ХАНГАЛТТАЙ НИГҮҮЛСЭЛ

Энэ нь биднийг “зэвсэглэлийн” дөрөв дэхь чухал зарчим дээр авчирч байна: Бурханы нигүүлсэл нь таныг ямар ч дайсагналыг ялан дийлэх хангалттай хүч болно.

Бид үүнийг Паулын хувийн зөрчлөөс харж болно. Паулын ухаарал, илчлэл нь харанхуйн хаанчлалыг хиаруулж байсан. Ариун Сүнснээс татаж авсан эдгээр үнэн нь Паулын цаг үеийн итгэгчдийг болон түүний залгамж үеийн итгэгчдийг ихэд хүчирхэгжүүлсэн юм. Хожим Паул:

Мөнөөх агуу гайхамшигт илчлэлүүдээс болж махбодод минь өргөс өгөгдөж, өөрийгөө хэт дөвийлгөхөөс сэргийлж намайг Сатаны зарлага элч дэлссэн аж. (2Коринт 12:7)

Паулын энэ үгээс болж Библийн багш нар өөр хоорондоо ихээхэн тэмцэлддэг. Гэхдээ үнэндээ ингэх шаардлагагүй юм. Яг одоо үүний учрыг олж, хужрыг тунгаа.

Нэгдүгээрт- хэн Паулд “махбодын өргөс?” өгсөн бэ? Энэ нь Бурхан байх учиргүй. Учир нь Иаков 1:16-17-р ишлэлд “Хайрт ах дүү нар минь, бүү мэхлэгдэгтүн. Аливаа сайн соёрхол ба аливаа төгс бэлэг нь дээрээс, гэрлүүдийн Эцэгээс бууж ирдэг. Түүнд өөрчлөлт ч, өөрчлөгдөх сүүдэр ч үгүй” гэдэг. Бурханаас төгс, сайнаас өөр юм гардаг гэж бодож байгаа хүн мэхлэгдэж буй хэрэг ажээ. Тэгвэл Сатаны зарлага элч яагаад ч сайн юмуу тэр тусмаа төгс байж чадахгүй. “Гэхдээ энэ чинь Паулыг бардамнахаас сэргийлж байсан учраас, нөгөө талаараа сайн зүйл биш үү?” гэж хэлэх хүн гарч магадгүй. Тэгвэл энэ буруу бодлыг элч Иаков эрс няцаажээ: “Хэн нь ч уруу татагдахдаа “Бурхан намайг уруу татаж байна” гэж бүү яриг. Учир нь Бурхан муу муухайд уруу татагддаггүй бас Өөрөө хэнийг ч уруу татдаггүй (хэний ч зам дээр ёрын мууг тавьдаггүй)” (Иаков 1:13).

“Бурхан хэний ч зам дээр ёрын мууг тавьдаггүй” гэсэн байгааг анхаарна уу. Бурхан Паул руу Сатаны элчийг илгээж, ёрын муугаар сорьчихоод, дараа нь Иаковын гараар худлаа үг бичүүлсэн байж таарах уу? Үгүй, Бурхан худлаа ярьж чадахгүй. Тэгэхээр Паулын “өргөс” нь Бурханаас ирээгүй юм.

Хоёрдугаарт - Паулын махан дахь “өргөс” нь юу байв? Библийн багш нар үүнийг өвчин, харааны бэрхшээл, биеийн ямар нэг төрлийн доройтол байсан хэмээн янз бүрийн таамаг дэвшүүлдэг. Тэдний энэ дүгнэлт нь Паулын доорх үгтэй холбоотой юм:

Үүнийг надаас ангижруулж өгөөч гэж энэ талаар би Эзэнээс гурвантаа хүсэмжлэн гуйсан юм. Тэр надад “Миний нигүүлсэл чамд хангалттай. Учир нь мөхөсдөлд [Миний] хүч бүрэн төгс болдог” гэж айлдсан. Иймд Христийн хүч надад орших тул би ихэд баяртайгаар мөхөсдлөөрөө (доройтлоороо) илүү сайрхана.” (2Коринт 12:8-9)

Би мөхөсдөл, доройтол гэдэг хоёр үгийг тэмдэглэлээ. Гэхдээ доройтол гэдэг үг дээр илүү төвлөрөе. Самуурсан багш нар Паулын “доройтол дотроо сайрхана” гэдэг үгээс Паулын өргөс нь биеийн доройтол юм байна гэсэн дүгнэлт гаргадаг. Доройтол гэдэг нь астения гэдэг Грек үг юм. Шинэ гэрээнд 12 удаа гардаг энэхүү үг нь Сайн мэдээний номуудад үнэхээрийн ч гол төлөв биеийн доройтлыг нэр заасан байдаг бол, харин захидлууд дээр хүний аливааг өөрийнхөө хүч чадлаар ялах чадваргүй, гүйцэтгэх чадваргүй сул дорой чанарыг хэлсэн байдаг. Тиймээс Паулын тохиолдолд ч яг энэ тухай өгүүлсэн болно.

Ром 8:26 ч яг үүний жишээ юм. “Үүнчлэн мөн Сүнс бидний сул дорой байдалд тусалдаг. Учир нь яаж залбирах ёстойгоо бид мэддэггүй юм. Харин Сүнс Өөрөө үгээр илэрхийлшгүйгээр ёолон бидний төлөө зуучлан гуйдаг.” Сул дорой гэдэг нь мөнөөх астения гэдэг Грек үг юм. Тэгэхээр Христэд итгэдэг хүнд бие махбодын доройтол (өвчин юмуу эмгэг) байх албагүй гээд хэлчихээд нэг их буруудахгүй байх. Тэгвэл зуучлан залбирлын тал дээр итгэгч хүн бүрт тулгардаг сул дорой байдал нь юу вэ? Хариулт нь: бид заримдаа хязгаарлагдмал хүчин чадлаасаа болоод яаж залбирахаа мэддэггүй.

Жишээлбэл би Колорагод аж төрдөг. Гэтэл Флоридад аж төрдөг ээжид маань гэнэтийн явдал тохиолдсон ч, би ээжтэйгээ холбоо барьж чадахгүй байна гэж бодъё. Энэ үед би хүнийхээ хязгаарлагдмал нөхцөл байдлаасаа болоод ээжийнхээ төлөө яг юу гэж залбирахаа мэдэхгүй. Гэхдээ Ариун Сүнс миний сул дорой байдалд туслан, ээжийнхээ төлөө яаж залбирахыг зааж өгнө. Энэ тохиолдолд астения нь бие махбодын доройтолтой ямар ч хамаагүй, харин хүний чадвартай холбоотой болж байна.

Өөр нэгэн жишээ нь Еврей 4:15 юм: “Учир нь бидэнд байгаа нь бидний мөхөсдлийг өрөвдөж эс чадах тэргүүн тахилч бус, харин нүгэлгүй атлаа бүх талаар бидэн шиг соригдсон Нэгэн билээ.” Энд ч бас астения гэдэг үгээр хүний биеийн доройтлыг хэлээгүй, харин хүний хүчин мөхөс байдлыг Бурханы чадвартай харьцуулжээ. Есүс хүний зөрчлийг Өөрийн биеэр мэдэрч, нигүүлслээрээ туслаж чадахын тулд хүмүүний эдгээр хүчин мөхөс чанарыг сайн дураараа Өөр дээрээ авсан юм. “Тэр

бидэнтэй адил бүх талаараа соригдсон ч, нүгэлгүй байсан...” гэдэг бичээс нь ч Есүс газар дээр амьдрахдаа бидний өмнөөс байнга өвддөг байсан гэсэн үг биш, харин бидний хүчин мөхөс чанарыг сайн дураараа Өөр дээрээ авсныг л хэлжээ.

Яг энэ ойлголтоор Паулын дээрх мэдэгдлийг дахин харъя:

Үүнийг надаас ангижруулж өгөөч гэж энэ талаар би Эзэнээс гурвантаа хүсэмжлэн гуйсан юм. Тэр надад “Миний нигүүлсэл чамд хангалттай. Учир нь мөхөсдөлд [Миний] хүч бүрэн төгс болдог” гэж айлдсан. Иймд Христийн хүч надад орших тул би ихэд баяртайгаар мөхөсдлөөрөө (доройтлоороо) илүү сайрхана. (2Коринт 12:8-9)

Би дахиад л мөхөсдөл, доройтол гэдэг хоёр үгийг онцлон тэмдэглэлээ. Учир нь эдгээр нь хоёулаа астения гэдэг Грек үг юм. Тэгэхээр Паулын энэ үгийг зүгээр л:

“Хүний мөхөс байдалд Миний хүч төгс болгогддог учраас Миний нигүүлсэл чамд хангалттай.” Тиймээс би Христийн хүчийг тээхийн тулд хүнийхээ хүчин мөхөс байдал дотор сайрхана” гэж хэлж болно.

Энэ үгийг Библийн зарим орчуулга яг ингэж хэлсэн байдаг. Тухайлбал Орчин цагийн Англи Библи дээр ““Чамд Миний энэрэл нигүүлсэл байхад л болно. Чамайг сул дорой үед л Миний хүч дээд хэмжээндээ тулдаг” гэдэг. Тиймээс Христийн хүч байсаар байгаа цагт би өөрийнхөө сул дорой байдлаар онгирсоор байна” гэжээ.

Ариун Сүнс энд өвчний тухай л хэлсэн гэж бодож байгаа бол, та мэхлэгджээ. Үнэхээр тийм л юм бол, Бурхан Паулд “Чамайг өвчин эмгэгтээ баригдсан үед чинь л Миний хүч дээд зэргээр ажиллана” гэж хариулсан болж, харин Паул “Тиймээс Христ надад хүчээ өгсөөр байвал, би ямар их өвчтэй гэдгээрээ онгирсоор байна” гэж хэлсэн болж таарч байна. Утгагүй байгаа биз дээ? Ингээд нягтлаад үзэхээр, бид заримдаа ийм л инээдтэй зүйлд итгэж үнэмшиж явсан болж таардаг.

Түүнчлэн дээрх хэсгийг бүхлээр нь аваад үзбэл, Паул ямар ч өвчин эмгэгийн талаар яриагүй нь бүр ч тодорхой болдог. Паул энэ байдлыг “Сатаны элчийн” дайралт гэж дүгнэжээ:

Иудейчүүд намайг таван удаа гучин ес ташуурдсан. Намайг саваагаар гурвантаа жанчиж, нэг удаа над уруу чулуу шидэцгээж байв. Гурван удаа би усан онгоцны сүйрэлд өртөж, гүн тэнгист өдөр шөнийг өнгөрөөж байлаа. Ахин дахин аялахдаа, гол усны аюул, дээрэмчдийн аюул, овог нэгтний аюул, харийнхны аюул, хот дахь аюул, цөл дэх аюул, тэнгис дэх аюул, хуурамч ах дүүсийн дундах аюул, зүдэл зүтгэл, дараа дарамт, байнгын нойр дутал, өлдөл цангал, үргэлжийн мацаг, ноорол нүцгэрэл, даарал хөрөлд байлаа. Сайрхах ёстой бол би мөхөсдлөөрөө сайрхана.
(2Коринт 11:24-27, 30)

Паул Сатаны элч түүнд ямар их саад бэрхшээл учруулсныг тоочжээ. Паул энэ бүх гэнэтийн бэрхшээлээс өөрийнхөө хүчээр сэргийлэх юмуу таслан зогсоох арга байгаагүй. Тиймээс л тэрбээр: “Сайрхах ёстой бол, би мөхөсдлөөрөө л сайрхана” гэдгээ мэдэгджээ. Тэгэхээр Паулын захидалдаа өгүүлсэн сул дорой байдал буюу “махан бие дэхь өргөс” нь харааны бэрхшээл, эмгэг өвчин, бие махбодын доройтолтой ямар ч хамаагүй болно.

Паулын “махан бие дэхь өргөс” нь өвчинтэй ямар ч хамаагүй гэдгийг бүр баталгаатай болгох үүднээс энэ үгийг Бичээсийн өөр нэг хэсэгт ямар утгаар хэрэглэснийг харцгаая. Энэ хэллэг нь Хуучин гэрээнд гурван удаа гарахдаа, тус бүр Израильчууд руу зогсоо зайгүй халдах Канаанчуудын талаар ярихдаа хэрэглэгдсэн байдаг. Бурхан Өөрийнхөө хүмүүст “Харин та нар нутгийн оршин суугчдыг өмнөөсөө хөөн зайлуулахгүй бол тэднээс та нарын үлдээх үлдэгсэд нүдэнд чинь өргөс, хажуу хавиргад чинь сундуу болно. Тэд та нарын амьдрах нутаг дээр та нарыг зовоох болно” (Тооллого 33:55) гэжээ. Энд “бие дэхь өргөс” гэдэг үгээр үр жимстэй амьдрахад саад бологч эсэргүү хүмүүсийг дүрслэн хэлсэн байна. Тэгэхээр өргөс гэдэг үг нь Хуучин гэрээнд ямар ч өвчин эмгэгийг дүрслээгүй ажээ. Яг үүнтэй адилхан бичээсийн

эрдэмтэн Паул ч бас өргөс гэдэг үгээр амьдралынх нь замд тулгарсан аюул саадыг дүрслэн хэлжээ.

СЭТГЭЛГЭЭНИЙ ЭРС ӨӨРЧЛӨЛТ

Паул зогсоо зайгүй нүүрлэж байгаа энэ бүх садаа, бэрхшээл, аюул заналаас залхсандаа Бурханд хандан нэг биш, харин гурвын гурван удаа энэ бүхний ард байгаа Сатаныг зайлуулж өгөхийг хүсэн гуйжээ. Миний бодлоор Бурхан анхандаа Паул буруу хүсэлт тавьж, буруу мод сэгсэрч байсан учраас хариулаагүй байх. Харин гурав дахиа гуйсны дараа Эзэн Паулыг ухааруулж, өөрт нь хэдийн байгаа шийдлийг нь олж харуулжээ. Бурхан Паулд:

Чи өдий хүртэл ухаараагүй хэрэг үү? Би чамд дайсны бүх хүчээс давуу нигүүлсийг өгсөн (хязгааргүй хүчийг). Чамд Миний нигүүлсэл (хүч) байхад л болно. Миний нигүүлсэл чамайг хүнийхээ хүчээр хийж чадахгүй юмсаа хийх хүчтэй болгоно. Өөрөөр хэлбэл зүгээр л итгэсэн нөхцөлд хэдий том эсэргүүцэл ирнэ, чи төдий том нигүүлслийг (хүчийг) үзнэ гэж айлджээ (2Коринт 12:9 зохиолчийн найруулга)

Паул үүнийг ухаарах үед гайхамшиг болж, бодол сэтгэлгээ нь сууриараа эргэжээ. Паул зогсоо зайгүй бөмбөгдөх Сатаны эсэргүүцэлд тэс өөрөөр ханддаг болов. Паул зовлонг зайлуулж өгөхийг гуйж гувшихаа болих нь бүү хэл маш баяр хөөртэйгээр ингэж бичжээ:

Иймд Христийн төлөө мөхөсдөл, доромжлол, гачигдал, хавчлага, шахалтдаа би баяртай байна. Учир нь би хэзээ мөхөсдөнө, тэр үедээ хүчтэй байдаг. (2Коринт 12:10)

Паул “Одооноос эхлээд би ямар ч тлипсисийн өмнө хүнийхээ хүчин мөхөс чанарт баярлана!” хэмээн онгирчээ.

Байзаарай, баярлах гэнэ ээ? Юу гэсэн үг вэ? Өөр нэгэн орчуулгад “Би энэ дарамтанд таатай байна” гэдэг бол, бас нэгэн

орчуулгад “Таашаал эдлэдэг...” гэдэг. Паул солиорчихоогүй байгаа аа? Эсвэл жаахан давс хужир нэмэх юмуу хачирлаж бураад байна уу? Яалаа гэж! Бурхан худлаа ярьж чаддаггүй учраас Ариун Сүнсний хөтөлгөөгөөр Бичээсийг бичсэн ямар ч хүн худлаа юм бичиж чадахгүй. Тэгвэл хүн яаж бэрхшээл, доромжлол, аюул занал, дайсагнал тэргүүтэй зовлонг таашааж, зовлонд “баярладаг” байна аа? Хариулт нь маш энгийн:

Эсэргүүцэл том байх тусам, үүнийг илүү том хүчээр ялж гарах бөгөөд ирэх ялалт нь ч тэр том байна.

Ихэнх итгэгчид хүнд хэцүү байдалд орохоороо царай алдчихдаг. Тэд дайсантай байлдана гэхээс “сүнс нь зайлдаг”. Тэд тэмцэлгүй, хялбар, таатай, тухтай амьдралыг л хүсдэг. Тэдний зүрхэнд Паулын олж мэдсэн үнэн байдаггүй. Эсэргүүцэл бүр нь ердөө л доторх хүчээ (нигүүлсэлээ) харуулж, Христ дотор нэг шат өсч төлөвших боломж гэдгийг тэд ухаардаггүй. Паул Бурханаас ухаарал олохоосоо өмнө дайсагналд яг л ингэж ханддаг байсан. Гэхдээ Бурханы ганц үг Паулын бодол сэтгэлгээг эрс шинэчлэсэн юм. Паул 2Коринт захидлаа МЭ 56 он хавьцаа бичсэн. Үүнээс хэдэн жилийн дараа тэрбээр Ромчуудад хандсан захидлаа бичсэн. Тэгэхдээ Паул Ром номд тлипсист тэс өөрөөр хандсан байгааг ажиглаарай:

Хэн биднийг Христийн хайраас салгах юм бэ? Гамшиг уу, шахалт уу, хавчлага уу, өлсгөлөн үү, нүцгэрэл үү, аюул уу, илд үү? Харин бид энэ бүхний дотор биднийг хайрладаг Түүгээр дамжин давуулан дийлдэг. (Ром 8:35, 37)

“Харин бид энэ бүхний дотор биднийг хайрладаг Түүгээр дамжин давуулан дийлдэг” гэсэн үгийг онцлон хүлээж аваарай. Нөгөө зовлонгоос авраач хэмээн Бурханаас гуйж гувшиж байсан Паул чинь одоо “Бурханы нигүүлсэл байхад бид бэрхшээлийг давж гарахаар барахгүй, гялалзсан ялалтанд ч хүрнэ” хэмээн тэс өөр юм ярьж байна. Үнэндээ Паул ханцуйгаа шамлаад: “За муу дайсан! Чамд гүйгээд ирэхийн

гүзээ байна уу? Христийн дотор чамайг ёстой болгоод, дархан цолоо мандуулаад өгье!” хэмээжээ. Паул “зовохоор зэвсэглэжээ.” Тэр дайралцаад, алалцаад, тулаанд орсноосоо ч илүү хүчирхэгжээд ялаад гарч ирэхээр нүд нь гялалзаж, шүд нь тачигнаж байна.

ЗОВЛОНГ БОЛОМЖ ГЭЖ ҮЗ

“Зэвсэглэх” ёстой сүүлийн зарчим бол бэрхшээлийг эхнээс нь дуустал өөдрөгөөр үзэх юм. Сорилтыг зовлон гэж биш, боломж гэж хардаг хүн өөдрөг байж чадна.

Элч Иаков “Ах дүү нар минь, элдвийн сорилтод орохдоо үүнийг бүрэн баяр хөөр гэж үз” гэжээ (Иаков 1:2). Бид энэ дайнд Христийн дотор хэдийнээ ялсан бөгөөд тэнгэрийн бүх эрх мэдэл, хүч бидний арыг хамгаалж байна. Өөрсдөө л буугаад өгчилгүй, мятрашгүй зогсоод, тулалдбал, ялаад л гарна. Бурхан бидэнд ийм л хувь тавилан, хүсэл зэхсэн.

Үүнийг ч Ром 8:31 дээр Паул чангаар батлан хэлсэн: “Бурхан бидний төлөө байхад, хэн биднийг эсэргүүцэх вэ?”

Нигүүлсэл дотор хүчтэй

Учир нь бидний тэмцэл бол мах цусны эсрэг биш,
харин энэхүү харанхуй ертөнцийн захирагчид, эрх мэдэл,
хүчнүүд, тэнгэрлэг оршихуй дахь ёрын муу
сүнслэг хүчний эсрэг билээ.

Ефес 6:12

Бурханы хүүхэд бүр байлдаж байна. Байлддаггүй нэгэн нь зүгээр л өөрийгөө Бурханы хүүхэд гэж андуурсан энэ дэлхийн хүн юм.

Хатуу үг санагдаж магадгүй ээ. Гэхдээ үүний бодит байдлыг би танд нэгэн жишээгээр дүрслэн ойлгуулахыг хичээе. Бид Гитлерийн Германд аж төрж байна гэж бодъё. Гитлер Европ даяар Нацистын Германы бүрэн захиргааг тогтоохыг хүсчээ. Хүмүүс Гитлерийг туйлын цэвэр сэтгэлтэн хэмээн талархан хүлээн авч байв. Харин Гитлер Еврейчүүдийг үзэж чаддаггүй байлаа. Хэрэв та Герман гаралтай, ухаантай, эрүүл чийрэг бөгөөд Адольф Гитлерийн үзэл баримтлалыг дэмждэг хүн бол, айж эмээх явдалгүй, амар сайхан амьдарч чадах байв.

Харин та Еврей гаралтай бол, таныг тэс өөр амьдрал хүлээнэ. Та цаг үргэлж алуулах, гүтгүүлэх, нулимуулах, хорлон сүйтгүүлэх, цөлмүүлэх аюулд байгаа учраас хэзээ баривчлагдаж, боолчлогдож, тамлуулж, алуулах бол хэмээн байн байн баруун зүүнээ харж явах хэрэгтэй болно. Арга

ухаанаар зэвсэглэсэн сэрэмжтэй Еврейчүүд нь амиа аврахын төлөө хэрэгтэй бүхнийг хийж байхад, ингэж чадаагүй нь шоронд орж, хорих лагерьт амиа алдаж байв.

Тэгвэл Саган ба түүний хамсаатнууд нь Гитлерээс хэд дахин дор юм. Хэрэв та диаволаас гаралтай бол, тэд таныг яах ч үгүй. Та цэрэг хүн шиг цаг үргэлж тулаанд бэлэн байх шаардлагагүй. Есүс тухайн үеийнхээ хоёр нүүртэй сүнслэг удирдагч нарыг “Та нар энэ дэлхийнх” (Иохан 8:23) гэсэн байдаг. Тэгээд энэ санаагаа улам батжуулах үүднээс “Та нар эцэг диаволаасаа гаралтай” (Иохан 8:44) хэмээн шууд хэлжээ. Тэдгээр удирдагч нар өөрсдийгөө Аугаа хүчирхэг Бурханд үйлчилж байна бодож байсан ч, үнэндээ тэд энэ дэлхийн дарангуйлагчид үйлчилж байжээ.

Та Бурханы хүн мөн л бол, цаг үргэлж тулаанд бэлэн байх ёстой. Учир нь таны амьдарч байгаа энэ дэлхий нь Бурханд хамаатай бүхэнтэй дайсагнадаг юм. Эзэн маань:

Та нар ертөнцийнх байсан бол ертөнц өөрийнхнийгөө хайрлахсан. Харин та нар ертөнцийнх биш, гагцхүү Би та нарыг ертөнцөөс сонгосон юм. Тиймээс ертөнц та нарыг үзэн яддаг. (Иохан 15:19)

Есүс “Ертөнц та нарыг үзэн яддаг” гэж айлдсан байгааг анхаарна уу. Энэ мэдэгдлийг зөөлрүүлэх арга байхгүй. Та энэ дэлхийнх бол, дэлхий таныг хайрлана; та Бурханых бол дэлхий таныг нүд үзүүлэн эсэргүүцнэ.

НИГҮҮЛСЛИЙН ЗЭВСГҮҮД

Тэгэхээр бүрэн “зэвсэглэхийн” өөр нэгэн чухал зарчим нь Есүс Христ доторх зэвсгээ ажиллуулж мэддэг байх юм. Паул “Бидний байлдааны зэвсэг нь махбодынх бус, харин ялагдашгүйг ч ялж чадах Бурханы хүчит зэвсгүүд (тэнгэрлэг хүч) юм. Бид цэцэрхлийг нурааж...” (2Коринт 10:4) гэж хэлсэн учраас эдгээр нь хоёулаа хүчирхэг сүнслэг зэвсэг ажээ.

Хүчирхэг цайзыг нураадаг “тэнгэрлэг хүч” гэж юу вэ? Мэдээж бүх итгэгч нарт хайрласан яндашгүй бэлэг болох

Бурханы гайхамшигт нигүүлслээс өөр юу байхав. Үүнийг санангаа судлалаа Петрийн нэгдүгээр захидлаар үргэлжлүүлэе. Судлалынхаа явцад нигүүлсэл гэдэг үгийг хүч юмуу хүч чадал гэдэг үгсээр солбиж уншина гэдгийг мэдээрэй.

Залуус аа, та нар мөн түүнчлэн ахлагчдадаа захирагд. Та бүгд бие биендээ даруу хандах байдлаар хувцасла. Учир нь Бурхан бардмыг эсэргүүцдэг, харин дарууд нигүүлсэл (хүч) өгдөг. Иймд Бурханы хүчирхэг мутрын дор өөрсдийгөө даруу байлга. Тэгвэл Бурхан зохистой цагт та нарыг өргөмжилнө. Тэр та нарт санаа тавьдаг учраас бүх зовнилоо Түүнд хая. Эрүүл ухаантай, сонор сэрэмжтэй бай. Та нарын өрсөлдөгч болох диавол нь хэн нэгнийг залгихаар хайж буй архирах арслан мэт гэтэн явдаг. Харин та нар бат итгэлээрээ түүнийг эсэргүүц. Дэлхийд буй ах дүү нар чинь адилхан зовлон эдэлж байгааг та нар мэднэ. Христ дотор та нарыг Өөрийн мөнх алдарт дуудсан, бүх нигүүлслийн (хүч чадлын) Бурхан Өөрөө, түр зуур зовсны чинь дараа та нарыг төгс болгож, бататгаж, бэхжүүлэн байгуулах болно. Сүр хүч нь үеийн үед Түүнд байх болтугай. Амен. Энэ нь Бурханы жинхэнэ нигүүлсэл (хүч) гэдгийг би та нарт гэрчилж, сургамжлан бидний итгэмжит ах дүү болох (би тэгж үздэг) Силуанаар дамжуулан товчхон бичлээ. Энэ нигүүлсэлд бат зогс.
(1Петр 5:5-12)

Би эхлээд Петрийн энэ их баялаг үгийг хураангуйлаад, дараа нь хэсэгчлэн задлан заамаар байна. Энд ерөөсөө л Бурханы нигүүлслийн тухай өгүүлжээ. Петр яриагаа биднийг бие биедээ захирагдахаас эхлэжээ. Өөрөөр хэлбэл “нэгэн даалгавар дор ор” гэжээ. Үүнийхээ дараа Бурхан нигүүлслээ даруу хүнд өгдөг бөгөөд зовнилоо өөрийнхөө хүчээр шийдэх биш, Бурханы нигүүлсэлд (хүчинд) даатгах нь даруу байдал юм гэсэн байна.

Петр ямар зовнилын талаар ярина вэ? Үүнд зовнил, хариуцлага, хэрэгцээ тэргүүтэй амьдралын төрөл бүрийн асуудал орно. Зовнил маань түр зуурын ч байж болно эсвэл хаанчлалын баялгийг эдлээд эцэстээ бусдынхаа хэрэгцээг

хангах гэсэн мөнхийн ч зовнил байж болно. Нигүүлслийн энэ даалгавраа биелүүлэх замдаа бид диавол болон түүний хамсаатнуудын зүгээс ирэх эсэргүүцэлтэй тулдаг. Сатан биднийг зовоодог - гэхдээ энэ нь Бурханы хүсэл биш юм. Тиймээс эрүүл саруул ухаанаа хадгалж, Бурханы гэрээний амлалтыг санаж, залбирлаараа сонор соргог байх хэрэгтэй. Түүнчлэн бид Бурханы хаанчлалын зорилгыг ахиулж, дайснаа сөрж гарахын тулд хэзээд Бурханы нигүүлслээр онцсайн бэлтгэгдсэн байх ёстой.

Гэхдээ бид ганцаараа зүтгээгүй, даян дэлхийн итгэл нэгт ахан дүүс маань яг адилхан нигүүлслийн даалгавар биелүүлэхээр, яг адилхан дайнд яг адилхан тулалдаж яваа. Эдгээр тулаан нь биднийг илүү хүчтэй, төлөвшилтэй болгодог учраас бидэнд харин ч тустай юм. Тулаанд ялах тусам бид Христийн дотор илүү өндөр эрх мэдлийн байр суурь руу дэвшинэ.

Петр яриагаа “Энэ бол Бурханы жинхэнэ нигүүлсэл мөн” гэсэн үнэхээр урамтай үгээр өндөрлөжээ. Бурханы жинхэнэ нигүүлсэл гэдэг үгийг бичүүлэхээр хоёр мянгаад жилийн тэртээ Ариун Сүнс Петр дээр буусан гэж бодохоор гайхмаар биш үү? Эцсийн өдрүүдэд буюу өнөөдөр Бурханы нигүүлслийн талаарх ойлголт (ядаж л Барууны Христэд итгэгчдийн сэтгэлгээнд) нүглийн хаацайлал,

■

**Дийлэнх итгэгчид
нигүүлслийн
зэвсгээ
ашигладаггүй**

■

тэнгэрт орох тасалбар төдий болтлоо хумигдана гэдгийг Ариун Сүнс урьдаас харжээ. Хэдийгээр энэ хоёр нь Бурханы нигүүлсэлд яахын аргагүй багтдаг боловч, нигүүлслийн хамгийн гол чанар нь биднийг хүлээсэн даалгавраа биелүүлэхийн төлөө төрөлх

чадвараасаа давсан хүчтэй болгодог. Энэ даалгаврын томоохон тал нь Бурханыг алдаршуулж, Бурханы хаанчлалыг тэлэхийн төлөө өөрсдийгөө онцгойруулах юм.

Өнөөдөр улам л цөөхөн итгэгчид гэрэлтэж байгаа нь ч аргагүй юм. Учир нь бид тулалдаж байж өөрсдийгөө онцгойруулдаг байтал, дийлэнх маань тулаанаас зугтаж байна. Дайсан хий хэвтэж байгаад л бидний ажлыг хийлгэчихнэ гэж

бодож байвал та эндүүрч байна. Дайсан бидний даалгаврыг таслан зогсоохын төлөө чадахаасаа чадахгүйгээ хүртэл явах учраас бид ч бас дайсны өөдөөс босоо байж л Бурханы зорилгыг биелүүлнэ. Нью Стандарт Вержн Библи дээр “Энэ бол Бурханы үнэн нигүүлсэл. Үүн дотор бат зогс” гэдэг. Энэ үгийн дараа Тимотод хандсан Паулын үг улам ч баттай болно:

Иймд хүү минь, Христ Есүст буй нигүүлслээр зоригтой бай.
Христ Есүсийн сайн цэрэг адил надтай хамт зов.
(2Тимот 2:1, 3)

Паул Тимотод биеэр, харилцаагаар, сэтгэл санаагаар юмуу оюунаар хүчтэй бай гэж хэлээгүй, харин нигүүлслээр хүчтэй бай гэжээ. Энэ бол бидний амжилттай төгсгөх зэвсэг юм. Дийлэнх итгэгчид нигүүлслийн зэвсгээ ашигладаггүй болохыг үйлчлэлийн талбарт тавин таван жил тулалдаж яваа хүнийхээ хувьд би мэднэ. Үүнийг ч бидний хийсэн судалгаа батласан. Бид өөрт байгаа зэвсгээ мэддэггүй.

2Тимотын 2-р бүлгээс өмнө Паул Тимотыг эсэргүүцэл, хавчлагад бууж өгснийг нь засч залруулсан байдаг. Залуу Тимот дайснаас хулчийж, Паулын харж байсан хэмжээнд дайснаа сөрөн зогсож, тулалдаж чадаагүй болтой. Тэр үед Паул Тимотод Бурхан түүнд айдсын сүнснийг биш, харин хүч, хайр, биеэ захирах сүнснийг өгснийг нь хэлжээ. Итгэгч бидний нэгэн адил Тимотод бүх эсэргүүцлийг ялж гарахад шаардлагатай бүхэн хэдийнээ байсан учраас Паул түүнийг сэрээж, Христ доторх нигүүлсэл дотор хүчтэй байхыг ятган сэнхрүүлжээ (2Тимот 1:6-7; 2:1).

Өндөр дуудлага руу ахина гэдэг хэн дуртайд нь олддог зүйл биш юм. Бид тэр аугаа амьдрал руу өлмий дээрээ бүжсээр юмуу эсвэл салхины хурдаар орохгүй. Паул өөрийгөө “Христ Есүс дотор Бурханы дээш чиглэсэн дуудлагын шагналын төлөө бариа өөд урагшилдаг (давшдаг)” (Филиппой 3:14) гэсэн. Давшина гэдэг үг нь эсэргүүцэл, сөргөлдөөнийг давхар илтгэнэ.

Дөрөвдүгээр бүлэгт гарсан завьтай хүнийг санаж байна уу? Сайхь эр голын хүчтэй урсгал өөд хүч үзэн зогсоо зайгүй

сэлүүрдсээр байгаад эцэстээ тамирдсан. Яагаад? Миний бодлоор хажуугаар нь ямар ч тэмцэлгүй, эрх дураараа хөвж, жаргалдаа умбаж яваа “амжилттай” завинуудыг харсаар байгаад цөхөрсөн байх. Тэгээд тэрбээр угтаа хуурамч зэрэглээ боловч, ядарч цөхсөн түүнд дэндүү бодитой харагдсан хялбар замыг сонгожээ. Тэрбээр тэмцэлгүй, амар хялбар “итгэлийн” амьдралаар амьдарч болдог юм байна гэж бодсон ч, харамсалтай нь энэ нь аймшигтай худал байдаг.

Өөр нэгэн жишээ хэлье. Чөлөөнд байгаа цэрэг хүн галын шугаманд байгаа нөхөд шигээ зовохгүй. Гэхдээ тэр цэрэг л тулалдахгүй, чөлөөнд байгаа болохоос, дайн үргэлжилсээр байгаа. Завьтай хүний адил энэ цэрэг ч бас цэрэг хувцастай, бүрэн зэвсэгтэй, винтов буутай, өөрөөр хэлбэл байлдаанд бэлэн байгаа ч, түүнд ямар ч эсэргүүцэл ирээгүй байна.

Хаанчлалыг тэлж, диаволын ажлыг нураахдаа, Христ шиг харагдах биш, Христ шиг үйлдэх нь бидний зорилго мөн (1Иохан 3:8). Харин Христ шиг үйлддэг хүнд эсэргүүцэл ирнэ.

Бид Бурханы нигүүлслээр (хүчээр) ямар ч бэрхшээлийг давж гарна. Гэхдээ үүнийг хөдлөшгүй итгэлээр л хийнэ. Учир жинхэнэ итгэлийг ямагт үйлдэл дагалддаг. Петр усан дээгүүр алхсан нь ямар ч боломжгүй, ер бусын явдал байсан. Есүсийн “Хүрээд ир” гэсэн ганц үгт Петрийг усан дээр алхуулахад хэрэгцээтэй бүх нигүүлсэл багтсан байжээ. Харин Петрийг итгэхээ болиход, нигүүлсэл (буюу хүч) замхарч, тэрбээр живж эхэлсэн юм. Гэтэл Петр итгэсээр байсан бол, хүрээд ир гэдэг ганц үгэн дэхь нигүүлсэл (буюу хүч) нь Петрийг Есүс дээр очуулж эсвэл бүр Галил далайг бүрэн гатлуулж ч чадах байв. Гэхдээ Петр итгэж чадаагүй учраас нигүүлсэл ч ажиллаагүй юм. Христ доторх хязгааргүй нигүүлсэлд бид гагцхүү итгэлээр л хүрнэ: “нигүүлсэл уруу бид Түүгээр дамжин итгэлээр орох боломжтой болсон (Ром 5:2).

Тэгэхээр асуудал нь нигүүсэлдээ биш, харин бидний итгэлгүй байдалд бий. Итгэл байхгүй учраас нигүүлсэл (буюу хүч) тасардаг. Тийнхүү бид өөрийнхөө хүчээр үзэлцсээр хоцордог. Гэрийнхээ сангийн хоолойг аваад үз. Хоолой хагарвал, ус тасарна. Хэдийгээр хотын цэвэр усны нөөц санд хязгааргүй их ус байгаа ч, танай сангийн хоолой эвдэрсэн учраас, гэр орон

чинь усгүй болно. Итгэл бол хоолой; ус бол нигүүлсэл.

Тиймээс итгэлээ байгуул. Яаж? Бурханы Үг дотор булх ; Бурханы сайн сайхныг нь магтан хүндэтгэж, нигүүлслийнх нь хангамжид таларх; Сүнс дотор залбир. Эдгээрээр итгэлээ байгуулахгүй бол, эцэстээ итгэхээ больж, Бурханы хүчээр биш, өөрийнхөө хүчээр амьдарч эхлэнэ. Тэгээд тун удалгүй дэлхийг захирахаа больж, дэлхийд захирагдаж эхлэнэ.

Тиймээс л Петр биднийг “Харин бидний Эзэн бөгөөд Аврагч Есүс Христийн нигүүлсэл болон мэдлэг дотор өсөгтүн” (2Петр 3:18) гэж ятгажээ. Петр бидэнд Бурханы хүч дотор өсөх хариуцлага оноожээ. Үүнийг итгэлээ байгуулснаар л хийх бөгөөд бид итгэлээ өсгөж чадна. Ром 1:17 дээр Паул “«Зөвт хүн итгэлээр амьдарна» гэж бичигдсэнтэй адилаар, Бурханы хүртээх зөвт байдал нь сайн мэдээний дотор итгэлээс итгэлд илчлэгддэг” гэжээ. Итгэл чинь өсөх тусам, “хоолой” чинь томорч, эцэстээ танд очих “ус” (буюу нигүүлсэл) чинь ч ихсэнэ. Тийнхүү таны Бурханаас хүлээж авах үүрэг даалгавар чинь ч томорно.

Би таныг Еврей номын үгээр урамшуулмаар байна:

Иймд сульдсан гар, салгалсан өвдгөө тэнхрүүлэгтүн.
Доголон нь замаасаа хазайхгүй, харин эдгээгдэхийн тулд хөлдөө зориулж шулуун жим тавь. Хэн чинь ч Бурханы нигүүлслээс хоцрохгүйн тулд болон аливаа гашуун үндэс урган хор учруулж, түүгээр олноороо бузарлагдахгүйн тулд сэрэмжил. (Еврей 12:12-13,15)

Бурханы нигүүлслээс эргэнэ гэдэг нь өөртөө ханаж, идэвхигүй төлөвт шилжин, дайсандаа бууж өгнө гэсэн үг. Бид яагаад Бурханы ер бусын, гайхамшигтай хүчээс эргэх ёстой гэж? Яагаад Бурханы гайхамшигт нигүүлслийн хүчийг зохих ёсоор нь ашиглахгүй цалгардуулах ёстой гэж?

Бид дайтаж байна. Энэ дайныг сайн төгсгөх цорын ганц арга нь мятрашгүй итгэлээр амьдрах. Эзэнд баясдаг мятрашгүй итгэлтэй хүн харанхуйн хаанчлалыг жинхэнэ утгаараа сүйрүүлдэг. Энэ бол Эзэн Есүс Христэд үйлчлэх

бидний дуудлага, хувь тавилан, завшаан мөн.

ДАРУУ БАЙДЛЫН ЗЭВСЭГ

Залуус аа, та нар (бүгдээрээ) мөн түүнчлэн ахлагчдадаа захирагд. Та бүгд бие биедээ даруу хандах байдлаар хувцасла. Учир нь Бурхан бардмыг эсэргүүцдэг, харин дарууд нигүүлсэл өгдөг. Иймд Бурханы хүчирхэг мутрын дор өөрсдийгөө даруу байлга. Тэгвэл Бурхан зохистой цагт та нарыг өргөмжилнө. Тэр та нарт санаа тавьдаг учраас бүх зовнилоо Түүнд хая.

1Петр 5:5-7

Библид, “Бие биедээ захирагдаж... даруу чанараар хувцаслаж... өөрсдийгөө даруусга” гэжээ.

Амьдарсан шиг амьдарч, амьдралаа сайн дуусгамаар байвал, Петрийн энэ үгийг цээжилж явбал зохилтой. Петр эхлээд “бие биедээ захирагд” гэжээ. Захирагдах гэдэг үг нь энд “нэгэн даалгавар дор орох” гэсэн утга илэрхийлнэ. Тэгвэл өөр өөрийн гэсэн зан чанар, хүч, хүсэлтэй энэ олон хүн яаж үүнийг хийх вэ? Өөрсдийгөө даруу чанараар хувцасласнаар л хийж чадна. Бурхан бардам хүнийг эсэргүүцдэг. Харин бид Бурханы дургүйг хүргэж, Бурханаар эсэргүүцэгдэхийг хүсэхгүй! Бурхан даруу хүнд нигүүлслээ (буюу хүчээ) өгдөг.

Тэгвэл хэн бардам, хэн даруу вэ?

ДАРУУ НЬ БУРХАНЫ НИГҮҮЛСЛИЙГ ХҮРТЭНЭ

Жинхэнэ даруу Христэд итгэгчид нь амин хувийнхаа бодол, шалтгаан, мэдрэмж, хүслээс илүү Бурханы Үгд итгэж, найдаж, дагаж, Бурханы чадварт бүрэн төгс найддаг. Тэд амин хувийнхаа юмуу хүмүүсийн хүслийг биш, Бурханы хүслийг хайдаг. Тэд Бурханы даалгаврыг биелүүлэхийг зорьдог. “Харагтун, бардам нэгний сэтгэл нь зөв бус байдаг юм. Харин зөвт хүн итгэлээрээ амьдарна” (Хабаккук 2:4).

Хабаккук 2:4 дээр бардамнал ба итгэлийг өөр хооронд нь сөргүүлэн дүрслэжээ. Энэ ишлэлийг “Харагтун, даруу бишийн сэтгэл нь зөв бус байдаг юм. Харин зөвт хүн итгэлээр амьдарна” гэж хэлж болно. Энд даруу байдал, итгэл хоёр мөр зэрэгцэн алхаж байна. Бардамнал, итгэлгүй байдал хоёр ч ялгаагүй. Бурханд итгэхгүй байх нь өөрийгөө Бурханаас дээр үзэж, Бурханы биш, өөрийнхөө үзэл бодолд итгэх явдал юм. Итгэлгүй байдал нь ердөө л зүсээ хувиргасан бардам зан юм.

Ийм нэгэн түүх бий. Израиль Египетээс чөлөөлөгдснөөс жилийн дараа Эзэн Мосед “Израилийн хөвгүүдэд Миний өгөх гэж буй Канаан нутгийг тандуулахаар өөрсдөөсөө хүмүүсийг илгээ. Эцгүүдийнх нь овог бүрээс, тэдний дунд удирдагч болох хүн бүрийг чи илгээгтүн” (Тооллого 13:2) хэмээн айлддаг. Бурхан энэ үгээ ямар ч маяггүй, яг л зангаараа түс тас хэлжээ.

Мосе ч арван хоёр овгийн удирдагч нарыг илгээв. Гэхдээ тэдний өөрсдийнх нь хэлснээр тэр арван хоёрын арав нь маш даруу, харин үлдсэн хоёр хүн нь маш бардам байжээ. (Та энэ түүхийг мэддэг ч гэсэн надтай хамт байгаарай. Би гол санаагаа тодруулах үүднээс жаахан хошин шогийн мэдрэмжээ ашиглалаа шүү).

Манай арван хоёр ч Амлагдсан газрыг дөч хоногийн хугацаанд хөндлөн гулд туулаад эргэж ирэв. Тэгээд арван хүн нь: “За бид их ч явлаа, ихийг ч үзлээ. Үнэхээрийн ч сүү балаар халгисан сайхан нутаг юм. Энэ жимсийг л харчих. Гэхдээ тэдний цэрэг дайчид нь дийлдэшгүй юм - дээрээс нь үлэмж биетэй ч юм! Бидэнтэй зүйрлэшгүй мундаг зэр зэвсэгтэй мэргэшсэн дайчид юм. Хажууд нь бид юу вэ - харлаж яваа

боол явсан улс шүү дээ. Хэдий тийм ч бид чинь бас ар гэртэй улс! Юу гэж ар гэр, амраг садангаа эргийн нөгөө талд отох аймшигт харгислал, тамлал, хүчин, үхлийн аманд аваачаад хийчихэв дээ? Бид чинь айл гэрийн хариуцлагатай, сайн аав, эр нөхөр болсон хүмүүс. Үнэн байдал маань л энэ. Энэ газрыг эзлэнэ гэдэг бүтэшгүй хэрэг” гэжээ.

Ард түмэн ч тэр газрыг хүсч байсан ч, аюулгүй байдалдаа нэн түрүүнд санаа зовсон тул мөнөөх арвын мэргэн ухааныг хурайлан дэмжив. Энэ мэдээг дуулсан дийлэнх аав, ээжүүд тэр арван туршуулын энэрэнгүй сэтгэлийг бахдан сайшаасан гэдэгт эргэлзэх юм алга. Израильчууд өөр хоорондоо: “Энэ сайхан хүмүүс бидний өмнөөс яваад ирсэн нь юутай сайн хэрэг вэ? Ард түмнийхээ аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьдаг яасан мундаг удирдагч нар вэ! Тэдний энэ торгон мэдрэмж байгаагүй бол, бид ер нь яах байсан бол?” хэмээн дуу дуугаа авалцан магтсан байх.

Гэтэл Иошуа, Калев гэдэг хоёр “бардам” нөхрийн хашхираа тэдний магтаалыг тасалдуулж орхив. “Байзаарай! Энэ чинь юу болж байна? Бид яг одоо яваад, тэр газрыг эзлэх хэрэгтэй! Бид чадна! Бурхан бидэнд амласан. Бидэнд Бурханы амлалт үг байна! Бид тэр хүмүүсийг ялж чадна. Тиймээс яг одоо шийдэцгээе!”

Хүмүүс нам болов. Тэд чихэндээ ч итгэсэнгүй. Тэд амаа ч нээж чадахгүй, хий л бие биеэ гөлөрнө. Калев, Иошуа хоёрын энэ их шавдуу, болгоомжгүй зөвлөгөөг сонсоод, мөнөөх арав яасныг төсөөлж байна уу? Миний бодлоор анхныхаа сочролоос гармагцаа нэг иймэрхүү юм хэлсэн байх: “Та хоёр чинь юугаа донгосно вэ? Солиороо юу? Бид бүгдээрээ л яг адилхан юм харсан - бүгдээрээ л тэр улсын хүч, зэвсэг, бат хэрмэн хотууд, аварга биетэй, ур чадвар ихтэй дайчдыг харсан. Бидний хэдэн боол тэдний хаа ч хүрэхгүй. Та хоёр наанадаж бидний ар гэр, цаанадаж энэ олон түмнийг бодохгүй байна уу? Амиа хичээсэн, бодлогогүй, идеалист амьтад юм даа та нар!”

Энэ үгийг сонссон түмэн олон сэтгэл уужирч: “Бид ч ёстой ард түмнээ бодсон Бурханы ийм мундаг удирдагч нарын ачаар л амьдрах юм даа. Ийм даруу төлөв, бодлоготой

хүмүүс амьдрал дээр олон байдаг нь бидний зол. Удирдагч нар бүгдээрээ энэ Иошуа, Калев хоёр шиг харласан дотортой, харлаган бодолтой, ихүүн зантай байсан бол юу болохыг ёстой бүү мэд” гэж шаагилдаа байх.

Гэхдээ эцсийн үгийг хэзээд Бурхан л хэлдэг. Тэгээд Бурхан Мосед: “Энэ ард түмэн хэр удаан Намайг хилэгнүүлэх вэ? Тэдний дунд Миний бүтээсэн бүх тэмдэг байсаар байхад тэд Надад итгэхгүй хэр удаан байх юм бэ?” (Тооллого 14:11) гэжээ. Бурхан сүргийн сэтгэлгээнд дургүйцсэн. Хүмүүс өөрсдийгөө даруу загнаж байна гэж бодсон ч, тэр нь даруу зан байсангүй. Үнэндээ тэдний итгэлгүй байдал нь бардамнал байсан юм. Тэд бүх тооцоогоо өөрийнхөө цэц ухаан, чадвар, хүч дээр тулгуурлан гаргаж байв.

Үүнээс нилээд хожуу Хуучин гэрээнд Бурхан: “Аяа, итгэл нь хүн төрөлхтөнд, хүч чадал нь бие махбод уруугаа, Зүрх сэтгэл нь ЭЗЭНээс эргэсэн нэгэн нь хараалтай яа. Харин ЭЗЭНд итгэдэг, ЭЗЭН итгэл найдвар нь байдаг хүн ерөөлтэй еэ!” (Иеремиа 17:5,7) хэмээн айлдсан байдаг. Арван туршуул үлэмж биетэй хүмүүсийг үзээд, өөрийнхөө хүч дээр тулгуурласан өчүүхэн дүгнэлт гаргасан бол, Калев, Иошуа хоёр дайсных нь дэргэд Бурхан ямар том болохыг үзэж, зөвхөн Бурханы нигүүлсэл дээр үндэслэсэн тооцоо хийжээ. Тэгээд эцсийн дүнд Калев, Иошуа хоёр ерөөгдсөн бол, мөнөөх арван туршуул нь итгэлгүй бүх хүний хамт хараагдсан юм.

Тэгэхээр туршуулуудын хэн нь үнэхээр даруу, хэн нь бардам байв? Бурханы мэлмийд арав нь бардам, хоёр нь даруу байжээ.

Итгэлтэй байхын тулд жинхэнэ даруу байдал хэрэгтэй. Учир нь даруу хүн даваагаа давахдаа өөрийнхөө чадварт биш, Бурханы чадварт (буюу нигүүлсэлд) найдаж итгэдэг. Арван туршуул Бурханы амлалтад даруугаар найдсан бол, тэр газрыг эзлэж авах байсан. Тэд хүний хязгаартай хүч, учир шалтгаандаа биш, харин Бурханы Үгд захирагдснаараа бие биедээ захирагдах буюу нэгэн даалгавар дор нэгдэх байжээ.

Гадны хүмүүс “Абрахамын үр сад өөрийнхөө хүчээр дайтаж байна даа” гэж бодсон ч, цаагуур нь өөрийнхөө хүмүүсийг ялалтад хүргэхээр Бурханы ер бусын хүч болох нигүүлсэл

ажлаа хийж байх байлаа. Заримдаа бид Бурханы нигүүлслээр хүчирхэгжихдээ, өөрийнхөө хүчээр хийгээд ч байгаа юм шиг санагдах үе байдаг ч, заримдаа Бурханы чадвар ажиллаж байгаа нь маш тодорхой харагддаг. Гэхдээ яаж харагдах нь хамаагүй - хамгийн гол нь бид Бурханыхаа хүчийг мэдэж, хүчинд нь бүрэн найдаж, Түүний Үг дээр суурилан урагш хөдлөдөг.

Энэ бол мятрашгүй итгэл бөгөөд Бурханы болоод бусдын өмнө даруу байхаас л эхлэнэ.

Даруу байдлаар хувцаслах гэдэг нь өөрийнхөө биш, Бурханы хуяг дуулгыг өмсөнө гэсэн үг юм. 1Петр 5:5-6 дээр “Даруу чанараар хувцаслаж... Бурханы хүчирхэг мутрын дор өөрсдийгөө даруусга” гэсэн. Бурханы мутар гэдэг нь Бурханы чадвар, хүч, чадал, тэнхээ буюу зэвсэг юм.

Үүнийг амьдрал дээр яаж ойлгох вэ? Бид Бурханы хүч ба чадлын өмнө өөрийгөө даруу болгох ёстой. Өөрийн байна уу, өрөөлийн байна уу - аливаа хүний санаа, туршлагыг Бурханы Үгээс дээгүүр тавьж болохгүй. Ямар ч нөхцөлд Түүний үгд итгэж, тэр үгээр үйл хэргээ залуул.

Израильчууд Египетэд дөрвөн зуун жил дарлагдахдаа, өөрсдөөсөө илүү зэр зэвсэгтэй, хүчирхэг цэрэг армийн өмнөөс цорволзож болдоггүйг сурчээ. Тэд Египетэд захирагдсан. Тэд чөлөөлөгдөхийн төлөө юу ч хийж чадаагүй. Гэхдээ Бурхан тэднийг хүчирхэг мутраараа сүр жавхлантайгаар чөлөөлсөн юм. Гэтлэл 13:9 дээр Мосе “Үүнийг гартаа тэмдэг, нүднийхээ хоорондох санамж болгож, ЭЗЭНий хуулийг амандаа байлга. Учир нь хүчит мутраараа ЭЗЭН чамайг Египетээс гаргасан билээ” хэмээн дурссан байдаг.

Гэтэл тэд төдөлгүй үүнийг мартчихсан гэдгийг ч бид мэднэ (Дуулал 106:13). Израильчууд өөрсдийг нь чөлөөлсөн Бурханы мутраас зуурахын оронд олон жил боол явсан туршлагаасаа

зуурчээ. Египетийг хиаруулсан тэр л хүчирхэг мутар Египетийн цэргийн хүчээс хол дорой Канааны цэргийг хиаруулж чадах л байсан.

■

**Итгэлтэй байхын
тулд жинхэнэ даруу
байдал хэрэгтэй.**

■

Гэхдээ Израильчуудын итгэлгүй байдлыг чичлэхээсээ өмнө эхлээд өөрсдийгөө толинд харъя. Бид ингэдэггүй гэж үү? Бурханы цэрэгт татагдахаасаа өмнө бид Сатаны дарангуйлалд дор амьдарч, Сатаны мөн чанарыг өвлөж, түүний савраас зугтах аргагүй байсан. Гэтэл Бурхан хүчирхэг мутраараа “биднийг харанхуйн хүчээс аварч, аюулгүйгээр хайртай Хүүгийнхээ хаанчлалд авчирсан” (Колоссай 1:13). Ийм боломжгүй зүйлийг үйлдсэн Бурхан бидний амьдралын аахар шаахар асуудал, зөрчлийг шийдвэрлэж чадахгүй гэж үү? Өвчнөөс эдгээж, хэрэгцээг хангаж, цэц ухаан хайрлаж, онцгой байх хүчээр цэнэглэж, “боломжгүй” нөхцлийг ялж чадахгүй юу? Бурханы үйлсийг мартсан Израилийн алдааг давтахгүй байя. Иошуа, Калев хоёр шиг даруу чанараар хуяглацгаая.

ДАРУУ ЗАНГ ТАШАА ХӨРВҮҮЛЭХ НЬ

Гэхдээ хүмүүс даруу чанарыг сул дорой, сэтгэлгүй, зан чанаргүй байдалтай байнга эндүүрдэг нь дэндүү харамсалтай. Даруу зан нь эдгээр чанартай огт эвсэхгүй. Библи дээр ч жинхэнэ даруу хүмүүсийг бардам, сэхүүн гэж үзсэн тохиолдол олон байдаг. Үүний тод жишээ бол Давид. Аав нь Давидыг Филистинчүүдтэй байлдаж байгаа ах нараа эргээд ир хэмээн явуулдаг. Давид дайны талбарт иртэл манай талынхан нэг л хачин жигтэй байдалтай угтдаг. Израилийн цэргүүд Голиат гэдэг аварга биетэй Филистин цэргээс айгаад, хадны араар учиргүй бөмбөгнөчихсөн нуугдаж байх юм гэнэ. Цэргүүд нь дөч хоног ийм янзтай байсныг олж мэдсэн Давид эр бор дуугаар: “Энэ филист хүнийг алж, Израилиас ичгүүр шившиглэлийг арилгах хүнийг яах вэ? Амьд Бурханы цэргийг шившиглэн ичээгч энэ хозлуулаагүй филист хүн хэн юм бэ?” (1Самуел 17:26) хэмээн зарладаг.

Гэтэл Давидын том ах Елиаб нь дүүгийнхээ энэ занд эгдүүцэв. Елиаб дүүгээ их санаатай жулдрай гэж үзсэн учраас: “Би чиний их зан (бардам зан), муу санааг чинь мэднэ” (28-р ишлэл) хэмээн дайрдаг. Ямар эрээ цээргүй зэмлэл вэ! Орчин цагийн Англи Библи Елиабын энэ үгийг “Ухаантай царайлсан

амьтан!” гэдэг бол, Нью Интернэйшнэл Вержн Библи дээр “Чамайг ямар их зантай болохыг чинь мэднэ” гэдэг. Тэгэхээр Елиаб Давидыг хамраа сөхсөн, овлигогүй, бардам гэж үздэг нь илэрхий байна.

Гэхдээ хэн нь үнэндээ бардам бэ? Энэ явдлаас нэг бүлгийн өмнө зөнч Самуел дараагийн хааныг томилохоор Иессегийн гэрт ирсэн түүх гардаг. Тэр үед Елиаб сонгон шалгаруулалтад тэнцээгүй. Иессе ч, Самуел ч Елиабыг хамгийн өндөр, хамгийн хүчтэй ууган хүү учраас ирээдүйн хаанаар тодорно гэж харсан ч, Бурхан “Би түүнийг тоохгүй” хэмээн маш тодорхой айлдсан юм (1Самуел 16:7).

Бурхан яагаад Елиабыг тоогоогүй вэ? Дүүгээ ялласан тэр бардамнал нь Елиабын өөрийнх нь зүрхэнд байсан юм биш байгаа? Хожим нь Бурхан Давидыг “Миний зүрх сэтгэлийг дагадаг хүн” (Үйлс 13:22) хэмээн айлдахдаа, Давидын даруу чанарыг батласан юм. Даруу чанар нь Давидын амьдралыг цогцлоосон бөгөөд тэр аугаа удирдагч хэзээ ч зан чанаргүй, сул дорой, сэтгэлгүй хүн байгаагүй гэдгийг бид мэднэ. “ЭЗЭН миний талд, би айхгүй. Хүн надад юу хийж чадах вэ?” (Дуулал 118:6) гэж бичсэн нэгэн чинь Давид шүү дээ.

Буцаад нөгөө түүхдээ орё. Давид Елиабын доромж үгийг сэгсэрч хаяад, Голиаттай аймшиггүйгээр халз тулаад, тун удахгүй хар толгойноосоо хагацахыг нь дуулгажээ. Тэгээд Давид дайсны хуаран руу дайраад, Голиатыг дүүгүүрдсэн ганц чулуугаараа намнаж унагаад, амласныхаа дагуу толгойг нь цавчдаг.

Давидын ах нар арван туршуултай адил тэр тулааныг өөрсдийнхөө хүчин чадал дээр тулгуурлан тооцоолсон бол, харин Давид тэр тулааныг Бурханы хүчээр буюу хүчирхэг мутраар хийнэ гэж харжээ. Давид өөрийгөө даруу чанараар хувцасласан. Саул хаан Давидад хуяг дуулга өгсөн ч, Давид Бурханы зэвсэгт итгэсэн учраас татгалздаг. Гэхдээ өөрийнхөө хүчинд найддаг хүмүүс Калев, Иошуа хоёрыг буруутгасан шигээ Давидыг ч бас хамраа сөхсөн, бардам зантай гэж ялласан юм.

Дайсан бидний даруу зангийн талаарх ойлголтыг завхруулах гэж ихэд хичээсэн гэж би боддог. Гэнэн цагаан Христэд итгэгчид даруу чанарыг зөөлөн дуутай, хойрго үйлдэлтэй,

нүүрэлдэхээс зайлсхийх байдалтай андуурдаг. Гэхдээ даруу чанарт ийм утга ширхэг ч байхгүй. Үүний тод жишээ бол Мосе, Есүс хоёр.

Тооллого номд “Мосе гэгч хүн газрын хөрсөн дээрх хэнээс ч илүүгээр маш даруу нэгэн байлаа” (Тооллого 12:3) гэдэг.

Маш хүчтэй мэдэгдэл! Бидний талаар ингэж хэлбэл ямар догь вэ? Мэдээж бид өөрийгөө хэзээ ч ингэж хэлэхгүй, хэлэх талаар санах ч үгүй. Зөвхөн хамраа сөхсөн, өөртөө дурласан, амиа хичээсэн хүн л өөрийгөө ямар даруу болохыг зарлана биз дээ? Гэхдээ Тооллого номыг хэн бичсэн гээч? Мосе бичсэн! Бурханы энэ аугаа хүн өөрийгөө газар дээрх хамгийн даруу нэгэн гэж хэлжээ.

Энэ чинь юу гэсэн үг вэ? Үйлчлэгч хүн түмний өмнө гараад: “Сонс, би бол маш даруу хүн. Даруу байна гэж яадгийг надаас суралц” гэж байна гээд бод доо. Нүдний булай, түмний шившиг болоод бууна биз дээ?

Тэгвэл Есүс “Зүдэж зүтгэгсэд хийгээд хүнд ачаа үүрсэн бүгд ээ, Над дээр ир. ...Надаас сур. Би дөлгөөн, зүрхэндээ даруу” (Матай 11:28-29) гэжээ.

Есүс үндсэндээ “Над дээр ир. Би даруу учраас даруу байна гэж юу байдгийг та нарт зааж өгье” гэжээ. Өнөөдөр бол Мосе, Есүс хоёр шиг өөрийгөө даруу гэж зарлах нь тун явцгүй үйлдэл болно. Гэхдээ асуудал нь Мосе, Есүс хоёрын хэлсэн үгд байгаа биш; асуудал нь даруу чанарын талаарх бидний ойлголт мэдлэг үлэмж төөрөлдсөнд л бий. Өнөөдөр бид даруу чанарыг өөрийгөө өчүүхэн ч чадваргүй, өт хорхой шиг үнэ цэнэгүй өдийхөн амьтан болохыг зарлаад явахыг хэлнэ гэж боддог болсон. Гэтэл Бурханы бүтээсэн даруу чанар нь маш эерэг, хүчирхэг зан чанар юм. Жинхэнэ даруу чанар нь Бурханд төгс дуулгавартай хандаж, найдах явдал юм. Даруу чанар нь Бурханыг нэгдүгээрт, бусдыг хоёрдугаарт, өөрийгөө гуравдугаарт тавих явдал юм. Даруу чанар нь өөрийгөө доош хийсэн, намуухан дуутай байхтай ямар ч холбоогүй, харин ч Бурханы үнэ төлбөргүй өгсөн бэлэг болох нигүүлслийн хүч дотор мятрашгүй, зоригтой амьдрах амьдрал юм.

ДАРУУ ЧАНАР БИДНИЙГ МЯТРАШГҮЙ БАЙЛГАНА

Мятрашгүйгээр тэвчиж, сайн төгсгөсөн хүмүүс шагнуулна гэдгийг санаж байна уу? Цэц ухааны дүртэй хуурамч даруу байдал таныг энэ шагналаас чинь салгаж дөнгөнө гэдгийг Паул сэрэмжлүүлжээ: “Хуурамч даруу байдалд таашаал авдаг... хэн ч шагналыг чинь бүү булааг” (Колоссай 2:18).

Арван туршуул Амлагдсан газарт орохоос татгалзсан зөвлөгөө өгсөн. Тэдний тоочиж байгаа шалтгаан нь учир зүйтэй, бодлоготой, зөв харагдсан ч, тэр нь Бурханы амлалт, цэц ухаанаас бус, харин сайн мууг мэдүүлэгч мэдлэгийн модноос гаралтай ухаан байжээ. Тэд өөрсдийгөө төдийгүй, ар гэр, ард түмнээ мэхлэжээ. Тиймдээ ч тэдний нэг нь ч Амлагдсан газарт орж чадаагүй юм. Харин сүнслэг даруу чанар дотор ярьсан Калев, Иошуа хоёр л Бурхан тэр үеийнхэн дундаас шинэ газарт орохыг зөвшөөрсөн хоёрхон том хүн байсан юм. Иошуагаар удирдуулсан Израилийн шинэ үеийнхэн Бурханы хүчирхэг мутар дор Амлагдсан газрыг эзлэжээ.

Нэгэн удаа надаас нэг хүн: “Жон, чи янз бүрийн гаралтай сая сая хүнд номлохыг сонгох уу эсвэл арваадхан удирдагчид номлохыг сонгох уу?” гэж асууж билээ.

Намайг: “Сая сая хүнд” л гэж хариултал, тэрбээр:

- “Энэ чинь тийм ч мэргэн явдал биш. Учир нь амлагдсан газрыг тагнасан арван туршуулаас болж сая сая хүн хувь тавилангаасаа салахад хүрсэн” гэж хэлсэн юм.

Бид бүгдээрээ удирдагч, нөлөөлөгч болохоор дуудагдсан. Тэгвэл та яаж удирдаж байна? Та Бурханы хүчирхэг мутар дор даруу чанараар хувцаслан ирж байна уу эсвэл даруу царйлчихаад өөрийнхөө хүчээр ажилласаар байна уу?

Ром 8:37 дээр Паул биднийг “Харин бид энэ бүхний дотор биднийг хайрладаг Түүгээр дамжин давуулан дийлдэг” гэсэн боловч, Бурханы Үгээс гадуурх бидний өөрийн санаа, төлөвлөгөө юмуу чиглүүлэг “...нь өөрсдийн бий болгосон шашны үзэгдэл болоод хуурамч даруу байдал мөн биеийг

зовоох байдлаар мэргэн ухаан мэт үзэгдэвч, үүнд махбодын хүслийн эсрэг ямар ч нэмэр үгүй” (Колоссай 2:23) байж мэднэ.

Калев, Иошуа хоёрын үеийнхэн уг нь байлдан дагуулах байр сууринд байсан. Элиаб дүү нартайгаа отгон дүү Давидыгаа ирэхээс ч өмнө Филистинчүүдийг бодийг хөтлөж чадах л байсан. Гэхдээ худлаа даруу зан тэдний хүч, амлалт, үр жимс, амьдралд захирах чадвар тэгээд мөнхийн шагналыг нь суйлжээ. Тиймээс л Паул: “Өөр хоорондоо нэг санаатай байцгаа. Ухаан бодолдоо ч бүү ихэрх. Харин төлөв даруу байхыг эрхэмлэ. Өөрөө өөрийгөө ухаалаг бүү болго” (Ром 12:16) хэмээн хатуу анхааруулсан юм.

Даруу оюун ухаан нь өөрөөрөө сайрхдаггүй. Нэг удаа олон улсын нэгэн алдартай сэтгүүл нэг маргаантай сэдвээр нийтлэл бичсэн юм. Тэгээд эрхлэгч нь энэ тал дээрх миний санаа бодлыг сонсохоор манай байгууллага руу утасдсныг туслах маань надад дамжуулав. Би ч түүнд: “Надад бодох хугацаа хэрэгтэй байна” гэж хэллээ.

Дараагийн өдөр нь миний сүнс нэг л тавгүйрхээд байсан боловч, би учрыг нь олохгүй байв. Тэгээд “Энэ юунаас болоод байна?” хэмээн өөрөөсөө асуусаар байсан ч, юунд зовниод байгаагаа хэлж мэдэхгүй байв. Эцэстээ энэ асуудлаа Эзэнд залбирлаараа өргөтөл, ганц хоёр өдрийн дараа гэнэт учир нь тайлагдав. Би Лизатай ярьж байснаа: “Би яагаад тэр сэтгүүлийн хүсэлтээс болж тавгүйтээд байснаа мэдлээ. Маш энгийн зүйл байж: Би хувийнхаа санал бодлыг илэрхийлж байх хэн юм? Элчин сайдууд чинь хувийнхаа санаа бодлыг илэрхийлдэггүй биз дээ?” гэж хэлж билээ.

Библи биднийг “Иймээс бид Христийн төлөөх элчин сайд юм. Бурхан биднээр дамжуулан ятгаж байгаачлан Христийн төлөө та нараас бид гуйя” (2Коринт 5:20) гэдэг. Америкийн ерөнхийлөгч өөрийнхөө үгийг дамжуулахаар элчин сайдаа илгээж байхад, элчин нь ерөнхийлөгчийнхөө биш, хувийнхаа үгийг хэлээд байвал, асуудал үүснэ. Үүнтэй адилхан хэрэв бид Бурхан Аавынхаа төлөө, Эзэн Есүс Христийнхээ төлөө ярьж байгаа бол, Түүний л үгийг дамжуулах ёстой. Надад хувийнхаа бодол санааг хэлэх эрх байхгүй. Арван туршуул яг

л ийм алдаа гаргасан. Би тэр сэтгүүлд хувийнхаа санаа бодлыг илэрхийлэх нь надад даалгагдсан Бурханы нигүүлслийн захиргааг доромжилсон хэрэг болно.

Энэ явдал надад үүнээс нилээд хэдэн жилийн өмнө залбирч байхад Эзэний хэлсэн үгийг эргэн сануулсан юм. Бидний үйлчлэлийн эхний дөрвөн жил яг л цөл шиг хүнд хэцүү байлаа. Лиза бид хоёр жижиг Хонда Сивиктээ хэдэн жаалаа суулгаад, илүү дутуу зайгаар нь ачаа тээшээ чигжиж аваад л Америкийн зүүн нутгуудаар доошоо дээшээ давхидаг байв. Тэр үед бид үүд хаалга нээгдэхийн төлөө амь тэмцэн залбирдаг байв. Гэвч дийлэнхдээ зуу гаруйхан хүнтэй цуглаанд л заахаас цаашгүй бөгөөд нэг их өсөлтгүй, нийгэмдээ нөлөөлөх нь ч бага байв.

Хүнд хүчир энэ дөрвөн жилийн дараа нэгэн өглөө залбирч байтал Эзэн надтай ярив: *Жон, Би чамайг өнгөрсөн дөрвөн жил өчүүхэн нөлөөтэй жижиг чуулган, конференц рүү явуулахад, чи Намайг дуулгавартай дагалаа. Чиний үйлчилсэн хүмүүсийг Би Өөрөө цааш нь аваад явна. Харин чиний төлөө Би одооноос эрс өөрчлөлт хийнэ. Би одоо чиний мөрөөдөж байснаас ч том өсөлтийг бий болгоно. Чиний хүрэлцээ олон дахин үржиж, чи хотууд хийгээд үндэстнүүдэд ач холбогдолтой том нөлөө авчрах чуулган, конференцт уригдах болно. Чи санхүү, харилцаа, сүнсээр үсрэнгүй ерөөгдөнө. Одоо чи Миний юмыг зохицуулж, Миний Үгийг үй олон хүнд хүргэх цаг нь ирлээ.*

Би энэ үгийг зүрхэндээ тодоос тод сонсоод, зог тусан хөөрөн баясав. Тэгээд Лизадаа хэлтэл тэр ч хөөрлөө. Гэтэл хэдхэн эгшний дараа Эзэн надад дахин ингэж хэлсэн юм: *Энэ бүхэн мөн сорилт байх болно. Чи нэр нөлөө багатай газруудад очихдоо төгрөг бүрийнхээ төлөө, хэлэх Үг бүрийнхээ төлөө Надад найддаг байсан. Миний хүслийг алдах аваас, хүч хөдөлмөр чинь талаар болно гэдгийг мэддэг байсан учраас чи зогсоо зайгүй Миний зөвлөгөөг асууж гуйдаг байсан. Харин одоо Би чамайг санхүүгээр ерөөсөн учраас чи мөнгөө баруун зүүнгүй цацах уу? Эсвэл ангамал хуурай цөлд байсан шигээ Миний зөвлөгөөг хайсаар байх уу? Одоо чи мөнгөтэй болсон учраас Миний чиглүүлгийг авахын оронд хүссэн газраа явах уу? Одоо чи индрийн араас хэлэх үг бүрийнхээ төлөө Надад*

найдахын оронд өөрийнхөө санал бодлыг хэлдэг болох уу? Хүү минь, Миний хүүхдүүд хоёр гол талбар дээр шалгагддаг: цөлд хийгээд элбэг дэлбэг газарт. Тэгээд дийлэнх нь цөлд биш, чухамдаа элбэг дэлбэг газарт алддаг юм шүү.

Би чичирч байлаа. Тэгээд залбирлаа дуусгаад, Бурханы хэлсэн үгийг тэр даруй Лизадаа хэлтэл, тэрбээр надад: “Жон, чи надад Бурханы Үгийн эхний хэсгийг хэлэх үед би гал тогоондоо галзуу юм шиг бүжиглэмээр болсон. Харин одоо Бурханы Үгийг бүхлээр нь сонсоод аймшигтай айж байна!” гэсэн юм.

Тэгэхээр нь би Лизад: “Тэр чинь сайн хэрэг. Яагаад гэвэл яг л тэгж хариу хандах ёстой юм - *Эзэнээс эмээх ёстой!*” гэж хэлж билээ.

Эзэнээс эмээх гэдэг нь Бурханаас айх гэсэн үг биш, харин Бурханаас холдохоос айх явдал мөн! Эзэнээс эмээхүй нь эрүүл саруул, цэц ухаантай, хүчирхэг, аюулгүй амьдралын үндэс. Жишээлбэл Бурханаас эмээдэг хүн эд баялгаа зүй зохистой зохицуулж, ухаалгаар авч явах ёстой. Ер нь худал хуурмаг хүн эд баялгаас амархан гогддог. Матай 13:22 дээр Есүс биднийг “эд баялгийн хуурамч байдлаас сэрэмжлээрэй” хэмээн анхааруулсан боловч, хэрэв бид Бурханы зөвлөгөө, Үг, цэц ухаан дотор буюу Эзэнээс эмээхүй дотор байсаар байвал, энэ заль мэх биднийг урхидаж, хорлож чадахгүй.

Христийн элчин сайд атлаа хувийнхаа санал бодлыг илэрхийлж явах нь бурханлаг эмээхүй байхгүйн шинж буюу энэ нь товчхондоо бардамнал юм. Тиймээс л Паул “...Харин төлөв даруу байхыг эрхэмлэ. Өөрөө өөрийгөө ухаалаг бүү болго” (Ром 12:16) хэмээн захижээ. Калев, Иошуа хоёр үеийнхнийхээ санал бодолд автаагүй. Учир нь Бурхан тэдэнд Өөрийнхөө хүслийг хэдийнээ илэрхийлсэн байв. Тэд Бурханаас эмээсэн учраас сайнаар дуусгаж чадсан. Сургаалт үгс номд “Тохуурхагчдыг Тэр тохуурхдаг атлаа дарууд нигүүлсэл үзүүлдэг” (3:34) гэдэг.

Эрүүл ухаантай ямар ч хүн Бурханы тоглоом болохыг хүсэхгүй. Гэвч өөртөө цадсан хүнтэй яг л ийм зүйл тохиолддог. Алдрын Бурхан бардам занг үзэн яддаг. Бурхантай маш ойр дотно байсан Люсифер гэдэг тэнгэрэлч Бурхан Эзэнээсээ эмээж яваагүй учраас адгийн муугаар төгссөн. Дуулал 19:9 дээр “ЭЗЭНЭЭС эмээхүй нь цэвэр, мөнхөд оршдог. ЭЗЭНий

шүүлтүүд үнэн бүгд зөв шударга” гэдэг. Эзэнээс эмээхүй нь бидэнд сайн дуусгах чадвар өгдөг тулгуур хүч юм. Адам, Ева хоёр Бурханы алдрын оршихуй дотор амьдарч байсан ч, Бурханаас холдохоос айх хэмжээнд эмээн хүндэтгэж яваагүй учраас Еденд мөнхөд амьдарч чадаагүй юм.

Бурханлаг айдас, итгэл, даруу чанар нь амар хялбар таслаж чадахгүй гурамслаж гөрсөн сур юм (Номлогчийн үгс 4:12). Та Бурханаас эмээдэг бол, ямар ч боломжгүй нөхцөл байдлын нүүрэн дээр Эзэнд л итгэнэ. Та Эзэнээс эмээдэг бол, өөрийнхөөрөө цэцэрхэхгүй, даруу байна. Тийм боловч бардамнал, тэрслэл, итгэлгүй зан нь таслахад бэрх харанхуйн гурамслаж гөрсөн сур юм. Өөрийнхөө бодлыг мандуулан, Бурханы Үгийг үл тоож, үл тооцдог хүн бэрхшээлийг тэсч гарахгүй. Түүнд аврагдах ганц л найдвар бий - үнэн голоосоо гэмшиж, өөрийгөө даруусгах.

■

**Эзэнээс эмээхүй
нь эрүүл саруул,
цэц ухаантай,
хүчирхэг, аюулгүй
амьдралын үндэс.**

■

НУРУУНЫ ХАМГААЛАЛТ

Бардамнал маш зальтай чанар. Энэ нь биднийг сайн дуусгахад саад хийдэг дайсны хамгийн үр дүнтэй зэвсэг гэж хэлж болох байх. Бардам хүн дайсны цохилтыг хардаггүй - учир нь дайсан ямагт хамгаалалтгүй газар руу буюу нуруунаас цохидог. Хамаг юмаа алдаж, сүйрчихээд: “Би мэдээгүй ш дээ!” хэмээн халаглаж байгаа хүнийг та харсан уу?

Энэ нь ч шалтгаантай. Хэрэв та Библи дээрх Бурханы хуяг дуулгыг жагсаалтыг үзбэл, бүгд биднийг урдаас маань л хамгаалах зориулалттай байгаа: үнэний бүс, зөвт байдлын цээживч, амар тайвны сайн мэдээний гутал, итгэлийн бамбай, авралын дуулга, илд болсон Бурханы Үг... Тэгвэл бидний ар нурууг юу хамгаалах вэ? Үүнд зөнч Исаиа хариулжээ: “Эзэний алдар чиний арын хамгаалалт болно (Исаиа 58:8).

Нью Ливинг Транслэйшн Библи дээр “Эзэн чамайг араас чинь хамгаална” гэдэг. Бурхан алдраараа бидний ар нурууг хамгаалдаг. Гэхдээ Бурхан алдраа хэнтэй ч хуваалцахгүй гэснийг бид мартаж болохгүй (Исаиа 42:8). Бид өөрийнхөө саналыг Бурханыхаас дээгүүр тавихдаа бардам зан гаргаж, Бурханы алдрын хамгаалалтыг алдаж, нуруу нүцгэн үлдэнэ!

Бид жинхэнэ даруу зан, бардамналын талаар ийм л буруу ойлголттой явдаг. Бурхан “Миний хүмүүс мэдлэгээр гачигдснаасаа болж сүйрсэн (Хосеа 4:6) гэдэг. Бидний хэд маань мэдлэггүй байдлаасаа болж устсан, устдаг, устах бол? Арван туршуул, Израиль тэр чигээрээ Калев, Иошуа хоёрын даруу байдлыг бардамналтай андуурч, Элиаб Давидын даруу байдлыг бардамналтай андуурч байсан бол, өнөөдөр байдал ямар байгаа бол?

Энэ нь яг л хаана зэрлэг араатан отож байгааг мэдэхгүйгээр замд гарахтай ижил юм. Та замаа мэдэхгүйгээр яваад, төөрвөл том аюулд орно.

Лиза бид хоёр нэгэн удаа Африкийн Сафарид уригдсан юм. Бид маш гоё байгальтай, таван одтой тансаг зочид буудлын нэгэн урцанд байрлав. Шөнө бүр биднийг буутай рэнжер задгай зоогийн газраас урц руу маань хүргэж өгнө. Зам нь ч овоо хол. Эхний шөнө тэр рэнжер Лиза бид хоёрт: “Юу ч болж байсан шөнө байрнаасаа гарч болохгүй шүү. Шууд л амьтны хоол болно. Өлөн араатнууд шөнөөр анд гардаг бөгөөд тэднийг хорих ямар ч хашаа байхгүй” гэж анхааруулав.

Бид үүнийг мэдэхгүйгээр шөнө хоол идэхээр гарч гүйсэн бол яана? Өөрсдөө оройн зоог болох байж. Мэдлэггүй байдлаасаа болж үхэж болох байж. Тэгэхээр Хосеагийн үгийг “Миний хүмүүс жинхэнэ даруу зан, бардамналын ялгааг мэдэхгүйгээсээ болж сүйрсэн” гэж хэлж болох ажээ.

Та жинхэнэ даруу зан гэж юу болохыг мэдэхээр суралцаж байгаа нь юутай сайн. Гэхдээ үүгээр зогсож болохгүй шүү. Бичээсийг нягтлан судлаж, таныг гэгээрүүлж өгөхийг Ариун Сүнснээс гуй. Мэдлэггүй байдлаасаа болж нүцгэн газраа цохиулж, ялагдал хүлээх вий.

Номой нэгний баяр хөөр ЭЗЭНий дотор өсөн нэмэгдэж, хүн төрөлхтний үгээгүйчүүд Израилийн Ариун Нэгэндээ баясна. (Исаиа 29:19)

Ямар аугаа амлалт вэ! Баяр хөөрт дургүй хүн байхгүй. Гэхдээ энэ амлалт өөр юугаараа тийм чухал вэ?

Нехемиа 8:10 дээр “Эзэний баяр баясал нь таны хүч” - сайн дуусгах хүч гэдэг. Бид уралдаанд мятрашгүй гүйсэн атлаа яг барианыхаа өмнө зогсчихож болохгүй. Даруу байдлаар хувцасласаар байвал, та бид хоёр баяр баясал, хүчээр өснө гэдгийг Бурхан амлажээ. Түүнчлэн:

“Сүнсэндээ дарууг нь сэргээхийн тулд, Зүрхнээсээ гэмшсэнийг нь сэргээхийн тулд Сүнсэндээ даруутай нь, гэмшсэн нэгэнтэй нь Би өндөрт, ариун газарт оршдог. (Исаиа 57:15)

Бурхан бидний дотор байвал, бид гүйлтээ сайн дуусгахдаа л нэг дуусгана. Бурханыг оршихуйг үе үе урих биш, харин Түүнтэй цаг үргэлж хамт амьдар.

Анд минь, “Бурхан бардамыг эсэргүүцэн, дарууд нигүүлсэл өгдөг учраас, даруу байдлаар хувцасла.” Бурханы хүчирхэг мутар дор даруулгатай амьдарбал, цаг нь болохоор Бурхан таныг өргөмжилнө.

АЧААГАА ХАЯ

Залуус аа, та нар мөн түүнчлэн ахлагчдадаа захирагд. Та бүгд бие биендээ даруу хандах байдлаар хувцасла. Учир нь Бурхан бардмыг эсэргүүцдэг, харин дарууд нигүүлсэл өгдөг. Иймд Бурханы хүчирхэг мутрын дор өөрсдийгөө даруу байлга. Тэгвэл Бурхан зохистой цагт та нарыг өргөмжилнө. Тэр та нарт санаа тавьдаг учраас бүх зовнилоо Түүнд хая.

1Петр 5:5-7

Даруу байдлаар хувцаслахын нэг чухал тал нь Кaleb, Иошуа хоёр шиг Бурханы захиргаан дор байх юм. Ингэж байж л бидний тэнгэрлэг даалгавар, бидний өнөөнгийн байр суурь хоёрын дунд хөндөлсөгч дайсныг ялна. Бид өөрийнхөө хүчинд биш, Бурханы хүчинд - Түүний хүчирхэг мутарт даруугаар найдна. Бид хүний шилдэг логик, учир шалтгааныг тоочих биш, харин даруугаар Бурханыхаа мэдээнд л итгэнэ. Бид өөрийнхөө мэдрэмж, төрөлх мэдлэгтээ захирагдах биш, харин даруухнаар итгэлээр алхана.

Бид энэ замаар амьдрахын тулд бүх зовнилоо Эзэнд өгөх ёстой. Зарим нэг зовнилоо биш, харин бүх зовнилоо өгөх ёстой. Кaleb, Иошуа хоёр яг тэгсэн. Тэд мэдээж аав, эр нөхрийнхөө хувьд гэр бүлээ юу юунаас илүү бодож байсан. Гэхдээ тэд Эзэний үгийг хүний логик, айдсаас дээгүүр тавьжээ. Бурханы хүслийг нэгдүгээрт тавьбал, гэр бүл нь ч аюулгүй, амгалан

байхыг тэд ойлгож байв. Калев, Иошуа хоёр Эзэний өмнө төгс даруу байсны ачаар ар гэр нь ч энэ ертөнц дээрх хамгийн найдвартай гарт очжээ.

ТҮҮНД БҮХ ЗОВНИЛОО ХАЯХ

Бүх зовнилоо Бурханд хаясан хүн даалгавартаа мятрашгүй үнэнч үлдэх чадвартай болдог. Бид хүнд хүчир ачаа үүрчихээд хол явахгүй. Библи “Тиймээс бид өөрсдийг минь хүрээлэн буй үүл мэт үлэмж их гэрч нартай тул аливаа саад тотгор ба амархан урхиддаг нүглийг хажуу тийш нь тавьж, өмнөө тавигдсан уралдаанд тэвчээртэйгээр гүйцгээе” (Еврей 12:1) гэжээ.

Жин нь бидний хурдыг сааруулж, сайн дуусгахад садаа болно. Хөл тус бүрээсээ 20 кг туухай чирчихээд, марафон гүйлтэд оролцох гээд үз. Гүйлтээ дуусгах нь бүү хэл, гүйхэд ч хэцүү байна!

Бидний ахиц дэвшилд садаа болдог маш хүнд чиргүүл бол бидний зовнил, амдралын аахар шаахар асуудал юм. Яг үүнээс болж арван туршуул амьдралаа сайн дуусгаж чадаагүй. Ар гэр, эхнэр хүүхэддээ учирч болзошгүй аюулын талаарх зовнил нь тэднийг Бурханы амлалт дотор урагшилж, Бурханы хүслийг биелүүлэх чадваргүй болгожээ.

Гэхдээ гэр бүл маань бидэнд ачаа болдоггүй, харин гэр бүлээ гэсэн зовнил маань л ачаа болдог юм шүү. Бурханы хамгаалан хангадаг чадвар, хүсэлд эргэлзэх нь Бурханы шударга чанар, хүчийг доромжилж буй хэрэг юм. Калев, Иошуа хоёр Канаанчуудтай дөчин жил дайн байлдан хийх үед гэр бүлүүд нь яагаа ч үгүй байдаг. Энэ нь Израильчууд хичнээн буруу байсныг нотлож байгаа юм. Үнэндээ харин ч тэр дайны ачаар л тэр хоёрын гэр бүл үр жимстэй газар нутгийг өвлөн авч, асар их ерөөгдсөн билээ.

Энэ хүмүүсийн өөр өөр хувь тавиланг эргэцүүлж үзээрэй. Бурханы удирдамжид найдалгүй, гэр бүлдээ зовнисон арван туршуул нь гэр бүлдээ цөлийн хоосон амьдралыг авчирсан юм. Мэдээж дөчин жилийн гачигдал, бэрхшээлтэй ийм золгүй төгсгөлийг хэн ч хүсээгүй. Харин Бурханы Үгд итгэж, дагаж,

гэр бүлээ Бурханы шударга чанарт даатгасан хоёр удирдагч нь үр удамдаа “сүү балаар халгисан” Амлагдсан газрыг өвлүүлжээ.

Хүн бүр амьдралынхаа аль нэг үе шатан дээр аюулгүй байдал хийгээд хувь тавилангийнхаа аль нэгийг сонгох ёстой болдог. Бид Бурханы замыг сонгох уу эсвэл ая тух, сайн сайхан байдлаа баталгаажуулах уу? Та амиа хоохойлсон сонголт хийбэл, тэнгэрлэг хувь тавиландаа хэрхэвч хүрэхгүй. Та аюулгүй байдлаа хангаснаараа амжилт олж болох ч, хожим Христийн шүүх сэнтийн өмнө очихдоо, зуурдын жаргалаар Бурханы ямар төгс төгөлдөр, элбэг дэлбэг, бүрэн дүүрэн амьдралыг сольчихсноо ухаарах болно.

Үүнийг Бурханы Үг ахин дахин баталгаажуулдаг. Хэрэв та Бурханы замаар явах гэж байгаа бол, бүх зовнил асуудлаа Эзэнд хаях хэрэгтэй. Эзэний зам хамгийн адал явдалтай, итгэлийн зам бөгөөд шагнал нь ямагт таны аюулгүй байдал, тав тухын мэдрэмжээс аугаа байдаг.

■

**Хүн бүр ...
аюулгүй байдал
хийгээд хувь
тавилангийнхаа
аль нэгийг сонгох
ёстой болдог.**

■

МИНИЙ ТҮҮХ

Би ч бас амжилттай гүйхийн тулд ачаагаа хаяж сурснаа тантай хуваалцмаар байна. Айл гэрийн аав, эр нөхөр хүн гэр бүлээ авч явах ёстой байдгийг би хар нялхаасаа л ухаарч ойлгосон юм. Аав минь бидэнд “хадгалсан зоос бүр нь олз” байдгийг сургаж, өөрөө ч энэ үүргээ яаж биелүүлэхийг яруу тодоор үлгэрлэн харуулсан билээ. Тиймээс би хар багаасаа л гэр бүлээ аюулгүй, тогтвортой орон гэрээр хангах үүргээ ухамсарласан юм. Би нисгэгч болохыг хүссэн ч, тухайн үед нисгэгчийн ажил нь маш эрсдэлтэй мэргэжил байсан учраас аав минь хориглож, арай баталгаатай мэргэжил рүү чиглүүлэв. Би их сургуулиа инженерээр төгсөөд, 1981 онд Роквел Интернэйшнэлд ажилд оров.

Шинэхэн инженер гэхэд би тун дажгүй цалин авч, гэргийгээ юугаар ч дутаалгүй, хангалттай амьдруулж байгаадаа ч баяртай байв. Би жаахан хүү байхдаа сурсан үлгэр загвараараа л амьдарч байлаа. Гэхдээ үнэнийг хэлэхэд, миний дотор нилээд том мөргөлдөөн болж, сэтгэл маань Бурханд үйлчлэхийн төлөө дүрэлзэж байв. Ийнхүү хэдэн жил өнгөрсөн ч, яаж ч бодсон би үйлчлэлд гарбал, үйлчлэгч хүний өчүүхэн орлогоор гэргий, үр хүүхдээ яагаад ч гэжээж чадахгүй гэж санагдаж байлаа. Тиймээс Лиза бид хоёр төлөвлөгөө зохиов.

Би ажлынхаа газрын нэг хүнээс хэрэв манай компаний ажилчид хилийн чанадад буюу ялангуяа Ойрх Дорнод ажиллабал, асар их хэмжээний цалин өгдөг гэж сонссон учраас, хариуцсан захирал дээрээ давхиж ороод, Саудын Араб руу шилжүүлж өгөөч гэсэн хүсэлт тавилаа. Лиза бид хоёр тэнд хэдэн жил тэсчихбэл, овоо мөнгө нөөцлөөд, Америкт буцаж ирээд, гайгүй байшин аваад, түүнийхээ дараа Бурханд үйлчилж эхлэнэ гэж тооцоолсон юм.

Гэхдээ энэ төлөвлөгөөний гол асуудал нь энэ маань бидний өөрсдийн маань хүчин чадал дээр тулгуурласан төлөвлөгөө байв.

Нэгэн орой Лиза бид хоёртой олон жил нөхөрлөж яваа нэгэн үйлчлэгч найз маань намайг суулгаж байгаад, бүтэн хоёр цаг зэмлэв. Тэрбээр товчхондоо: “Бурхан чамайг дуудсан. Гэтэл чи юу ч хийхгүй байна. Хэрэв чи энэ янзаараа байгаад байвал, хамаг хувь тавилангаа алдчихсан инженер өвгөн л болж дуусна шүү” гэж л хэлсэн юм.

Хэдий хатуу ч яах аргагүй үнэн үг байлаа. Тэр орой би харьж ирээд, Лизад: “Би чуулганы ямар ч хамаагүй орон тоонд ажиллалаа. Надад ямар л хаалга нээгдэнэ, би түүгээр орно. Чи надтай хамт уу, үгүй юу?” гэж хэлтэл, Лиза:

“Би чамтайгаа хамт!” гэсэн юм.

Тэгээд надад үйлчлэх үүд хаалга нээж өгөхийг Бурханаас хэдэн сар уйлан хайлан гуйв. Тэр хооронд би чуулгандаа сайн дураараа чадах чинээгээрээ үйлчилсээр байлаа. Утгагч боллоо, шоронгийн үйлчлэлд нэгдлээ, тэр бүү хэл пасторынхаа хүүхдүүдэд ч теннис тоглохыг зааж өгөв. (Би коллежид байхдаа усан спортын болон цохиурын клубт гурван жил теннисний багшаар ажилласан юм л даа).

Хэдэн сарын дараа буюу 1983 онд надад бүтэн цагаар үйлчлэх үүд нээгдэж, тийнхүү би Роквелээс гарч, нутгийнхаа чуулганд үйлчилж эхлэв. Чуулганд үйлчлэхийн тулд би маш өндөр цалинтай ажлаасаа гарсан бөгөөд Роквелийн захирал, аав хоёр маань намайг галзуурчихаж гэж бодсон юм. Найзуудын нүд нь орой дээрээ гарч, би өөрөө ч гэр бүлээ яаж тэжээхээ мэдэхгүй байлаа. Яаж ч төлөвлөсөн, сарын орлого маань зарлагынхаа хаана ч хүрэхгүй байв.

Гэхдээ Бурхан намайг үйлчлэлд дуудсаныг би сайн мэдэж байлаа. Тиймээс Лиза бид хоёр хэрэгцээний талаарх зовнилоо Бурханд даатгав. Бид хэзээ ч хоосон хонож үзээгүй бөгөөд Бурхан бидний хэрэгцээг ямагт хангадаг байв. Хэнд ч хэлээгүй байхад л Бурхан бидний хэрэгцээг гайхамшгаараа хангаж өгдөг байлаа. Лиза бид хоёр дор дорноо хэрэгцээгээ Бурханд хэлж, дайсны зүгээс ирэх гутралыг эсэргүүцэхдээ, гайхамшиг ар араасаа цуврахыг үздэг байв.

Нэг удаа бид Бурханд арван хувиа өргөх уу, хоол хүнс авах уу гэсэн сонголттой тулсан юм. Гэхдээ бид тэгтлээ зөрчилдөөгүй л дээ. Учир нь бид хэзээд Бурханыг нэгдүгээрт тавина гээд шийдчихсэн байсан учраас, цалингийнхаа арван хувийг өргөлдөө хийв. Үлдсэн 90 хувиар нь өр төлбөр, машинаа засуулах гээд төлөвлөсөн төлөвлөөгүй зардлаа барагдуулах ёстой байсан учраас, бид хоол хүнсний мөнгөгүй үлдэв.

Тэр үед манай ганц унааны жанам нь эвдэрчихсэн байв. Гэтэл би чуулганыхаа ажилд дарагдаад, засуулах ч цаг олддоггүй. Тэгээд ч би чуулганыхаа вэнийг уначихдаг учраас ажилдаа очих, ажлаасаа тарах тал дээр асуудалгүй байлаа. Ийнхүү унаа маань паг суув. Тэгтэл хэдэн өдрийн дараа бас дугуй нь хагарчихав. Манайд солих дугуй байсангүй. Тэр үед бидний амьдардаг Техасын Хьюстонд зуны халуун шатаж байв. Нэг орой гэртээ иртэл, машины маань нэг цонх юу ч үгүй үйрчихсэн байлаа. Гэтэл машин доторх агаар хэт халаад, салхины шилийг үйртэл нь тэлчихжээ.

Ийнхүү таагүй үйл явдлууд дээр дээрээсээ овоорсоор байлаа. Би ч яах учраа олохгүй байв. Жанамыг нь заслаа ч, дугуйгүй унаагаар яах ч билээ. Бид машиныхаа цонхыг

гялгар уутаар таглаад битүү скочдсон ч, хүчтэй бороонд навс цохиулж, ус нэвтрээд, бүхээг бүхэлдээ илжрэх учраас машинаа өдөр алдалгүй засуулах шаардлагатай байв. Хэд хэдэн засварын газар руу утасдсан ч, тэнгэрт хадсан үнэ хэлэв. Бидэнд машинаа засуулах мөнгө байсангүй. Инженерийнхээ ажлыг хийж байсан бол, ядах юмгүй засуулчих байлаа. Би нэг өөрийгөө өрөвдөөд л, нэг зогсоол дээр зэвэрч байгаа машинаа хараад л, үнэхээр яахаа мэдэхгүй байв.

Тэгээд эцэстээ “Гүйцээ!” гэж хэлсэн юм. Тийнхүү Бурхантай хоёулханаа уулзах нууц газар олж байгаад: “Эзэн минь, Та намайг бүх зовнилоо Танд хаяарай гэсэн. Тиймээс яг одоо би энэ машины асуудлыг бүхлээр нь Таны гарт өгч байна. Одооноос энэ миний биш, Таны асуудал боллоо. Энэ машин зэвэрч дуусбал, энэ миний асуудал биш учраас, миний буруу биш болно! Би Таны хийгээрэй гэсэн зүйл дээр л анхаарна. Надад шийдэл зааж өгсөнд баярлалаа, Бурхан минь!” гэж хашхирав.

Би хэлье гэж бодсон бүхнээ л гаргаж хэлээд, машинаа эвдэрсэн цагаас хойш анх удаа хачин их амар тайвныг мэдэрсэн юм. Бурхан Өөрөө:

Юунд ч санаа бүү зов. Харин аливаа зүйлд залбирлаараа болон гуйлтаараа талархалтайгаар хүсэлтээ Бурханд мэдүүл. Бүх оюун ухааныг давах Бурханы амар тайван нь та нарын сэтгэл санааг Христ Есүс дотор хамгаална. (Филиппой 4:6-7)

Дараа нь би дайсандаа хандаж хэдэн үг хэлэв: “Сатан аа, сонсож бай. Миний Бурхан Аав Өөрийнхөө алдар дахь баялгаар хэрэгтэй бүхнээр минь намайг хангадаг. Би юуны түрүүнд Түүний хаанчлалыг хайдаг учраас юугаар ч гачигдахгүй, миний хэрэгтэй бүхэн надад нэмж өгөгдөнө. Тиймээс би чамайг Есүсийн нэрээр эсэргүүцэн, бузар савраа манай санхүүгээс болон машинаас минь татахыг тушааж байна!”

Ямар нэг юм ховхорчих шиг л болов. Би тэр даруй инээд алдаж: “Би галзуурч байна уу?” гэж бодлоо. Гэтэл миний голоос баяр хөөр олгойдов. Энэ бол надад хэрэгтэй хүч болох Эзэний баяр хөөр бөгөөд энэ л хүчээр мятрашгүйгээр

гүйж чадна гэдгээ би мэдэж байлаа. Миний зовнил Бурханы хүчирхэг мутарт очиж, харин дайсан хүлэгдэв. Надад Эзэний хангамжийг догдлон хүлээхээс өөр юм үлдсэнгүй.

Тэгтэл маргааш нь Лизагийн маань найз манайд зочлохдоо, байрны гадаах зогсоол дээрх эвдэрхий машины маань нүд хальтирам дүр зургийг үзээд Лизад: “Лиз, надад нэг засварчин найз бий. Түүнд үзүүлбэл, нэг юм хэлэх байх” гэжээ. Тэгээд тэр засварчин манай машиныг маш хямдаар бүрэн засч өгсөн юм. Бурхан бидний хэрэгцээг гайхамшгаар хангаж өгөхийг үзээд Лиза бид хоёр улам хүчирхэгжив.

Гэхдээ арван хувиа Бурханд өргөчихсөн учраас дахиад 12 хоногийн дараа цалинтайгаа золгох хүртэл бидэнд хүнс авах мөнгө байсангүй. Нэгэн орой бид хоёр машиндаа сууж байгаад хамтдаа жаал уйлав. Бид итгээгүйдээ биш, жаахан сэтгэлээр унасандаа л уйлсан юм. Бусад хүмүүс маш амар хялбар аж төрж байхад, яагаад бид бүх зүйлийнхээ төлөө үхэн хатан тэмцэж байгааг бид ойлгохгүй байлаа. Бид Паултай адил энэ бүх сорилт дунд юу өрнөж байгааг ойлгоогүй байв. Эдгээр сорилт нь бидэнд ядаргаатай, залхмаар, цагийн гарз л санагдаж байлаа. Бид хожим Бурханд илүү том алдар авчирч чадахын төлөө илүү том бэрхшээлтэй нүүр тулж чаддаг болохын тулд Бурханы нигүүлсэл дотор хүчирхэгжиж байгаагаа мэдээгүй байлаа. Лиза бид хоёр жаал уйлж аваад, дараа нь Бурханы Үгд итгэх итгэлээ батлан, тэнгэрлэг даалгавраа биелүүлэх замаараа үргэлжлүүлэн алхсан юм.

Гэтэл Лиза бид хоёртой тэр долоо хоногт анх танилцсан Сан-Антониогоос ирсэн нэгэн гэр бүлийн хос хоёр өдрийн дараа надтай уулзаад: “Жон, бид хоёр яагаад гэдгийг нь мэдэхгүй. Гэхдээ Бурхан үүнийг та хоёрт өгөөрэй гэж хэлсэн юм” гээд, хоёр зуун долларын чектэй дугтуй өгөв. Лиза бид хоёр ёстой ангайв. Бидний байдлыг Бурханаас өөр хэн ч мэдэхгүй учраас Бурхан л бидэнд дахин хангаж өгчээ.

ИЛҮҮ ТОМ ЗОВНИЛОО ХАЯЖ СУРСАН МИНЬ

Ийнхүү бид хоёр хэдэн жилийн турш итгэл, төлөвшлөөр өссөөр эцэстээ би Флоридагийн томоохон чуулганы залуусын чуулганы пасторын ажлыг хүлээн авав. Энэ ажлын төлөө би дахиад л цалингаа буурууллаа. Гэхдээ энэ удаа манайх ой зургаан сартай хүүтэй болоод байсан учраас байдал бүр ч хэцүүдсэн юм. Бид зовнилоо ахин дахин Бурханд өгч, дайсныг сөрөн, Бурханы гайхамшигтай хангамжийг хүлээн авсаар байв. Би ч үйлчлэл дээрээ төвлөрч, Бурхан ч биднийг ер бусын арга замаараа тасралтгүй хангасаар байлаа.

1988 оны 9-р сард Бурхан надад бүтэн цагаар аялж заах үйлчлэлийн дараагийн шаг руу гарах цаг болсныг харуулсан юм. Би ч дээрээ пастортой хүн учраас Бурхан Өөрөө түүнд миний талаар хэлэх хүртэл таг дуугүй байхаар шийдэв. Энэ тухай Лизагаас гадна өөр мужид аж төрдөг нэг найз маань л мэдэж байлаа.

1989 оны 2-р сард пастор маань ажилчдын хуралд ирээд, урд орой үзсэн тод зүүдээ яриу. Пастор маань Лиза бид хоёрыг чуулганаасаа явж, бүтэн цагаар аялан үйлчилж байгааг харжээ. Би түүнийг сонсоод шууд л уйлсан юм. Ийнхүү Ариун Сүнс Үйлс 13:1-5 дээр Паул, Барнаб хоёрт хүслээ баталгаажуулсан шигээ надад ч бас хүслээ баталгаажуулж өгөв.

Зургаан сарын дараа 1989 оны 8-р сард гурван долоо хоногийн дотор би долоон газраас заалгах урилга хүлээж авлаа. Би пастортаа хэлтэл тэрбээр инээд алдаад: “Бурхан бидэнд үүнийг л үзүүлж дээ. Одоо чи замаа хөөх болсон болтой” гэснээ: “Энэ намар чадах чинээгээрээ аялаарай. Он дуустал чуулган цалинг чинь олгоно. Харин шинэ оны 1 сарын 1-нээс санхүүгээ чи өөрөө хариуцна шүү” гэж хэлсэн юм.

Тийнхүү би хэдэн сарын хугацаанд мөнөөх долоон газартаа очиж, амжилттай сургалт хийсэн ч, дахиж урилга нэмэгдэж ирсэнгүй. Би ч хэзээ л бол хэзээ явахад бэлэн байсан ч, хаанаас ч урилга ирэхгүй байв. Пастор маань ч үүнийг анзаарч, шинэ он эхлэхээс хоёр сарын өмнө миний талаар тун сайхан захидал бичээд, Америк даяарх зургаан зуун чуулганд илгээх

санал дэвшүүлэв (Манай пастор дотоод гадаадад маш нэртэй үйлчлэгч байсан юм).

Би ч пасторынхаа захидлыг хувилаад өөрийнхөө захидалтай хамт дугтуйлан, пасторынхаа өгсөн 600 чуулган руу илгээхээр хаяглаж эхлэлээ. Тэгээд бараг дөчин дугтуй наагаад байтал Ариун Сүнс: “*Хүү минь, чи юу л хийгээд байна даа?*” гэх нь сонсдов.

“Би энэ хүмүүст чуулганд нь очиж зааж чадна гэдгээ мэдүүлэх гэсэндээ л...” гэтэл Ариун Сүнс:

“*Чи Миний хүслээс гажчихлаа*” гэх нь тэр.

“Тэхдээ Бурхан минь, ингэхгүй л бол, намайг хэн ч мэдэхгүй шүү дээ” гэж намайг ээртэл Ариун Сүнс:

“*Би чамайг мэднэ. Надад итгэ*” гэв.

Тэр үед би шийдвэр гаргах ёстой болов: нэг бол зүрхэнд минь хэлсэн Бурханы удирдамжинд захирагдан, *даруу байдлыг сонгох* эсвэл өөрийнхөө хүчин зүтгэлээр мөнгө олох. Өөрөөр хэлбэл би санаа зовнилоо нэг бол Бурханд даатгах эсвэл өөртөө даатгахын аль нэгийг хийх ёстой болов. Тэгээд би тэр даруй шийдсэн юм. Оюун ухаан, сэтгэл мэдрэмж маань олон юм ярьж эхлэхээс өмнө би дугтуйлсан дөчин захидлаа шууд урж хаяад: “*Би нэг бол яг Бурханы үгийг сонссон эсвэл галзуурсан байх*” гэж бодлоо.

Цаг хугацаа өнгөрсөөр, 12-р сар дундаа орчихоод байхад, би хоёрхон урилгатай л сууж байв. Эхнийх нь нэгдүгээр сарын эхний долоо хоногт Өмнөд Каролинагийн жижиг хотод, хотын салах ёс гүйцэтгэх байранд хийдэг жижиг чуулганаас ирсэн урилга бол, нөгөөх нь хоёрдугаар сарын сүүлээр Теннесигийн уулан дахь жижиг чуулганд заалгах урилга байлаа.

Тэр үед манай пастор бидний төлөө үнэхээр сэтгэл зовж байв. Пастор маань өөрөө өнөө маргаашгүй дэлхий даяар цацагдах өдөр тутмын зурагтын хөтөлбөрөө эхлүүлэх гэж байлаа. Лиза өмнө нь телевизийн салбарт ажиллаж байсан учраас, пастор маань Лизад цагийн дөчин таван доллараар ажиллах санал тавьлаа. Үүнийг сонсоод Лиза бид хоёр ч баярлаж, жаахан уужрав. Аялан үйлчлэл маань хөлөө олж ядаж байгаа энэ үед тэр мөнгө бидэнд амин чухал байлаа.

Гэтэл хэдэн өдрийн дараа намайг залбирч байтал, Ариун Сүнс дахин надтай яриад: “*Хүү минь, Лиза телевизийн ажилд*

орбол, Би түүний олсон мөнгийг чиний аялан үйлчлэлээсээ олсон мөнгөнөөс чинь хасч тооцох болно. Лиза чиний пасторын төлөө ажиллах биш, чамтай хамт байгаасай гэж Би хүсч байна” гэж хэлэв.

Би ч хэлэх үггүй болов. Тэгээд энэ тухай Лизадаа хэлтэл, Лиза санал нийлсэн нь намайг бүр ч гайхшруулав. Гэтэл Лиза залбирч байхдаа, яг адилхан үг хүлээж авсан юмсанж! Тэгээд бид пасторгаа ихэд талархан байж саналаас нь эелдгээр татгалзсан боловч, пастор маань бидэнд санаа тавьсаар л байлаа.

Ийнхүү 12-р сарын адагтай золгов. Чуулганаас авах цалин маань зогсох гээд байтал, би хоёрхон уулзалтын л урилгатай сууж байлаа. Тэгтэл пастор маань надтай дахин уулзаад: “Жон, энэ бүтэн сайны шууд цуглаанаар би чамайг тайзан дээр гаргаад, орон даяар биднийг үзэж байгаа пасторуудын өмнө үйлчлэлийг чинь танилцуулж, ямар ч чуулганд очиж заах боломжтойг чинь зарлана. Үүнээс гадна манай чуулган чамд сар тутмын дэмжлэг өгнө” гэж хэлсэн юм.

Би ч дахиад л баярлалаа. Манай пастор бол нэвтрүүлгийг нь сая сая хүн үздэг, Америкийн хамгийн алдартай хүний нэг. Тиймээс энэ бол намайг яах аргагүй Бурханы арга зам мөнөөс мөн гэдэгт би итгэв.

Гэтэл хэдэн өдрийн дараа намайг залбирч байтал Ариун Сүнс надтай дахин ярив: *Хүү минь, пастор чинь чамайг зурагтаар зарлахгүй, чуулган ч чамд сар тутмын дэмжлэг өгөхгүй.”*

Миний гэдэн хөдлөв. Тэгээд: “Яагаад үгүй гэж? Пастор амласан шүү дээ” хэмээн урвагналаа.

Гэтэл Ариун Сүнс тэр даруй надад: *“Тэр бол Миний үгэнд ордог хүн. Харин би түүнд ийм юм хийхийг зөвшөөрөхгүй”* гэж хариулах нь тэр.

Би Ариун Сүнсэнд: “Та яагаад зөвшөөрдөггүй юм?” гэтэл, Ариун Сүнс надад хэзээ ч мартахын аргагүй нэг үг хэлсэн юм.

“Яагаад гэвэл хэрэв тэр үүнийг хийвэл, хүнд хэцүү үедээ чи Над руу биш, түүн рүү гүйдэг болно!”

Тэгээд мэдээж пастор маань юу ч зарлаагүй, сар тутмын дэмжлэгээ ч өгөөгүй. Гэхдээ би үүнд нь ч баярладаг. Үүний

ачаар би зовнилоо Бурханд даатгаж, дутагдаж гачигдах үедээ мөнгө нөлөөтэй хүнийг царайчлах биш, харин залбирч дайтаж сурсан юм.

Тэгээд 1-р сар гарч, чуулган ч цалингаа зогсоолоо. Лиза бид хоёр ердөө гурван зуухан доллартай л үлдэв. Тэр үед бид гурван ой хагастай Аддисон, нэг сартай Аустин гэдэг хоёр хүүтэй болсон байлаа. Бид сар тутам байрныхаа моргэйжид 1000 доллар, машиндаа 200 доллар төлөх ёстой байв. Дараагийн хэдэн цаас хэзээ хаанаас ирэхийг мэдэхгүй учраас, би зогсоо зайгүй залбирч, үүнийхээ ачаар Ариун Сүнстэй маш дотно болсон юм.

Хаалга үүд хамгийн ер бусын арга замаар нээгдэхийг бид хардаг байв. Нөгөө салах ёс гүйцэтгэх газар болдог чуулганд хийсэн цуглаан маш хүчтэй болсон учраас, бүтэн долоо хоног болгон сунгав. Энэ тухай мэдээ газар сайгүй тарж, Өмнөд Каролина мужийн Колумби хотын нэгэн пастор ирж оролцжээ. Төгсгөлийн цуглаан дээр тэр пастор намайг чуулгандаа урилаа. Лиза бид хоёр ч дуртайяа очсон бөгөөд тэндээсээ дараагийн чуулгандаа уригдаж, аян маань үргэлжилсээр байв.

Түүнээс хойш хэдэн сар өнгөрсөн ч, миний цагийн хуваарь бас л хоосон байлаа. Бидэнд санхүүгийн асар их дарамт ирж байсан ч, бид нэг ч төлбөрөө хоцроож байсангүй. Нэг өглөө би залбирахаар гадаа гарав: “Бурхан Аав аа, би Таны хэлснийг л хийж байна. Хэрэв та хийх уулзалт, санхүү мөнгөөр хангаж өгөхгүй бол, би хүнс уутлагчийн ажилд ороод, Бурхан Аав маань хүүхдүүдээ хангаж чадаагүй гэж ярих болно. Гэхдээ Аав аа, би өөрийгөө худалдмааргүй байна. Та бидэнд хаалга нээж өгнө. Би энэ зовнилыг Танд л бүрэн даатгана” гэж хашхирлаа.

Тэгээд хойд зүг рүү хараад, үүд нээгдэхийг тушаалаа. Дараа нь өмнө, зүүн, баруун зүг рүү хараад үүд нээгдэхийг тушаав. Тэгээд дайсанд ухрахыг тушааж, бидэнд эзлэхийг тушаасан Бурханы замд саад хийхийг диаволд хориглолоо.

Тэр залбирлаас хойш нэг их удалгүй Мичиганы нэгэн чуулган надаар дөрвөн өдрийн сургалт хийлгэхээр урив. Тэнд Бурханы гал хүчтэй бууж, дөрвөн өдрийн цуглаан маань долоо хоног болж суналаа. Хүмүүс энд тэндээс хүрэлцэн ирж, зарим нь бүр

140 км хол газраас ч ирэн, орой бүр тэр чуулганы байрыг пиг дүүргэж байв. Би Флоридад манай аав, ээжийн гэрийн ойролцоо байдаг нийтийн усан санд хүүхдүүдээ зугаацуулж байсан эхнэртэйгээ утсаар ярин, миний байгаа газар юу болж байгааг хэлээд, тэр цуглаан яг хэзээ дуусах нь тодорхойгүй байгаа тул хөвгүүдээ аваад Мичиганд ир, би тасалбар илгээнэ гэж хэлэв.

Гэтэл Лизагийн дэргэд амралтаараа явж байсан нэгэн пастор сууж байгаад, бидний яриаг санаандгүй сонсчихсон юмсанж. Тэрбээр Лиза дээр хүрч ирээд: “Өршөөгөөрэй, би сая таны нөхөртэйгээ ярьсан яриаг сонсчихлоо. Би өөрөө Нью Йоркийн 1500 гаруй хүнтэй чуулганы пастор хүн л дээ. Би өөрөө ч чуулганд маань Бурханы хүчирхэг үйлс өрнөөсэй гэж өлсөж цангаж явдаг. Тэгээд Эзэн надад танай нөхрийг урих хэрэгтэй гэж хэлэх шиг боллоо” гэжээ.

Тиймээс Мичиганы цуглааны дараа бид Нью Йорк явлаа. Тэнд ч бас маш хүчирхэг үйлчлэл болов. Бид тэр чуулганд байнга зочилдог болсон доо. Иймэрхүү зүйлс долоо хоног тутам ээлж дараалан өрнөдөг болов. Үнэндээ аялан үйлчлэлийнхээ эхний дөрвөн жил бид нэг ч чуулган руу захидал илгээгээгүй, нэг ч удаа утасдаагүй юм. Цуглаан болгон цаанаасаа л ямар нэг арга замаар нээгддэг байв.

НЭГ Ч ТАСРААГҮЙ ХАНГАМЖ

Би дахин хэлье. Би гэр бүлээ авч явах эр нөхрийн эрх үүргийг хар багаасаа ухаарч ойлгосон хүн. Үүнийг хийдэггүй хүн үл итгэгч хүнээс ч дор гэдгийг 1Тимот 5:8 батлан хэлдэг. Гэр бүлээ тэжээх нь бурханлаг бөгөөд эрхэм хариуцлага юм. Гэхдээ хэрэв би энэ хариуцлагыг нэн тэргүүнд тавьбал, хэзээ ч Бурханыг бүрэн дуулгавартай дагаж чадахгүй байв. Энэ хариуцлага маань намайг гүйхэд хүнд ачаа болох байлаа.

Ийнхүү хэдэн жил амьдарсны дараа би өөр сонголт хийсэн юмуу асуудлаа Бурханд бүрэн төгс даатгаагүй үйлчлэгч нарыг анзаарах болсон юм. Тэдгээр үйлчлэгч нар мөнөөх арван туршуултай адил хангамжаа өөрийнхөө чадварт тулгуурлаж тооцоолдог нь илт харагддаг. Тэд өөрсдийгөө худалдаж,

хэрэгцээгээ цухалзуулж, улс төрийн тоглоом тоглох нь ажиглагдана. Амьдралын дуудлага нь жинхэнэ боловч, амар хялбар аргаар өөрсдийгөө болоод Бурханыг худалдаж байгаа нь үнэхээр гашуудмаар байв. Өнөөдөр ч олон үйлчлэгч нар хаанчлалын захиргаандаа ороогүй л явна. Нэгэн пастор “Хэрэгцээгээ цухуйлгадаггүй итгэл бол итгэл биш” гэж хэлэхийг сонсоод зүрх минь үйрэх шиг л болж билээ.

Аяныхаа эхний жил Бурхан биднийг юугаар ч дутаалгүй, гайхамшигтай арга замаар хангахыг Лиза бид хоёр харсан. Нэг удаа бид маргаашийн дотор байрныхаа төлбөрт 700 доллар төлөх шаардлагатай байв. Шуудангаа шалгатал Алабамад аж төрдөг нэгэн хиппи хосоос захидал ирсэн байлаа. Тэд газраар гудас дэвсээд, найман хүүхэдтэйгээ унтдаг, тийм л эгэл бор амьдралтай хүмүүс ажээ. Гэтэл тэд *“Жон, Лиза хоёр минь, бид учрыг нь мэдэхгүй. Гэхдээ та хоёрт энэ 300 долларын чекийг явуулах ёстойг Бурхан өнөөдөр бидний зүрхэнд маш тодорхой хэллээ”* гэж бичсэн байв.

Мөн тэр орой би 40 гаруй хүнтэй нэгэн цуглаанд номлоод, пастораас нь талархлын өргөл хүлээж авсан байлаа. Харьж ирээд, унтахаар хэвтэж байхдаа нөгөө өргөлөө тоолохоо мартсанаа санах. Гэхдээ Лиза бид хоёр бүх зовнилоо Бурханд бүрэн даатгачихсан учраас би маргаашийн төлбөрт нэг ч зовохгүй байлаа. Тэгээд босоод өргөлөө тоолтол 397 доллар 26 цент байв. Үүнийг хиппи хосын бэлэгтэй нийлүүлбэл, яг байрны маань төлбөрт хүрч байв. Бурхан энэ удаа ч бас хангаж өгчээ.

Цаг хугацаа өнгөрөх тусам, би Бурханы ажилладаг арга замыг ухаарч эхэлсэн юм. Лиза бид хоёр машины жанам зэрэг жижиг зүйлийг Бурханд даатгахыг сурсан. Бага орлоготой үед хэрхэн итгэж, тэмцэхийг сурах нь чухал байв. Яагаад? Яагаад гэвэл бид бүтэн цагийн аялалын үйлчлэлд хөл тавихдаа, бага цалингаас огт цалингүй нөхцөлд орсон юм. Бид итгэлээр өсч, илүү хэцүү даалгаварт бэлэн байв. Аялалын эхний жилийн бэрхшээл нь биднийг ихэд өсгөж, итгэлийн дараагийн төвшинд бэлтгэсэн юм.

Энэ номыг бичиж байхад Мессенжер Интернэйшнэл дэхь бидний долоо хоног тутмын төсөв 100,000 долларт хүрээд байна. Хэрэв би зовнилоо Бурханд өгч, алхам тутмаа Түүнд

итгэж сураагүй бол, хэдийнээ бяцарчихсан байгаа. Гэхдээ би хэрэгцээнийхээ төлөө нэг ч шөнийн нойроо хугасалж үзээгүй. Ойлголтоос хол давсан Бурханы амар тайван амласныхаа дагуу бидний зүрхийг Христ Есүсийн дотор ер бусын байдлаар хамгаалж, сахисаар ирсэн билээ.

ИТГЭЛЭЭС ИТГЭЛД

Бурханы ажилладаг арга зам нь надад бодибилдингийн санагдуулдаг юм. Би гучин тавтай байхдаа биеийн тамир спортыг цагийн гарз гэж үздэг, асар завгүй аялдаг номлогч байлаа. Гэтэл нэгэн удаа Жоржиагийн Атлантад индрийн ард шургачиж унах шахаж билээ.

Манай нэг хөрш мэргэжлийн тулаанч байсан юм. Манай хоёр гэр бүл ч сайхан нөхөрлөдөг байв. Тэрбээр намайг бэлтгэлдээ урьсан боловч би өөрөө дургүйцсэн юм. Харин Атлантад болсон явдлын дараа миний хандлага өөрчлөгдөж, би найзаасаа тусламж хүсэв.

Найз маань 118 кг жинтэй атлаа дөрөвхөн хувийн өөхний эзлэхүүнтэй булаа эр байв. Түүний гарын булчин нь миний гуяас ч бүдүүн. Бид хоёр тогтмол бэлтгэл сургууль хийдэг болов. Эхэндээ би түүний бодигийн тамирчин найзуудтай танилцаж, тэдний бэлтгэлээс туршлага судлалаа. Тэгээд хөнгөн жингээр олон өргөх нь булчинг хөгжүүлдэггүйг мэдэж авав. Залуус өөрсдөө хүнд жингээр дээд тал нь гурав юмуу дөрвөн удаа л шахна. Тэгээд гурав дахиа явуулаад, дөрөв дэхь удаагаа өргөхөд л жинхэнэ адал явдал өрнөнө. Сандал дээр хэвтэж байгаа хүн хамаг тамираа барж, нүүр нь минчийж, судас нь тодорч, бие нь чичрэхэд, нөхөд нь бүгд: “Явуул, өргө!” гэж орилолдоно. Тэгээд нөгөө хүн дөрөв дэхь өргөлтөө гүйцээх гэж хамаг хүчээ шавхана. Яг энэ үед биеийн булчин ажиллаж өснө.

Би анх бэлтгэлд ороод 43 кг л шахсан бөгөөд бүтэн сар энэ хэмжээгээ л барив. Дараа нь аажмаар 61 кг руу ахилаа. Зургаан сарын дараа 84 кг, тэгээд сүүлдээ 93 кг-д хүрсэн ч, үүнээсээ жил хөдлөсөнгүй.

Гэтэл манай байгууллагад бодигийн тамирчин байсан нэг хүн ажилд оров. Түүнтэй ярилцах зуур, тэрбээр надад хүч, булчин хөгжүүлэхэд яах ёстойг сануулж өгсөн юм. Булчин хөгжүүлэхэд хүнд жингээр тултал нь хийх ёстой байдгийг би мартчихжээ. Тэгээд бид хоёр Калифорнигийн Фреснод хамтдаа үйлчлэх хүртлээ бэлтгэлээ тасралтгүй хийв. Конференцийн завсарлагаар бидний хэдэн хүн бэлтгэл хийсэн бөгөөд бэлтгэлийн үеэр манай залуус над руу “бүлэглэн дайрав”. Манай хамтрагч “Жон, чи өнөөдөр 100 кг шахна” гэлээ.

Би ч: “Тэр ярихгүй” гэв.

Гэтэл тэр: “Чадна аа! Зүгээр л хэвт. Бид заагаад өгнө” гэлээ. Тэгээд мэдээж би өргөж, хөл газар хүрэхгүй баярлав. Би бэлтгэлээ хийсээр 110 кг шахдаг болов. Гэхдээ дахиад л гацчихав. Нэг л өдөр 143 кг шахдаг болохыг мөрөөдөж байсан ч, энэ маань ёстой биелэшгүй мөрөөдөл байв.

Намайг Мичиганы Детроитын нэгэн чуулганд үйлчилтэл, пастор нь улсын нэртэй бодигийн дасгалжуулж асан гишүүнийхээ талаар хэлэв. Тэр пастор өөрөө саяхан 250 кг шахсан ажээ. Бүтэн сайны цуглаанаас хэдэн өдрийн дараа пастор намайг мөнөөх дасгалжуулагчтайгаа уулзуулж, би ч түүний ачаар 120 кг шахаж, ухаангүй баярлав! Тэр хүн намайг эрчимт хөтөлбөртөө оруулж, манай ажилтан бид хоёр хэдэн сарын турш хичээнгүй хичээллэв.

Дараагийн удаа би Детроитод эргэж ирэхдээ, Бүтэн сайны өглөө, оройны цуглаан дээр Ариун Сүнсний талаар номлов. Нэг дэхь өдөр нь бид бэлтгэлээ хийж байтал, мөнөөх дасгалжуулагч маань надад: “Жон, өнгөрсөн шөнө би чамайг 136 кг шахаж байна гэж зүүдлэлээ” гэв.

Би ч: “Тэр ярихгүй!” хэмээн жуумагналаа.

Гэтэл тэр над руу хараад: “Залуу минь, чи өөрөө өчигдөр Ариун Сүнс бидэнтэй яаж ярьдаг талаар заагаа биз дээ? Тэгээд Ариун Сүнс надтай шөнө ярьсан. Тиймээс дуугай л хэвт. Чи өнөөдөр 136 кг шахах л болно” гэв.

Би ч “ухаантай юм болохоороо” дуугаа аядаад, сандал дээр хэвтлээ. Биеэ халаасны дараа найз маань хөндлөвч дээр 136 кг-ын туухай углав. Тэгээд “төмрөө өөр рүүгээ буулгамагцаа юу ч бодолгүй, зүгээр л түлхээрэй!” хэмээн эрчтэй шивэглэв.

Хөндлөвчийг хамгийн доод цэг дээрээ татаж авчирмагц, багш маань намайг тойрсон баахан хүмүүсийн хамт: “Түлхээрэй, түлх! Уухай ёстой, түлх, түлх, түлх!” хэмээн хашхиралдлаа. Гэтэл дээшээ явж байна шүү! Бүр тултал явлаа! Тэд хөндлөвчийг авахад, би сандлаасаа босоод, хашхиран дэгдлээ. Ёстой гайхамшигтай байв.

Дасгалжуулагч маань намайг таван минут баярлуулснаа, шууд мөнөөх чухал царайгаа гарган цоо ширтсэнээ: “Одоо чи 143 кг шахна” гэлээ.

“Өө, ёстой барахгүй. Чи шөнө ингэж зүүдлээгүй биз дээ?” гэтэл

Тэрбээр эелдэг нь аргагүй инээмсэглэсэнээ: “Дуугай л хэвт” гэлээ.

Ингэж би дөчин дөрвөн насандаа 143 кг шахсан юм. Баярласандаа дээшээ доошоо үсрэн цовхчиж билээ. Энэ мэдээг хэлэх гэж Детроитын онгоцны буудлаас Лиза руугаа залгаж байснаа хэзээ ч мартахгүй.

Хожим нь Бурхан надад тэдгээр дасгалжуулагч нар - манай ажилтан, Калифорнийн пасторууд, Детроитын олон улсын дасгалжуулагч нар нь яг л Ариун Сүнс шиг ажилласныг харуулсан юм. Паул: *Та нарт учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл. Бурхан итгэмжтэй, Тэр та нарыг хэр чинь хэтэртэл соригдохыг зөвшөөрдөггүй, харин дааж гарахын тань тулд сорилттой хамт мөн гарцыг ч буй болгоно* (1Коринт 10:13) гэж хэлснийг санацгаа.

Намайг юуг дийлэх, юуг дийлэхгүйг дасгажуулагч нар мэдэж байсан. 143 кг туухай өргөж дийлэх хүн дээр 184 кг тавьж болохгүйг тэд мэдэж байсан. Тэд хүний хүчин чадлыг мэддэг, ур чадвартай хүмүүс байсан. Тэд миний харж чадахгүй байгааг харж байсан нь үнэхээр биширмээр. Би тэднийг харах тоолондоо би ингэж чадахгүй гэж боддог байсан. Гэтэл тэд миний өөрөө ч мэдэхгүй хүчин чадлыг харжээ.

Ариун Сүнс ч бас адил. Ариун Сүнс таныг юуг дийлэх, юуг дийлэхгүйг мэднэ. Хэрэв миний бэлтгэлийн анхны өдөр манай мэргэжлийн бодигийн тамирчин найз маань хөндлөвчинд 143 кг-ын туухай углачихсан бол, юу болох байсан бэ? Хөндлөвч

миний дээрээс газрын татах хүчний хурдаар унаж ирээд, хэдэн хавиргыг минь бяцлахаар барахгүй, намайг алчих байсан биз. Би 44 кг - аар эхлээд, бага багаар ахиулсан юм.

Үүнтэй адил Лиза бид хоёрт юу хадгалагдсан байгааг Ариун Сүнс мэдэж байсан. Иеремиа 29:11 дээр “Та нар зориулсан төлөвлөгөөг зөвхөн Би л мэднэ.” Тэр бидний итгэлийг байгуулах ёстой байсан, харин бид энэ явц дунд зовнилоо Түүнд өгч сурах ёстой байжээ. Энэ бүхэн хэзээ ч амархан байгаагүй ч, хэзээд ашиг тустай байсан юм. Би олон удаа бууж өгмөөр байсан ч, Есүс надаас хэзээ ч урваагүй учраас, би Түүнээс яагаад ч урваж чадахгүй байсан.

Бид тэнгэрлэг даалгавартаа үнэнч үлдэж, замынхаа турш эсэргүүцлийг сөрсөөр давсаар өнөөг хүрсэн.

Эргээд бодоход, бага цалин, машины эвдрэл, мөнгөний

асуудал тэргүүтэй тэр бүх сорилт нь биднийг айсуу ирээдүйд бэхжүүлэх барилгын тоосго байжээ. Хэрэв бид долоо хоног тутам 100,000 долларын төлөө Бурханд итгэхээс эхэлсэн бол, энэ нь бэлтгэлийнхээ анхны өдөр 143 кг туухай өргөхтэй л адил байх байж. Ариун Сүнс биднийг аажмаар тогтвортойгоор Бурханд илүү найдаж чаддаг болох хүртэл маань барьж байгуулжээ.

**Ариун Сүнс таныг
юуг дийлэх, юуг
дийлэхгүйг мэднэ.**

БЭЛТГЭЛЭЭ БҮҮ ТАСЛА

Бид бэлтгэлийнхээ анхан шатанд машинаа засах, идэх уух, төлбөр түрээсээ төлөх гэх мэт хувийн асуудалтай тулгардаг байсан бол, өнөөдөр амин хувийнхаа асуудлыг ардаа орхиж, Бурханы даалгасан үй олон хүний сайн сайхны төлөөх асуудалтай тэмцдэг болсон билээ. Хэрэв бид Бурханы анхан шатны бэлтгэлээс зугтсан бол, яаж өнөөдөр Бурханы даалгасан энэ олон хүнд үйлчилж чадах билээ? Бурхан бидний оронд чаддаг хүнийг нь гаргаж ирэх байсан биз.

Бурханы бэлтгэл сургуулийг тасласан учраас, Бурханы даалгасан хүмүүст хүрч чаддаггүй хүн олон бий. Тэд тухайн үед 143 кг туухай өргөж чадаагүй бол, одоо юу гэж 184 кг туухай өргөж чадах билээ? Тиймээс Бурхан тэдний даалгаврыг өөр хүнд өгдөг.

Өөрт ирсэн сорилтыг давж чадаагүйгээсээ болоод захиргаанд хөл тавьж чадалгүй, Бурханы дуудлагаас холуу тасарчихсан эрэгтэй, эмэгтэй бизнесмэнүүд бий. Тэд бэрхшээлтэй тулгарахдаа, Бурханд итгэхийн оронд хүний арга ухаан сүвэгчилж, дарангуйлсан, ноёрхсон арга хэрэглэдэг учраас Бурханаас өгсөн хүчин чадалдаа хүрдэггүй.

Израилийн арван туршуул Калев, Иошуа хоёр шиг бэлтгэгдээгүй байсан. Магадгүй тэд сорилтод орохдоо, Бурханд итгэхийн оронд аль болох зугтах арга сүвэгчилдэг байсан байх. Тэд итгэлээ байгуулаагүй. Тиймээс үхэл амьдрал шийдэгдэх цаг ирэхэд, тэд итгэлийн тэнхээгүй байсан юм.

Хүн бүрт ямар дасгал сургууль зохихыг Аав маань мэднэ. Хэдийгээр Аав маань зовлонгийн зохиогч биш боловч, бидэнд хандсан хувь тавиланд биднийг бэхжүүлэхийн тулд тэр зовлонг ашигладаг.

Тиймээс бэлтгэл сургуулиа битгий тасла. *Өнөөдрийн сорилт нь таныг маргаашийн аугаа үйлсэд бэхжүүлнэ. Найз минь, Бурхан таныг амжилтанд хүрдэг болтол чинь бэлтгэхгүйгээр хэзээ ч ачаа үүрүүлэхгүй.*

Алдраас алдарт, итгэлээс итгэлд, хүчээс хүчинд хүрэхийн тулд даруугаар бүх зовнилоо Бурханд даатгаж сураарай.

ЭРҮҮЛ УХААНТАЙ, СОНОР СЭРЭМЖТЭЙ БАЙ

Залуус аа, та нар мөн түүнчлэн ахлагчдадаа захирагд. Та бүгд бие биендээ даруу хандах байдлаар хувцасла. Учир нь Бурхан бардмыг эсэргүүцдэг, харин дарууд нигүүлсэл өгдөг. Иймд Бурханы хүчирхэг мутрын дор өөрсдийгөө даруу байлга. Тэгвэл Бурхан зохистой цагт та нарыг өргөмжилнө. Тэр та нарт санаа тавьдаг учраас бүх зовнилоо Түүнд хая. Эрүүл ухаантай, сонор сэрэмжтэй бай. Та нарын өрсөлдөгч болох диавол нь хэн нэгнийг залгихаар хайж буй архирах арслан мэт гэтэн явдаг. Харин та нар бат итгэлээрээ түүнийг эсэргүүц. Дэлхийд буй ах дүү нар чинь адилхан зовлон эдэлж байгааг та нар мэднэ.

1Петр 5:5-9

Петрийн баялаг сэнхрүүлгийг цааш нь үргэлжлүүлэн олборлохоосоо өмнө, эхлээд хураангуйлж харъя: Элч маань Бурханы жинхэнэ нигүүлсийн талаар өгүүлжээ. Нигүүлсэл нь бидний дан ганц аврал, нүглийн уучлалын төлөө өгөгдөөгүй. Нигүүлсэл нь биднийг алдагдсан харанхуй ертөнцийг гийгүүлэх хүчтэй болгодог. Гэхдээ үүнд асар их тулаан дундуур гарч байж л хүрнэ. Тиймээс бид нигүүлсийн зэвсгээр зэвсэглэх учиртай.

Зэвсэглэл нь даруу байдлаар эхлэнэ. Учир нь даруу хүмүүст нигүүсэл өгөгддөг. Петр биднийг даруу чанараар “хувцасла” хэмээн сэнхрүүлсэн. Жинхэнэ даруу байдлын амин чанар нь амьдралын бэрхшээлийг өөрийнхөө хүчээр шийдвэрлэх гэж оролдохын оронд бүх зовнилоо Бурханд даатгахад оршино. Хувийн ачаандаа дарагдаад байвал, бид уралдаанд гүйж, үр дүнтэй тулалдаж, бариа хүртлээ тэсч чадахгүй. Зовнил, гутрал, айдас нь бидний хувь тавилангийн дайсан юм. Эдгээрийг Бурхандаа үүрүүлбэл, бид илүү хурдан гүйж, илдээ ч хавьгүй хүчтэй далайна.

Товчхондоо - жинхэнэ даруу чанар бидэнд энэ дэлхийн системийг чөлөөтэй сөрөх эрх чөлөө өгдөг. Зангуугаа санаа зовнилын шавар шавхай дундуур чирч ядан яваа хүн өөдөөс орж ирэх голын хүчтэй урсгалд цохиулаад, даалгавраа биелүүлж чадахгүй.

Петр биднийг эрүүл ухаантай, сонор сэрэмжтэй байгаарай гэсэн.

ЭРҮҮЛ УХААНТАЙ БАЙ

Эрүүл ухаантай гэж орчуулсан үгийг “нухацтай, мэдрэг, албан” гэж тодорхойлж болно. Нефо хэмээх энэхүү Грек үг нь архинд согтуурахын эсрэг утгыг илэрхийлэх буюу “эрүүл бай” гэсэн үг юм.

Би согтууруулах ундааг ахлах сургуулийн эхний жилдээ анх амсаж үзсэн бөгөөд төгсөх ангид орох хүртлээ амралтын өдрөөр тогтмол уудаг болов. Их сургуулийн оюутан болоод аав, ээжийнхээ мэдлээс гарсан учраас уух маань бүр ч ихсэв. Ахан дүүсийн холбоонд нэгдсэн маань архидан согтуурах явдлыг маань улам л дэвэргэв. Оюутан ахуй үеийн нэг чухал хэсэг нь наргиан цэнгээн байсан учраас, би ч нилээд уудаг болсон юм. Гэхдээ хоёрдугаар дамжаанд байхад минь Есүс намайг аварсанд би хязгааргүй баярладаг. Тэр намайг юу гээчийн аймшигт төгсгөлөөс хэлтрүүлснийг би төсөөлж ч чадахгүй. Үүнийг Бурхан л мэднэ.

Хэд хэдэн удаа шал согтоод, өөрийнхөө яаж мангартсныг маргааш нь найз нөхдөөсөө л олж сонссон юм. Товчхондоо согтуу

хүн хараа хамгаалалт, сонор сэрэмжээ нэг мөр гээдэг. Манай хуурай ахан дүүс нар бие биеэ байнга цаашлуулдаг байсан учраас, согтсон нэгнээрээ хайр найргүй тоглодог байв. Бид эрүүлдээ хэзээ ч хийхгүй байсан юмсаа согтуудаа үйлддэг байсан юм.

Нэг тоглоом нь эд юмсыг нь хулгайлах байв. Согтуу хүн үнэтэй сайтай зүйлээ алдснаа мэдэхгүй. Харин маргааш нь юмаа алдсанаа олж мэдээд, сүйд майд болж, ойр хавийнхаа юмсыг онгичиж, орон байраа буулгана. Тэрбээр эд юмаа хэзээ хэнд алдсанаа ч мэдэхгүй. Тэгээд лабораторынхаа төсөл, түрийвч, найз охиныхоо зургийг алдсандаа сандарч уцаарлаж, уйлагнаж, зарим нь бүр чичрэн хашхичдаг байв. Энэ үеэр бусад нь жуумагнан шоолсоор, бахаа ханатал зовоосныхоо дараа пис хийтэл хөхрөлдөн юмыг нь гаргаж өгдөг байлаа.

Мэдээж бид тоглож байсан. Гэхдээ согтууг нь далимдуулаад хэн нэг нь жинхэнээсээ хулгай хийбэл яах уу? Согтуу хүн хулгайчийн өгөөш болж, үнэт зүйлээ алдана.

Архидан согтуурал нь мөн аймшигтай зодоон нүдээн үүсгэдэг. Нэгэн үдэшлэг дээр эрүүл, согтуу хоёр найз маань нударга зөрүүлж билээ. Уг нь согтуу найз маань уугаагүй байсан бол эрүүлийгээ маш амархан дийлчихэж чадах хүн боловч, согтуу учраас хэмх нүдүүлсэн юм. Хүмүүс дундуур нь орж байж салгаагүй бол, бас л эвгүй юм болох байв.

Танилцуулга хэсэгтээ бид бодит явдлаас сэдэвлэсэн Сүнс, Харангуй хоёр гэдэг киноны тухай ярьсан. Төмөр замын инженер Паттерсон, алдарт Америк анчин Ремингтон хоёр 130 хүнийг алсан хоёр арсланг устгадаг. Гэхдээ харамсалтай нь анчин Ремингтон хоёр арслангийн нэгэнд нь бариулж амиа алддагийг би хэлээгүй өнгөрсөн. Паттерсонтой хамт хэдэн өдөр хөөцөлдөж байж нэг арсланг нь алсан Ремингтон тэр үдэш баяраа тэмдэглэж байна гэж архидаж унаад, хоёр дахь арсланд бариулдаг. Үүний дараа Паттерсон найзыг нь алсан тэр арсланг цааш нь харуулна.

Ремингтон мундаг анчин байсан ч, согтуу хүнд энэ гоц чадвар нь ямар ч нэмэр болоогүй юм. Тэрбээр арслангаас хол давсан хүчирхэг зэвсэгтэй байсан ч, согтсон учраас араатныг алах нь байтугай, өөрийгөө ч хамгаалж чадаагүй юм.

СҮНСЛЭГ СОГТУУРАЛ

Сүнслэг амьдрал дээр ч адил. Согтуу хүнийг дайсан ядах юмгүй дээрэмдэж, сүйрүүлж чадна. Бид эрүүл ухаантай байж дайсныг нигүүлслийн зэвсгээр хядах ёстой байтал согтуу толгойлоод явбал, хараа хамгаалалтаа алдаж, дайсанд хялбархан дийлэгдэнэ.

1Петр 5:8 дээр Петр: “Та нарын өрсөлдөгч болох диавол нь хэн нэгнийг залгихаар хайж буй архирах арслан мэт гэтэн явдаг” хэмээн анхааруулжээ. Дайсан бардам хүмүүсийг, санаа зовдог хүмүүсийг төвөггүй урхидаж чаддаг ч, согтуу хүмүүс түүний нэн тэргүүний өгөөш болдог. Петр архидалдын тухай ярьсан уу? Магадгүй юм. Гэхдээ Петр юу юунаас илүү энэ дэлхийн дарсанд согтсон итгэгчдийн тухай ярьжээ.

Илчлэл номын төгсгөл хавьд Иохан Вавилон хэмээх аугаа их янханы шийтгэлийн тухай өгүүлдэг. Тэнгэрэлч түүнд:

Долоон аягатай долоон тэнгэрэлчийн нэг нь ирж надтай ярилцан —Нааш ир. Их усны дээр суух их янхныг шүүх шүүлтийг би чамд харуулъя. Дэлхийн хаад тэр эмтэй завхайрч, дэлхий дээр нутаглагсад түүний завхайрлын дарснаас ууж согтуурцгаасан гэв. (Илчлэл 17:1-2)

Энэ янхан нь чухам юу болохыг янз янзаар л тайлбарладаг. Зарим нь Католик сүм гэдэг. Нөгөө нь эртний Вавилон хотыг хэлж байгаа гэдэг бол, үлдсэн нь энэ нь Ромын эзэнт гүрний буюу Ромын нэг хот гэдэг.

Миний хувьд “аугаа их янхан” нь энэ дэлхийн санхүүгийн систем гэдэгт итгэдэг. Учир нь тэр янхны духан дээр “Дэлхийн янхнуудын ба жигшүүрт юмсын эх их Вавилон” гэсэн бичиг байдаг (Илчлэл 17:5) нь ингэж итгэх нэг шалтгаан болж байгаа юм. Бусад орчуулга дээр жигшүүрүүд гэсэн үг хэрэглэдэг боловч, миний бодлоор эртний Вавилон, Ром, Ромын эзэнт гүрэн юмуу Католик сүм нь “Дэлхийн янхнуудын ба жигшүүрүүдийн эх” арай л биш байх. Харин Бичээс “мөнгийг хайрлах хайр нь бүх ёрын муугийн үндэс” (1Тимот 6:10) гэдэг бөгөөд ёрын муу гэдэг үгийг янхнууд ба жигшүүрүүд гэдэг үгээр орлууллаа ч,

ишлэлийн утга нь алдагдахгүй, хэвээрээ байна. Би энэ талаар маргах гээгүй. Гэхдээ бодоход илүүдэхгүй л юм.

Тэгэхээр энэ дэлхийн систем нь хүний мэдэрхүйг урхидаж согтоох чанартай. Илчлэлийн дээрх хэсэгт “Дэлхий дээр нутаглагсад түүний завхайрлын дарснаас ууж согтуурцаасан” гэж хэлсэн Иоханы үгийг тэмдэглэнэ үү. Хүн энэ дэлхийн зовнил, баялаг, таашаалд хөлчүүрхэхдээ, Ариун Сүнстэй тогтоох дотно харилцаанаасаа хөндийрдөг. Энэ нь маш зальжин арга зам юм. Учир нь итгэгч хүн бурханлаг дүр исгэсэн хэвээрээ энэ дэлхийн хүсэл тачаалд мансуурч чадна. Сүнсний хараа хяналтаа нэг л алдахад, тэр эрэгтэй, эмэгтэй хүн дайсны хулгай, мэхлэл, сүйрэл, тэр бүү хэл үхлийн хялбар бай болно.

Соломонтой яг ийм явдал тохиолдсон юм. Түүний амьдрал бурханлаг цэц ухааныг хүсэн тэмүүлснээр эхлэсэн бөгөөд Бурхан ч Соломоны хүслийг биелүүлж, үлэмж амжилт, эд баялагт хүргэжээ (Сургаалт үгс 28:11-21). Гэвч он цагийн явцад Соломон хаан цэц ухааныхаа үр өгөөжид бялууран хөлчүүрхэж, энэ бүгдийг өгсөн Бурханаас хараагаа салган, дэлхийн таашаал, тачаал, баялгаас гударч, согтсон хойноо эрүүлдээ хэзээ ч хийхгүй байсан зүйлээ хийн, хуурамч бурхдад мөргөжээ.

Соломон Бурханыг хоёр ч удаа харчихаад, ингэж шогтсон нь сэтгэл өвдмөөр. Гэхдээ миний саяын заасан зарчмаар Соломоны үйлдлийг гэрэлтүүлж харах юм бол, түүний яагаад ийм байдалд хүрснийг амархан ойлгоно. Бид согтохоороо эрүүлдээ хэзээ ч хийхгүй байсан зүйлээ хийдэг. Соломон ч бас тэгжээ.

Тэгвэл яаж ийм алдаанаас сэргийлж, эрүүл ухаантай байх вэ? Биднийг жинхэнээсээ хангадаг Эзэний дотор тасралтгүй хооллож, ундаалснаараа. Ефес 5:18 дээр Паул “Дарсанд бүү согтуур. Эс бөгөөс хэт самуурал буй. Харин Сүнсээр дүүр” гэсэн. Паул дарс гэдэг ундааны талаар яриагүй, харин биднийг согтоож, Бурханы арга замаас хадууруулдаг зүйлсийн талаар ярьсан гэж би боддог. Энэ нь ажил бизнес, эсрэг хүйсийн хүн, спорт юмуу аль нэг хобби, нийтийн сүлжээ гэх мэт бидний хамаг анхаарлыг сордог зүйлс юм.

Бурхан “... харин биднийг баясгах бүхнээр арвин хангагч Бурханд найд” (1Тимот 6:17) гэжээ. Тиймээс угтаа дээрх юмст

ямар ч асуудал байхгүй. Эдгээр нь бидний бүтээлч чанар, эрүүл саруул зугаа, спорт тэмцээн, хоол хүнс, байгалийн үзэсгэлэн, тэр бүү хэл бидэнд технологийн үр өгөөжийг эдлүүлэх зорилготой, төгс сайхан зүйлс юм. Харин хэрэв бид эдгээртэй хэт хутгалдаж, сэтгэл ханамжаа Бурханаас биш, эдгээр юмсаас авдаг болбол, дээрх сайн зүйлс нь хортой донтолж болж эхлэжээ гэсэн үг юм.

Есүс л бидний дээдийн дээр хайр, хүсэл Есүс л байх ёстой. Бид Есүсийн Сүнсээр л согтох ёстой.

ӨӨРИЙГӨӨ ТОГТМОЛ ШАЛГА

Энэ дэлхийн юмст согтож, суларч, эрүүл ухаанаа алдахгүйн тулд Бурханы хүүхэд бүр өөрийгөө тогтмол шалгаж байх хэрэгтэй. Бид өөрөөсөө: “Би юугаар өлсөж цангаж байна?” гэж шударгаар асуух ёстой. Өнгөц биш, ямар ч найраагүй шударгаар хариул. Чөлөөт цагаараа юун дээр хамаг цагаа зарж байна? Юуны талаар зогсоо зайгүй бодож, юуг зогсоо зайгүй үйлдэж байна? Хөл бөмбөг үү? Тэгвэл та хэтэрхий их хөл бөмбөг ууж байгаа бөгөөд энэ чинь жирийн сайхан зугаа байхаасаа өнгөрчээ. Эсвэл таны дуртай ундаа чинь эсрэг хүйсийн чинь хүн үү? Эсвэл яаж мөнгө олох талаар өдрийн бодол, шөнийн зүүд болж байна уу? Та өөрийнхөө дуртай “дарсыг” мэдэж л байгаа. Иймээс л Бурхан биднийг Өөрийнхөө Үгийг уншиж, анхаарлаа хандуулж, тунгаан бод гэжээ. Та хамгийн дуртай ундаагаараа л цангаж, дуртай хоолоороо л өлсөнө.

Манай ахлах сургуулийн теннисний багш коланд яаж донтохыг би харсан юм. Эхлээд өдөрт нэгийг уудаг байснаа, сүүлдээ хоёр, гурвыг уудаг болсон. Энэ байдал нь даамжирсаар, багш маань өдөр нэг багц кола уудаг болтлоо донтсон юм. Хөргөгчинд нь хэд хэдэн багц кола, хөргөгчнийх нь гадна ч нөхөж хөргөхөөр зэхсэн хэд хэдэн багц кола давхарлаатай байдаг байлаа.

Хэт их хийтэй ундаа ууснаас болж таргалж, өвчин эмгэгт баригдаж байгаа хүмүүсийг ч би харсан. Энэ бие маань

Бурханы сүм учраас зүй зохистой авч явах ёстой гэдгийг би шинэ итгэгч байхаасаа л ухамсарласан юм. Би хийтэй ундаанд агуулагддаг тэр олон муухай бодисыг биедээ шингээхийг хүсээгүй учраас хийтэй ундаанаас татгалзсан юм. Амархан байгаагүй! Бие маань хийжүүлсэн ундаа нэхэж байгаа нь мэдрэгдэж байлаа. Гэхдээ надад татгалзах зорилго байв.

Есүс бидэнд: “Хэн нэг нь Миний араас дагахыг хүсвэл тэр өөрийгөө үгүйсгэн, загалмайгаа авч Намайг дага” (Матай 16:24) хэмээн айлдсан. Согтуурлаас чөлөөлөгдөхийн тулд бид хүсч тачаадаж байгаа зүйлээ эсэргүүцэх хэрэгтэй. Би хийтэй ундааны оронд нимбэгтэй ус ууж сурсан. Миний бие ус биш, хийтэй ундаа нэхэх үед би өдөрт бараг хоёр литр ус хүчээр уудаг байв. Хэдэн сарын дараа бие маань кола нэхэхээ больсон юм. Өнөөдөр надад кола уух ямар ч хүсэл байдаггүй. Би ус л уух дуртай!

Бурханы Үгийн тухайд ч ижил юм. Есүсийн үг бол сүнс, амь, үнэн мөн. Өөрийнхөө хүсэл тачаалыг Бурханы Үгээр дахин ноцоохын тулд бид заримдаа өөрийгөө үгүйсгэх ёстой болно. Учир нь хүний хүсэл тачаал, цангаа жолоогоо алддаг. Жишээлбэл утсынхаа дэлгэцийг зогсоо зайгүй мааждаг хүн үүнээсээ мацаг барих хэрэгтэй. Гурван сар фэйсбүүк энээ тэрээс холдож, Бурхантай, Бурханы Үгтэй хамт бай. Зарим маш чухал, үр дүнтэй мацаг нь хоолны мацаг биш, чухамдаа хэвлэл мэдээний мацаг байдгийг би харсан.

Өөрийгөө Бурханы үгээр дүүргэж, дуулгавартай дагаж, цаг гарган залбирч, Түүний чиглүүлгийг дагахдаа, бид Ариун Сүнсээр дүүрнэ. Биднийг боомилсон Вавилоны согтуурал, донтолтын атга тавигдана. Хүмүүс биднийг юу гэж бодох нь хамаагүй. Одоо бид уух зуршлаасаа чөлөөлөгдөж, жинхэнээсээ хангадаг, хүчирхэгжүүлдэг, гардаггүй дарсаар цангадаг болсон.

Одоо бид саруул ухаанаар сэтгэж, зөв шийдвэр гаргаж, биднийг отож буй дайсныг таньдаг болсон. Эрүүл ухаантай итгэгчийг дайсан дийлэхгүй. Учир нь бид Бурханы гэрээний амлалтыг мэддэг, тунхагладаг, сонор сэрэмжтэй, нухацтай амьдардаг болсон. Бид бүрэн зэвсэглэж, тулаанд бэлэн байх болсон.

СОНОР СЭРЭМЖТЭЙ БАЙ

1Петр 5:5-9 дээр Петр: “Эрүүл ухаантай, сонор сэрэмжтэй бай” гэсэн. Эрүүл байхгүйгээр сонор сэрэмжтэй байж чадахгүй ч, эрүүл атлаа сонор сэрэмжгүй байж болно. Сонор сэрэмж нь эрүүл ухаантай итгэгч хүний ухамсарт үйлдэл юм.

Сонор сэрэмж гэдэг үг нь “болзошгүй аюул, бэрхшээлийг анхааралтай харуулах” гэсэн утгатай юм. Өөр нэгэн эх үүсвэр дээр бас “Дуг хийхгүйгээр, мөнхийн сэрүүн, сэргэгээр харуулах” хэмээн тодорхойлдог. Христийн дагалдагч бүр яг л ийм байх учиртай. Сонор сэрэмж нь бидний бас нэгэн амин чухал зэвсэг мөн.

Өмнө бид Гитлерийн Германы амьдралыг дүрслэн ярьсан. Тэр аймшигт он жилүүдэд ухаант Еврейчүүд нь сонор сэрэмжтэй амьдарч байсан шиг, итгэгч хүн ч өдөр бүр эгшин тутамд сонор сэрэмжтэй явах ёстой. Диавол урхидах хүнээ шиншин эргэлдэж байдаг тул аюул бидний хажууд л байдаг. Гэхдээ Нацистийн үе ба өнөөгийн дэлхийд асар том нэг ялгаа бий: Еврейчүүд Гитлерийн дээр ямар ч эрх мэдэлгүй байсан бол, бид дайсныхаа дээр эрх мэдэлтэй. Дайсан дэлхийг захирдаг боловч, биднийг захирдаггүй. Гэхдээ бид өөрсдөө зөвшөөрбөл, тэр биднийг атгандаа оруулж дөнгөнө. Тиймээс л элч Паул та бид хоёрт “Өөрсдийгөө залбиралд зориул. Үүндээ талархалтайгаар сэргэг байгтун” (Колоссай 4:2) хэмээн анхааруулжээ.

Бидний хувьд сонор сэрэмжтэй байх нэн тэргүүний арга нь залбирал юм. Залбирал бидэнд жирийн юмсын цаадхи сүнслэг ертөнцийг харуулж, аюулыг биелэхээс нь өмнө илрүүлэн сөнөөх чадвар өгдөг өгдөг. Есүсийг цовдлогдохын өмнөх орой яг ийм үйл явдал өрнөсөн юм.

Сүүлийн зоог дээр Есүс айсуу аймшигт сорилтыг мэдэрч байв. Тухайн үед ноцтой юм болоогүй, бүх юм тайван байсан ч, цаана нь юу исэлдэж байгааг Есүс сайн мэдэж байлаа. Зоогийн дараа Есүс дагалдагч нараа дагуулан, залбирах дуртай газар болох Гетсемен цэцэрлэгт ирээд, Петр, Иаков, Иохан

нарт “Сэтгэл минь үхтлээ зовж байна. Энд үлдээд, Надтай хамт сэргэг байцгаа” (Матай 26:38) гэж хэлжээ. Эзэн тэдэнд “Надтай хамт сэргэг бай” хэмээн онцлон анхааруулсан буйг тэмдэглэнэ үү. Сонор сэрэмжтэй байдлыг өөрөөр бас “аюулыг анхааралтай харуулах” гэж тодорхойлж болно. Есүс Өөрөө сонор сэрэмжтэй, сэргэг байсан ч, дагалдагч нар нь энэ талаар ямар ч мэдрэмжгүй, бүрхэг байгааг Есүс мэдэж байжээ.

Есүс: “Сэтгэл минь “үлэмж их шаналж байна”” гэж хэлээд,

сонор сэрэмжтэй явахын хамгийн гол зэвсгийг хэрэглэсэн буюу залбирчээ. Тогтмол залбирдаг хүн сүнслэг ертөнцөд өрнөж буй үйл явдалтай хөл зэрэгцдэг учраас, анаж буй аюулыг таньж, хөрвүүлж, зохих ёсоор хариу үйлдэж чаддаг. Ингэж байж л бид дайсны урд гарна.

■

**Согтуу хүнийг
дайсан ядах
юмгүй дээрэмдэж,
сүйрүүлж чадна.**

■

АЮУЛЫН ДОХИО

Лиза бид хоёр гэрлэлтийнхээ эхний хэдэн жил хэл амаа олох гэж нилээд зүдэрсэн юм. Бидний хэн хэн нь удам дамжиж ирсэн янз бүрийн асуудалтай гэр бүлээс гаралтай, шинэхэн итгэгчид байв. Лизагийн гэр бүлийнхэн хоорондоо эв түнжингүй, ахин дахин салж, ахин дахин гэрлэдэг түүхтэй байлаа. Сатан Лизагийн гэр бүл дээр хэдэн үе дамнан тогтоосон энэ загвараа манай гэр бүлд ч залгамжлуулахыг хүссэн учраас, Лиза бид хоёр руу хэд хэдэн удаа хүчтэй довтолсон юм.

Миний хувьд өдөр бүр 1-2 цаг залбирдаг байсандаа тэр үү сүнслэг зүйлст тун мэдрэг болсон гэж хэлж болно. Тэгээд үе үе аюулхай дээр минь үлэмж гуниг зангираад явчихдаг байсан нь ямар нэг зүйл буруудсны дохио болдог байв. Үүнийг яг онож дүрслэх хэцүү. Гэхдээ голоор минь холхиж, дотрыг минь сүлбэж, мэрсэн нэг тиймэрхүү таагүй мэдрэмж байдаг байлаа. Магадгүй “дотоод шаналал” гэж хэлбэл онох байх.

Анхандаа би учрыг нь олдоггүй байлаа. Бүх юм хэвийн, Лиза бид хоёр ч инээж ханиагаад л хачин сайхан байж байтал гэнэт нөгөө мэдрэмж төрөөд явчихна. Харамсалтай нь эхний хэдэн сар би энэ шаналалыг тоодоггүй байв. Гэтэл энэ мэдрэмж төрснөөс хойш төд удалгүй манай гэр бүлийн харилцаанд там асав уу гэлтэй юм өрнөдөг байсан юм. Бид хоёр аймшигтай хэрэлдэж уралцаж, харилцаа маань эдгэрэх гэж хэдэн өдөр, хэдэн долоо хоног, бүр хэдэн сар ч болдог байв.

Яваандаа би энэ дохиог таньдаг болсон учраас төрөх бүрийд нь бүх юм хэвийн байсан ч хамаагүй аль нэг газар очоод гэрлэлтийнхээ төлөө бүх сэтгэлээрээ залбирдаг болсон юм. Мэдээж диавол ч довтолдоогоороо довтолно. Гэхдээ бид урьдчилан залбирлаараа хариу цохилт хийдэг болсон учраас дайсны довтолгоо тэр даруй маш бага юмуу огт хор хохиролгүй дарагддаг байв.

Өнөөдөр дайсан бидний гэрлэлт рүү бараг дайрахаа больсон. Тэр бидний “сэлэмний цавчилтаас” айдаг болсон гэдэгт би итгэдэг. Намайг бүү ташаа ойлгоорой. Мэдээж Лиза бид хоёр өнөөдөр ч гэрлэлтээ хамгаалан, сонор сэрэмжтэй байж, дайсныг эсэргүүцэн залбирдаг. Гэхдээ гэрлэлтийнхээ эхэн үе шиг зогсоо зайгүй, амьсгаа авах чөлөөгүй тулалдахаа больсон.

Бид энэ тэмцлийн ачаар дайсны аюулын дохиог таньж сурсан билээ. Өдгөө бид хоёр санхүү, эрүүл мэнд, харилцаа, үйлчлэлийг маань онилсон дайсны аюулын дохиог дотроо таньж, амьдралын тал бүр дээр сонор сэрэмжтэй байхыг сурсан. Ийм урьдчилсан сэргийлэх дохионы үеэр би яг юу гэж залбирахаа мэддэггүй учраас Ариун Сүнснээс заавар чиглүүлэг авч сурсан. Ариун Сүнс надад тусладаг бол, танд ч туслана. Ариун Сүнс таны л төлөө байдаг! Түүнд бүрэн бууж өгбөл, Тэр танаар дамжуулан залбирна.

“Үүнчлэн мөн Сүнс бидний сул дорой байдалд тусладаг. Учир нь бид яаж залбирах ёстойгоо мэддэггүй юм. Харин Сүнс Өөрөө үгээр илэрхийлшгүйгээр ёлон бидний төлөө зуучлан гуйдаг. Сүнсний бодол санаа юу болохыг зүрхнүүдийг Нягтлагч нь мэддэг. Учир нь Бурханы хүслийн дагуу ариун хүмүүсийн төлөө Сүнс зуучлан гуйдаг юм.”
(Ром 8:26-27)

Бидэнд төрдөг энэ ёлоон нь Есүс цовдлогдохынхоо урьд орой цэцэрлэгт байхдаа мэдэрсэн тэр шаналал юм. Танд ийм шаналал төрсөн бол, та зохих ёсоор үйлдэх ёстой. Та энэ шаналалыг тоолгүй хаяж болно. Эсвэл сонор сэрэмжтэй хандан, Бурханы Сүнсээр залбирч болно.

Ариун Сүнс биднийг зүгээр ёлоод суугаад байгаасай гэж хүсдэггүй. Тэр бидэнд айсуу нөхцөл байдлыг шийдвэрлэх залбирлыг зааж өгөхийг хүсдэг. Паул: “Тэгвэл яах вэ? Би сүнсээр залбирах болно (миний дотор байгаа Ариун Сүнсээр), бас ухаанаар (оюун ухаанаараа) залбирах болно. Би сүнсээр дуулах болно бас ухаанаар дуулах болно” (1Коринт 14:15) гэсэн байдаг.

АНХААРАЛТАЙ БАЙ, ЗАЛБИР

Гетсемен цэцэрлэгт Есүс сэтгэлийнхээ үлэмж шаналалыг буюу ёлооныг дагалдагч нартаа мэдэгдсэнийхээ дараа тэдэнд: “Надтай хамт сэргэг бай” хэмээн үүрэгджээ (Матай 26:38). Тэгээд гурван дагалдагчаа үлдээгээд, Өөрөө зайдуу очин цаг гаруй залбирсан байдаг.

Гэхдээ Есүс эргэж ирэхдээ, дагалдагч нараа унтаж байхыг харжээ. Тэд унтаж байсан! Тэд яагаад унтав? Хэтэрхий орой болсон учраас уу? Өдөржин ажиллаад ядарсан учраас уу? Сүүлийн зоог дээр хоолоо ихдүүлсэн учраас уу? Тэднийг яагаад унтсныг Лукын сайн мэдээ маш тодорхой хэлдэг: “Тийнхүү залбирсныхаа дараа Тэр босож шавь нар уруугаа очоод, уй гунигаасаа болж унтаж буй тэднийг олж харжээ” (Лук 22:45).

Дагалдагч нар ч бас Есүстэй адил айсуу аюулын дохиог буюу шаналалыг мэдэрсэн байна. Сүүлийн зоог дээр Петр Эзэнийгээ үгүйсгэж байснаас үхсэн минь дээр хэмээн мэдэгдсэн.

■

Бидний хувьд сонор сэрэмжтэй байх нэн тэргүүний арга нь залбирал юм.

■

Петр өөрийгөө эцсээ хүртэл мятрашгүй зогсох тэнхээтэй гэж бодсон. Бусад нь ч эцсээ хүртэл Эзэнтэйгээ хамт гэдгээ дуу дуугаа авалцан хэлдэг. Харин Есүс Аавдаа үнэнч байдлаасаа болж аймшигтай соригдохоо мэдэхээр барахгүй, дагалдагч нар нь ч Өөрт нь үнэнч байдлаасаа болж хатуу соригдоно гэдгийг мэдэж байв.

Есүс нойрсож буй дагалдагч нартаа айлдруун:

Та нар Надтай ганц цаг ч сэргэг байж чадсангүй юу?

Уруу татагдахгүйн тулд сэргэг бай, залбир. Сүнс чухамдаа тэсэн ядаж байна, харин махбод дорой юм. (Матай 26:40-41)

Юу ч болж байсан Бурханд үнэнч үлдэх үү эсвэл зүгээр л хүсэхээс цаашгүй байсаар урвах уу гэдгийг шийдвэрлэх түлхүүр нь энд байна. Бид сонор сэрэмжтэй байж залбирах ёстой. Иуда “Хайртууд минь, харин та нар хамгийн ариун итгэл дээрээ өөрсдийгөө сүндэрлүүлж, Ариун Сүнсээр залбиран...” (Иуда 20) гэдэг. Залбирал махан биеийг хүлж, дотоод хүнийг байгуулдаг.

Хүний бие нь сул дорой бөгөөд ямагт тэмцэл багатай арга замыг хайдаг ч, энэ нь голдуу буруу зам байдаг. Махан бие дэлхийн урсгалыг сөрөхийг хүсдэггүй. Харин залбирал махан биеийн хүслийг дайрч гарах дотоод хүчийг маань байгуулдаг. Залбирал биднийг хэвтэрт орохоос сэргийлдэг. Есүс “сэтгэл алдрахгүйгээр байнга залбирах ёстойг тэдэнд ойлгуулахын тулд Тэр ийм нэг сургаалт зүйрлэл айлдав” (Лук 18:1). Өөрөөр хэлбэл нэн ялангуяа ёлооны дохио ирэх үед залбираагүй хүн сэтгэлээр унаж, “хэвтэрт ордог.”

Тэр шөнө дагалдагч нар сэтгэлээр унасан. Залбирч байх ёстой байсан хүмүүс унтчихсан. Тэд анах аюулыг мэдрээгүй. Тэд сонор сэрэмжгүй, хайхрамжгүй, хойрго байжээ.

Өнөөдөр та бид хоёр Ариун Сүнсний сэрэмжлүүлгийг зурагт үзэх эсвэл ижил дасал болсон гар утсаараа нетээр хэсэх, мессежээр харилцах, фэйсбүүкээр аялах, компьютер тоглоом тоглох, завгүй ажиллах, хөргөгч ухах гэх зэрэг олон юмсаар төөрүүлдэг болсон. Бид Ариун Сүнсний удирдамж, сэрэмжлүүлэгт улам л сэрэмжгүй, хайхрамжгүй болсоор

байна. Тийнхүү бэрхшээл ирэхийн цагт хоёр хөл дээрээ ч зогсож чадахгүй. Бурханы нигүүлслээр зүгээр өгөгдсөн мятрашгүй хүч маань байхгүй байна.

Тиймээс Есүс Өөрийнхөө хамгийн дотны хүмүүст дахин нэг удаа: “Уруу татагдахгүйн тулд сэргэг бай, залбир. Сүнс чухамдаа тэсэн ядаж байна, харин махбод дорой юм” (Матай 26:41) хэмээн зааварлаад, холгүй очоод дахин нэг цаг залбирчихаад, эргээд иртэл нөгөөдүүл нь мөн л унтаж байсан. Энэ удаа Есүс тэднийг сэрээж сэнхрүүлээгүй. Учир нь тэд хэдийнээ сонголтоо хийсэн байв.

Бурхан биднийг нэг, хоёр удаа сэрэмжлүүлж байхад нь бид тоохгүй бол, гэмшихээс минь нааш Бурхан дахиж юм хэлдэггүй. Тэгээд хэцүүдээд ирэхээрээ бид: “Бурхан минь, Та хаана байсан юм бэ?” гэж гомдол урсгадаг. Бурхан бидэнд анхааруулсан - бид өөрсдөө л Түүнийг тоогоогүй.

Есүс дагалдагч нараасаа холдоод, нөгөө газартаа очоод, дахин нэг цаг залбирсан. Түүнийг залбирч дуусахад, дагалдагч нар нь унтаж л байсан. Яг тэр үед урвагч Иуда Есүсийг баривчлуулахаар Санхедриний хамгаалагч нарыг дагуулан цэцэрлэгт ирдэг.

АМЖИЛТ БҮТЭЛГҮЙТЛИЙН ЯЛГАА

Есүс сонор сэрэмжтэй байж, залбирлаар сэргэг, эцсээ хүртэл мятрашгүй цэх байснаараа нигүүлслийн гайхамшигтай даалгавраа амжилттай гүйцэтгэсэн юм. Гэтэл дагалдагч нар өөрсдийгөө бат зогсож чадна хэмээн сэтгэж, бат зогсох хүслээ илэрхийлсэн ч, хүчин мөхөсджээ. Тэгээд Есүсийн хэлснээр бүгд дайралтад өртөөд ялагдсан ч, энэ нь эш үзүүлэгчдийн Бичвэр биелэгдэхийн төлөө байжээ. Дагалдагч нар бүгд Эзэнээ орхиод зугтсан (Матай 26:56). Петр Эзэнээ үгүйсгэхгүй гэж хэлсэн ч, хийхгүй гэж хэлсэнээ хийсэн. Гэхдээ ядаж л Есүсийг алуулах хүртэл нь дагаж явсан нь мундаг юм даа. Иоханаас бусад бүх дагалдагч амь амиа авран, цэцэрлэгээс арилцгаажээ.

Сайхан сэтгэлтэй ч, хэлсэндээ хүрч чаддаггүй итгэгчид олон буй. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл тэд яг Есүсийн дагалдагч

нар шиг сэргэг байж залбирдаггүй учраас тэр! Сүнс нь хүсэвч, бие нь сул дорой байдаг. Итгэгчид бүрэн зэвсэглээгүйгээсээ болоод хүссэн шигээ амьдарч чаддаггүй.

“Өөрсдийгөө зэвсэглэх” талаар элч Петрээс өөр сайн зааж чадах хүн бий гэж үү? Петр тэр чухал шөнө тийм том дуугарчихаад, тун өчүүхэн авир гаргасан. Есүс түүнд хандан: “Симон оо, Симон оо, үзтүгэй, чамайг буудай мэт шигшихийн тулд Сатан зөвшөөрөл гуйсан” гэж анхааруулсаар байтал. Петр ба түүний нөхдөд шөнөжин бат зогсох мятрашгүй тэнхээ дутсан юм. Тиймээс л хожим Петр та бидэнд ганц шөнийг байна уу, бүтэн улирлыг байна уу, бүхэл амьдралаа байна уу хүчтэй дуусгахын тулд өөрийгөө бүрэн зэвсэглээрэй хэмээн захиж үлдээжээ.

Сонор сэрэмжтэй, сэргэг хүн л тулаанд бүрэн зэвсэглэсэн байна. Энэ дэлхийн уруу татлага бидний бүх талаараа Христтэй адил байх шийдвэр, зориулалтыг мөхөөхийг зөвшөөрч болохгүй. Диавол биднийг урхидахаар шиншиж яваа учраас бид мятрашгүйгээр анхааралтай байхгүй бол, тэр биднийг сүйрүүлнэ.

ДИАВОЛЫГ ЭСЭРГҮҮЦ

Эрүүл ухаантай, сонор сэрэмжтэй бай. Та нарын өрсөлдөгч болох диавол нь хэн нэгнийг залгихаар хайж буй архирах арслан мэт гэтэн явдаг. Харин та нар бат итгэлээрээ түүнийг эсэргүүц. Дэлхийд буй ах дүү нар чинь адилхан зовлон эдэлж байгааг та нар мэднэ.

1Петр 5:8-9

Харин одоо бид Петрийн яг яаж тулалдахыг заасан заавар дээр ирлээ. Петр диавол нь хамсаатнуудынхаа хамт идшээ залгихаар тэнэж явдаг арслантай адил гэжээ.

Гэхдээ арслан гэдэг нь диаволын нэр биш шүү. Бичээс түүнийг могой, луу, хулгайч зэрэг олон нэрээр нэрлэсэн ч, хэзээ ч арслан гэж нэрлээгүй. Есүс бол жинхэнэ Арслан, “Иудагийн Арслан” юм (Илчлэл 5:5). Гэхдээ диавол нь арслан мэт идшээ залгихаар архиран тэнэж явдаг ажээ. Тэгээд боломжийг нь олгобол, ямар ч өршөөлгүй тасчиж хаяна. Гэхдээ хөнгөн хуумгай бүү хандаарай. Тэр ялагдсан нь үнэн боловч, ямар ч өршөөл энэрэлгүй харгис атаатан учраас түүнд хөнгөн хийсвэр хандаж болохгүй. Тэр хэзээ ч хэнийг ч өршөөхгүй бөгөөд түүнд хулгайлж, алж, устгах ганц л даалгавар бий.

Та хүн иддэг арслангийн нутаг болох Танзанийн тал нутгаар хэзээ ч гар хоосон, хөл нүцгэн явахгүй. Зэвсэггүй явбал, шууд

арслангийн хоол болно. Эрүүл ухаантай хүн ийм газраар явахдаа хүчтэй винтов барихаас гадна буудаж чаддаг байх ёстой. Тийнхүү зэвсэгтэй, зэвсгээ хэрэглэж мэддэг, эрүүл ухаантай, сонор сэрэмжтэй хүн л энэ тулаанд амь гарч, ялалт байгуулна.

ДИАВОЛЫГ ЭСЭРГҮҮЦ

Есдүгээр ишлэлд Петр биднийг диаволыг эсэргүүцэхийг ухуулан ятгажээ. Эсэргүүц гэдэг нь аутистемай гэдэг Грек үг юм. Тэйер үүнийг “аливаа зүйлийн өөдөөс байршуулах, сөрөх, сөргөлдөх” гэж тайлбарласан бол, Стронгийн тайлбар тольд “сөрөн зогсох үйлдэл” гэж тодорхойлжээ. Мөн өөр нэгэн толь бичигт “үйлдэл, аргументээрээ сэргийлэх явдал” гэж тодорхойлдог. Ямартаа ч энэ үг нь хурц зөрчлийг илэрхийлж байна.

Хэрэв бид зэвсэгт мөргөлдөөнд орох гэж байгаа бол, Есүсийн гаргаж өгсөн баталгааг үзэх хэрэгтэй. Тэрбээр бидэнд: “Харагтун, могой ба хилэнцэт хорхойнуудад халдах, дайсны хамаг хүчээс дээгүүрх эрх мэдлийг Би та нарт өгсөн. Та нарт юу ч хор учруулахгүй” (Лук 10:19) хэмээн амласан. Зориг ормоор байгаа биз? Хүчирхэг нигүүлсэл дотор алхаж яваа хүнийг хэн ч, юу ч - тэр бүү хэл диавол өөрөө ч хорлож чадахгүй гэдгийг

Бурхан батлажээ. Үүнээс илүү баталгаа гэж юу байхав.

**Бурхан газар тэнгэр
дэхь бүх эрх мэдлийг
Есүст өгөх тушаал
буулгасан бол, Есүст
эрх мэдлээ бидэнтэй
хуваалцсан юм.**

Гэхдээ та өөрт өгөгдсөн хүчээ ашиглах ёстой. Ашиглахгүй бол, энэ нь танд ямар ч нэмэр болохгүй бөгөөд та хор хохирол амсана. Иймээс л Петр бидэнд чөтгөрийг эсэргүүц гэж тушаажээ. Петр “Диаволыг зайлуулж өгөөч гэж залбир” гэж хэлээгүй. Бид

диаволыг эр зоригтой, эрс шулуун эсэргүүцэх ёстой.

Шинэ Гэрээ бидэнд диаволыг зайлуулж өгөөч гэж Бурханаас гуй гэж нэг ч хэлээгүй. Үнэндээ Бурхан үүнийг хийж чадахгүй! Та “Энэ Жон хэн болчихоод Бурханыг “чадваргүй” гэж хэлнэ вэ?” хэмээн эгдүүцэж байж магадгүй. Гэхдээ би худлаа хэлээгүй.

Бурхан газар дээрх эрх мэдлийг танд гардуулсан бөгөөд үүнээсээ буцахгүй. Тиймээс л Бурхан могойг Адамтай уулзах үед хөндлөнгөөс оролцоогүй юм. Тиймээс л Есүс диаволыг ялахаар Хүний Хүү болж ирсэн юм. Тиймээс л Христийн бие Сатаныг болон түүний хамсаатнуудыг эрс эсэргүүцэх ёстой юм.

Бурхан газар тэнгэр дэхь бүх эрх мэдлийг Есүст өгөх тушаал буулгасан бол, Есүст эрх мэдлээ бидэнтэй хуваалцсан юм. Есүсийн бие болсон бид тэмцэх ёстой бөгөөд Бичээс үүнийг “сайн тэмцэл” (1Тимот 6:12) гэдэг.

ҮЛГЭР ДУУРИАЛ

Чөтгөрийг яаж эсэргүүцэхийг Есүсээс өөр сайн заах хүн байхгүй. Бид Есүсийн цөлийн сургуулиас ихийг сурна.

Есүс Ариун Сүнсээр дүүрч Иорданаас буцаж цөлд Сүнсээр хөтлөгдөн, дөчин өдрийн турш диаволд соригджээ. Тэр өдрүүдэд юу ч идээгүй ба тэдгээрийг гүйцэхэд Тэрээр ихэд өлсжээ (Лук 4:1-2).

Дайсан Есүсийг дөч хоногийн турш сорьжээ. Өөрөөр хэлбэл Есүс маш их тэмцэлдсэн. Бичээс дээр тэмдэглэгдэж үлдсэн эхний сорилт нь дөч хоногийн сүүл хавиар өрнөсөн байдаг. Тухайлбал дайсан Есүсийг тэнгэрлэг хүчээ ашиглан Бурханы Хүү мөн гэдгээ батлахыг шаардахдаа, Есүсийн өлсөж тамирдсан байдлыг далимдуулан, чулууг талх болгох санаа өгчээ. Гэтэл Есүс: ““Хүн ганц талхаар биш, Бурханы амнаас гарах үг бүрээр амьдардаг” гэж бичигдсэн байдаг” (Матай 4:4) хэмээн дайсны амыг шууд тагласан.

Бид үүнээс дор хаяж гурван зүйл сурах ёстой. Нэгдүгээрт, Есүс сорилтыг дор нь таньж, газар дээр нь шийдвэрлэсэн. Есүс энэ санааг ургуулан бодож, зугаацаагүй. Хэрэв тэгсэн бол Есүс Сатанд дараа дараагийн зам мөрийг нь засч өгөх байв. Бид Есүсийг дууриах ёстой.

Хоёрдугаарт, Есүс шууд диаволд хандаж ярьсан. Есүс диаволыг сорилттой нь хамт зайлуулж өгөөч гэж Аваасаа

гуйгаагүй. Эсвэл дайсанд: “Сатан аа, Аав минь чамд Намайг ялахыг зөвшөөрөхгүй. Тиймээс би энэ сорилтод дийлдэхгүй” гэж хэлээгүй. Есүс Сатаныг газар дээр нь шууд шийдвэрлэсэн. Та бид хоёр ч ялгаагүй ингэх ёстой. Ефес 4:27 дээр: “Диаволд боломж бүү олго” гэдэг.

Гуравдугаарт, Есүс ямагт зөвхөн Бурханы бичигдсэн үгийг л ишлэжээ. Энэ тийм чухал гэж үү? Энэ маш чухал. Яагаад гэвэл Бурханы Үг бол бидний илд юм. Паул “... Бурханы үг болох Сүнсний сэлмийг ав” (Ефес 6:17) гэсэн. Бурханы Үг нь биет зэвсэг биш боловч, сүнсний ер бусын сэлэм юм. Есүс сүнслэг сэлмээрээ дайсныг жинхэнээсээ дүрсэн бөгөөд дайсан ч асар хүнд шархдсан нь эргэлзээгүй. Гэхдээ дайсан бууж өгдөггүй. Тэрбээр цохиулсан ч, довтолсоор л байна.

Дараа нь Сатан өөрт нь мөргөсөн нөхцөлд Адамын алдсан дэлхийн хаанчлалд эзэн суух дөт замыг Есүст санал болгожээ. Гэтэл Есүс үүнд нь: “Миний ард гар Сатан аа! Учир нь “... Бурхан Эзэндээ чи мөргөж, зөвхөн Түүнд үйлчил” хэмээн бичигдсэн байдаг (Лук 4:8) гэсэн хариу өгчээ.

Есүс дайсанд ардаа гарахыг тушаажээ. Энэ нь “гэдрэг ухар!” гэсэнтэй адил юм. Есүс дайсныг Бурханы үгээр дахин цохижээ.

Дайсан энэ удаа гурваас олон цохиулж дийлэхээ больсон учраас арилж одсон байна. Лук “Диавол хамаг сорилтоо бараад, тохиромжтой цаг иртэл Түүнийг орхин оджээ” (Лук 4:3) гэдэг.

ЗОВЛОНД УНАСАН ПАСТОР

Хэдэн жилийн өмнө Кен манай өрөөнд орж ирэв. Кен гэдэг нь бодит хүний зохиомол нэр шүү. Кен бол сайхан гэр бүлтэй, хүчтэй залуу пастор. Тэрбээр өөрийг нь хар тамхинд донтож явахад нь аварч чөлөөлсөн Бурханаа хүндэтгэх бүрийдээ талархаж уйлдаг байв. Би түүний Есүсийг хайрлах хайрыг нь биширдэг. Үүгээр барахгүй Кен халамжтай сайн хань, мундаг аав байв. Тэр өөрөө асар том нүглээ уучлуулсан учраас бусдыг ч өгөөмрөөр хайрладаг байсан юм.

Гэхдээ Кен сүүлийн хэдэн сар дотроо хүчтэй тэмцэлдэж яваагаа хэнд ч хэлэлгүй нуужээ. Тэгээд тэсэхээ болихоороо надад дэлгэхээр шийдсэн ажээ. Кен өрөөнд маань орж ирэхдээ үнэхээр базаахгүй харагдаж байлаа.

“Кен, чи яагаав ээ?” хэмээн намайг асуутал, Кен надад учир явдлаа дэлгэв.

Түүний гэр бүлийн эрчүүд нь зүрхний өвчнөөр хар залуугаараа нас бардаг байжээ. “Жон, би зүрхээр явна гэхээс үнэхээр айж байна. Би эмчид тогтмол үзүүлдэг. Эмч ч намайг эрүүл гэсэн. Гэхдээ л гэнэт үхнэ гэсэн айдсаас ерөөсөө салж чадахгүй юм. Өдөр бүр тэсээд амьдардаг ч, заримдаа үнэхээр дийлэхгүй байна. Яг тийм үед хар хөлс цутгаж, хувцас маань шалба нордог. Энэ явдал шөнө юмуу ганцаараа байхад эсвэл чуулганы хүмүүсийн дунд байхад - ер нь хэзээ л бол хэзээ болно. Би энэ айдсыг дийлж чадахгүй байна. Энэ айдас гэнэт л гарч ирээд, надаар дураараа тоглодог. Энэ айдсыг зайлуулж, энэ мэдрэмжид дийлдэхгүй байхад туслахыг би Бурханаас байдгаараа гуйдаг.”

Ингэж хэлэхэд нь би Кенийн үгийг таслалаа: “Кен, яг иймээс л чи үр дүнд хүрэхгүй байгаа хэрэг. Чи Бурханд хандан залбирсаар байна. Гэтэл бид цөлд байсан Есүс шиг шууд дайсанд хандаж ярих ёстой. Бурханы Үг “Диаволыг эсэргүүц, тэгвэл тэр чамаас зайлна” гэсэн. Чи яг тэгэх ёстой! Есүс Сатаныг ялсан. Есүс дээш өргөгдөж, тэнгэрт Бурхан Аавынхаа баруун гарт залран суухаасаа өмнө дайсны дээрх бүх эрх мэдэл, хүчээ бидэнд өгөөд: “Гэсэн хэдий ч сүнснүүд эрхшээлд чинь орсон...” (Лук 10:20) гэж хэлсэн. Тиймээс муу сүнснүүд чамайг сонсоно. Бид дайсанд Бурханы үгийг, Бурханы гэрээний амлалтыг дагахыг тушаах ёстой.

Кен анхааралтай сонсож байлаа. “Кен минь, дайсан намайг ч сүрдүүлдэг. Тэгээд даварч эхлэгц нь би хүнгүй газар очиж байгаад, хашхичиж гардаг. Бүх сүнс, сэтгэл, биеэрээ улайран хашхирдаг. “Бие” маань дуугаа өргөн: “Муу диавол аа, надтай үзэлцэх гээд байгаа бол, үзэлцье л дээ! Гэхдээ надад илд байгаа, харин чамд байхгүй учраас чи юу ч үгүй нүдүүлнэ гэдгийг чамд хэлчихье. Би Сүнсний илдээрээ чамайг зумлаад,

амь тэмцэн мөлхтөл чинь хэдэн хэсэг болтол жиргээд өгье. Бурханы Үгд ингэж ингэж бичигдсэн байдаг” гэж ирээд л тунхагладаг.”

Кен эдгэрэл, айдас, хангамж, чөлөөлөлтийн талаарх Бурханы Үгийг ишлэхийг минь анхааралтай сонсож байлаа. Би бичигдсэн амлалтыг яаж тулааны зэвсэг болгон ашиглахыг Кенд харуулаад, тэр айдсын сүнсэнд хандан зоригтой тушаахыг зааж өгөв. Ийнхүү хэсэг ярилцсаны эцэст би Кенийн төлөө залбирч өгөөд явуулсан юм.

Зургаан сарын дараа Кен барайчихсан буцаж ирэв. Тэрбээр зовсоор байгаа нь илэрхий байлаа.

“Жон минь, миний байдал шал дордлоо. Одоо би айдастай зургаан сарын өмнөхөөсөө ч хүчтэй тэмцэлдэж байна. Одоо тэр айдас өдөр бүр намайг дайрч, хар хөлс цутгаж, хамаг хувцас норж, өөртөө итгэх итгэл маань дагжиж байна. Үүнээсээ болоод би хүмүүст ч үйлчилж чадахаа болилоо.”

Кен чичирсээр толгой гудайгаад: “Жон би Бурханд залбирлаа, мацаг барьлаа, туслаач гэж хашхирлаа. Гэтэл ямар ч чөлөөлөлт алга. Би яг солиорлоо” гэв.

Би гайхав: “Кен, чи миний хэлснийг хийсэн үү? Чи хүнгүй газар очоод, диаволтой шууд тулалдсан уу? Дайсанд Бурханы үгийг хэлсэн үү?”

“Үгүй.”

Миний уур хүрэв. “Кен, чи дайсантай Сүнсний илд - Бурханы Үгээр шууд тулалдахгүй л бол, юу ч болохгүй, юу ч өөрчлөгдөхгүй.”

Кен толгой гудайсан хэвээрээ ч, миний үгийг сайн сонсож байлаа. Кен миний өмнөх зөвлөгөөг дагаагүй ч, надтай уулзсан хүмүүсийн амьдрал өөрчлөгдөж байхыг харсан учраас, миний үгийг сонсохоос өөр аргагүй гэдгийг мэдэж байв. Кен итгэлийн хүн бөгөөд Бурхан түүний хашхираанд хариулах хүчтэй гэдгийг мэдэж байсан ч, үр дүн гарахгүй байгаад цөхөрчээ.

Би Кенд яаж ойлгуулахаа бодон сууж байтал, гэнэт Ариун Сүнс надад тодорхой зураглал өгөв. “Кен, ерөнхийлөгч хүн бол улсынхаа зэвсэгт хүчний ерөнхий командлагч байдаг. Энгийнээр хэлбэл тэр бүх цэргийн тэргүүн, удирдагч, дарга юм.

Гэтэл манай нэгэн цэрэг Иракт байлдаж байлаа гэж бодъё. Дайснууд түүнийг бүх талаас нь шүршиж байхад, манай цэрэг нэг ч буудахгүй. Тэгээд айж цочирдсон цэрэг маань радио холбоогоо аваад, Цагаан ордон руу залгана. Ерөнхийлөгч харилцуурыг авмагц нөгөө цэрэг “Ноён ерөнхийлөгч өө, би ноцтой дайралтад өртлөө. Дайсан над руу буудаад хариугүй аллаа. Ерөнхийлөгч өө, та хүрч ирээд, намайг алах гээд байгаа энэ дайснуудыг сөнөөгөөд өгөөч. Би айж байна! Цөхөрч байна. Танаас гуйя, надад туслаач!” гэж уйлжээ.

Тэр цэргийн амь аюулд орсон уу гэвэл орсон. Гэхдээ ерөнхийлөгч түүний энэ солиотой хүсэлтэд хариулах уу?”

Тэгээд дараа нь өөрийнхөө асуултад өөрөө хариулав. “Ерөнхийлөгч тэр цэргийг зад загнаад: “Чи юугаа хийгээд над руу залгаад байгаа юм? Чи энэ дэлхийн шилдэг цэргийн сургуулийг дүүргэсэн, чамайг энэ дэлхийн шилдэг зэвсгээр тоногдсон. Чамд дайсныг дарах эрх мэдэл өгөгдсөн. Байлдагч аа, наад утсаа тавиад, дайснаа ал! Дайсантай тулалд!” гэж хэлээд, утсаа таслаад тэр цэргээс зохих үйлдлийг хүлээнэ.”

Кенийн нүдэнд гал асахыг би харлаа.

“Кен минь, чамд илд өгөгдсөн бол, дайсан чинь гар хоосон байгаа. Үнэндээ Колоссай 2:15 дээр “Захирагчид болоод эрх баригчдыг зэвсэггүй болгоод, Тэр тэднийг загалмай дээр ялж, тэднийг нийтэд үзүүлэн болгов” гэсэн. Чамд хууль ёсны зэвсэг байгаа бол, дайсанд хулхи зэвсэг байгаа. Үүнээс гадна чи Есүсийн нэрээр олгогдсон бүх эрх мэдэл, хүчийг бүслэсэн. Дайсан Есүсийн нэрэнд бөхийж, Түүний Эзэний эрхийг хэл бүр хүлээн зөвшөөрнө (Филиппой 2:10-11) гэдэг.

Чамд зөвт байдлын цээживч, итгэлийн бамбай, авралын дуулга гэх мэт Бурханы хуяг дуулга өгөгдсөн. Итгэлийн бамбай чинь дайсны зарим нэг галт сумаас биш, харин бүх галт сумаас хамгаална. Бурхан Өөрийнхөө үгд “Чиний эсрэг бүтээгдсэн нэг ч зэвсэг амжилт олохгүй. Шүүх дээр чиний эсрэг боссон хэл бүрийг чи яллана. ЭЗЭНий зарц нарын өв нь энэ бөгөөд Тэдэнд Надаас зөвтгөл ирнэ” гэж ЭЗЭН зарлиг болгов” (Исаиа 54:17) гэдэг. Кен минь, энэ тулаанд дайтах ёстой хүн нь чи өөрөө гэдгийг Бурхан хэлж байна. Бурхан байлдахгүй. Чи

өөрөө дайсанд тушаах ёстой. Чи Бурханыг дуудаад байвал, Бурхан яг л ерөнхийлөгч шиг “Дайснаа буудаач! Илдээр дүрээч!” гэж л чамд тушаана.

Кен намайг цоо ширтэж байлаа. Тэрбээр Ариун Сүнсний өгсөн жишээний цэц ухааныг олж ухаарчээ. Тэрбээр манай өрөөнөөс итгэл, найдвар өвөрлөөд гарав. Гурван долоо хоногийн дараа Кен манай өрөөнд хоёр чихэндээ тултал мишээсээр орж ирлээ. Түүний хөл нь хөнгөрч, нүд нь гялалзаж, дуу нь цангинаж: “Жон, юу болсон гээч?” гэлээ.

Би ч Кенийн гайхамшигт түүхийг сонсохоор бөхийлөө.

“Намайг Бүтэн сайны өглөө цуглаан руугаа явж байтал, нөгөөдөх чинь эхлэсэн. Миний дотор хар айдас хуралдаж, юу юугүй л зүрх минь зогсож, би үхэдхийн унах юм шиг санагдаж, хамаг бие минь усан хулгана болтлоо норсон. Гэхдээ энэ удаа би урьдынх шигээ Бурхан руу аврал эрэн хашхирахын оронд “Гүйцээ!” гэж шийдээд, диавол руу маш ууртайгаар хашхирсан. Миний дотор буцалж, хажуудаа сууж байсан гэргийдээ ч анхааруулалгүйгээр шууд л машиныхаа урд тавцанг зангидсан гараараа шаагаад авсан. Гэргий маань машины таазанд тултал огло үсэрсэн байх. Харин би: “Муу диавол аа, гүйцээ! Би чамайг ч, чиний өгдөг айдсыг ч цаашид хүлцэхгүй!” гэж орилоод, Бурхан амлалт Үгсийг хашхиран тунхаглаж эхэлсэн.

Жон, би машиныхаа урд тавцанд цохиод: “Муу диавол аа, гүйцээ!” гэж хэлж байхдаа нэг үзэгдэл харсан юм. Намайг Сагантай халз тулах үед тэнгэрийн сэнтийдээ залран суугаа Есүс Эзэн минь огло харайж босоод: “Зүйтэй!” гэж хашхирахыг би харсан!”

Кен инээд алдаад: “Жон, Есүс яг л: “Би чамаас үүнийг л хүсч байсан. Чи ойлгож, үйлдсэн чинь юутай сайн!” гэж хэлэх шиг л санагдсан” гэж хэлсэн юм.

Түүнээс хойш Кен дахиж тэр айдаст дарлуулаагүй юм. Энэ явдлаас хойш хориод жил өнгөрсөн ч, Бурханы энэ эрхэм хүн эсэн мэнд, эрүүл саруул амьдарсаар Америкийн өмнөд нутгаар том чуулганаа байгуулсаар л явж байна. Түүний бие ч, сүнс ч хүчирхэг байгаа.

МЯТРАШГҮЙГЭЭР ЭСЭРГҮҮЦ

Одоо Петрийн үгийг илүү нарийн үзье:

Эрүүл ухаантай, сонор сэрэмжтэй бай. Та нарын өрсөлдөгч болох диавол нь хэн нэгнийг залгихаар хайж буй архирах арслан мэт гэтэн явдаг. Харин та нар бат итгэлээрээ түүнийг эсэргүүц. Дэлхийд буй ах дүү нар чинь адилхан зовлон эдэлж байгааг та нар мэднэ (1Петр 5:8-9).

Тэвчээртэй гэдэг үг нь мятрашгүй гэдэг үгтэй ижил утгатай болохыг бид нэгдүгээр бүлэгт үзсэн. Бид дайсныг ганц эсэргүүцэхэд л дайсан нэг мөр далд орно гэж Библи хэлээгүй. Харин ч эсрэгээрээ - дайсан удаа дараа довтолно. Яг энэ тал дээр олон итгэгчид урам хугарч, ялагддагийг би туршлагаараа мэднэ. Тэд: “Би ч чадахгүй юм шиг байна өө. ...Над шиг хүн ч чаддаггүй болтой” гэдэг. Гэтэл эдгээр нь аймшигтай худал юм. Ийм бодлыг хэзээ ч өөгшүүлж болохгүй.

Би үүнийг нэгэн жишээгээр тайлбарлая. Лиза маань нялхдаа нэгэн төрлийн гэдэсний өвчтэй байсан юм. Энэ өвчинд голдуу нэгээс доош насны нярай хүүхдүүд өртдөг. Үүгээр өвчилсөн хүүхдүүд асар их зовиурлаж, нэг уйлахаараа олон цагаар уйлдаг бөгөөд өвчнийг нь намжаах ямар ч арга байдаггүй. Нялх хүүхдүүд хэдэн сарын турш өдөр бүр хэдэн цагаар ч уйлж болно. Эмч нар энэ өвчний шалтгааныг олж тогтоогоогүй байгаа ч, голдуу хоол боловсруулах системийн эрхтнүүд дутуу хөгжснөөс болдог гэж итгэдэг.

Манай ууган хүү Аддисон ч бас ийм өвчтэй байсан юм. Учир нь олдохгүй хэдэн цагаар ээрдэг байсныг нь санаж байна. Анхандаа тэр хэзээ ч уйлахаа болихгүй юм шиг л санагддаг байлаа. Бид түүний нурууг нь илж, бүүвэйлж, дуулавч уйлаад, уйлаад, уйлаад л байна. Хүүгээ ингэж зовохыг харах зүрх зүсэгдмээр байдаг байв. Яваандаа би хүүгээ тэврээд, тэр өвчинд миний хүүгээс зайлахыг тушаадаг болов. Хүүгийнхээ хоол боловсруулах системд шууд тушаана. Тэгээд Сүнсээр чанга, хүчтэй залбирах үед Аддисон маань тайвшраад унтчихдаг болов.

Нэгэн шөнө би орондоо орчихсон, Лиза маань унтахаар зэхэж байтал, хүүгийн өрөөнөөс час хийсэн дуу хадлаа. Лиза ч: “Жон, дахиад л өвдөөд эхлэлээ!” гэж дуу алдав.

Би өндийгөөд цагаа хартал шөнийн 00 цаг 11 минут болж байлаа. Би ч хүү дээрээ гүйж очоод, энгэртээ тэврээд, тэр өвчинг миний хүүгийн биеэс зайлахыг Есүсийн нэрээр тушааж, хүүгээ унтгал нь Сүнсээр залбирлаа. Энэ хооронд 15 минут л болсон байх.

Маргааш нь эхнэр бид хоёр дахиад л унтахаар хэвтэж байтал, хүү чарлав. Үнэнийг хэлэхэд надад шууд л: “Хэрэг алга! Хүүгийнхээ төлөө хичнээн залбирсан ч, юу ч дээрдэхгүй байна. Чамд ямар ч итгэл, үр нөлөө алга” гэж бодогдов. Гэхдээ би тэр бодлыг таягдаж хаяад, залбиралд хариулна гэсэн Бурханы амлалт үгээр орлуулаад Лизад: “Би очъё!” гэж хэлэв.

Босоод цагаа хартал, цаг дахиад л 00 цаг 11 минутыг зааж байв. Санамсаргүй тохиолдол! гэж бодогдлоо. Би хүүгийнхээ өрөө рүү гүйж очоод, хүүгээ элгэндээ наагаад, тэр өвчинд зайлж явахыг Есүсийн нэрээр тушаагаад, хүүгээ унтгал Сүнсээр залбирав. Мөн л арван таван минут болсон байх.

Маргааш нь Лиза унтлагын өрөөндөө энгэсгээ арилгаж, харин би орондоо хэвтэж байтал, хүү минь аймшигтай чарлав. Энэ удаа надад нилээд урт бодол төрөв: “Жон, чи хүүгийнхээ төлөө бараг хоёр долоо хоног залбирлаа. Өчигдөр, уржигдар залбирсан. Хүү чинь ер дээрдэхгүй байгааг зүгээр л хүлээн зөвшөөр! Залбирал чинь ажиллахгүй байна!” Гэсэн ч би энэ бодлыг дахиад л таягдаж хаяад, дахиад л Бурханы амлалт үгээр орлуулав.

Цагаа харсан ч, дахиад нягтлаж харах хэрэгтэй болов. Цаг маань гурав дахь шөнөө 00 цаг 11 минутыг зааж байв. Миний уур савсав! Би хүүгийнхээ өрөөнд харайж ороод, өвчиндөө шаналж буй хүүгийнхээ бяцхан цээжин дээр гараа тавихдаа, надтай хамт Ариун Сүнс миний хүүг ширтэж байгааг мэдрэв.

Тэгээд савссан уур, Эзэний эрх мэдэл хоёроор: “Гэдэсний өвчин, доройтлын сүнс чи, миний хүүг хангалттай зовоолоо! Лизагийн гэр бүлээр дамжиж ирсэн энэ өвчний хараал чамайг би тасар татаж байна. Миний хүүгээс бузар гараа тат! Хэзээ ч эргэж ирэхгүйгээр нэг мөр зайл!” гэж хашхирлаа. Уг нь тийм чанга дуунд нялх хүүхэд айж цочмоор. Гэвч харин ч эсрэгээрээ

миний хүү тэр даруй уйлахаа больж, над руу зөөлөн анивчсаар унтаад өгөв. Тэгж миний хүү тэр гэдэсний өвчнөөр сүүлийн удаа уйлж шаналсан юм. Тэр шөнөөс хойш миний хүү эв эрүүл, сав саруул болж билээ. Дайсан илдээр дүрүүлсээр байгаад тэсэхээ байжээ. Тэр Аддисоныг орхиж яваад, дахиж ирээгүй юм.

Гурван жилийн дараа удаах хүү Аустин маань ээж, аавдаа ирэв. Гэтэл Аустин хэдэн сар хүрээд мөнөөх гэдэсний өвнөөр өвдөж эхлэлээ. Энэ удаа би учрыг нь мэдэж байсан учраас тулаанд бэлэн байлаа. Тэгээд нэг билүү хоёр удаа тушааснаар нялх хүүгийн маань чарлаан зогсож, тэр гэдэсний өвчин хүүгээс минь зайлав. Гурав дахь хүү Алек маань энэ өвчнөөр нэг ч өвдөөгүй юм. Хараалын тойрог тасарчээ. Дайсан: “Би дахиад нэг оролдоод үзбэл, дахиад л Бурханы үгийн илдээр дүрүүлнэ” гэж л бодсон байх.

Найз минь, диаволыг мятрашгүйгээр эсэргүүц. Түүнийг Эзэн Есүс Христийн бүслэж өгсөн эрх мэдлээр эрс эсэргүүц. Бидний эрх чөлөөтэй байх шийдвэр маань биднийг боочлох гэсэн дайсны шийдвэрээс том байх ёстой.

Мексикийн уугуул хүмүүсийн дунд ажиллаж байсан нэгэн илгээлтийн эзний гэрчлэлийг би хэзээ ч мартдаггүй юм. Тэрбээр уулын жижиг тосгонд ажиллаж, түүний хүчин зүтгэлээр тэр тосгоны бараг хүн бүр Христэд итгэжээ. Нэгэн шөнө илгээлтийн эзнийг тосгоныхоны бөөн үймээн шаагиан сэрээжээ. Гэтэл илгээлтийн чуулганд оролцсон нэгэн хосын нялх хүүхэд нь нас барчихсан байв. Тиймээс гэр бүлийнхэн нь илгээлтийн эзнийг ирээд залбирч өгөхийг хүсчээ. Илгээлтийн эзэн ч тэр даруй очоод, үхлийн сүнсэнд хүүгийн биеэс зайлж явахыг тушаатал, хэдхэн минутын дотор нялх хүүхэд ханиаж, найтаасаар амьсгалж эхлэжээ. Хүү үхлээс амилжээ! Бүгд баярлалдаж, илгээлтийн эзэн маань ч гэртээ хариад унтжээ.

Гэтэл удалгүй нөгөө хүмүүс дахиад л илгээлтийн эзний хаалгыг нь нүдэж сэрээв. Хүүхэд дахиад л үхчихжээ. Илгээлтийн эзэн дахиад л хүү дээр очоод, үхлийн сүнсийг зэмлэтэл хүү ч амилав. Илгээлтийн эзэн диаволыг хэд хэдэн удаа зэмлэхэд, диавол хүүг орхиж явсан аж.

Тэр хүү амьдрахаар барахгүй, тосгоныхоо хамгийн эрүүл саруул, цовоо сэргэлэн хүүхдийн нэг болж өсчээ.

САЙНААС ЗУУР

Итгэгчид гарз хохирол үзэж байхыг би хардаг. Цагаан цайлган сэтгэлтэй итгэгчид Бурханаас хүлээж авсан ерөөл, эдгэрэл, гайхамшгаа хэдхэн өдөр, сар, жилийн дотор алдчихдаг нь тун тоогүй. Тиймээс л Библи бидэнд: “Сайнаас зуур” гэдэг юм (1Тесалоник 5:21). Миний итгэлийнхээ амьдралын гараан дээр сурсан нэгэн сургамжийг итгэдэг хүн бүр эргэцүүлж, бодож, цээжилж, сахих ёстой.

Би өсвөр насанд байхдаа нурууны өвчтэй байсан юм. Тэгээд итгээд жил гаруй болж байхдаа, найзтайгаа хамт нэгэн цуглаанд сууж байтал, тэр цуглааныг хөтлөж байсан хатагтай: “Энд нурууныхаа доод хэсгээр байнга өвддөг нэг хүн байна” гэж хэллээ.

Би ч өөрийгөө хэлж байгааг мэдсэн ч, католик гэр бүлд төрж өссөн хүн чинь олны өмнө гарахаас санаа зовсон тул боссонгүй. Тэгээд мөнөөх хатагтай ярианыхаа сэдвийг өөрчлөхөөр нь санаа амарлаа.

Гэтэл арван минутын дараа мөнөөх хатагтай дахиад л: “Өршөөгөөрэй, гэхдээ Эзэн надаас шаардаад байгаа учраас яах ч арга алга. Эзэн энд байгаа нурууны өвчтэй хүнийг эдгээхийг хүсч байна” гэж хэллээ.

Би ч: “Тэр ярихгүй. Би энэ олон хүний өмнө яасан ч гарахгүй” хэмээн гүрийсэн ч, Ариун Сүнс намайг гарах гарцгүй болгосон учраас гарахаас өөр арга олдоогүй юм. Нөгөө хатагтай нөхрийнхөө хамт миний нурууны төлөө залбиртал би газар дээрээ эдгэж, түүнээс хойш нуруу маань нэг ч өвдсөнгүй. Тэр орой намайг эдгээсэн Бурхандаа би насан турш талархдаг.

Үүнээс хойш би нуруунаасаа болж шаналсангүй. Шүдээ угаах, сахлаа хусах гэж бөгтийсөн нуруугаа буцааж тэнийлгэх гэж зүдрэхгүй байгаадаа Бурханд баярлаад барахгүй байлаа.

Гэтэл сарын дараа унтахаар хэвтэж байтал, миний өрөөнд нэг юм орж ирэхийг мэдрэв. Юу болохыг нь харж чадахгүй байсан ч, маш тодорхой мэдэрч байлаа. Өрөөний маань цонхоор сарны гэрэл тусдаг ч, өрөө маань яагаад ч юм тас харанхуй болов. Тэр юмтай хамт айдас ч цуг орж ирлээ. Гэтэл гэнэт намайг олон жил

зовоосон мөнөөх нурууны өвчин дахин хөдлөхийг би мэдрэв. Тэгээд: “Эдгэрэл чинь байхгүй болчихлоо! Одоо дахиад л өвдөнө. Насан турш өвдөнө” гэсэн бодол харвав.

Би хэдий шинэ итгэгч байсан ч, Бурханы Үгийг унших дуртай байсан болохоор энэ бол дайралт байна гэдгийг шууд мэдлээ. Дайсан миний эдгэрлийг булааж авахын тулд намайг мэхлэх санаатай байжээ. Харин би шууд орноосоо босон харайгаад: “Сатан аа, би хоёр долоо хоногийн өмнө цуглаан дээр эдгэрсэн. Би бүр мөсөн эдгэрсэн! Библи намайг Есүсийн ормоор эдгэрсэн гэдэг. Чи намайг дахиж өвтгөхгүй. Би хэзээ ч өвдөхгүй. Тиймээс Есүсийн нэрээр миний бие, өрөө, гэрээс зайл!” гэж хашхирав.

Өрөө маань гэрэлтээд явчихлаа. Дайралттай хамт ирсэн нөгөө юм, айдас хоёр зайлж, өвчин ч арилав. Түүнээс хойш би нурууныхаа төлөө дахиж хэзээ ч тулалдаагүй билээ.

Есүс: “Би удахгүй очно. Хэнд ч титмээ алдахгүйн тулд өөрт буйгаа бат сахь” (Илчлэл 3:11) гэж айлдсан. Бурханаас хүлээж авсан зүйлээ тас зуураарай.

Миний номлосон цуглаан дээр гайхамшигтайгаар эдгэрсэн нэгэн хүний харамсалтай түүхийг би хуваалцмаар байна. Тэнд маш олон хүн байсан учраас би хүмүүсийн төлөө бөөн бөөнөөр нь залбирахаас өөр аргагүй байсан юм. Миний өмнө нааш цааш давалгаалах тэр олон хүний дундаас би бөхийгөөд уйлж байгаа нэгэн хүнийг олж харлаа. Түүн дээр очоод хэрэг байдлыг нь лавлалал, тэрбээр нуруундаа хэд хэдэн удаа мэс засал хийлгэж, насаараа тахир татуу болсон хүн байв. Би түүний төлөө залбирч, тэр ч төгс эдгэрсэн юм. Тэр хүн баярласандаа энгэнэтэл уйлсаар байлаа. Эдгэрснийхээ төлөө тэгтэл уйлж буй насанд хүрсэн эр хүнийг би хэзээ ч үзээгүй.

Хэдэн долоо хоногийн дараа бид хоёр ресторанд тааралдсан юм. Тэрбээр нүүр дүүрэн мишээж, эрч хүч цацраан, яаж тахир татуу байдлаасаа ангижирч, шинэ эрх чөлөөгөө эдлэж байгаагаа надтай хуваалцлаа. Би ч түүний төлөө баяртай байв.

Жилийн дараа бид хоёр дахин тааралдсан юм. Тэрбээр намайг хараад урьдын адил инээмсэглэсэнгүй. Үнэндээ тэр над дээр хүрч ирсэн ч үгүй, харин би түүнийг таниад, өөрөө

явж очоод биеийг нь асуусан юм. Гэтэл түүний нуруу дахиад л өвддөг болсон ажээ. Тэгээд тэр орой цуглаан дээр үнэхээр эдгэрсэн эсэхээ мэдэхгүй байгаа ч, Бурхан тэр өвчнөөр дамжуулж түүнд сургамж өгч байгаа учраас өвдөх нь тийм ч муу зүйл биш байх гэж ярив. Би түүнд Есүс “Сайнаасаа зуур” гэж хэлснийг сануулах гэсэн ч, тэрбээр миний үгийг тоосон ч үгүй. Тэр хүн өөр зүйлд итгэсэн байв.

Мэдээж тэрбээр сайн аав, нөхөр, хүн мөн. Гэхдээ Есүс түүнийг чөлөөлөх гэж асар их үнэ төлчихөөд байхад, тэрбээр хүнд ачаагаа үүрсээр яваа нь дэндүү харамсалтай.

ЕРӨӨГДӨХГҮЙ БАЙХ ЯМАР Ч ҮНДЭСЛЭЛГҮЙ

Одоо миний хэлэх үгийг сайн сонсоорой. Энэ маш чухал шүү. Хэрэв та итгэж бас диаволыг тууштайгаар эсэргүүцбэл, ямагт ялна. “Диаволыг эсэргүүц. Тэгвэл тэр та нараас зайлна” (Иаков 4:7) гэсэн амлалтыг зууран, тунхаглаж, үүн дээрээ үйлд.

Зайлах гэдгийг Грекээрээ фэюго гэдэг. Энэ нь “арилах, зугтах, нисч одох, аюулгүй газар руу нисэх” гэсэн утгатай. Түүнчлэн “зүрх үхэн зугтах” гэсэн утгатай ч гэж сонсож байлаа. Янзтай байгаа биз! Бурхан “Диавол та нараас зайлж ч мэднэ, зайлахгүй ч байж мэднэ” гэж хэлээгүй. Үгүй, хэрэв та нар диаволыг эсэргүүцбэл, диавол зайлна. Дайсан библийн ул суурьтай, хурц эсэргүүцлийг тэвчдэггүй!

Дайсан танаас айдаг. Дайсан танаас Есүсийг олж хардаг. Та бол Христийн бие, Бурханы тослогдсон нэгэн. Та Сатаныг бут цохиж, хамаг зэвсгийг нь булаасан Нэгэний дүр төрхөөр бүтээгдсэн. Та бол дайсны хувьд маш том аюул занал юм. Бид Сатаны хүчийг дэвэргэн төсөөлдөг боловч, үнэндээ тэр таны доор, Христийн биеийн хөлийн улан дор байгаа юм. Та Христийн биеийн хөлийн чигчий хуруу байсан ч, дайсны

бүх хүч Христийн доторх таны байр сууриас хол доор байна. Исаиа 14:12-16 дээр Бичээс:

Аяа, Үүрийн хүү, гялбаат цолмон.
Чи яаж тэнгэрээс унав аа?
Үндэстнүүдийг дордуулагч
Чи хөсөр хаягдлаа!
Учир нь чи зүрхэндээ
«Би тэнгэрт гарна.
Би Бурханы оддын дээр сэнтийгээ босгоно.
Би умардын хамгийн чанадад
Чуулганы уулан дээр заларна.
Би үүлсийн орой дээр гарна.
Би өөрийгөө Хамгийн Дээд Нэгэн лугаа адил болгоно» гэсэн.
Гэвч чи Үхэгсдийн орон уруу,
Хамгийн гүн нүхэнд хаягдана.
Чамайг харсан хүн бүр гайхан мэлэрч
«Дэлхийг донсолгон, Хаанчлалуудыг чичрүүлсэн хүн энэ
мөн үү?»

Түүхийг нь үзбэл, Исаиа энд Вавилоны хааны тухай бичжээ. Гэхдээ эш үзүүлэл бүхий Бичээс нь хоёр өөр хэрэгжүүлэлт, биелэлтэй байдаг - нэг нь биет, нөгөө нь сүнслэг. Исаиа хувь хүн, гэр бүл, үндэстнийг устгасан хүчтэй нэгний тухай бичсэн боловч, сүнслэг талбар дээр энэ нь Сатан гэдэг нь эргэлзээгүй юм.

Тэр дайсны төгсгөл нь "...хүхэр бүхий галт нуурт хаягдлаа. Тэнд мөн араатан болоод хуурамч эш үзүүлэгч байх агаад тэд үеийн үед өдөр шөнөгүй тарчилна" (Илчлэл 20:10) гэжээ.

Итгэлээрээ харанхуйн хүчийг сөрөн зогсож байгаа хүн Бурханаар ерөөгдөхгүй байх ямар ч үндэслэлгүй. Энэ нь санхүү, цэц ухаан, эрүүл мэнд, ажил хэрэг болон юу юунаас илүүтэй бусдад туслах талбар байж болно. Сүнсний илдээр байлдаж байгаа хүн яг Есүс шиг ямагт ялна.

АНХААРУУЛАХ ҮГ

Энэ бүлгийнхээ төгсгөлд Христийн биеийн дотор байдаг хоёр туйлшралын талаар сэрэмжлүүлмээр байна. Эхний туйлшрал нь юм л бол диаволын нэрийг барих. Энэ төрлийн итгэгчид хамаг анхаарлаа Эзэн дээрээ биш, чөтгөр дээр тавьчихдаг. Энэ нь маш эрүүл бус зүйл юм.

Удаах туйлшрал нь Кен пастор шиг Бурханд хайртай атлаа дайсныг огт мэдэхгүй байх явдал юм. Энэ бүлэгт багтдаг итгэгчид голдуу *“Бид ёрын мууг тоохгүй байвал, тэр аяндаа яваад өгнө”* гэж үздэг. Энэ бол ямар ч нэмэргүй, худлаа бодол. Бурхан бидэнд ялан ялтлаа дайсныг эрс эсэргүүцсээр байхыг тушаасан. Есүсийн нэрээр нэг мөр шийдээгүй юмс хэзээ ч өөрчлөгддөггүй гэдгийг бид санах ёстой. Нүүр тулж, шийдвэрлэхээс бүү ай! Энэ бол хаанчлалын иргэн таны Бурханыг дуулгавартай дагах үүрэг бөгөөд үүнийг та Бурханы нигүүлслийн хүчээр хийж чадна.

Библи бидэнд сүнсээр яаж эрүүл саруул амьдрахыг заасан. *“... өмнөө тавигдсан уралдаанд тэвчээртэйгээр гүйцгээе. Итгэлийг Эхлүүлэгч бөгөөд Төгсгөгч болох Есүс өөд харцгаая”* (Еврей 12:1-2). Есүсээс хараагаа салгалгүй, ширтэж амьдардаг хүн л бүрэн дүүрэн амьдарна. Замд чинь диавол ба түүний хамсаатнууд таарбал, шууд дайр! Тэгвэл тэд зайлна! Тэгээд хараагаа дахин Есүс дээр шууд тавь. Тэр бидэнд итгэл өгсөн, Тэр Өөрөө итгэлийг маань төгс болгоно.

ХАМГИЙН ТОМ ЭСЭРГҮҮЦЭЛ

Харин та нар бат итгэлээрээ түүнийг эсэргүүц. Дэлхийд буй ах дүү нар чинь адилхан зовлон эдэлж байгааг та нар мэднэ.

1Петр 5:9

Танай улсыг нэгэн ёрын муу хаан эзлээд, олон жил дарлажээ гэж бодъё. Танай улс эрх чөлөө, тусгаар тогтнолоо олохын тулд дайсны цэргүүдтэй байлдах ёстойгоос гадна тэдний барьж байгуулсан олон тооны цайз хэрмийг устгах ёстой. Эдгээр нь нууц бөмбөг, урхи, хавх, газар доорх нуувч, баазууд юм.

Гэхдээ нураахад хамгийн төвөгтэй цайз хэрэм нь танай улсын иргэдийн тархинд суулгагдсан муу ёрын, бузартсан сэтгэлгээ юм. Үүнийг шууд тулаанаар ялж чадахгүй. Яагаад гэвэл энэ бол сэтгэлгээний тулаан. Гэхдээ хэрэв та энэ талбар дээр ялалт байгуулж чадахгүй бол, бусад бүх ялалт чинь ч талаар болж мэднэ.

Тэгэхээр энэ бүлэг бидэнд ийм төрлийн тулаанд яаж зэвсэглэхийг зааж өгнө. Мэдээж мөн л ялгаагүй зөвхөн мятрашгүй, тууштай тэмцлээр л бид энэ талбарт ялалт байгуулна. Эс бөгөөс тулааны бусад бүх төрөл ч үр дүнгүй болно. Иаков 4:7 дээр Элч Иаков “Бурханд захирагд. Дияволыг эсэргүүцбэл, тэр та нараас зайлна” гэж бичихдээ, чухам энэ

талаар л өгүүлжээ. Дьяволтай тулалдах хамгийн сайн арга нь Бурханд захирагдах гэдгийг Иаков хэлжээ. Энэ нь Бурханд цаг ямагт найдаж, үгэнд нь орно гэсэн үг. Ингэж л бид хүрээлэн буй завхарч доройтсон дэлхийдээ Бурханы арга зам, сэтгэлгээ, зарчмыг тогтооно. Төгс дуулгавартай байдал л бидний эрх мэдэл, захиргааны шинэ төвшинд гарахын төлөө дайсны бат цайз, цохилтыг эсэргүүцэх суурь зарчим маань болдог.

2Коринт 10:3-6 дээр Паул:

“Учир нь бид махбодод алхдаг ч, махбодын дагуу дайтдаггүй. Бидний байлдааны зэвсэг нь махбодынх бус, харин ялагдашгүйг ч ялж чадах Бурханы хүчит зэвсгүүд юм. Бид цэцэрхлийг нурааж, Бурханы мэдлэгийн эсрэг босогч алив бардамналыг устгаж, бодол бүрийг Христийн дуулгаварт олзолдог. Та нарын дуулгавар биелэгдэх үед бид бүх дуулгаваргүйг шийтгэхэд бэлэн байна.”

Дьяволын цайз хэрэм гэдэг нь Бурханы хүсэл, мэдлэгтэй зөрчилдөх сэтгэлгээний үйл явц, суурь сэтгэлгээ, учир зүйчлэл, оюуны үзэл бодол, төсөөлөл юм. Үүнд атаархал, шунал, амиа бодох явдал, дарангуйлал, тачаал, өдөөн хатгалга, өдөөлт, жөтөөрхөл тэргүүтэй олон юмс багтана. Тархи, зүрхний иймэрхүү юмс нь Бурханы үнэнтэй дайсагнаж, сүнслэг мөргөлдөөн өдөөдөг. Гэхдээ эдгээр дуулгаваргүй чанарыг бидний дуулгавартай зан ялан дийлдгийг Паул хэлсэн билээ.

ХРИСТИЙН ДОТОР ӨСӨХ

Дайсагналыг давж гарах үед бидний эрх мэдэл, хүч өсдгийг өмнө сурсан. Өөрөөр хэлбэл бид өссөөр захирах төвшинд хүрнэ.

Иймээс Христ нэгэнтээ махбодоороо зовсон тул та нар ч гэсэн ижил санаагаар өөрсдийгөө зэвсэглэ. Учир нь махбодоороо зовсон нь нүглийг дуусгасан. Энэ нь биеэр амьдрах үлдсэн хугацаандаа цаашид хүний хүсэл тачаалын төлөө бус, харин Бурханы хүслийн төлөө амьдрахын тулд

юм. (1Петр 4:1-2)

Махбодоороо зовсон нь нүглийг дуусгажээ. Петр юун тухай ярина вэ? Тэрбээр Христийн дотор “эрийн цээнд” хүрч, сүнсээр төлөвших тухай ярьжээ. Хаанчлалын “насанд хүрсэн сүнслэг хүн” өөрийнхөө хүслээр амьдрахаа больж, Бурханы хүсэлд бүрэн захирагддаг юм.

Тэрбээр дэлхийн системийн өмнө жижгэрэхээ больж, цайз хэрмүүдийг бут цохидог нэгэн болно. 2Коринт 10:6 дээр Паул энэ хүчийг “Та нарын дуулгавар биелэгдэх үед бид бүх дуулгаваргүйг шийтгэхэд бэлэн байна” гэсэн.

Бид биеэр хэдэн настай байхаасаа үл хамааран, Бурханы гэр бүлд нярай болж мэндэлдэг. Дараа нь Бурхан биднийг өсч төлөвшөөсэй гэж хүсдэг. Тэрбээр бидэнд “үгийн цэвэр сүүг нялх хүүхдүүд адил хүсэн тэмүүл. Ингэснээр та нар үүгээр авралд хүртлээ өсөх юм” (1Петр 2:2) гэж тушаажээ. Хүний нас биеийн өсөлт нярай, нялх, хүүхэд, өсвөр нас, насанд хүрэгч зэрэг үе шатаар дамждаг шиг сүнслэг төлөвшил ч бас үе шаттай. Паул “Ах дүү нар аа, би та нартай сүнслэг хүмүүстэй мэтээр ярьж эс чадлаа. Харин махбодын хүнтэй, Христ доторх балчир хүүхэдтэй ярих мэт ярьсан” (1Коринт 3:1) гэжээ. Коринтын тэдгээр итгэгчид биеэр насанд хүрсэн ч, сүнсээр нялх байжээ. Энэ нь итгэгчдийн хувьд удаан байх зохистой үе шат биш юм.

Паул өөр нэгэн захидалдаа сүнслэг өсөлтийн дараах үе шат буюу хүүхэд насны тухайд: “Бид цаашид хүүхэд байхаа больж, давалгаанд энд тэнд шидэгдэн, аливаа номлолын салхи, хүмүүсийн ов мэх болон зальхай хуйвалдааны башир аргад туугдалгүй...” (Ефес 4:14) гэжээ. Мөн тэрбээр: “Ах дүү нар аа, ухаанаараа хүүхдүүд байж болохгүй. Бузар мууд балчир болж, харин ухаанаараа төлөвшсөн бай” (1Коринт 14:20) гэсэн байдаг. Бид хорон мууд нялх хүүхэд мэт заль мэхгүй цэвэр байх ёстой ч, харин ойлголт, тууштай зан чанарын хувьд насанд хүрсэн том хүн болох ёстой.

Хүүхэд сайн муу хүмүүжснийхээ дагуу л үйлддэг. Хүүхэд мөн нөлөөнд автамхай, эмзэг байдаг. Харин том хүн буруу хүчинд амархан авталгүй, юуны төлөө зогсохоо мэддэг. Бид

Христийн дотор өсч, үнэн дотор бат зогсож, дуулгаваргүй байдлыг таягдан хаяж шийтгэх ёстой. Христийн дотор төлөвшихөд ойлголт хэрэгтэй байдгийг Паул хэлжээ. Гэхдээ Петр ч төлөвшлийн талаар их ярьсан байдаг.

Сүнсээр яаж өсөх вэ? Эхлээд биеийн болоод сэтгэлгээний өсөлтийг авч үзбэл тустай байх. Биеийн өсөлтийн үйл явц нь юунд баригддаг вэ? Цаг хугацаанд. Зургаан сартай атлаа 180 см өндөртэй хүүхдийг та харж байсан уу? Үгүй, хүн хорь гаруй насандаа л бүрэн өсч боловсордог. Биеийн өсөлт нь цаг хугацааны үйл явц юм.

Биеийн өсөлттэй харьцуулахад сэтгэлгээний өсөлт нь цаг хугацаанд баригдахгүй. Би 14 настайдаа ахлах сургуулиа дүүргэсэн, гоц ухаантай хүүхэдтэй уулзаж явсан. Мөн ахлах сургуулиа ч дүүргээгүй тавин настай хүнтэй таарч явсан. Тэгэхээр сэтгэлгээний юмуу оюуны өсөлт нь цаг хугацаанд баригддаггүй, оюуны мэдлэг хөгжлийн үйл явц ажээ.

Хүүхэд нэгдүгээр ангиа дүүргээд, хоёрдугаарт ангидаа дэвшиж ордог бөгөөд ийм маягаар төгсөх хүртлээ явна. Гэхдээ хүсбэл хурдан юмуу удаан явж болно.

Тэгвэл сүнслэг өсөлт төлөвшил нь цаг хугацаанд баригддаг үйл явц уу? Юу л даа - бид дахин төрөөд жилийн дотор насанд хүрчихсэн хүмүүсийг хардаг. Нөгөөтэйгүүр аврагдаад хорин жил болчихсон атлаа “живхнээсээ” ч салалгүй, Христчин удирдагч, итгэл нэгт нөхдөө зовоож яваа хүмүүсийг ч бас хардаг.

Тэгвэл сүнслэг өсөлт төлөвшил нь оюуны мэдлэг хөгжилд баригддаг үйл явц үү? Фарисайчууд Библийн эхний таван номыг цээжээрээ мэддэг байсан ч, нүдэн дээр нь өвчтэйг эдгээж, чөтгөрийг хөөж байгаа Бурханы Хүүг таниагүй. Тэд хоёр нүүрээр амьдарч, Мессаиагийн айлчлал, үйлчлэлд сүнсээр таг сохор байжээ.

Тэгвэл сүнслэг өсөлт нь юуны үйл явц вэ, юугаар хязгаарлагддаг вэ? Хариулт нь зовлон. Петрийн үгийг дахин харна уу: “Иймээс Христ нэгэнтээ махбодоороо зовсон тул та нар ч гэсэн ижил санаагаар өөрсдийгөө зэвсэглэ. Учир нь махбодоороо зовсон нь нүглийг дуусгасан” (1Петр 4:1). Нүгэл хийхээ больсон нь бүрэн сүнслэг төлөвшилд хүрчээ.

Тэгэхээр “Зовсоор байгаад энэ хорвоогоос хальсан хүмүүсийг би мэднэ” гэж хэлэх хүн гарах байх. Ийм зүйл үнэхээр болдог. Тиймээс зовлонд чухам сүнслэг төлөвшилд хүргэдэг өөр нэг чухал бүтэц байх ёстой аж. Еврей 5:8 дээр бичээч: “Тэрээр Хүү нь байсан хэр нь зовсон зүйлсээсээ дуулгаварт суралцсан” гэжээ.

Энэ ишлэлд Есүс газар дээр угаасаа л дуулгавартай төрсөн гэж хэлээгүй байна. Есүс үүнд суралцсан бөгөөд үнэхээр төгс сурчээ. Тэр ширхэг ч нүгэл, алдаа хийгээгүй. Тэгэхээр *Есүс зовлонгоор дамжуулж дуулгавартай байхад*

■

**Сүнслэг өсөлт нь
бидний амьдрал дээр
нар мандаж байхад
ирдэггүй ажээ.**

■

суралцжээ. Энэ бичээсийг Петрийн үгтэй нэгтгэж үзбэл, сүнслэг өсөлт нь бидний амьдрал дээр нар мандаж байхад, хүн бүр биднийг магтаж байхад юмуу зам маань дардан цагаан байхад ирдэггүй ажээ. Бид сорилт дунд Бурханд дуулгавартай байснаараа л сүнсээр өсч төлөвшдөг. Хүмүүс биднийг гүтгэж, цуурхал тарааж, муухай хандаж, гомдоох үед эсвэл ажилгүй болох үед, хуульчаасаа юмуу эмчээсээ муу мэдээ сонсох үедээ хаанаас ямар мөнгө ирэхийг мэдэхгүй үедээ Бурханы цэц ухаанд захирагдснаараа бид хүчтэй болдог.

Нөхцөл байдал бидний эсрэг байсан ч, бид бэрхшээл дунд Бурханд итгэхийг сонгодог. Бид юуны түрүүнд Бурханы үгд захирагдснаараа л бидэн рүү довтлох диаволыг эсэргүүцдэг. Энэ үед л жинхэнэ сүнслэг өсөлт ирнэ. Үүнийг Иаковын хүү Иосефийн амьдрал маш уран яруугаар харуулдаг.

ИОСЕФИЙН МӨРӨӨДӨЛ

Бурхан Абрахамтай гэрээ байгуулсан. Энэ амлалт нь Абрахамын хүү Исаакт хийгээд Исаакийн хүү Иаковт болон ач хүүд нь залгамжлагджээ. Иаков арван хоёр хүүтэй байсны арван нэг дэхь нь Иосеф байв. Иосефийн ах нар яагаад дүүгээ үзэж чаддаггүй байсныг Бичээс тайлдаг. Залуу Иосеф аманцар

(Эхлэл 37:2), онгиороо (5-р ишлэл) байжээ. Иаков ч Иосефийг алган дээрээ бөмбөрүүлэн хайрлаж, өнгө өнгөөр алагласан дээл авч өгчээ. Энэ явдал ах нарынх нь дургүйг бүр ч сэдрэв.

Гэтэл Бурхан Иосефт хоёр зүүд өгсөн явдал нь ахан дүүсийн харилцааг цаашид тэсэх аргагүй болгожээ. Эхний зүүдэнд нь Иосеф талбай дээр багцалсан сүрэл харжээ. Тэгтэл Иосефийн сүрэл цэх зогсож, харин ах нарынх нь сүрлүүд түүний сүрэлд мөргөж байх юм гэнэ. Хоёр дахь зүүдэнд нь Иосеф нар, сар, арван нэгэн одод түүнд мөргөхийг үзжээ. Иосеф хар буруу саналгүй эдгээр зүүдээ гэр бүлдээ яриад, хэзээ нэгэн цагт би та нарыг захирна хэмээн хэлж орхитол, ах нар нь Иосефийн баяр хөөрийг хуваалцах нь бүү хэл, улам л жигших болов.

Хожим арван ах нь аавынхаа сүргийг бэлчээрлүүлэх шинэ бэлчээрийн эрэлд гаран гэрээсээ хол яваад нилээд удсан тул ах нар нь яажшуу байгааг мэдэхээр аав нь Иосефийг явуулдаг. Ах нар нь Иосефийг ирж явахыг хараад: “Манай зүүдлэгч, удирдагч, мөрөөдчихсөн захирагч жаал ирж явна. Бүгдээрээ түүнийг алчихъя! Тэгээд тэр зүүд нь биелэхийг харцгаая л даа” гэжээ (миний хөрвүүлэг).

Тэд дүүгээ алахаар нүхэнд хаясан ч, хэдэн цагийн дараа тэдэнтэй Египетийг зорьж яваа Ишмаелийн удмын жинчид таарсанд, дөрөв дэхь хүү Иудад нэг мэргэн санаа төрж, тэрбээр: “Бүгдээрээ дүүгээ нүхэнд орхибол, ашиггүй болно. Үүний оронд боол болгоод зарчихбал, мөнгөтэй болно. Тэр биднийг дахиж зовоохгүй учраас, үхсэнээс ялгаагүй болж, харин бид зоостой болно. Тэгээд ч бид хүн алж, гараа бузарласан хэрэгт унахгүй” гэжээ (миний хөрвүүлэг).

Энэ санаа нөгөө хэдэд нь ч таалагдаж, тэд дүүгээ хорин мөнгөн зоосоор худалдана. Ах нар нь атаархал, үзэн ядалт, хорон санаагаа хэрэгжүүлэн төрсөн дүүгээ өв залгамжлал, гэр бүлээс нь салгажээ. Төрсөн ах нар нь ийм юм хийсэн гэдгийг бүү мартаарай!

Иосефийн туулсан шударга бус тавиланг бид ойлгож чадахгүй. Боол болгож зарна гэдэг алснаас ялгаа юун? Дээр үед хүүтэй байна гэдэг амин чухал байсан. Учир нь хөвгүүд аавынхаа нэрийг төдийгүй, өв хөрөнгийг нь залгамжилдаг

байв. Гэтэл Иосефийн ах нар дүүгээсээ энэ үнэ хүндэтгэлийг нь дээрэмджээ. Тэд дүүгээ нэр нүүргүй хэн ч биш болгожээ. Тэр цагт хүн өөр улс руу боол болж зарагдсан бол, үхэн үхтэлээ боол чигээрээ үлдэхээс гадна эхнэр хүүхэд нь ч боол болдог байв. Иосеф танил дотно, эрхэм нандин бүхнээсээ хагацжээ. Боол болж төрөөд, насаараа боол байх нь хэцүү боловч, баян хүний хонгор хүү байгаад, мах цусны тасархай болсон ах нарынхаа урвалтаар боол болох нь зүйрлэхийн аргагүй аймшигтай! Яг л амьсгалтай үхдэл шиг л байсан байх. Боол байснаас үхсэн минь дээр гэсэн бодол Иосефт төрсөн л байх. Түүний ах нар дэндүү харгис, хорон үйл хийжээ.

Жинчид Египетэд ирээд, Иосефийг Потифар гэдэг Фараогийн түшмэлд зарж орхино. Ийнхүү Иосеф Потифарийн өмч болов. Та бид хоёр энэ түүхийг хэдэн мянган жилийн дараа Библиэс уншиж байгаа болохоор төгсгөлийг нь мэднэ. Гэтэл Иосефт унших Эхлэл ном байгаагүй. Иосеф хүний нутагт боол болж зарагдснаа л мэдэхээс, өөрийг нь ямар амьдрал тосч байгааг мэдээгүй. Тэр аавыгаа, нутгаа, нөхдөө хэзээ ч харахгүй гэж бодсон. Мөнөөх зүүдний талаар бол бүр ярих ч хэрэггүй. Биелэх ямар ч боломжгүй! Тэрбээр насаараа хүний өмч болсон, Египетээс хэзээ ч явах эрхгүй болсон хүн.

Гэхдээ бид харснаараа биш, итгэлээр алхдаг.

Иосеф Потифарт арван жил зүтгэжээ. Нутаг ус, аргэрээс нь ямар ч сураг байхгүй. Жил өнгөрөх тусам, аргэрийнхэн нь Иосефийн үхэлтэй эвлэрсэн байх. Хайрт аав нь ч уй гашуугаа хэдийн тайлаад, хүүгээ мартсан шиг л санагдаа байх. Аав нь хүүгээ аврах нь бүү хэл, амьд мэнд байгааг нь ч мэдэхгүй шүү дээ.

Цаг хугацаа өнгөрөх тусам Потифар Иосефийг хайрлах болжээ. Тэрбээр Иосефт гэр орон, аж ахуй, эд хөрөнгөө бүгдийг нь даатгав. Гэвч энэ хооронд Иосефийг нэгэн аюул отож байжээ. Потифарын эхнэр Иосефт унаж тусан, үүнийгээ ч нууж хаасангүй. Үнэндээ тэр хүүхэн өдөр бүр Иосефийг хоргоох болжээ. Тэрбээр санасандаа хүрдэг баян эмэгтэй байсан тул Иосефийг өөрийн болгохоор санаа шулуудсан байв. Тэгээд ч мэдээж маш хүчтэй өдөөгч сүнстэй эмэгтэй байсан биз.

Гэвч Иосеф тэр эмэгтэйн өдөөлт бүрийг эрс эсэргүүцсээр байв: “Энэ гэрт надаас илүү их хүн байхгүй. Та түүний эхнэр учир тэр танаас бусад юуг ч надад хориглоогүй. Би яаж ийм ёрын муу хэрэг хийж, Бурхандаа нүгэл үйлдэх билээ?” (Эхлэл 39:9). Хэдийгээр Иосеф бага залуудаа урвалт, шархаас болж асар их хор хохирол амссан ч, Бурханд захирагддаг, шулуун шударга эр хүн байжээ.

Нэгэн өдөр Иосеф, Потифарын эхнэртэй хоёулхнаа гэртээ үлдэж таартал, эмэгтэй Иосефийг уруу татан, хувцсыг нь угзран: “Нөхөр маань алга. Хоёулаа унтъя. Хэн ч мэдэхгүй. Өдөржин хоёул жаргая” гэх ухааны юм хэлжээ.

Иосеф дахиад л бэлгийн ёс бус явдлыг эсэргүүцэн, гэрээс гарч зугтав. Тэрбээр огцом зугтсан учраас хувцсаа эмэгтэйн саварт үлдээгээд оджээ. Ичсэн хүн хүн ална гэгчээр мөнөөх эмэгтэйн ичгүүр уур хилэн болон дүрэлзээд: “Та минь ээ, хүчин, хүчин!” гэж чарлав.

Потифар ч тэр дороо Иосефийг Фараогийн гянданд хийжээ. Ийнхүү Иосефийн амьдрал дахиад л ганцхан өдрийн дотор сүйрэв.

ГЯНДАН ДОТОРХ ТЭМЦЭЛ

Фараогийн гяндангийн дэргэд манай Америкийн шорон ч диваажин л даа. Би хэд хэдэн шоронд үйлчилж явсан бөгөөд хэдийгээр таагүй боловч, тэдгээр нь Ойрхи Дорнын гянданийн хажууд тансаг зочид буудал л гэсэн үг. Би Ойрхи Дорно дахь эртний шоронд бас очиж үзсэн. Нарны гэрэл ч байхгүй, илч ч байхгүй, аймаар жихүүн нуранги. Тэнд Америкийн шорон шиг биеийн тамирын, зурагтын, хоолны, ариун цэврийн өрөө, угаалтуур, унтах матраас байхгүй. Зүгээр л чулуугаар зүссэн бохирын савтай, хөндий хоосон өрөө. Ихэнх өрөө нь 120 - 150 см өндөртэй, хүн байхын аргагүй аймаар газар.

Иосефийн үед хоригдлуудыг амьтай голтой байлгах хэмжээний л хоол, унд өгдөг байв. Учир нь үхүүлчихбэл хоригдлуудыг жаргаасан хэрэг болдог байв (1Хаад 22:27). Дуулал 105:18-аас үзбэл, Иосефийн хөлийг дөнгөлж, төмрөөр

гинжилсэн байжээ. Потифар түүнийг гянданг хөнөөхийг хүсчээ. Иосеф ядаж Египет хүн байсан бол, суллагдах жаахан ч атугай горьдлого байна. Гэтэл хааны тэргүүн түшмэлийн гэргийг хүчиндэхийг завдсан харь боолд амьд гарах ямар ч найдлага байхгүй. Иосеф үхэхээс наагуур л болжээ.

Тэр харанхуй хар гянданд Иосефт юу гэж бодогдсон бол? Цагаас өөр юм байхгүй түүн рүү дайсан ёстой хайр найргүй довтолж тамласан байх даа. Иосефт: “Би Потифар гуайнд арван жил хоёргүй цэвэр сэтгэлээр үйлчилсэн. Түүнд би гэргийгээс нь ч үнэнч явсан. Би өдөр тутмын ёс бус явдлаас бултан, Бурхандаа ч, эзэндээ ч итгэмжтэй байсан. Үүний минь төлөө надад яаж ингэж хандаж чадав аа? Миний шагнал энэ гяндан гэж үү? Би зүгээр л бусад эрчүүд шиг, боломжийг ашиглан тэр эмэгтэйтэй жаргахгүй яав? Эзнийгээ эзгүй хойгуур нь эзэгтэйтэйгээ унтчихсан бол, өдийд хэн ч мэдэхгүй, би ч энд байхгүй байлаа” гэсэн бодол орж ирсэн л байх.

Гэхдээ Иосеф энэ худал бодолд итгэсэн бол, гутрал хорсолдоо улам живээд: *“Тэгэхээр, мөнөөх хайрын итгэмжтэй Бурхан нь Өөрийг нь дагасан хүнд ингэж ханддаг юм биз дээ? Тэр Бурхан итгэмжгүйгээр барахгүй, зарц нараа дарладаг ажээ. Адгийн нэгэн нь цэцэглэж, дуулгавартай нь ингэж тамлагдаж байдаг. Бурханыг дагах ямар хэрэгтэй юм? Тэр надад удирдагчийн зүүд өгсөн, би түүнийг нь зүгээр л ах нартайгаа хуваалцсан - тэгээд юунд хүрэв? Нүхэнд хаягдаж, боол л болох шив. Үүний дараа ч би Бурханд дуулгавартай байж, ёс бус явдлаас зугтсан. Тэгээд юу олж долоов? Гянданд л хатах шив! Дуулгавартай байх тусам, улам л дорддог болтой. Бурханд үйлчилнэ гэдэг харгис тоглоом ажээ”* гэж бодох байсан биз.

Иосеф шоронд байхдаа ямар ч эрх чөлөөгүй байсан ч, амьдралдаа тохиолдсон бүхэнд хэрхэн хандах эрх чөлөө нь түүнд байсан. Хорсож хатуурхах уу? Тарчлан эрээ цээрээ алдах уу? Бурханы үгийг жигшин, өс хонзондоо автаж, үзэн ядалтыг өөгшүүлэх үү?

Эсвэл сэтгэл мэдрэмжээр нь халих сөрөг бодол, мэдрэмжийн урсгалыг тууштай сөрсөөр байх уу?

Иосефийг хаанчлалд бэлтгэж байсан Бурханы арга зам болох эдгээр аймшигтай цуврал үйл явдал өрнөх хооронд Иосефт ямар хэцүү байсныг төсөөлөхөд ч бэрх. Иосеф зовлон дунд дуулгавартай байхыг сурчээ. Түүний дуулгавартай байдлын булчин хязгаартаа тултал сунажээ. Яг л сандал дээр хэвтээд 143 кг төмөр өргөж байхад хамаг юм нь “Зогс, зогс!” гэж хашхирч байгаа юм шиг л байсан байх. Иосеф “Түлх, түлх, түлх!” гэдэг тэнгэрийн уухайг сонссон уу эсвэл хүний логикийг сонсон, өшөө хорслын дөт замыг сонгож, жиндээ дарагдсан уу?

БУРХАН МАРТЧИХСАН УУ?

Иосефийн хувь заяаг ах нар нь л шийдчихсэн гэлтэй. Тэд байгаагүй бол Иосеф юу гэж тийм аймаар байдалд орох вэ дээ? Гянданд хоригдсон эхнийхээ хоёр жил Иосеф ах нар нь тийм юм хийгээгүй байсан бол, амьдрал нь тэс өөрөөр эргэх байсан талаар мянгантаа бодсон байх.

Бид ч бас нэг бодолтойгоо хичнээн дахин тэмцэлддэг билээ? Танд ч иймэрхүү бодол төрдөг л байгаа:

- Даргаас болж л би дэвших биш, халагдлаа.
- Салсан нөхрөөсөө болж л би санхүүгийн асуудалд орлоо.
- Ажил дээр намайг гүтгэсэн тэр этгээдээс болж л би ажилгүй болж, түрээсийн байрныхаа менежерт адлагдаж явна.
- Аав ээж хоёроос болж л би ингэж амьдарч явна.

Тэр нэг гайтай хөөтэй хүн байгаагүй бол, таны амьдрал хичнээн сайхан байх байсныг гайхан, амьдралдаа тохиолдсон бүхэнд хавийн амьтныг яллах амархан. Гэхдээ харамсалтай нь ийм бодол бидний эсэргүүцэх чадварыг улам сулруулж, эцэстээ хор хөнөөлд хүргэдэг. Бидний жинхэнэ дайсан бол бидэнд тулгарсан нөхцөл байдал биш, харин хүнд хэцүү үед шургалдаг буруу бодол итгэл

юм. Бид Бурханы дархан төлөвлөгөөнд баг итгэж, Бурханы Үгтэй сөргөлдөх бүх логикийг эрс эсэргүүцэх ёстой.

Эцэстээ “биднийг Бурханы хүслээс гаргаж чадах хүн байтугай чөтгөр ч байхгүй! Бидний хувь тавиланг Бурхан ганцаараа атгаж байдаг” гэдгийг хэзээ ч бүү мартаарай. Бурханы Иосефт өгсөн зүүдийг ах нар нь үгүй хийх гэж оролдсон. Үгүй хийчихлээ ч гэж бодсон. Тэр бүү хэл бие биедээ “За, одоо цөмөөрөө нааш ир, түүнийг цохиж алаад, энэ нүхнүүдийн нэгэнд хаяж “Зэрлэг араатан түүнийг идсэн” гэж хэлцгээе. Тэгээд түүний зүүд юу болохыг харцгаая л даа” (Эхлэл 37:20) гэж хэлцгээсэн байдаг. Тэд дүүгээ үнэхээр хөнөөхөөр шийдсэн байжээ. Энэ нь санамсаргүй явдал биш, санаатай хэрэг байсан! Тэд Иосефийн зүүдийг талаар болгохыг хүсчээ.

Ах нар нь дүүгээ боол болгон зарахыг Бурхан мэдээгүй гэж бодож байна уу? Бурхан Аав, Хүү, Ариун Сүнс гурав бие биеэ бүлтэгнэн хараад, сандарч мэгдсэн дуугаар: “Одоо яадаг билээ? Иосефийг ах нар нь зарчихлаа ш дээ! Тэд Бидний Иосефт зориулсан төлөвлөгөөг баллачихлаа ш дээ. Одоохон нэг арга бодохгүй бол! Бидэнд “Б” төлөвлөгөө байгаа билүү?” гэсэн гэж бодож байна уу?

Гэтэл бид Бурхан яг л ингэдэг юм шиг царайлдаг. Аав нь Есүст: “Есүс ээ, урсгал чиглэлийнхэн нь Боб пасторыг өвчтэй хүний төлөө залбирсных нь төлөө халчихлаа! Ингэнэ чинээ санасангүй. Түүгээр удирдуулчих өөр чуулган чамд байна уу?” гэх юмуу эсвэл: “Есүс ээ, Сарагийн салсан нөхөр нь хүүхдийнхээ тэтгэмжийг ерөөсөө төлөөгүй юм байна шүү дээ. Үүнээс болж Сара хэдэн хүүхэдтэйгээ ямар ч орлогогүй болчихож. Ядаж байхад энэ дэлхийн эдийн засгийн байж байгаа царайг. Одоо боловсрол ч үгүй, ур чадвар ч үгүй тэр хүүхэн яана даа? Бид бас яана даа?” гэдэг гэж бодож байна уу?

Шал утгагүй боловч, бид Бурханыг яг л ингэдэг юм шиг царайлдаг.

ИОСЕФИЙН ХАМГИЙН ХҮНД ШАЛГАЛТ

Тэгвэл хариугаа авбал ямарав? Иосеф бидэн шиг байсан бол, яах байсан гээч? Өшөө авах төлөвлөгөө боловсруулна. Тэрбээр Бурханы Үгтэй зөрчилддөг санаагаар өөрийгөө тайтгаруулах байсан (Ром 12:19-ийг үзнэ үү). Энэ шоронгоос гардаг л юм бол, тэднээс хариугаа авна даа. Хамгийн шилдэг хуульчийг хөлслөөд, ах нартайгаа шүүхдээд, турсгыг нь хуулна! Эсвэл ингэж цаг, мөнгө алдаж байснаас, шууд л алчихъя. Яг л намайг хорлосон шиг нь золгүй явдал болгож харагдуулъя.

Гэхдээ Иосеф ийм санаа өвөрлөсөн бол, Бурхан түүнийг гянданд нь хатаах байсан байх. Яагаад гэвэл Иосеф ийм төлөвлөгөө өвөрлөсөөр шоронгоос гарсан бол, Израилийн арван хоёр овгийн арван тэргүүнийг нь цааш нь харуулах байж! Тэдний дунд Давидыг төрүүлсэн, тэгээд цаашаа бүр Есүсийг төрүүлсэн овгийн тэргүүн Иуда байх байлаа. Тийм ээ, Иосефийг хорлосон хүмүүс нь Израилийн өвөг дээдэс байсан юм.

Иосеф өөрсдийгөө Бурханы арга замаас дээгүүр өргөмжилсөн энэ бүх учир шалтгаан, баримт, бодол, төсөөлөлтэй мятрашгүйгээр тэмцэх ёстой байжээ. Тэрбээр Бурханы амлалтад үг дуугүй итгэх ёстой байсан ч, итгэл, найдварынх нь хамгийн хүнд шалгалт бас л болоогүй байв.

Тэгтэл гянданд өөр хоёр хоригдол орж иржээ. Тэдний нэг нь Фараогийн сөнч, нөгөө нь Фараогийн талхчин байв. Нэгэн удаа тэд дор дороо учир битүүлэг зүүд зүүдлэснээ Иосефт хэлжээ. Тэгвэл Иосефийн шалгалт юу байв? Иосеф энэ хоёр хүнд өөрийнх нь амьдралд арваад жил үзэгдээгүй тэр Бурханыг итгэмжтэй хэмээн тунхаглаж чадах уу? Бод доо: Иосеф арваад жилийн тэртээ ах нарыгаа захирч, ах нар нь түүнд үйлчилж байна гэж зүүдлэсэн. Гэхдээ түүний амьдралд тэр амлалтын хэлтэрхий нь ч биелээгүй. Иосеф бидэн шиг байсан бол, тэр хоёр хүнд: “Та хоёр зүүдлээ л биз. Би ч бас цагийн сайханд зүүдлэж л явлаа. Намайг тайван байлга” гэж хэлэх байсан.

Иосеф ингэж хандсан бол “Бурхан амлалтандаа хүрдэггүй, хар худалч!” хэмээн хорссоор гяндандаа хатах байсан биз. Тэр хувь тавилангаа сүйтгэх байсан. Учир нь хоёр жилийн дараа Иосеф фараогийн зүүдийг тайлахаар шоронгоос гардаг юм. Тэр ганцхан үйл явдал Иосефийг гяндангийн нүхнээс

Египетийн ерөнхий сайд болтол өргөж, цаашилбал есөн жилийн дараа мөнөөх зүүд нь биелэхийг харуулдаг юм.

Тийнхүү Иосеф хорин нэгэн жилийн дараа Бурханы амлалт биелэхийг үзжээ. Гэхдээ Бурхан амлалтаа итгэмжтэйгээр биелүүлдэг учраас, зүүд нь биелэхдээ л биелсэн юм. Тэгвэл бид яадаг уу? Залбирлын хариулт ирэхгүй гурван жил болоход л бууж өгдөг. Эсвэл бүр гурван сар юмуу гурван долоо хоног өнгөрөхөд л хамаг горьдлого тасардаг. Бурхан яг бидний хүссэн цагт, бидний хүссэн арга замаар хариулахгүй байвал, бид Бурханд гомддог. Мөрөөдлийг Бурхан биш, бид өөрсдөө үгүй хийдэг юм! Бидэнд Бурханы нигүүлслийн засаглал дорх тэвчээр, мятрашгүй итгэл, дуулгавартай зан, хүч хэрэгтэй. Эдгээр нь Бурханы бидэнд зүгээр өгсөн бэлэг учраас бид зүгээр л Бурханы Үгд найдаж, Түүний дотор итгэл дээрээ хөдлөшгүй зогсох ёстой. Шургачиж унаагүй хүн ургацаа хураахдаа л хураана.

Таны амьдралд зориулсан Бурханы төлөвлөгөөг ямар ч эрэгтэй эмэгтэй хүн, чөтгөр таслан зогсоож чадахгүй. Та энэ үнэн дотор ургаа хад мэт дүнхийж, Бурханы хаанчлалын юунд ч дийлдэшгүй нэгэн хүч болно. Нэг зүйлийг санаж яваарай: Таны хувь тавиланг үгүй хийж чадах цорын ганц хүн нь та өөрөө юм!

Израилийн ард түмнийг аваад үз. Бурхан тэднийг Египетийн дарлалаас чөлөөлж, Амлагдсан газарт аваачихаар Мосег илгээсэн. Бурхан тэднийг Египетээс гаргаад, жилийн дотор Канаанд оруулахыг хүссэн. Гэтэл тэр хүмүүс итгэлгүй байдал, буруу бодол, гомдол, Мосег буруутгаснаасаа болоод хувь тавиландаа хүрээгүй юм. Тийнхүү Калев, Иошуа хоёроос бусад тэр үеийн бүх насанд хүрэгчид цөлд үхжээ. Тэд Бурханыг итгэмжгүй байлаа гэж зогсоо зайгүй гомдоллож байсан ч, үнэндээ өөрсдөө л Бурханд үнэнч байгаагүй юм. Тэд итгэл, дуулгавартай байдлаа эцсээ хүртэл сахиа ч үгүй, хувь тавилангаа биелүүлээ ч үгүй билээ.

Таны амьдралд зориулсан Бурханы төлөвлөгөөг ямар ч эрэгтэй эмэгтэй хүн, чөтгөр таслан зогсоож чадахгүй.

ЗАХИРАХ ЗАН ЧАНАР

Иосеф анхандаа аманцар, онгиороо, сагсуу байсан ч, энэ хэвээрээ төгсөөгүй юм. Тэрбээр амьдралын хэцүү бэрхийг дуулгавартайгаар туулж гараад, эцэстээ Египетийн дээрээсээ хоёр дахь эрх мэдэлтэн, жинхэнэ хүчирхэг удирдагч болжээ. Иосеф ах нартаа хорсож, зүхэж, гомдож, үл уучлан үзэн ядсаар байсан бол, ерөнхий сайд болмогцоо ах нараа гянданд хатааж, тамлаж, алж ч чадах байсан. Гэхдээ Иосеф ийм юм хийгээгүй. Иосеф ах нартаа хүссэн буудайг нь ямар ч үнэ төлбөргүйгээр өгч, гэр бүлийг нь Египетийн хамгийн сайхан нутагт суурьшуулсан. Иосеф ах нартаа Египетийн эдийн сайныг эдлүүлж, идээний дээжийг зооглуулсан. Тэр өөдгүй хүмүүст шүү! Иосефийн зүрхэнд Христтэй адилхан төлөвшсөн зан чанар суулгагдаж, бэхэжсэн байжээ. Учир нь Иосеф өөрийг нь хараасан ах нараа ерөөж, өөрийг нь нүд үзүүрлэсэн тэдэнд сайныг үйлджээ (Матай 5:44-45).

Одоо Петрийн үгийн дүгнэлтийг үзнэ үү:

Харин та нар бат итгэлээрээ түүнийг эсэргүүц. Дэлхийд буй ах дүү нар чинь адилхан зовлон эдэлж байгааг та нар мэднэ. Христ дотор та нарыг Өөрийн мөнх алдарт дуудсан, бүх нигүүлслийн Бурхан Өөрөө, түр зуур зовсны чинь дараа та нарыг төгс болгож, бататгаж, бэхжүүлэн байгуулах болно. (1Петр 5:9-10)

Бүх нигүүлслийн Бурхан таныг төгс болгож, бататгаж, бэхжүүлж, байгуулах (суулгах) болтугай.

Эдгээр нь та бид хоёрт хандсан туйлын хүчирхэг амлалт үг болой. Би үг тус бүрийн утгыг Жэймс Стронгийн тайлбар толиос ишлэн үзүүлье:

1. Төгс болгох - “засвар, тохиргоо, заслаар сэргээн босгох юмуу бүрэн гүйцэт болгох.”
2. Бататгах - “хурдан босгох, тодорхой нэг чиглэл рүү шийдвэртэйгээр эргүүлэх, засах, барих, тууштайгаар

зорих.”

3. Бэхжүүлэх - “сүнслэг мэдлэг, хүч дотор батжуулах юмуу хүчжүүлэх.”
4. Байгуулах (суулгах) - “аль нэг зүйлд зориулж суурь тавих, цутгах.”

Бурхан Иосефийг захиргаанд бэлдэхдээ яг эдгээр дамжлагаар явуулжээ. Иосеф засал завсар авч, мөнөөх аманцар, онгиороо, ихэмсэг зангаа хаясан. Иосеф Бурханы ер бусын нигүүлслээр хувь тавилангийнхаа суудлыг эзэгнэж, хүчирхэгжсэн. Иосеф сүнсээр бэхжиж, ах нараа хараалгүй, харин ерөөсөн. Хамаг горьдлого тасармаар нөхцөлд Иосефийн дотор байсан мятрашгүй дуулгавартай зан л үгүйсгэхийн аргагүй цэц ухаан, урам зориг, зан чанар гаргажээ.

Тэгэхээр Бурханы Үгээс зуурч, тунхаглах замаар дайсантай шууд үзэлцэх нь ямар чухал байдгийг бид үзлээ. Гэхдээ Үгийг тунхаглах нь бидний хамгийн том зэвсэг биш юм. Дайсантай нүүр тулах бидний хамгийн хүчирхэг зэвсэг бол эцсээ хүртэл Бурханы Үг дотор дуулгавартай зогсох юм. Энэ нь Бурханы үнэнээр сэтгэж, ярьж, амьдрахыг хэлж байгаа юм. Бурхан Иеремиа гэдэг зөнчөөрөө дамжуулан: “Хэл юугаа тэд нум татах мэт хөвчлөөд Худал хуурмагаар газар нутгаа эзлүүлж Үнэн гэдэг нь огт үгүй болжээ. Эд ёрын муугаас ёрын муу тийш явдаг бөгөөд Тэд Намайг мэддэггүй” (Иеремиа 9:3) хэмээн хашхирсан байдаг.

Бурхан таныг ямар аугаа амьдралд дуудаа вэ! Таныг эхийнхээ хэвэлд бүрэлдэж ч амжаагүй байхад, Бурхан танд зориулж төлөвлөгөө бүтээсэн байжээ. Бурхан Иосефийг дуудсан шигээ таныг ч бас аугаа амьдралд дуудсан.

Энэ нь Бурханы жинхэнэ нигүүлсэл гэдгийг би та нарт гэрчилж, сургамжлан бидний итгэмжит ах дүү болох (би тэгж үздэг) Силуанаар дамжуулан товчхон бичлээ. Энэ нигүүлсэлд бат зогс. (1Петр 5:12)

Мятрашгүйгээр дуулгавар дагах хүч нь Бурханы нигүүлсэлд бий. Тэгэхээр та дахиж Бурханы гайхамшигт нигүүлслийг нүглийн цагаатгал, тэнгэрт орох тасалбар төдийхнөөр төсөөлж

ойлгохгүй байх аа. Нигүүлсэл бол үлэмж том зүйл шүү!
Бурханы нигүүлслээр бид Эзэн Есүсийгээ алдаршуулахын
төлөө өөрсдийгөө олноос онцгой байлгах ёстой.

МЯТРАШГҮЙ ЗАЛБИРАЛ

Тэр өдөр та нар Надаас юу ч асуухгүй.
Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Та нар Эцэгээс нэрээр
минь юу ч гуйсан Тэр та нарт өгнө.

Иохан 16:23

Бурхантай хувийн харилцаа тогтоох талаар ярихгүй бол “Мятрашгүй” номын маань утга алдагдана. Бид яаж Бурханд ойртож, яаж Бурханаас гуйх вэ? Гөлөн гөлөн хийж, айж хулганасаар ойртох ёстой юу? Эсвэл Бурхан хариулахгүй байх вий хэмээн эмээхдээ, Түүнээс зөвхөн амьдралын “том том” асуудлын талаар залбирах уу? Залбирсан зүйлийнхээ хэдэн хувийг хүлээж авна гэж найдах вэ?

Хачин асуулт байна уу? Гэхдээ миний бие өдий хорь гаруй жил аялж, газар газрын үй олон итгэгч, удирдагч нартай хамтарч залбирсан хүнийхээ хувьд эдгээр асуулт нь хэтрүүлэг биш гэдгийг мэднэ. Ямар ч итгэл үнэмшил, гал хүчгүй үй олон залбирлыг би гэрчлэн харсан. Хүмүүс нь зуучлан залбирахын оронд ийш тийшээ өнгөлзөөд л, Библиэ наашаа цаашаа эргүүлээд л, магтан дуу аялаад л зогсдог залбирлын цуглаанд би очиж байсан. Тийм хүмүүсийг харахаар, зүгээр л шомбойгоод суусных нь төлөө Бурхан хариулна гэж бодсон юм болов уу эсвэл Бурхан хариулна гэдэгт бүх зүрхээрээ найдан, улайран залбирна гэж юу байдгийг мэддэггүй юм болов уу гэж гайхмаар байдаг.

Түүнчлэн удирдагч хүний үлгэн салган, бүрхэг залбирал шиг эмгэнэлтэй юм байхгүй. Ийм үед надад: “Энэ хүн Бурхантай ярьж байгаа шигээ ийм янзаараа аль нэг албан тушаалтантай ярьбал, “Та энд яах гэж ирсийм? Хүний цаг үрээд! Эндээс гар!” хэмээн шууд амбаардуулах байсан даа” гэж бодогддог юм. Тэд хүмүүст таалагдаж, хүлээн зөвшөөрөгдөх гэсэндээ л уран цэцэн үг урсгаад байх шиг санагддаг. Энэ бүгд нь маш олон итгэгчид залбирлын хүчийг бодитой авч үзэхгүй байгаагийн шинж бөгөөд тун эмгэнэлтэй хэрэг юм.

ЗОРИГТОЙ БӨГӨӨД ГАЛ ЦОГТОЙ БАЙ

Ертөнцийн Бурхан Өөрөө биднийг “нигүүлслийн сэнтий рүү зоригтой ирээрэй” (Еврей 4:16) хэмээн уриалгахнаар урьжээ. Зоригтой байна гэдэг нь итгэлтэй, урамтай, давшингуй, хүчтэй, бат бэх байх юм. Үүний эсрэг үгс нь “бүрэг, эргэлзэнгүй, ичимхий” болно. Бурхан таныг Өөр дээр нь итгэлтэй, хүчтэй, зоригтой хүрч ирээд, ерөөгдөөрэй гэжээ. Бурхан ийм л хүсэлтэй!

Элч Иаков “...Зөвтийн (зөвт хүний) залбирал үр нөлөөтэй, гал цогтой залбирал ихийг гүйцэлдүүлж чадна” (Иаков 5:16) гэсэн. Гал цогтой гэдэг нь “сүнсний их эрч хүч, мэдрэмж, идэвхитэй байх юмуу үүнийгээ харуулах” гэсэн үг. Өөрөөр бас гал халуун, чин сэтгэлийн гэж хэлж ч болно. Гал цогтой залбирал нь үр нөлөөтэй байдгийг Иаков хэлжээ. Нөгөөтэйгүүр үр дүнгүй залбирал нь дарамттай, галгүй, сэтгэлээсээ биш байдаг.

Гал цогтой гэдэг үг нь танд мятрашгүй гэсэн үг шиг сонсогдож байна уу? Тэгж сонсогдох ёстой. Иаков энэ санаагаа аугаа зөнч Елиагийн тухай яриагаар хэлжээ:

Елиа бидэнтэй адил жирийн хүн байсан. Бороо оруулахгүйн тулд түүнийг шургуу залбирахад гурван жил зургаан сар газарт бороо ороогүй билээ. Түүнийг дахин залбирахад тэнгэрээс хур бороо асгаж, газар үр жимсээ ургуулсан юм. (Иаков 5:17-18)

Елиа шаргуу - мятрашгүй залбирсан учраас гайхамшиг болжээ. Шаргуу гэдэг үг нь гал цогтой гэсэнтэй ижил утгатай үг юм. Үүнийг “нухацтай санаа, зорилго, хүчин зүтгэлтэй байх, хамаг сэтгэлээрээ улайрах” гэж тодорхойлж болно. Тэгвэл яаж үр дүнтэй залбирах вэ? Тодорхой: Бурхан биднийг Өөр дээр нь хэрэгцээ, хүсэлтээ барьж ирэхдээ чин зүрхний, мятрашгүй, гал халуун хүсэлтэй байгаасай гэж хүсдэг.

Елиа бороог зогсоотол залбирсан шигээ дараа нь бас бороо дахиж ортол залбирсан. “Харин Елиа Кармелын оройд гарлаа. Тэрээр газарт суун бөхийгөөд, толгойгоо өвдгөн завсраа хавчуулав.” (1Хаад 18:42)

Нью Ливинг Транслэйшн Библи дээр “газар унаад, залбирсан” гэдэг. Түүнийг Бурхан руу яаж бүх зүрхээрээ орь дуу тавин залбирсныг би төсөөлж байна. Тэрбээр сөхрөөд юмуу суугаад, хоёр өвдөгнийхөө хооронд толгойгоо хавчуулан, урагш хойш ганхан: “Абрахам, Исаак, Иаковын Бурхан минь, Та бороо оруулахыг хүсч байгаагаа надад хэлсэн. Тиймээс энэ газар дээр дахин хур шим эргэж ирэхийн төлөө би Таныг үүл авчран, бороо асгахыг дуудаж байна! Ард түмэн тань Таны сайн сайхныг дахин эдлэхийн тулд нэг ч сааталгүй, бороо авчраач!” гэж хашхирсан байх. Елиа эр зоригтойгоор,

■

**Бурхан биднийг Өөр
дээр нь хэрэгцээ,
хүсэлтээ барьж
ирэхдээ чин зүрхний,
мятрашгүй, гал
халуун хүсэлтэй
байгаасай гэж
хүсдэг.**

■

мятрашгүйгээр, гал халуун зүрхээр залбирсан. Дараа нь зарцаа: “Яваад тэнгисийн зүг хараатах” хэмээн илгээжээ. (1Хаад 18:43).

Израильд ган гачиг болохоос өмнө хур бороо Газрын Дундад тэнгисээс баруун зүг рүү чиглэн ирдэг байжээ. Елиа зарцаа яг тэр зүгт үүл хурж байгаа эсэхийг харуулахаар илгээжээ. Елиа итгэсэн зүйлээ үйл хэрэг болгожээ. Бид үнэхээр итгэж байгаа

л бол, үүнийгээ үйл хэрэг болгоно. Гэтэл харамсалтай нь зарц нь: “Юу ч алга” гэсээр ирэв.

Олон хүн ийм үг дуулаад шууд бууж өгдөг. Бид: “Би буруу сонсчихсон юм шиг байна. Бурхан Израилийг уучлах хүсэлгүй байх шиг байна. Ахаб хаанчилж байгаа цагт бид хур бороо үзэхгүй нь болтой” гэж бодох байсан биз. Тэгээд итгэл дээрээ бат зогсолгүй, залбирлаа зогсоож, Түүний хүслийг алдах байсан байх. Гэвч Елиа тэгсэнгүй.

Елиа Бурханы хүслийг сонссон учраас, Бурхан хариулна гэдгийг мэдэж байв. Елиа дахин залбирахдаа, Бурханд зоригтойгоор, гал цогтойгоор талархаж, залбирлынх нь хариулт ирээгүй байсан ч, итгэлээр үйлдэн, зарцаа Кармел ууланд хоёр дахь удаагаа гаргажээ.

Үйлдэлгүй итгэл нь шашны зан үйл, цагийн гарз юм. Гал цогтой залбирах гэдэг нь зүрх, сэтгэл, бие чинь хүсэн гуйсан зүйлээ хүлээж авахаар шулуудчихсан учраас, үүнийхээ дагуу үйлдэхийг л хэлж байгаа юм. Та Бурханы хүслийн дагуу хийж байгаагаа мэдэж байгаа учраас, үгүй гэсэн хариултыг хүлээж авахгүй.

Гэтэл энэ удаа ч бас Елиагийн зарц: “Юу ч алга” гэсээр хүрч ирэв.

Дийлэнх хүмүүс эхний удаадаа ажиггүй давчихдаг ч, хоёр дахь удаадаа цөхөрдөг. Тэгээд Бурхан яагаад залбиралд нь хариулахгүй байгааг теологийн аль нэг учир шалтгаанаар тайлбарлана. Гэхдээ Елиа тэгдэг хүн биш байв! Елиа дахин тэнгэрийн сэнтий рүү салхи татуулан очоод, зарцаа гурав дахь удаагаа уулан дээр гаргасан. Дахиад л хариу байхгүй. Елиа дөрөв, тав, зургаа, долоо дахь удаагаа явуулав! (Зарц нь ч ямар супер юм! Нэг өдрийн дотор долоон удаа Кармел уулын орой руу гараад ир гээд явуулахад нь үгэнд нь ороод гарч л байдаг!) Долоо дахь авиралтынхаа дараа зарц нь: “Тэнгисээс хүний атгасан гарын дайтай жижиг үүл хөөрч байна!” гэсэн мэдээ авчиржээ.

Атгасан гарын дайтай жижиг үүлнээс Елиагийн хүссэн бороо асгах нь тодорхой болов. Елиад энэ л хангалттай байлаа. Тэрбээр залбирлаа зогсоогоод, шууд ажилдаа оржээ. Елиа залбирлынхаа хариултыг авсан гэдгээ мэджээ.

Елиа —Явж Ахабт хандан “Аадар бороонд саатахгүйн тулд тэргээ бэлтгэн явагтун” гэж хэл гэлээ. Тун удалгүй тэнгэрт бараан үүл хуралдан салхи ширүүсэж, аадар бороо орж эхэллээ. Ахаб тэргэнд суун Иезреел уруу явжээ (1Хаад 18:44-45).

Елиа долоон удаа залбирч, долоон удаа зарцаа явуулсан. Елиа хариултаа авахаар шулуудан мятрашгүй залбирсан. Иаков үр нөлөөтэй, гал цогтой залбирлын талаар ярихдаа чухам ийм байх тухай л хэлжээ. Энэ нь итгэл, яриа, тэвчээр, үйлдэлдээ гал цогтой байх явдал юм.

ЖИЖИГ ҮҮЛ ХӨӨРӨН АЙСУЙ

Елиагийн хүлээж авсан зангидсан гарын дайтай жижиг үүл нь мятрашгүй залбирлын баталгаа юм. “Биднийг Бурханы хүүхдүүд гэдгийг Сүнс Өөрөө бидний сүнстэй хамт гэрчилдэг” (Ром 8:16). Энэ бол бидний жижиг үүл юм. Энэ нь заримдаа ганц үг, заримдаа олгойдсон хөөр баяр, заримдаа Бурханаас гуйж байгаа зүйл маань биелсэн гэх зүрхний баталгаа байж болно. Жижиг үүлээ харсан бол бид Элиа шиг зохих ёсоор үйлдэх ёстой.

Лиза бид хоёр дөрөв дэхь буюу отгон хүүгээ хэрхэн угтаж авсан түүхийг би хуваалцмаар байна. Лиза маань амаржихад дөрөв хоног дутуу байснаас гадна угаасаа жаахан илүү тээчихдэг байв. Гэхдээ энэ удаа тээлт нь нэг л биш байгааг Лиза мэдэрчээ. Хүү маань гэдсэндээ маш хүчтэй, огцом хөдлөж байв. Лиза эмчээ дуудаад зовиураа хэлтэл эмч нь: “Маргааш хэвтэнэ шүү, шууд төрүүлэхгүй бол болохгүй” гэлээ.

Маргааш өглөө нь эмч Лизагийн усыг хагалаад, шууд хүүхдийг төрүүлэх ажилдаа орсон юм. Тэгээд өвдөлт өгүүлэхийн тулд жаахан алх гээд Лиза бид хоёрыг гаргалаа. Лиза бид хоёр өглөөжин ямар ч ахицгүй баахан алхав. Үдийн алдад Лиза тамирдаж, амрахаар өрөөндөө орохдоо: “Жон, чи яваад залбир. Би өөрөө төрөхгүй бол, эмч нар хүүг маань хүчээр төрүүлнэ гэнэ. Би үүнийг хүсэхгүй байна” гэж хэлэв.

Эмч нарын төлөвлөсөн нэг арга нь Лизад маань Питоцин гэдэг эм уулган, эпидураль аргаар мэдээ алдуулж байгаад төрүүлэх байв. Лиза маань ууган хүүгээ төрүүлэхдээ ингэсэн бөгөөд үүнээс болж нуруу нь нилээд удаан өвдөж зовоосон учраас тэрбээр үүнийг хүсэхгүй байлаа. Өөр нэг арга нь маш үнэтэй хагалгаа байв. Гэхдээ дөнгөж үйлчлэлээ эхлүүлээд байсан бидэнд эрүүл мэндийн даатгал ч, мөнгө ч байсангүй.

Үдийн алдад би эмнэлгээс гараад, холгүй орилж хашхирч болох хүнгүй газар олж байгаад, байдгаараа залбирав. Дөчин таван минутын дараа Лиза дээр иртэл, ямар ч өөрчлөлт гараагүй байв. Би эхнэртэйгээр дахин нэг цаг байж байгаад, хоёр дахь удаагаа залбирахаар явлаа. Залбирал маань улам л шийдэмгий, хүчтэй болж байлаа. Тэгээд үдээс хойш эргэж иртэл бас л ямар ч ахиц гараагүй байв.

Бид хоёр дахин нэг цаг хамт байв. Лиза олон юманд санаа тавьж байсан ч, хамгийн гол нь хүүхдийнхээ аюулгүй байдалд зовниж байсан юм. Тэгээд: “Жон, яваад залбир. Би айж байна” гэлээ.

Би гурав дахь удаагаа гараад, нөгөө газраа ганцаараа залбирлаа. Энэ удаа бүр ч галтай, хүчтэй залбирав. Би Бурханаас хариултаа авч байж л салахаар шулуудсан байлаа. Би гэргийнхээ айдсыг харсан учраас тайтгаруулахыг хүсч байлаа. Тэгээд Бурханд Өөрийнх нь гэрээний амлалтыг ангиар сануулаад, дараа нь Сүнс дотор шатан залбирав.

Хэдэн минутын дараа зүрхэндээ: “Хүү чинь өнөөдөр төрнө. Маргааш өдийд гэхэд эх хүү хоёр эрүүл саруул гэртэй байх болно” гэх дуу сонсов. Ариун Сүнс надад үгээ өгөхдөө, залбирал минь Бурханд хүрснийг миний сүнстэй хамт гэрчилжээ. Ариун Сүнс надад “атгасан гарын дайтай жижиг үүл” харуулсан юм. Тиймээс би үйлдэл хийхэд бэлэн болов.

Би 17 цагийн үед Лиза дээр очоод: “Арден өнөөдөр төрнө. Маргааш гэхэд та хоёр эрүүл саруул гэртээ байна” гэж хэлэв. Эхнэр маань тайтгарсан ч, ямар ч өөрчлөлт гарахгүй байсан учраас Бурханы амлалт бүтэхгүй мэт харагдаж эхлэв. Ямар ч өвдөлт өгөхгүй байсан учраас хүүхэд тийм хурдан төрөх боломжгүй байв. Гэхдээ л би атгасан гарын дайтай жижиг үүл харчихсан байлаа.

Орой болж, эмч сувилагч нар дараагийн алхмаа хэлэлцэж эхлэв. Лиза надад: “Жон, чи яваад залбирахгүй юм уу?” гэлээ.

Харин би түүнд: “Шаардлагагүй. Хүүхэд шөнө дундаас өмнө төрнө!” гэж хэлсэн юм.

Цаг өнгөрөх тусам би бууж өгөөд, зүрхэндээ тов тодорхой сонссон Бурханы үгийг тавьж туух бодол маань улам бэхжиж байсан ч, Бурхан намайг сонссон гэдгийг мэдэж байсан учраас буугаад өгч зүгээр л чадахгүй байлаа.

Гэтэл 23 цаг дөнгөж өнгөрөв үү үгүй юу Лиза өвдөж эхлэв. Арден маань 23 цаг 51 минутад төрж билээ. Хүү маань төрөхдөө, хүйгээрээ хүзүүгээ ороосон байв. Толгой нь биеэсээ тэс өөр өнгөтэй байсан тэр аймшигтай дүр зургийг би одоо ч санадаг. Хүү маань боомилогдож байжээ. Эмч тэр даруй хүйг нь таслаад, Арденд нарийн үзлэг хийхээр авч явсан юм.

Маргааш нь бид 3 цаг 30 минутад эмнэлгээс гараад, 4 цаг 30 минут гэхэд гэртээ ирчихсэн байж байлаа. Бурханы үг яг л биелсэн юм.

ГУЙ, ГУЙСААР БАЙ

Бидний ихэнх нь Есүсийн “Би та нарт хэлье. Гуй, тэгвэл та нарт өгөгдөнө. Хай, тэгвэл та нар олно. Тогш, тэгвэл та нарт нээгдэнэ” (Лук 11:9) гэдэг үгийг мэднэ. Үүнийг Амплифайд Библи илүү нарийн хэлдэг:

Би та нарт хэлье. Асуу тэгээд асуусаар бай - тэгвэл энэ нь та нарт өгөгдөнө. Хай тэгээд хайсаар бай - тэгвэл та нар олно. Тогш тэгээд тогшсоор бай - тэгвэл та нарт хаалга тайлагдана. Учир нь асуудаг тэгээд асуусаар байдаг хүн бүр хүлээж авдаг, хайдаг тэгээд хайсаар байдаг хүн бүр олдог, тогшдог тэгээд тогшсоор байдаг хүн бүрт хаалга тайлагддаг. (Лук 11:9-10)

Есүс биднийг мятрашгүйгээр асууж, хайж, тогш гэж ятгажээ. Яагаад? Бурхан чих хатуу юу? Мэдээж үгүй! Гол нь бид үнэхээр итгэж байна уу үгүй юу гэдэгт л хамаг асуудал оршино. Би Бурханаас гуйлтынхаа хариултыг хүлээж авахаар

шулуудчихсан болон хүлээж авах хүсэлтэй хүмүүсийн аль алийг нь харсан. Тэдний хооронд том ялгаа бий. Шулуудчихсан хүн нь цөхрөшгүй, галтай, зоригтой байдаг. Тэрбээр яаж ч байсан гар хоосон буцахгүй. Харин хүлээж авах хүсэлтэй хүн нь хэдийд ч хамаагүй бууж өгөхөд бэлэн байна. Үнэхээр итгэж байгаа хүн хүлээж автлаа асуусаар, асуух тусмаа улайрсаар байдаг.

Эзэн Өөрөө бидэнд ийм жишээ хэлсэн:

Сэтгэл алдрахгүйгээр байнга залбирах ёстойг тэдэнд ойлгуулахын тулд Тэр ийм нэг сургаалт зүйрлэл айлдав. — Нэгэн хотод Бурханаас үл эмээдэг, хүмүүсийг ч эс хүндэлдэг шүүгч байжээ. Тэр хотод нэгэн бэлэвсэн эмэгтэй байв. Тэр эмэгтэй, шүүгчид очиж “Арцалдагчаас минь намайг өмгөөлөөч” гэдэг байлаа. Шүүгч туслахыг удтал хүсээгүй боловч дараа нь өөртөө “Хэдийгээр би Бурханаас эмээдэггүй, хүмүүсийг хүндэлдэггүй боловч энэ эмэгтэй амар заяаг минь үзүүлэхгүй нь. Түүнийг өмгөөлөхөөс, эс тэгвээс тэр ирж үргэлж надад төвөг удах вий” гэжээ. Тэгээд Эзэн — Шударга бус шүүгчийн юу хэлснийг сонс. Өөрт нь хандан өдөр шөнөгүй хашхирах Өөрийн сонгосон хүмүүсээ Бурхан өмгөөлөхгүй гэж үү? Тэр тэднийг удтал хойшлуулна гэж үү? Би та нарт хэлье. Тэр даруйд Бурхан тэднийг өмгөөлөх болно. Харин Хүний Хүү ирэхдээ газар дээр итгэл олох болов уу? гэжээ. (Лук 18:1-8)

Есүс тэд хэзээ ч бууж өгч болохгүй гэж хэлсэн байгааг анхаараарай. Энэ нь дажгүй санаа биш, харин таныг хэзээ ч битгий бууж өгөөрэй гэсэн Бурханы хүсэл юм.

Дээрх түүхнээ шударга бус шүүгчийг бууж өгтөл нь шалсан, бууж өгөхийг мэддэггүй эмэгтэйн гарч байна. Товчхондоо тэр эмэгтэйн цөхрөлтгүй зан шүүгчийг бараг галзууруулахад хүргэжээ. Тэгээд тэр бурханлаг бус захирагч тэр авгайгаас салахын түүс болохдоо, хүссэн зүйлийг нь хийж өгөхөөс өөр аргагүй болсон байна. Есүс ийм түүхээр бидэнд Бурханаас яаж гуйхыг заасан нь үнэхээрийн биширмээр. Есүс “Үүнээс

сургамж ав” гэсэн. Тэгээд Бурханаас өдөр шөнөгүй гуйж гувшиж байгаа хүмүүсийнхээ залбирлыг “Бурхан хойш тавьж чадна гэж үү?” гэж асуусан. Бурхан шударга. Бурхан бидний төлөө. Тиймээс бид өөрсдөө л шийдчихсэн байвал, Бурхан бидний гуйлтын хариултыг тэр дор нь баталгаажуулж өгнө.

Гэхдээ энд нэг тодруулга хийх хэрэгтэй. Сургаалт үлгэрийн буруу ташаа хэрэгжүүлснээс болж, зарим хүмүүс залбиралд яг өдөр шөнөгүй уншдаг маани мэгзэм шиг хандахад хүрдэг. Есүс ч яг энэ талаар анхааруулсан: “Залбирахдаа харийнхан шиг утгагүй хоосон үг бүү давт. Олон үг хэлснийх нь төлөө өөрсдийг нь сонсоно хэмээн тэд боддог юм” (Матай 6:7). Бид залбирлынхаа зорилгыг ямар ч бодлогогүйгээр ахин дахин хэлдэг уншлага болгож болохгүй. Бид Бурханы өмнө хүсэлтээ мятрашгүй, галтай, тууштай өргөхөд анхаарах ёстой. Бид хүсэлт маань Бурханы хүсэлтэй таарч байгаа учраас, Бурханаар няцаагдахгүй гэдгийг мэдэн, Бурхан дээр итгэлтэй явж очдог. Элиа “үгүй” гэсэн хариултыг хүлээж аваагүй. Тэгээд залбиралыг нь Бурхан сонсжээ гэдгийг харах хүртлээ тууштай залбирсан.

УЛАЙРАН ХАЙЖ ТОГШИХ

Есүс бидэнд гуйсаар бай гэснээс гадна хайсаар бай, тогшоор бай гэжээ. Гал цогтой залбирал нь амнаас хальж, чин сэтгэлийн үйл хэрэг болдог. Өөрөөр хэлбэл, асуусан зүйлээ амьдрал болгоно гэсэн үг. Ингэж байж л үр дүнгээ үзнэ.

Жишээлбэл би өөрийнхөө амьдралын маш олон түүхээс нэгийг жишээлж ярья л даа:

Хавайд хийх конференцийнхээ өмнө Хавайн Мауи арал дээр хоёр өдөр хагас амрах завшаан Лиза бид хоёрт олдсон юм. Сүүлийн үед хамтдаа амрах цаг олдохгүй, дээрээс нь Лизагийн маань аав дөнгөж өнгөрчихсөн байсан болохоор энэ нь бид хоёрт нэн хэрэгцээтэй амралт байсан учраас би ч гараа гарган бэлтгэв.

Амралт маань ойртовч, зогсоо зайгүй усан бороо асгасаар, тэнгэр онгойх шинжгүй байлаа. Энэ байдлаараа байвал, бидний хайран төлөвлгөө яйран болох байсан тул би бороо

зогсохын төлөө, бороо бидний амрах газрыг тойрохын төлөө, тэнгэрэлч нар миний залбирлыг биелүүлэхийн төлөө чин сэтгэлээсээ залбирч эхлэв.

Лиза: “Бороо орно, бороо орно” гэсээр, харин би: “Бороо орохгүй. Тэнгэр сайхан байна” гэсээр байлаа.

Биднийг Хавайд буудаг орой бүрхэг тэнгэр угтав. Цаг агаарын мэдээ ч “Бороо орно!” хэмээн тунхаглалаа. Зочид буудлын зурагтаар цаг агаарын мэдээ танилцуулж байхыг үзтэл, Хавай арал дээр төдийгүй, Номхон далай хавийн нийт нутгаар бороо хуртай байна гэсэн зураг гарав.

Өглөө сэрээд хөшгөө яртал тас хар үүл, шал нойтон тэнгэр л угтлаа. Тэр хар үүлнээс ширхэг ч завсар үзэгдсэнгүй. Гэхдээ би гуйсан зүйлээсээ өөр юм хүлээж авахгүй байхаар шийдчихсэн байсан тул: “Баярлалаа Аав аа, энэ сайхан нарлаг өдрийг өгсөнд. Би гэргийгээ усны хувцсаа өмсөөд, наранд амарч хэвтэхийг нь харж байна” хэмээн дуу алдсан юм.

Лиза миний дүрсгүйтлийг хараад инээд алдав. Би ч тоглоом шоглоом хийгээд өнгөрсөн ч, дотроо бол үнэн сэтгэлээсээ ярьж байлаа. Би бууж өгөхийг хүссэнгүй. Дараа нь бид хоёр өглөөний цайгаа уулаа. Усан борооны улмаас рестораны ажилчид гадаа байсан ширээний тал хувийг зочид буудлын үүдэн хэсэгт овоолсон байв.

Хоол ирэх үед би усан борооны хар үүл рүү ширтэж байгаад: “Эзэн минь, энэ хоолонд баярлалаа. Есүсийн нэрээр ариутгаж байна. Бас энэ сайхан нарлаг өдрийн төлөө баярлалаа” гэж залбирлаа.

Лиза инээмсэглээд: “Жон, чи яг хариултаа авч болох зүйлээ залбирвал яасын?” хэмээн намайг явуулж, бид хоёр ч инээлдэв. Манай Лиза ер нь их шооч хүн л дээ.

Гэхдээ би түүнд: “Хонгор минь, гэхдээ би тоглоогүй байна. Өнөөдөр сайхан өдөр болно, чи харж л байгаарай!” гэж хэлсэн юм.

Зөөгч бидэн дээр ирээд: “Хэрэгтэй зүйл байвал хэлээрэй!” гэж хэлэхээр нь би: “Байна аа, энэ бороог зогсоогоод өгөөч” гэв.

Бид инээлдээд өнгөрсөн ч, өглөөний цайгаа ууж дуусахаас өмнө бороо зогсож, хар үүл нүүж, тэнгэр цэлмэж, нар шарчихав. Биднийг Мауигаас яван явтал ширхэг ч үүл гараагүй юм.

Дараа нь бид Хавайн Оахуд конференц хийхээр зочлохдоо, биднийг Мауид наранд шарагдаж байх яг тэр үеэр Оахуд усан бороо цутгаж байсныг хэд хэдэн хүнээс сонсож билээ. Угтаа бид Оахугийн хуурай хэсэгт байсан ч, усан борооноос болж далайд хортой хаягдал асгарсан учраас, наран шарлагын газрууд нь бүгд хаалттай байв. Мауид тийм сайхан цаг агаар байсан гэдэгт нутгийн хүмүүс мэл гайхаж билээ.

Миний гайхамшигт Бурхан өчүүхэн миний залбирлыг сонсож, цаг агаарын системд нэг нүх гаргачихсан гэдэгт би одоо хүртэл итгэдэг.

ГАЧИГДСАН ХҮМҮҮСТ ЗОРИУЛСАН НОМ

Тэгэхээр би саяын түүхээрээ Бурхан зөвхөн “том том хүсэлтэд” хариулдаг гэсэн ташаа ойлголтыг няцааж байгаа юм шүү. Бурхан бол бидний амьдралын хэсэг бүрт санаа тавьдаг, бидний Аав! Тэгвэл харин одоо би үүнээс хавьгүй чухал хүсэлтэд буюу бусдын төлөөх залбиралд Бурхан хэрхэн хариулдгийг гэрчилмээр байна.

Бидний номууд бол даян дэлхийн чуулганд Бурханаас өгөгдсөн үг гэдэгт Лиза бид хоёр итгэдэг. Тэр номууд дээр миний нэр байгаагийн цорын ганц шалтгаан нь би тэр номын анхны уншигч учраас л тэр. Тиймээс ч Лиза бид хоёр даян дэлхийн чуулганд Бурханаас үг хүлээн авахын төлөө залбирч, хүргэх асар өндөр үүрэг хариуцлага хүлээсэн нярвууд юм.

**Бурхан бол бидний
амьдралын хэсэг
бүрт санаа тавьдаг**

Одоогоор миний бичсэн номууд дэлхийн жар гаруй хэл дээр хөрвүүлэгдээд байна.

Бүх номоо хөгжиж байгаа юмуу хаалттай байгаа улсын пастор удирдагч нарт хүргэхийн төлөө насан турш залбирах нь ч бидний амин чухал үүрэг мөн. Үнэндээ бид номоо зарахаасаа илүү үнэгүй тараахад л анхаардаг.

Сүүлийн арван жилд бид Иран, Пакистан, Энэтхэг, Фижи, Танзани, Рвандаа, Уганда, Монгол тэргүүтэй олон улсад

250,000 гаруй ном хүргэсэн. Гэхдээ тараасан номын маань тоо зарагдсан номын тооноос хол хоцорсоор л явна. Учир нь манай номууд хэдэн сая хувиар борлогддог.

2011 оны эхээр манай удирдлагын баг цаашдынхаа стратегийг боловсруулж байхдаа 2010 онд гучин гуравхан мянган ном тараасныг олж мэдсэн юм. Тэгээд ярилцаж байгаад би: “Энэ жил бид хилийн чанад дахь удирдагч нарт 250,000 ном тараана” гэж зарлав.

Өрөө нам гүм болов. Тэгтэл нэг ажилтан маань: “Энэ арай л өндөр зорилго биш үү? Өнгөрсөн жилийнхээс хэт өндөр тоо байна. Бид энэ том санаа зорилгоо санхүүгийн түншүүддээ танилцуулаад, алхам алхмаар сонирхлыг нь нэмэгдүүлэх хэрэгтэй. Бидэнд хугацаа хэрэгтэй. Энэ жилдээ 100,000 дээр тогтоод, дараа жил арай илүүг сэтгэбэл?” гэлээ.

Тэгэхээр нь би: “Үгүй ээ, бид Бурханд итгэж, дэлхий даяар буй гачигдсан чуулган, пасторуудад хүрэх ёстой. Хоёр зуун тавин мянга гэдэг тийм ч боломжгүй тоо биш” гэлээ.

Бидний яриа хурцдав. Нөгөө гишүүн маань миний зорилго яагаад хэт том байгааг нэмэлт учир шалтгаанаар цохон тайлбарлаад, эцэстээ энэ санааг ямар ч утгагүй зорилго гэдгийг түс тас хэллээ. Тэрбээр маш оновчтой, логиктой ярьж байсан ч, Бурханы нигүүлслийг тооцоолоогүй юм.

Тэгэхээр нь би тас зөрлөө: “Нөхөд өө, энэ номуудыг өөр ямар ч үйлчлэл тарааж чадахгүй. Бурхан үүнийг бидэнд л итгэмжилсэн. Манай номуудыг бид л хүргэж чадна. Үүний төлөө бид л Бурханд итгэх үүрэг хариуцлагатай. Бид өндрийг харах хэрэгтэй.”

Эсэргүүцэл үргэлжлэв. Тэгэнгүүт нь би улам гөжөөд, бүр чангаар: “Шүүлтийн сэнтийн өмнө Есүсийн урд очоод, яагаад ийм өчүүхэн зүйл гуйснаа тайлбарлах гэж гөлөлзмөөргүй байна шүү. Тэр үед пасторууд биднээс: “Та нар яагаад Бурханы та нарт итгэмжилсэн энэ номыг бидэнд өгөөгүй юм бэ?” гэж асуубал яах уу? Үүний төлөө өөр үйлчлэлүүд биш, зөвхөн бид л тайлангаа тавина!”

Уулзалт маань нилээд хурцадмал, дарамттай өнгөн дээр дуусав. Мэдээж нөхцөл байдлыг тэгтэл хурцатгаж, тийм хатуу үг хэлсэндээ би харамссан. Манай хэлтсийн удирдагч нар

үйлчлэлийнхээ сайн сайхны төлөө л явдаг бурханлаг, цэвэр сэтгэлтэй хүмүүс. Гэхдээ яасан ч ухарч болохгүй гэдгийг би зүрхнийхээ гүнд мэдэж байлаа. Дэлхий дээрх хөгжиж буй улс орны өлсөж цангасан пасторууд, гачигдсан чуулганы төлөө ангал дээр зогсох л ёстой.

Хэдэн өдрийн дараа нөгөө захиргааны удирдагч маань над дээр ирээд: “Жон, бид чиний зүрхэнд байгаа зүйлийг хийнэ. Бид энд Лиза та хоёрын алсын харааг биелүүлэхээр л байгаа. Үнэхээр 250,000 номд итгэж байгаа бол хэл. Үнэхээр залбираад, итгэбэл, бид чамтай эцсээ хүртэл 100 хувь хамт байна. Үүний төлөө залбирч, хичээнгүй ажиллана” гэв.

Би дахиад л Бурханыг хайлаа. Бас 250,000 ном тараана гэдэгтээ итгэл дүүрэн байлаа. Бидэнд Вьетнам, Либери, Хятад, Иран, Турк, Гана, Таджик, Ливан, Бирм тэргүүтэй олон улсад хүрэх үүд хэдийн нээгдсэн байв. Үүнээс өөр олон газраас ч хүсэлт ирнэ гэдгийг бас мэдэж байлаа. Ийм тооны ном хэвлэж, тараахад дор хаяж 600-700 мянган доллар хэрэгтэй байв. Энэ нь бидний хувьд аймшигтай том тоо байсан болохоос биш, Бурханы хувьд том байгаагүй юм.

Хоёр долоо хоногийн дараа намайг Флоридагийн нэгэн зочид буудалд байж байтал манай багийнхан над руу утасдав. Тэгээд баяр хөөртэйгээр: “Жон, бид дөнгөж сая хилийн чанад дахь пасторуудад зориулж ном хэвлэхэд зориулсан 300,000 долларын чек хүлээж авлаа” гэж хэлэхэд нь би баярласандаа зочид буудлынхаа тагтан дээр гараад цовхчин хашхирлаа.

Гэтэл манай нэг ажилтан Техасын бизнесмэнтэй алсын хараагаа хуваалцтал, тэр бизнесмэн чек бичиж өгсөн юмсанж. Манай үйлчлэл хорин жил оршин тогтнохдоо хамгийн ихдээ 5,000 долларын чек л хүлээж авч үзсэн юм. Тэгэхээр бидний хувьд энэ үнэхээр гайхамшиг байв! Энэ мөнгөөр 150,000 ном хэвлэж чадна. Энэ чинь бид 2011 оны зорилгынхоо талаас илүү хувийг биелүүлчихлээ гэсэн үг бөгөөд тэр үед дөнгөж хоёрдугаар сартай л золгож байлаа. Тэр утасны дуудлага бидэнд бөөн баяр, эрч хүч хайрлав.

Тэгээд утсаа таслахаасаа өмнө би: “Залуус аа, хоёр долоо хоногийн өмнөх уулзалтан дээр намайг яагаад тийм хатуу үг

хэлснийг одоо та нар ойлгов уу?” гэж асуусанд, надтай нилээд хатуу ам мурийсан захиргааны удирдагч маань инээд алдаад: “Би чамайг “Миний ард гар Сатан аа!” гэж хэлэх нь л гэж бодсон шүү” гэж хэлээд, бид бөөн инээдэм болцгоосон юм.

Тэр өдөр Лиза надад: “Бурхан биднийг боломжтой зүйлийн төлөө биш, боломжгүй зүйлийн төлөө Өөрт нь итгээсэй гэж хүсдэг. Хэрэв бид зорилгоосоо зуураагүй байсан бол, тэр 300,000 долларын чек бидэнд орж ирэхгүй байж” гэж хэлсэн юм. Би ч Лизагийн цэцэн үгтэй санал нийлнэ.

Жил дуусахад 250,000 ном маань дэлхийн 41 орны удирдагч нарын гар дээр очсон байлаа. Энэ ажил манай түншүүдийн дэмжлэг, залбирал, гар бие оролцсон хүн бүрийн хичээл зүтгэлгүйгээр бүтэхгүй байсан. Энэ ажлаас төрсөн гэрчлэлийг бичих гэвэл хэдэн боть болох биз.

Энэ нь манай багийнхны хувьд үнэхээр итгэл байгуулсан үйл явдал болсон юм. Бид тэр олон хүнд туслах үүд нээгдэхийн төлөө тууштай асууж, хайж, тогшсон. Бурхан “Эдүгээ, дотор маань ажилладаг хүчний дагуу гуйх буюу бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар үйлдэх чадвартай” (Ефес 3:20) гэдгийг бид мартаж болохгүй. Бид хүнийхээ хязгаарлагдмал тархинд бодол, итгэлээрээ Бурханыг хязгаарлаж болохгүй. Үнэхээр итгэж байгаа бол, Бурханы алдар илчлэгдэх хүртэл тууштай асуусаар, хайж, тогшоор л байна.

ЮУ ХҮЛЭЭГЭЭВ?

Хаанчлал нь эхлээд сүнслэг талбар дээр тэлж байж л бодит ертөнц дээр тэлдэг. Паул Тимотод: “Итгэлийн сайн тэмцлээр тэмц. Мөнх амийг зуур. Чи үүнд дуудагдсан бөгөөд олон гэрчийн өмнө сайн гэрчлэл хийсэн” (1Тимот 6:12) хэмээн захисан. Мөнх амийг зуурах гэдэг нь Есүсийн хангамжаас тас зуурах явдал бөгөөд үүнийг хагас дутуу зүрх сэтгэлээр хийх боломжгүй. Бурхан хүүхдүүдээсээ яг ийм хичээл зүтгэлийг хүсдэг бөгөөд харуутаа үйл хэрэг болгохоор хөдлөдөг.

Еврей 11:6: “Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм.

Учир нь Бурханд ойртон буй нь Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь (хичээнгүй) хайгчдад Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой” гэдэг. Бурхан Өөрийг нь хааяа нэг хайсан бологчдыг шагнадаг гэж хэлээгүй. Бурхан Өөрийг нь хичээнгүй хайгчдыг шагнадаг юм.

Яг үүнтэй адил Бурхан зөнч Иеремиагаараа дамжуулан:

Учир нь та нарт зориулж байгаа төлөвлөгөөнүүдийг Би мэдэх бөгөөд тэдгээр нь та нарт ирээдүй ба найдварыг өгөх гай гамшгийн бус, сайн сайхны төлөөх төлөвлөгөөнүүд юм» гэж ЭЗЭН тунхаглаж байна. «Та нар Намайг дуудаж, ирж, Над уруу залбирахад Би та нарыг сонсоно. Та нар Намайг хайх бөгөөд бүхий л зүрхээрээ Намайг хайвал олно. Би Та нарт олдоно» гэж ЭЗЭН тунхаглаж байна. «Би та нарын сайн сайхныг сэргээж, та нарыг бүх үндэстэн болон Миний та нарыг зайлуулсан бүх газраас цуглуулах болно» гэж ЭЗЭН тунхаглаж байна. «Та нарыг цөллөгт илгээсэн газраасаа Би та нарыг буцааж авчирна.» (Иеремиа 29:11-14)

Танд хандсан Бурханы төлөвлөгөө хэзээд сайн байдаг. Гэхдээ энэ баялаг хангамжийг хүлээж авахын тулд улайдсан сэтгэлээр тууштай явах хэрэгтэй. Энэ бол жинхэнэ итгэл юм.

Шударга бус шүүгч, эмэгтэй хоёрын сургаалт үлгэрийн төгсгөлд Есүс юу гэж хэлснийг санаж байна уу? “Хүний Хүү ирэхдээ, энэ газар дээрээс итгэлийг олох уу?” гэж асуусан. Аймаар асуулт шүү!

Тэрбээр итгэл шиг итгэлийг олох уу эсвэл газрын, болгоомжилсон, хагас дутуу итгэлийг олох уу? Мессеж Библи дээр “Хүний Хүү эргэж ирэхдээ, газар дээрээс тийм маягийн тууштай итгэлийг аль хэр олох бол?” гэдэг. Есүс уйгагүй мөрдлөгө мөшгилтөөрөө шүүгчийг залхааж, санасандаа хүрсэн тэр эмэгтэйнх шиг итгэлийн талаар өгүүлжээ.

Тиймээс Бурхан дээр очихоосоо бүү ич. Санал хүслээ жижиглэх хэрэггүй. Зоригтой, хүчтэй, тууштай, тодорхой бай. Бурханаас тууштай асуубал, Бурхан залхсандаа биш, харин

■
**Бурхан дээр
очихоосоо бүү ич**
■

биднийг хайрладагтаа Өөрийнх нь нэрээр зоригтой асууж гуйсан зүйлийг маань баталгаатай өгнө.

Тэгэхээр та юу хүлээнэ вэ? Таны эргэн тойронд хязгааргүй хэрэгцээ байна. Бурхан дээр зоригтой очоод, залбирах хэрэгтэй хүмүүс зөндөө байна. Тэдний гэрэл бол! Бурхан дээр очоод, мятрашгүйгээр залбир!

ШАГНАЛЫН ТӨЛӨӨ ГҮЙ

Уралдааны замд гүйгчид бүгд гүйдэг ч нэг нь л шагнал
хүртдэгийг та нар мэдэхгүй гэж үү?

Та нар ялахын тулд гүйцгээ.

1Коринт 9:24

Тэгэхээр та бид хоёр бартаат уралдаанд гүйж яваа ажээ. Хүн бүр ганцаарчлан гүйж явааг 1Коринтын 9:24 хэлжээ.

Гэхдээ бид бие биетэйгээ өрсөлдөөгүй, харин бидний амьдралыг таагүй төгсгөхийн төлөө ажилладаг хүчнүүдтэй өрсөлддөг юм. Та бид хоёр нүгэлт дэлхий дээр амьдарч байгаа учраас, бидэнд эсэргүүцэл зайлшгүй ирнэ. Бид барилдаж байна. Нью Кинг Жэймс Вержн Библи дээр “Шагнал авч чадахын төлөө тийм маягаар гүй” гэсэн байдаг.

Паул “шагнал авч чадахын төлөө тийм маягаар гүй” гэжээ. Бид яаж гүйх ёстой вэ? Бид мятрашгүйгээр гүйх ёстой. Еврей 12:1 дээр “...өмнөө тавигдсан уралдаанд тэвчээртэйгээр гүйцгээе” гэжээ.

Би биеийн тамир спорттой насаараа холбогдсон учраас мэргэжлийн ба сонирхогч маш олон тамирчин найзтай. Мэргэжлийн тамирчид маш хатуу чанга дасгал сургууль хийдэг. Паул “Тэмцээнд өрсөлдөгч бүр бүх талаар биеэ захирах чадварт

өөрийгөө дасгалжуулдаг аж (1Коринт 9:25) гэсэн. Юуны төлөө тэр вэ? Элч үүнд ингэж хариулжээ: “Тэд муудах титэм хүртэхийн төлөө бол, харин бид үл муудах титмийн төлөө юм.”

Америк хөл бөмбөгчний дээд шагнал нь Супер цом юм. Мэргэжлийн гольфчны хувьд ПиЖиЭЙ тэмцээн, Мастерс юмуу өөр нэгэн томоохон тэмцээн байж болно. Хоккейн тамирчны хувьд Стэнли цом, Олимпийн тамирчны хувьд алтан медаль. Тамирчид энэ шагналын төлөө л бэлтгэл сургууль хийдэг. Шагнал авахаар эргэлт буцалтгүй шийдсэн тамирчид нь шагнал авсан ч яахав, аваагүй ч яахав гэсэн санаатай тамирчдаасаа хавьгүй шаргуу бэлтгэдэг.

Би булгалчихсан шагайгаа дэвхийтэл боолгоод үргэлжлүүлэн тоглохоор зүтгэж байгаа хоккейчныг харсан. Шагайгаа булгалсан жирийн хүн гишгэж ч чадахгүй бол, тэр тамирчин гулгасаар байсан. Нармайгаа нээлгэчихсэн атлаа цусаа тогтоолгож аваад үргэлжлүүлэн тоглож байгаа Америк хөл бөмбөгийн тамирчинг би харсан. Супер цомоо л ялж байвал, тэр юу ч үгүй болсон хамар, садрах цус юу ч биш ажээ. Ер нь бид спорт дээр ч, өөр талбар дээр ч ийм явдал болохыг байнга хардаг. Алсын хараа бол хамгийн том хөдөлгүүр юм. Алсын хараатай хүмүүс бусдаас онцгойрдог. Шагнал дээр хараагаа тавьсан хүмүүс л ийм бэрхшээлийг давж гарна.

Тэгвэл өдөр бүр Сатаны хүчирхэг, сүйтгэгч цэргүүдтэй дайтаж байгаа Хаанчлалын хүмүүс бид юуны төлөө байлдаж байгаагаа мэдэх ёстой. Сайн дуусгахын төлөө биднийг хөдөлгөдөг тэр хөдөлгүүр юу вэ? Яагаад эцсээ хүртэл итгэмжтэй байх нь тийм чухал вэ?

Паул энэ бүхнийг тамирчин хүний амьдралаар дүрслэн тайлбарласан юм. Бид шагналын төлөө хөдөлмөрлөдөг: “харин бид үл муудах титмийн төлөө юм.” Элч Иохан насныхаа адаг дээр Бурханы яг адилхан тушаалыг бичсэн байдаг:

Та нар бидний гүйцэлдүүлснийг алдалгүй, харин дүүрэн шагналыг хүлээн авахын тулд өөрсдийгөө хяна. (2Иохан 1:8)

Соломон хараагаа энэ зорилго дээр тавиагүй учраас сайн дуусгаж ч чадаагүй, дээд шагналаа ч авч чадаагүй.

Сайн эхлүүлэх нь чухал боловч, сайн дуусгах нь бүр ч чухал юм. Тэвчээртэй, мятрашгүй хүн л сайн дуусгаж, дээд шагналыг хүлээн авна. Тэгэхээр үүнээс маш чухал нэгэн асуулт төрнө: Бидний алдаж болохгүй хэмээн зүтгээд байгаа тэр шагнал нь юу вэ?

Энэ шагналыг хоёр төвшинд авч үзэж болно. Тэгэхээр энэ бүлгээрээ эхний шагналыг нь үзээд, удаах бүлгээрээ хоёр дахийг нь үзье.

ЭХНИЙ ШАГНАЛ

Эхний шагнал маань бид Бурханы мөнхийн мөнх орших гэрийг барихын төлөө амьдарсан эсэхтэй маань шууд холбогдоно.

Бурхан Өөртөө зориулж сүр жавхлантай гэр барьж байна. Энэ бол хэдэн мянган жилийн тэртээгээс Бурханы амьдран суухыг хүссэн гэр юм. Бурхан ч энэ гэрээ барьж байгаадаа хязгааргүй баярладаг.

Лиза бид хоёрт 1980 оны сүүлээр Флоридагийн Орландод аж төрж байхдаа хувийн байшин бариулах завшаан тохиосон юм. Бидэнтэй мундаг мундаг хувийн байшин барьдгаараа алдартай Роберт гэдэг нэг эрхэм уулзаад: “Би танай үйлчлэлд хайртай. Тиймээс танайд хувийн сууц барьж өгмөөр байна” гэлээ. Тэр үед манайх санхүүгийн хувьд тааруухан байсан учраас түүнийг тэнгэрт тулсан үнэ хэлэх байх гэж айтал, Роберт: “Би үүнийг “Бурханы шагналын” төлөө хийж өгье” гэх нь тэр. Үнэндээ Роберт тэр байшинг барьж өгснийхөө төлөө биднээс нэг ч төгрөгийн ашиг аваагүй юм.

Үүнээс өмнө Лиза бид хоёр 2 ч байшин бариулж үзсэн байлаа. Аль аль нь хямд төсөр, умгар байшин байсан бөгөөд цаанаас нь бүх хар зураг, тогтсон загвар, өнгө материалыг нь гаргаад өгчихсөн учраас бид хоёр өөрсдийнхөө хүсэл санааг нэмэрлэх ямар ч эрхгүй байлаа. Тиймээс мөрөөдлийнхөө байшинг бариулна гэдэг бидний хувьд танил бус зүйл байв.

Роберт манай жижиг байшингийн гал тогооны өрөөнд сууснаа ширээн дээр хоосон цаас гаргаж тавиад, цоглог

дуугаар: “За, мөрөөдлийнхөө байшинг зураарай!” гэж хэлж байсныг би хэзээ ч мартахгүй.

Бид хоёр зог тусав. Ийм юм болно чинээ санасангүй. Гэтэл Лиза маань тэр даруй ажилдаа оров. Яг л өмнө нь маш удаан бодсон юм шиг л зурж гарлаа (Үнэндээ тэгсэн л дээ!) Харин би жаахан удаан зурж, ажлын өрөө, гараж энэ тэрээ тооцоолж, үлдснийг нь гэргийдээ үлдээв. Тэгээд шинэ байраа юунд ч баригдалгүй өөрийнхөө хүссэнээр хийж болохыг ойлгох тусам улам зугаатай, улам догдлом болж байв.

Тэр ганц том цаасан дээр бүдүүн баараг гаргагдан, архитектор дизайнеруудын гараар орж бэлэн болсон бидний мөрөөдлийн байшингийн хар зургийг Роберт Лиза бид хоёрт авчирч үзүүлэх үед ямар догдолмоор байсан гээч. Төдөлгүй барилгачид газраа хагалан, барилгын ажлаа эхлүүлж билээ.

Лиза бид хоёр өдөр бүр барилгын талбай дээр очоод, ажлын явцтай танилцдаг болов. Заримдаа хоёр удаа очно. Бид ихэд догдлон, байшингийн дараагийн үе шатыг тэсэн ядан хүлээнэ. Шинэ байшиндаа нүүж орох гэсэн хүсэл догдлолоос минь болоод тэр хэдэн сар яг л хэдэн жил шиг, харин өдөр хоног нь яг л сарууд шиг удаан санагдаж байлаа. Хуудас цаасан дээр сараачсан мөрөөдөл маань нүдний маань өмнө цогцлон босохыг харах итгэхийн аргагүй гайхамшигтай байв!

Бурхан ч мөрөөдлийнхөө гэрийг барихдаа яг л бид хоёр шиг догдлон баярладаг гэдэгт би итгэдэг. Гэхдээ Бурхан хэдэн сар биш, хавьгүй удаан хүлээж байна. Үнэндээ Бурхан дэлхийн суурь тавигдсан цагаас л үүнийхээ биелэлийг харуулдан хүлээж байна.

Хүмүүс бид онцгой байшин бүрт нэр өгдөг. Жишээлбэл Английн хатан хааны гэрийг Буркингхамын Ордон гэнэ. Америкийн ерөнхийлөгчийн гэрийг Цагаан ордон гэнэ. Жүжигчин Майкл Дугласын Бермуд дахь гэрийг Лонлэйндс гэнэ. Битлзийн гишүүн Жорж Харрисон агсны гэрийг Фриар Парк гэнэ. Николас Кэйжийн гэрийг Мидфорд Кэстл гэнэ. Гэхдээ байшинд нэр өгөх трэндийг биднээс аль эртүү Бурхан эхлүүлснийг бид мэддэггүй. Тэрбээр яг одоо баригдаж байгаа мөнхийн гэрээ Сион гэдэг. Дуулал 132:13-14 дээр:

Учир нь ЭЗЭН Сионыг сонгож,
 Орших газраа хэмээн Түүнийг хүсэв.
 “Мөнхөд амрах газар минь энэ болой.
 Үүнийг хүссэн тул
 Би энд амьдран сууна.
 (Дуулал 132:13-14)

Лиза бид хоёр шинэ байшингаа тэсэн ядан хүлээж байсан шиг Бурхан ч бас гэрээ тэсэн ядан хүлээж байна. Сион гэдэг тэр гэр нь үеийн үед Бурханы зүрхэнд байсныг бичээс хэлжээ: “Учир нь ЭЗЭН Сионыг босгон байгуулж, Цог жавхлангийнхаа дунд үзэгдэнэ” (Дуулал 102:16); “Сионд оршигч ЭЗЭНд Магтаалыг дуулагтун. Түүний үйлсийг хүмүүсийн дунд зарлагт” (Дуулал 9:11); “Үзэсгэлэнгийн дээд болох Сионоос Бурхан гэрлээ цацруулж байна” (Дуулал 50:2).

Хүн байшин барихдаа сууриасаа эхлэдэг. Исаиа: “Тиймээс Эзэн БУРХАН “Үзэгтүн. Би Сионд нэгэн чулууг, Шалгагдсан, үнэт, бат суурилуулсан суурийн булан чулууг тавина. Түүнд итгэгч нь үл тэвдэнэ” (Исаиа 28:16) гэжээ. Тэгэхээр тэр суурийн булангийн чулуу нь юу (тодруулбал хэн) бэ? Тэр булан чулуу нь Бурханы хайртай Хүү Есүс Христээс өөр хэн ч биш юм. Исаиагийн үгээс үзбэл, Есүс бол Бурханы мөнхийн гэр Сионы барилгын материалын нэг хэсэг ажээ. Үнэндээ Есүс Бурханы гэрийн булан чулуу учраас хамгийн чухал хэсэг нь юм.

1Петр 2:5 дээр: “Иймд амьд чулуу мэт болсон та нар ч Есүс Христээр дамжуулан Бурханд тааламжит, сүнслэг тахилуудыг өргөх ариун тахилч болохын тулд сүнслэг байшин болон баригдагтун” гэжээ. Петрийн ярьж буй гэр нь мэдээж Сион юм. Есүс биднийг чулуутай зүйрлэжээ. Бид “амьд чулуу”, Есүс булангийн чулуу бөгөөд харин итгэгчид бүгдээрээ Есүстэй хамт Бурханы мөнхөд орших гэрийг цогцлоох барилгын материал юм.

Тийм бол та нар цаашид гаднынхан болон ирмэл хүн бус, харин ариун хүмүүсийн адил нутгийн иргэд бөгөөд Бурханы гэр бүлийнх юм. Та нар элч нар болон эш үзүүлэгчдийн суурин дээр босгогдож байгаа бөгөөд Христ Есүс Өөрөө

булангийн чулуу нь ажээ. Түүний дотор бүх барилга холбогдон Эзэн доторх ариун сүм болохоор өсөж байна. Та нар ч гэсэн Сүнс дотор Бурханы орших газар болохоор Христ дотор хамтдаа байгуулагдаж байна. (Ефес 2:19-22)

Биднийг гэрийн барилгын материал гээд зогсохгүй бас барилгачид гэжээ (1Коринт 3:9). Орчин цагийнхаар бол “гүйцэтгэгч нар” юм. Гүйцэтгэгч гэж хэн бэ? Сангийнхан, цахилгаанчин, цутгагч, хана босгогч, дээвэрлэгч, плита наагч, тоосго өрөгч, шаллагч нар юм. Энэ хүмүүс байшинг барьдаг. Роберт манай байшинг барихдаа ширхэг ч хадаас хадаагүй, тоосго өрөөгүй, мод хөрөөдөөгүй. Үүнийг гүйцэтгэгч нар л хийсэн.

Тэгвэл яг барилга барьдаг хүмүүс нь гүйцэтгэгч нар юм бол, барилгачид нь юу хийдэг юм бэ? Тэд гурван талт ажил хийнэ. Нэгдүгээрт - барилгачид байшингийн загварыг гаргана.

**Сайн эхлүүлэх нь
чухал боловч, сайн
дуусгах нь бүр ч
чухал юм.**

Бурхан байшингийнхаа мастер төлөвлөгөөг эрт дээр гаргажээ. Элч Паул “Түүний өмнө биднийг хайр дор ариун бөгөөд гэм зэмгүй байхын төлөө Бурхан ертөнцийн сууриас урьд биднийг Христ

дотор сонгосон юм” (Ефес 1:4) гэжээ. Мөн Еврей ном бидэнд “Түүний ажлууд дэлхийн сууриас дууссан” (Еврей 4:3) гэдэг. Бурханы гэр Адамыг бүтээгдэхээс ч өмнө төгс төлөвлөгдсөн байжээ. Ёстой гайхмаар!

Хоёрдугаарт - барилгачин байшинд хэрэгтэй материалыг захиалдаг. Бурхан биднийг захиалж авсан гэхээр баярламаар байгаа биз дээ? Тэрбээр: “Эхийн хэвлийд чамайг бүрэлдүүлэхээсээ өмнө Би чамайг мэдэж байсан. Төрөхөөс чинь өмнө Би чамайг ариусгаж, Үндэстнүүдэд эш үзүүлэгч болгон чамайг томилсон” (Иеремиа 1:5) гэдэг. Паул ч мөн “Түүний өмнө биднийг хайр дор ариун бөгөөд гэм зэмгүй байхын төлөө Бурхан ертөнцийн сууриас урьд биднийг Христ дотор сонгосон юм” (Ефес 1:4) гэжээ.

Барилгачны гурав дахь үүрэг хариуцлага нь гүйцэтгэгч нарын ажлыг хуваарилан зохицуулах юм. Энэ бол төслийн хамгийн чухал хэсэг. Учир нь сан юмуу цахилгааны ажлаас өмнө гипсэн ханаа босгочихож болохгүй. Дээвэр, будгийн ажлаас өмнө шалаа угсарч болохгүй. Гүйцэтгэгч нарыг зөв дарааллаар хуваарилахгүй бол, эмх замбараагүй байдал үүснэ.

Орчин үеийн барилгын бүтцэд “ахлах гүйцэтгэгч” гэж байдаггүй ч, Бурханы барилгын ажилд бол байна аа. Бурханы захиалгын гэрийг барьж буй ахлах гүйцэтгэгч нь хэн гэж бодож байна? Тийм ээ, зөв - Есүс Христ! Галаг 4:4 дээр “Харин цаг нь болоход эмэгтэй хүнээс хуулийн дор төрөх Хүүг Бурхан илгээсэн юм” гэдэг. Барилгачин Бурхан Сионы барилгын ажлын яг “зөв цагт” Есүсийг булан чулуу, ахлах гүйцэтгэгч байхаар илгээжээ.

Ахлах гүйцэтгэгч Есүс маань даалгавраа төгс гүйцэтгэн, онцсайн дуусгасан! Сүүлийн зоог дээр Есүс Аавдаа даруу бөгөөд итгэлтэйгээр “Хий гэж Надад өгсөн ажлыг тань гүйцэтгэн Би Таныг газар дээр алдаршуулав” (Иохан 17:4) гэж хэлж чадсан. Есүс Сионыг барих ахлах гүйцэтгэгчийнхээ ажлыг онц дуусгажээ.

Тэгвэл та бид хоёр яаж байна? Бурхан Өөрийнх нь гэрийг барилцах гүйцэтгэгч болох бидний үүргийн талаар юу хэлсэн?

“Учир нь бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн Түүний бүтээл мөн” (Ефес 2:10). Бид “сайн үйлс хийхээр” Христийн дотор бүтээгдсэн гэж буйг тэмдэглээрэй. Өөрөөр хэлбэл бид зүгээр л хэн нэгэн байхаар биш, харин ямар нэг зүйл хийхээр Христийн дотор бүтээгдсэн. Одоо анхаараарай: Сүүлийн үед Христийн бие дотор энэ талаар тэнцвэргүй сургааль их заагдах болсон. Сүүлийн үед итгэгчид бид Христийн дотор хэн болохоо хүчтэй хүчтэй мэдэгддэг болсон. Энэ ч чухал. Гэхдээ бид Христийн дотор хэн болох дээрээ хэт анхаарахдаа, Христийн дотор юу хийхээр бүтээгдсэнээ умартжээ. Энэ тэнцвэргүй байдлаас хоёр том асуудал үүсдэг.

Нэгдүгээрт - бид сайхан амьдралтай хөөцөлдөж, сүүлийн үеийн техник, байр сав худалдан авч, үр хүүхдийнхээ ирээдүй,

боловсролын төлөө хурааж, тэтгэвэртээ зориулж өндөг дардаг болсон. Бид Бурханаас хувьчлан хүлээж авсан захирамжаа биелүүлэхийн оронд амьдрал хөөдөг болсон. Бидэнд дуусгах ёстой “мөнхийн ажил” байгааг бид мартжээ.

Бодоод үз: Паул явах замаа мэдээгүй бол “Би сайн тэмцлээр тэмцсэн, замаа дуусгасан, итгэлээ сахисан” (2Тимот 4:7) гэж хэлж чадахгүй байх байсан. Би тайлбарлая. Холын зайнд гүйдэг тамирчид тэмцээний өмнө туулах замынхаа газрын зурагтай танилцдаг. Та холын зайнд гүйхдээ төлөвлөгөөт замаа мэдэхгүй бол, зүгээр л ухаан жолоогүй гүйсээр байгаад, хаа нэг газар бахардаж унаад, багийнхан чинь таныг дамжилж харих байх. Та замаа дуусгаж чадсан эсэхээ ч мэдэхгүй. Төлөвлөгөөт замаа мэдэж, гүйж дуусгасан хүн л замаа дуусгаж чадлаа гэж хэлж чадна.

Тэгвэл амьдралын өдөр тутмын аахар шаахар юмст хамаг ухаанаа өгсөн хүн яаж тэмцээнээ дуусгах билээ? Бурхантай долоо хоногийн Бүтэн сайнд л хальт холбогдож байгаа хүмүүс чинь яаж Бурханы ажил үйлсийг мэдэх билээ? Өдөр бүр Бурханыг хичээнгүйлэн хайхгүй байж, яаж Бурханы төлөвлөгөөг мэдэх билээ?

Хийх зүйл дээрээ биш, хэн гэдэг дээрээ анхаарсан тэнцвэргүй мэдэгдлээс үүссэн хоёр дахь уршиг нь итгэгчид “бүтэн цагаар үйлчилдэг хүмүүсийг л Бурхан дууддаг” гэж үздэг болжээ. Энэ бол дэмийрэл! Бурханы хүүхэд бүр, эр эм, хөгшин залуугаасаа үл хамааран бүгд тэнгэрлэг дуудлага хүлээж авсан бөгөөд Бурханы гэрийг барилцах итгэмжтэй гүйцэтгэгч байх ёстой юм. Үүнийг Ефес 2:10 дээр ч хэлдэг: “Учир нь бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн Түүний бүтээл мөн. Биднийг эдгээрийн дотор яваасай гэж Бурхан урьдаас бэлтгэсэн билээ.”

Бурхан таныг Өөрийнхөө мөнхийн гэр Сионыг барилцах гүйцэтгэгчээр томилжээ. Гэхдээ Бурханы гэр нь тоосго, цемент, мод, төмрөөр барьдаг байшин биш, харин хааны охид хөвгүүдэд зориулагдсан, хүний гараар баригдаагүй амьд гэр юм. Та Бурханы гэрийн ажилд өөрийнхөө оруулах хувь нэмрийг бүрэн гүйцэт харж чадахгүй байж мэдэх. Гэхдээ

үүнийг чинь мастер барилгачин болох Бурхан харж байгаа. Бурханы гэр баригдаж дуусах хожмын тэр өдөр л бидний хувь нэмэр утга төгс болж, бид Бурхантайгаа хамт оршихуйд нь мөнхийн мөнхөд амьдарна.

Роберт манай байшингийн гүйцэтгэгч нарыг хуваарилахдаа, бүгдэд нь байшингийн хар зураг, схем зургийг өгсөн юм. Роберт тэдэнд чухам юу барих гэж байгаагаа харуулжээ. Роберт ерөнхий төлөвлөгөөг мэдэж байсан бол, гүйцэтгэгч нар өөр өөрийнхөө хэсгийг л мэдэж, өөр өөрийнхөө хэсгийг л хийх ёстой байв. Тэд барилгын талбай дээр ирээд хүссэнээ юмуу харснаа хийж болохгүй. Тэд Робертын гаргаж өгсөн төлөвлөгөөг л дагах үүрэгтэй байв.

Бурхан та бид хоёрт зориулж “Есүс Христэд итгэж байгаа хүн бүрт зориулсан хамгийн сайн замыг гаргажээ” (Ефес 2:10). Манай байшинг барьсан гүйцэтгэгч нарын нэгэн адил Бурханы мөнхийн гэрийг барьж байгаа хүн бүр өөрийн гэсэн тодорхой үүрэг оройл хүлээдэг. Эдгээрийн аль нь ч нөгөөгөөсөө илүү юмуу дутуу биш. Бурхан гэрээ яг л Өөрийнхөө төлөвлөснөөр барьдаг бөгөөд энэ ажилд оролцож байгаа хүн бүр хүлээсэн ажил үүргээ онц хариуцлагатай хийх ёстой.

БАРИЛГАЧДЫН ШАГНАЛ БА ГАРЗ

Бичээс ямар учраас биднийг барилгачид гэснийг одоо та ойлгосон байх. Дуулал номд “Барилгачдын голсон чулуу Булангийн тулгуур чулуу болов” (Дуулал 118:22) гэдэг. Петр ч итгэгчдийг Бурханы гэрийн чулуу гэсэн. Гэвч Петр биднийг Христийн дотор хэн болохыг маань хэлснийхээ дараа барилгын гүйцэтгэгч нартай зүйрлэн, юу хийхээр дуудагдсныг маань хэлжээ: “Иймд амьд чулуу мэт болсон та нар ч Есүс Христээр дамжуулан Бурханд тааламжит, сүнслэг тахилуудыг өргөх ариун тахилч болохын тулд сүнслэг байшин болон баригдагтун. ...Тиймээс итгэгч та нарт энэ нь үнэт, харин үл итгэгчдэд “Барилгачдын голсон чулуу нь булангийн чулуу болов (1Петр 2:5, 7).

Итгэмжтэй, жинхэнэ гүйцэтгэгч нар нь Бурханы гэрийг барилцаж байхад, Үгийг (Бурханы хар зураг, загварыг) дагадаггүй хэсэг нь Бурханы эцсийн зорилгын эсрэг ажилладгийг Петр хэлжээ.

Үүнийг санангаа, элч Паулын өгүүлсэн үйл явцсын дүрслэл ба шагналыг үзье:

Таригч, услагч нь нэг юм. Тэд тусбүрдээ зүдэл зүтгэлийнхээ дагуу шагналаа авах болно. Учир нь бид Бурханы хамтран зүтгэгчид бөгөөд та нар Бурханы тариан талбай, Бурханы барилга мөн. Надад өгөгдсөн Бурханы нигүүлслийн дагуу би мэргэн барилгачин мэт суурь тавьсан бөгөөд өөр нэгэн түүн дээр барьж байна. Гэхдээ түүн дээр яаж барихаа хүн бүр анхаарагтун. Учир нь тавигдсан суурь болох Есүс Христээс өөр суурийг хэн ч тавьж чадахгүй. (1Коринт 3:8-11)

Нэн түрүүнд Бурханы шагналын талаар өгүүлсэн эхний өгүүлбэрийг харна уу.

Паул суурийг тавьсан. Тэрбээр энэ захидлаа 2000 гаруй жилийн тэртээ бичсэн хэдий ч, энэ нь өнөөдөр ч бидний Христийн доторх амьдралын маань бат бөх суурь болсоор байна. Флоридагийн байшингийн маань хамгийн эхний ажлыг суурь цутгагч нар гүйцэтгэсэн юм. Тэднийг ажлаа дуусгасны дараагаар л дараа дараагийн гүйцэтгэгч нар ажлаа хийж билээ.

Паул цааш нь: “Хэрэв хэн нэгэн энэ суурин дээр алт, мөнгө, эрдэнийн чулуу, мод, өвс болон сүрлээр баривал...” (3:12) гэжээ. Библи мөнхийн зүйлсийг алт, мөнгө, үнэт чулуугаар зүйрлүүлж ярьдаг бол, зуурдын юмсыг мод, өвс, дэрсээр төлөөлж ярьдаг. Бид амьдралынхаа алхам тутамд сонголт хийдэг. Бид нэг бол мөнхийн амьдралын төлөө барьдаг эсвэл зуурдын амьдралын төлөө барьдаг. Мөнгөтэй болох, нэр хүнд олох гэж хүмүүст туслах, амжилтын шагаар ахих гэх зэрэг амин хувийнхаа төлөө амьдарч байгаа бол, бид зуурдын настай л юм босгож байна. Харин гачигдаж дутагдсан хүмүүст Бурханы мөнхийн Үг, хангамжийг авчирч, Бурханы хаанчлал, гэрийг барихын төлөө амьдарч байгаа байвал, бид мөнхийн зүйлийн төлөө барьж байна.

Паул цааш нь “... ажил болгон нь илэрхий болно. Учир нь мөнөөх өдөр үүнийг харуулна. Юу гэвээс энэ нь галаар илчлэгдэх ба гал нь хүн бүрийн ажлын чанарыг шалгах болно” (3:13) гэжээ.

Гал бидний ажлыг шалгахаас гадна үүний цаадах санаа сэдлийг маань ч шалгана (1Коринт 4:5). Мод, өвс, дэрс үтэр түргэн шатаж дуусдаг. Алт, мөнгө, үнэт чулууг шатаахад, тэдгээр нь улам л шижир, үзэсгэлэнтэй болдог. Шалгагдаж цэвэршдэг гэсэн үг. Тэгээд эцэст нь: “Хэрэв хэн нэгний үүн дээр барьсан ажил нь үлдвэл тэрээр шагналаа хүлээн авна. Хэрэв хэн нэгний ажил шатвал тэрээр хохирол амсана. Тэр өөрөө гал дундуур гарсан мэт боловч аврагдана” (3:14-15).

Ажлаа сайн дуусгасан гүйцэтгэгч л шагнал авна гэснийг анхаараарай! Харин та Бурханы Үгээс гадуур ажил хийж, амиа хичээсэн, дуулгаваргүй, бардам санаа сэдэлтэй байсан бол, ажил чинь үнс болно. Христ доторх итгэгчийнхээ хувьд та тэнгэрт орох нь орох боловч, ажил хөдөлмөр чинь талаар болж, та шагнал авахгүй. Хатуу анхааруулга шүү!

Энэ аугаа хэсгийг ухах явцдаа, Паул хувь хүнд биш, харин бүхэл чуулганд хандаж хэлснийг тэмдэглээрэй:

Та нар өөрсдөө Бурханы сүм бөгөөд Бурханы Сүнс та нарын дотор оршдог гэдгийг мэддэггүй юм уу? Хэрэв хэн нэг нь Бурханы сүмийг устгавал Бурхан тэр хүнийг устгана. Учир нь Бурханы сүм бол ариун бөгөөд энэ нь та нар мөн. Хэн ч өөрийгөө бүү мэхлэг. Хэрэв та нарын дунд хэн нэг нь энэ үед өөрийгөө мэргэн гэж боддог бол тэр нь мэргэн болохын тулд мунхаг болог (3:16-18).

Бас л хүчтэй үг шүү! Бурханы гэрт буюу Христийн сүйт бүсгүйд буруу хандаж, буруу удирдахыг санаархсан хүн бүр энэ үгээс эмээх учиртай. Энэ нь Бурханы гэрийн хамгийн жижиг “тоосгонд” буюу бидний хэлдгээр “ариун хүмүүсийн хамгийн өчүүхэнд” нь ч буруу хандаж болохгүйг хатуу анхааруулсан үг юм.

ГҮЙЦЭТГЭГЧИЙН ШАГНАЛ

Паул эцэст нь “Хэн ч өөрийгөө бүү мэхлэг. Хэрэв та нарын дунд хэн нэг нь энэ үед өөрийгөө мэргэн гэж боддог бол тэр нь мэргэн болохын тулд мунхаг болог” (3:18) хэмээн дүгнэжээ. Харамсалтай нь амиа хоохойлсноосоо болоод хүчтэй дуусгаж чаддаггүй итгэгчид байдаг. Тэд Бурханы алдрын төлөө Бурханы гэрийг барих ажлаа орхиж, замхрах алдар, хүний болоод дэлхийн нэг л өдөр шатаж үгүйрэх таалалтай хөөцөлджээ.

Бүү мэхлэгд! Христийн дотор хийх ажил үүрэг дээрээ төвлөр. Таны ажил Бурханы гаргасан загварын дагуу гүйцэтгэгдэх ёстой. Эс бөгөөс та халагдаж, таны орыг өөр хүн залгана. Бурхан бидэнд хатуу анхааруулсан:

Надад өгөгдсөн Бурханы нигүүлслийн дагуу би мэргэн барилгачин мэт суурь тавьсан бөгөөд өөр нэгэн түүн дээр барьж байна. Гэхдээ түүн дээр яаж барихаа хүн бүр анхаарагтун. Учир нь тавигдсан суурь болох Есүс Христээс өөр суурийг хэн ч тавьж чадахгүй. Хэрэв хэн нэгэн энэ суурин дээр алт, мөнгө, эрдэнийн чулуу, мод, өвс болон сүрлээр баривал ажил болгон нь илэрхий болно. Учир нь мөнөөх өдөр үүнийг харуулна. Юу гэвээс энэ нь галаар илчлэгдэх ба гал нь хүн бүрийн ажлын чанарыг шалгах болно.

Хэрэв хэн нэгний үүн дээр барьсан ажил нь үлдвэл тэрээр шагналаа хүлээн авна. Хэрэв хэн нэгний ажил шатвал тэрээр хохирол амсана. Тэр өөрөө гал дундуур гарсан мэт боловч аврагдана (1Коринт 3:10-15).

Хэрэв бидний ажил Бурханы шалгалтад тэнцэхгүй бол, “барилгын тэр хэсгийг дахин нурааж, дахин эхлүүлнэ.” Харин үүнийг хүсэх хүн байхгүй л болов уу - ялангуяа ертөнцийн Бүтээгчийн төлөө хийсэн ажлаа!

Манай байшинг барьсан нэг гүйцэтгэгч яг ийм алдаа гаргасныг би сайн санаж байна. Тэрбээр Робертын өгсөн хар зургийн дагуу ажлаа гүйцэтгээгүй юм. Лиза бид хоёр барилгын талбай дээр өдөр бүр очиж байсан учраас, асуудлыг хамгийн

түрүүнд анзаараад, Роберттой барилга дээр уулзаж байгаад хэлсэнд, Роберт асар уурлав. Тэр гүйцэтгэгч Робертын байнгын түнш байгаагүй учраас Роберт түүнийг тэр даруй халсан юм. Тэр хүн шагналаа алдсан. Тэрбээр цалингаа алдаад зогсохгүй, манай сайхан байшинг барилцах завшаанаа алдсан юм.

Роберт тэр хүний хийсэн ажлыг нураахыг би хоёр нүдээрээ харсан. Дараа нь Роберт шинэ гүйцэтгэгч хөлслөн, тэр нь яг Робертын өгсөн хар зургийн дагуу ажлаа гүйцэтгэсэн юм. Тэр хүн шагналаа бүрэн бүтнээр нь авсан - цалингаа ч авсан, тийм сайхан байшин барихад хувь нэмрээ оруулсан гэдэг нэр хүнд, сэтгэл ханамжийг ч авсан юм.

Бурханы гэрийн барилгын ажил яг ийм зарчмаар өрнөдөг. Зарим хүмүүсийн нэг насаараа бөөн сүр дуулиан болж байж хийсэн ажил нь галд тэсэхгүй учраас Бурханы мөнхийн гэрийн нэг хэсэг болж чадахгүй, нураагдах ажээ.

Ингэж дүрслэе. Би өдөр бүр байшингийнхаа явцтай танилцдаг байсан болохоор байшингийн маань гүйцэтгэгч нар ч намайг сайн мэддэг болов. Тэд намайг “номлогч” гэж дуудна. Өдөр бүр ирээд машинаасаа буухад, тэдний асид рок тэр хавийг доргиож байдаг байлаа. Тэгээд намайг ирж явааг хармагцаа хэн нэг нь өсгөгч дээрээ гүйж очоод унтраачихна. Тэд Бурханы юмст хамаагүй хандалгүй, хүндэтгэж байгааг нь харах үнэхээр баярламаар байв. Би тэдгээр залуустай сайхан ярилцахаар барахгүй, заримдаа тэдэнд үйлчлэх ч боломж олддог байв.

Нэгэн удаа гүйцэтгэгч нар маань ямар ямар мундаг барилгын ажилд оролцож явснаа нүдэнд нь гал асан, ам уралдан ярьж билээ. Тийм сүр жавхлант ажлын нэг хэсэг байх нь ер бусын сэтгэл ханамж авчирдаг ажээ.

Тухайлбал Вашингтон Ди Си дэхь Цагаан ордныг барьсан гүйцэтгэгч нарт ямар байдгийг төсөөлж байна уу? Хүүхдүүд нь сургуулиасаа тарж ирээд, улсынхаа хамгийн алдартай барилгыг үзэхээр сургуулиараа аялах болсноо аавдаа хэлэх үед тэр барилгыг барилцаж явсан гэдгээ хүүдээ хэлэх аавын хөөр бахархлыг төсөөлж байна уу? Хүүгийнхээ ангийнхантай хамт Цагаан ордны босгоор алхаж орох тэр аавын сэтгэл мэдрэмжийг төсөөлж байна уу? Америкийн Нэгдсэн Улсын

ерөнхийлөгчийн аж төрдөг ордныг аав нь барилцсан гэдгийг ангийнхандаа хэлэх хүүхдэд ямар баяр бахдалтай байх бол?

Бурханы гэрийг барих нь яг үүнтэй адил юм. Бид хэдхэн зуун жилийн дотор нураагаад дахин баригдах зуурдын байшин дээр ажиллаагүй. Бид мөнхийн мөнхөд даяар ертөнцийн төв цэг байх байшинг барьж байна. Зөнч Мика ингэж хэлжээ:

Эцсийн өдрүүдэд ЭЗЭНий өргөөний уул нь Уулсын тэргүүнээр тохоогдон, Толгодын дээгүүр өргөгдөнө. Ард түмнүүд түүнд цутгана. Олон үндэстэн ирээд, “Ирцгээ, ЭЗЭНий уул, Иаковын Бурханы өргөө уруу явцгаая. Тийнхүү Тэрээр бидэнд замаа зааж, Бид жимээр нь алхах юм” гэгцгээнэ. Учир нь хууль Сионоос гарч, ЭЗЭНий үг Иерусалимаас гарна. (Мика 4:1-2)

Ертөнцийн бүх хэрэг явдал энэ гэрийг л тойрон өрнөнө. Бүх бүтээлийг засаглах цэц ухааны хууль энэ гэрээс л ундарна. Тэгээд хамгийн гайхамшигтай нь Бурханы гэр Сион нь одоогоос арван триллион жилийн дараа ч анх баригдсан шигээ л үзэсгэлэн төгөлдөр оршино.

Бурханд эцсээ хүртэл итгэмжтэй үйлчилсэн сайн мэдээний нэгэн аугаа үйлчлэгчийг би мэднэ. Тэрбээр жар гаруй жил итгэмжтэй үйлчлээд, шинэ мянганы босгон дээр шагналаа авахаар Эзэн рүүгээ явсан юм. Түүнээс жил гаруйн дараа дараа би Мидвестийн нэгэн том чуулганд зочилтол, магтаалын удирдагч нь надад Бурхан түүнд маш тод зүүд өгснийг хуучлав. Тэрбээр зүүдэндээ тэнгэрт очоод, нөгөө амьдралаа сайн дуусгасан үйлчлэгчийг харжээ. Мөнөөх үйлчлэгч нүүр дүүрэн инээмсэглээд, магтаалын удирдагчид: “Энд миний бодсоноос хавьгүй сайхан юм” гэж хэлжээ. Тэд хэдхэн минут ярилцаад дараа нь үйлчлэгч эргэж хараад, Сионыг босголцоход хувь нэмрээ оруулсан хэсгээ заатал, тэр нь маш том ажил байжээ. Тэр хүний итгэмжтэй үйлчлэлийн нөлөө нь дэлхийд байхдаа бодож мөрөөдөж байснаас нь хавьгүй том, хавьгүй хол нөлөөтэй байснаас гадна нүднийх нь өмнө бодитой харагдаж байжээ. Тэрбээр яг л мөнөөх барилгачид шиг “Энэ миний

хийсэн ажил” гэж хэлж чаджээ. Мундаг шагнал байгаа биз!

Та өнө мөнхлөлд очоод үр удам, үндэстнүүд, үй түмэн хүмүүст Бурханы сүр жавхлант гэрийн ажилд өөрийнхөө гүйцэтгэсэн ажлыг зааж харуулж байна гээд бод доо.

Сүрдмээр байгаа биз? Энэ шагналын төлөө зүтгэхэд харамсахгүй! Энэ шагналын төлөө сайн дуусгах хэрэгтэй!

Нөгөөтэйгүүр, сайн дуусгаж чадаагүй учраас Бурханы Сион гэрт хийж бүтээсэн юмгүй сууж байвал яах уу? Та хамаг ажлаа нураалгаад түүнийг чинь өөр итгэмжтэй хүн дахин хийж гүйцэтгэсэн учраас өвөг дээдэс, үр удамдаа харуулах юу ч үгүй сууж байвал яах уу? Энэ нь мөнхийн гарз болохыг 1Коринт 3 дээр Паул хэлсэн.

Ариун нэгэн минь, би танд ийм хувь тавилан хүсэхгүй

Үүнийг Бурхан ч хүсэхгүй. Гэхдээ ийм явдал олон итгэгч нарт тохиолдоно. Гэхдээ таныг ийм хувь тавилан угтах эсэхийг та яг одоо өөрөө шийднэ. Иоханы үгийг анхааралтай уншина уу: Та нар бидний гүйцэлдүүлснийг алдалгүй, харин дүүрэн шагналыг хүлээн авахын тулд өөрсдийгөө хяна (2Иохан 8).

Эзэн Өөрийнхөө хүүхэд бүрт Өөрийнх нь мөнхийн гэрийг барилцсныхаа төлөө шагналаа бүрэн бүтнээр нь хүлээж авах боломж, арга замыг бэлтгэдэг. Таны хөдөлмөр хэзээ ч талаар болохгүй, хуучрахгүй, орлуулагдах албагүй. Таны ажлыг мөнхийн мөнхөд тэрбум тэрбум хүн, тэнгэрэлч нар биширнэ.

Гэхдээ энэ нь Эзэндээ дуулгавартай бөгөөд итгэмжтэй байсныхаа төлөө хүлээж авах эхний л шагнал юм. Үүнээс гадна өөр нэг шагнал байдаг бөгөөд энэ талаар дараагийн бүлэгт үзье.

ХААНД ОЙРХОН

Та нар бидний гүйцэлдүүлснийг алдалгүй, харин дүүрэн шагналыг хүлээн авахын тулд өөрсдийгөө хяна.

2Иохан 8

Дайсагнал заавал ирнэ. Зөв шалтгаан бидэнд үргэлжлүүлэн гүйх хүч өгдөг бол, зорилгогүй хүмүүс нь бүдэрч унахаар барахгүй уралдаанаасаа гардаг. Сайн дуусгахад зорилго маш чухал юм.

Эхний шагнал нь Бурханд зориулан барьж байгаа гэрт оруулсан хүч хөдөлмөрөө үүрд мөнхөд гэрчлэн харж, энэ ажлаа Эзэнийхээ “Сайн байна” гэдэг үгээр мялаалгах шагнал бол, хоёр дахь шагнал нь биднийг мөнхийн мөнхөд Есүст аль зэрэг ойр амьдрахыг маань шийднэ.

ХААНТАЙ ОЙР БАЙХ

Энэ олон жил дэлхийгээр аялж, газар газрын итгэгчидтэй уулзаж учирсан туршлагаасаа харж байхад, Барууны итгэгчид Бурханыг “социалист Бурхан” гэж үздэг юм шиг байдаг. Олон итгэгчид Бурханыг бүгдийг эн тэнцүүхэн шагнаж, шинэ тэнгэр, шинэ газарт бидэнд бүгдэд нь тэгш эрх мэдэл, үүрэг хариуцлага, хүндэтгэл олгох юм шиг санадаг. Гэхдээ Бурхан авралаа л бидний ажил үйлсээс хамааралгүй, эн тэгш олгосон

болохоос биш, бидний итгэмжтэй байдлыг Өөрийнх нь үгийг хэр зэрэг дуулгавартай дагаж, тэсч, Үгээр нь амьдарснаар маань шагнана гэдгийг тэд мэддэггүй.

Энэ шагнал нь өмнөх бүлэгт үзсэн шагналаас ч аугаа юм. Энэ шагнал биднийг Есүстэй мөнхийн мөнхөд хэр зэрэг ойрхон амьдрахыг маань шийднэ. Хайрлаж биширдэг Хүнтэйгээ ойр дотно байх шиг гайхамшиг үгүй. Бичээс ч үүнийг дүгнэн нотлодог. “Хургыг явсан газар бүрийд нь дагах” завшаан ялагч нарт өгөгдсөн байна (Илчлэл 14:4). Мөнхийн мөнхөд Есүсийн бараа бологч болно гэдэг ямар аугаа завшаан, хүндэтгэл вэ!

Энэ үнэнийг Сайн мэдээнээс ч тодорхой харж болно. Есүс газар дээрх үйлчлэлээ төгсгөх дөхөж байтал хоёр дагалдагчийнх нь ээж нь Есүсээс: “Миний хоёр хүү Таны хаанчлалын хамгийн өндөр байр сууринд заларч, нэг нь Таны баруун гарт, нөгөө нь Таны зүүн гарт сууна гэж амлаач” хэмээн шаардсан байдаг (Матай 20:21).

Мэдээж Аавынхаа баруун гарт заларсан Есүсийн дэргэд суухаас илүү үнэ хүндтэй суудал байхгүй! Библи Бурханы сэнтийд маш ойрхон үйлчилдэг серафим нэртэй хүчирхэг тэнгэрэлч нарын тухай ярьдаг (Исаиа 6:1-6). Тэд зогсоо зайгүй өөр хоорондоо “Эзэн бол ариун, ариун, ариун!” хэмээн дуу дуугаа авалцан тунхаглан зарладаг. Яг энэ үгээр зохиосон магтуу дуулал ч байдаг. Гэхдээ тэнгэрэлч нар Бурханд Өөрийнх нь талаар сайхан мэдрэмж төрүүлэх гэж дуулаагүй, харин харсан зүйлээ магтахгүй байхын аргагүй учраас тийнхүү магтан дуулж буй ажээ. Тэнгэрэлч нар Бурханы аугаа чанарын илчлэлийг бишрээд “Ариун, ариун, ариун!” гэхээс өөр юу ч хэлж чадаагүй. Үнэндээ тэдний гүнээс ундрах чин үнэн дуунд тэнгэрт буй тэрбум тэрбум тэнгэрэлч, ариун хүмүүсийн сууж байсан хаалганы босгоны суурь нь доргиж байжээ.

Тэдгээр хүчирхэг тэнгэрэлч нар энэ ажилдаа дургүйцаагүй. Тэд битүүхэндээ: “Бид үүнийг хэдэн арван триллион жил хийж байна. Залхмаар юм. Жаахан амарч, газар үзэж аялахсан. Бурхан бидний ажлыг түр өөр хүмүүсээр хийлгэчихэж болдоггүй юм байх даа” гэж бодоогүй.

Тэнгэрэлч нар хаашаа ч хөдлөхийг хүсдэггүй. Бурханы дэргэд байж, Бурханы аугаа үзэсгэлэнг биширч, цэц ухааныг сонсохоос илүү юм гэж нэг ч үгүй. Товчхондоо, бүтээл бүтээлийн дундаас Бүтээгчээс Өөрөөс нь илүү үзэсгэлэнтэй зүйл үгүй юм. Бурханы хараанаас нуугдах юм нэг ч үгүй учраас та Бурханд ойрхон байвал бүгдийг давуу өнцгөөс харна. Хэдийгээр Бурхантай зүйрлүүлэхэд өчүүхэн жишээ боловч, Альберт Эйнштейн, Нэйл Армстронг, Ноён Исаак Ньютоны дэргэд суугаад гадаад сансар руу дуран авайгаар ширтэж байна гээд бод доо. Ямар гайхамшигийг олж харах бол! Мэдээж энэ нь Бурханы дэргэд юу ч биш л дээ. Гэхдээ та миний хэлэх гэсэн санааг ойлгосон байх аа.

Миний таньдаг нэгэн үйлчлэгч тэнгэрт очоод ирсэн юм. Тэрбээр тэнд байхдаа сэнтий рүү ойртох ханашгүй хүсэл тэмүүлэл мэдэрснээ ярьж билээ. Тэнгэр дэхь бүх хүмүүс үүнийг л хүсдэг - тэд Бурханд чадах чинээгээрээ ойр байхыг хүсчээ. Тэнгэр нь найзын маань төсөөлснөөс хол үзэсгэлэнтэй бөгөөд тэнгэрт Эзэнээс Өөрөөс нь илүү хүслэнтэй зүйл байдаггүйг тэрбээр ярьж билээ.

Иаков, Иохан хоёрын ээжийн хүсэл рүү эргээд очъё. Есүс тэдэнд: “Та нар аяганаас минь ууна. Харин баруун, зүүн талд минь суухыг Би болгоодог юм биш. Харин энэ нь Эцэгийн минь бэлтгэсэн хүмүүсийнх юм” (Матай 20:23) хэмээн айлджээ. Тэгэхээр тэнгэрт үнэхээр хүндэтгэлийн суудал байдаг уу? гэж асуух нь зүйтэй. Есүс: “Хөөе, хүндэтгэлийн суудлын талаар санах ч хэрэггүй. Чи яаж Аав, бид хоёрт ойр байх талаар бодож зүрхлэв? Хүүхдүүдийнхээ хамт Бурханы төлөө амьдрахаа л бод. Нэг өдөр бүх юм аяндаа шийдэгдэж, Бурхан Христэд итгэгч хүн бүрт адилхан хүндэт суудал өгнө. Энэ нь та нарын үйлсээр биш, Миний үйлсээр шийдэгдэх учраас үүнд бүү зов” гэж хэлээгүй.

Энэ асуултад хариулахын тулд дараагийн амьдралын талаар Есүст тавьсан өөр нэг асуултыг харах хэрэгтэй. Нэгэн өдөр Садукайчууд Есүсийг өөрсдийнхөө теологиор бугуйлдахаар иржээ. Тэгээд: “Ах дүү долоо байжээ. Ууган нь нэг эмэгтэйтэй гэрлээд, үр хүүхэдтэй болж амжилгүй нас баржээ. Хоёр дахь

ах нь бас тэр эмэгтэйтэй гэрлээд бас үр хүүхэд төрүүлэлгүй нас баржээ. Тийнхүү ээлж дараалан ах дүү долуулаа тэр эмэгтэйтэй гэрлэжээ. Тэгэхээр үхлээс амилуулагдах үед тэр эмэгтэй хэнийх нь эхнэр болох вэ?” гэж асуусан байна.

Есүс энэ удаа хоёр дагалдагчийнхаа ээжид хариулснаас тэс өөрөөр хариулжээ. Тэрбээр “гэрлэлт нь газар дээрх хүмүүст зориулагдсан юм” гэсэн байна.

Харин тэрхүү үе хийгээд үхэгсдээс амилалд хүрэх зохистой гэж тооцогдсон хүмүүс гэрлэхгүй бас гэрлүүлэхгүй. Тэд тэнгэрэлч нартай адил тул цаашид үхэх боломжгүй бөгөөд амиллын хөвгүүд тул Бурханы хөвгүүд юм (Лук 20:35-36).

Тийнхүү Есүс Садукайчуудыг засаад, тэнгэрт гэрлэлтэд яг хандахыг хэлж өгчээ. Гэхдээ Есүс Иаков, Иохан хоёрын ээжийг асуусан зүйлийнх нь төлөө засч залруулаагүй юм. Есүс тэнгэрт үнэхээр Түүний дэргэд залагдах үнэ хүндтэй суудал байна гэдгийг батлан хэлжээ. Шүүлт болоход Бурхан Аав энэ суудалд ялагчийг суулгана.

Энэ хүндэт байр сууриар уралдаанаа сайн дуусгасан, мятрашгүй итгэгч нар шагнуулахыг олон Бичээс хэлдэг.

ИРЭХ ЗҮЙЛСИЙН ХЭЛБЭР

Дээрх үнэнийг Езекиел номд тодорхой хэлсэн байдаг. Хэдийгээр энд Хуучин гэрээний тахилч нарын тухай ярьж байгаа ч, Езекиел бидэнд Бурханы мөнхийн гэр Сионы аугаа сүмд амьдрал ямар байхыг урьдаас зөгнөн харуулжээ.

Бурхан эш үзүүлэгч Езекиелээрээ дамжуулан Хуучин гэрээний тахилч нар болох левитүүдийн тухай өгүүллрүүн. Энэ бүхэн бидэнд ямар хамаатай вэ? Элч Иохан:

бас итгэмжит гэрч, үхэгсдээс анх төрсөн бөгөөд газрын хаадын захирагч Есүс Христээс та нарт байх болтугай. Биднийг хайрладаг бөгөөд Өөрийнхөө цусаар биднийг нүглээс маань чөлөөлж, биднийг хаанчлал төдийгүй, Бурхан

ба Эцэгийнхээ төлөөх тахилч нар болгосон Түүнд алдар хийгээд ноёрхол нь үеэс үед байх болтугай. Амен.
(Илчлэл 1:5-6)

Тахилч гэдэг үгийг цохон тэмдэглэсэн байгааг минь харж байна уу? Сүнсээр төрсөн Христэд итгэгчид нь өдгөө Бурханы мөнхийн тахилч нар болсон юм.

Харин Израиль төөрч явах үед Надаас холдсон левичүүд, шүтээнүүдийнхээ араас дагаж Надаас төөрсөн тэд хилэнцийнхээ шийтгэлийг үүрнэ. Гэсэн ч тэд өргөөний дааман хаалганд харуул, өргөөнд үйлчлэгч болж ариун газарт минь үйлчилнэ. Тэд ард түмний төлөө шатаалт тахил, нядлах тахилыг нядалж, ард түмэнд үйлчлэхээр тэдний өмнө тэд зогсоно. (Езекиел 44:10-11)

“Шүтээнүүд” гэдэг нь Израилийн шүтэж байсан шүтлэгийг хэлж байгаа юм. Хэдийгээр өнөөгийн нийгэм дэхь шүтээн шүтлэг нь тэр үеийнхээс хэлбэрээрээ өөрчлөгдсөн ч, Бурханы мэлмийд ялгаагүй л аймшигтай юм. Колоссай 3:5 дээр “Тиймд та нар газар дээрх эрхтнүүдийг үхүүл. Энэ нь садар самуун, бузар булай, тачаал, муу хүсэл, шунахайрал болох шүтээн шүтэх явдал юм” гэсэн байдаг. Бид энэ амьдралын хараа булаам юмстай хүчтэй таталцах үедээ шүтээн шүтэж эхлэдэг. Манай барууны соёлд нэвшсэн тушаал дэвших, өнгө мөнгө эдийн шунал, хэргэм зэрэг, алдар нэр, дур таашаал зэрэг атаа өрсөлдөөн, амин хувийн амбицитай хөөцөлдөх явдал нь бүгд шүтээн шүтэх явдал мөн. Бурханаас илүү хайрлаж, Бурханаас илүү хүсэн дурлаж байгаа зүйл нь бидний шүтээн болдог. Шүтээн бол бидний хамаг хүчээ өгдөг бас хамаг хүчээ авдаг тэр зүйл юм.

Идэж уухаас авахуулаад л амьдралын бүх хэсэг дээр шүтээн шүтэх явдал өрнөдөг. Хоолонд сувдагладаг итгэгчид үй түмээрээ л байна. Тэд гутрахаараа иднэ, баярлахаараа иднэ. Сайхан л санагдаж байвал, хэрэгтэй байна уу, хэрэггүй байна уу хамаагүй хусч л орхино. Тэр хүмүүс амтныхаа таашаалыг

хангахын төлөө биедээ зүгээр л хог хаягдал шахаж орхидог. Унадаг тэрэгтээ хэзээ ч ашиглачихсан, бохир тос хийдэггүй атлаа биедээ юу л бол юу хийнэ. Тэд хоолыг шүтэж байгаа юм. Учир нь тэд сайхан амт, гэдэс цадах түрхэн зуурын таашаалаас эрч хүчээ авч бас тэр мэдрэмжийнхээ төлөө бүх хүчээ өгдөг.

Хүний алдарших гэсэн хүсэл ч шүтээн шүтэх явдал мөн. Чуулган, ажил, нийгэмд “хүндтэй” байр суурь олж авахын төлөө яахаас ч буцахгүй хүмүүс байна. Тэд хүлээн зөвшөөрөл, байр суурь, эрх мэдэл олохын төлөө цуурч, гүтгэж, мэхлэж, худлаа ярьж, шударга зангаа уландаа гишгэдэг. Тэд алдар нэр, хэргэм зэрэг, олны магтаалаас хүч чадлаа олж, үүнийхээ төлөө бүх хүчээ өгдөг.

Шүтээн чинь таны мятрашгүй итгэмжтэй чанарыг чинь шимнэ. Тэдгээр нь уралдаанаа итгэмжтэй дуусгахад шаардлагатай хүчийг чинь сордог.

■

**Амьдралын бүх хэсэг
дээр шүтээн шүтэх
явдал өрнөдөг.**

■

Езекиелийн дээрх хэсэгт Бурхан түрхэн зуурын дур таашаалын төлөө Өөрийг нь орхиж явсан хүмүүсийн тухай ярьжээ. Шүтээн биднийг хэсэгхэн зуур хангаж болох ч, урт хугацаанд хэзээ ч хангахгүй. Шүтээн шүтэгчид үйлдсэн буруугаа заавал төлнө

гэдгийг хэлжээ. Тэдний шагнал нь шатах үед гарз хохирлоо амсана. Тэд аврагдах нь аврагдана - гэхдээ амь мөлтөс л аврагдана. Тэд Бурханы гэр бүлд багтавч, хамгийн үнэ хүндгүй дорд, аахар шаахар ажил л хийнэ.

Бурхан энэ үгээ яг та бидэнд хандаж айлдсныг ойлгоорой. Бурхан та биднийг Өөрийнх нь бидэнд зориулж хадгалсан баялгийг алдахыг хүсдэггүй. Тэнгэр бол бидний төсөөлсөнтэй зүйрлэшгүй аугаа газар. Тэнгэрийн гоо үзэсгэлэнг бараадах юм газар дээр байхгүй. Гэхдээ тэнгэрт агуу их хүндэтгэлийн байр суурь, арай доод төвшний байр суурь гэсэн төвшин төвшний хэргэм зэргийн байр суурь бий. Бурханы гэр дэхь ямар ч байр суурь нь газар дээрх ямар ч зүйлээс илүү. Давид ч үүнийг батлан хэлсэн. “Учир нь Таны хашаан дахь нэг өдөр Гадна байх мянган

өдрөөс ч дээр юм Гэм буруугийн майхнуудад оршин сууснаас Бурханыхаа өргөөний босгон дээр зогсохсон” (Дуулал 84:10).

Давид “Бурханы өргөөнд боол байх нь өөр ямар ч газар байснаас дээр буюу!” гэжээ. Ертөнц дээр Бурханы өргөө гэр шиг, Бурханы бодит оршихуй шиг хүслэнтэй газар байхгүй. Сионд эзлэх ямар ч байр суурь нь бүх зүйлээс, бүх газраас хүслэнтэй.

Гэхдээ энд Бурханы хэлсэн санааг анхаарна уу. Бурхан бидэнд дэндүү хайртай учраас “хамгийн шилдгээ зориулж чадахгүй бол асар их гарз хохирол үзнэ шүү” гэдгийг урьдаас анхааруулан хэлжээ. Энэ нь мөнхийн мөнхөд Бурханд ойр, ойрхон байх шагналаа алдах явдал юм. Итгэгчдийн шүүлтээр бөөн уйлаан болох бөгөөд “Эзэн тэдний нүднээс нулимс бүрийг нь арчина. Тэнд цаашид үхэл гэж байхгүй, гашуудах, уйлах, өвдөх гэж үгүй болно. Учир нь анхны юмс өнгөрөн оджээ” (Илчлэл 21:4) хэмээн батлан хэлжээ. Гэхдээ биднийг мөнхийн амьдралд оруулсан газар дээрх богино амьдралаа үрэн таран хийсэн харуусал хэзээ ч арилахгүй. Зуурдын жаргалтай хөөцөлдснийхөө балгаар юу алдснаа бид мөнхөд санаж явна. Энэ гарз хохирлын талаар би өмнөх бүлгийнхээ турш ярьсан (1Коринт 3:12-15).

Нөгөөтэйгүүр Езекиел 44:15 дээр Бурхан мөн: “Харин Израилийн хөвгүүдийг Надаас төөрч явахад ариун газрын минь үүргийг сахисан Левийн тахилч, Задокийн хөвгүүд Надад үйлчлэхээр Надад ойртох бөгөөд тэд Надад өөх, цусыг өргөхөөр Миний өмнө зогсох болой” гэжээ.

Бурхан энд Хуучин гэрээний тахилч нарын талаар өгүүлжээ. Гэхдээ Колоссай 2:17 дээр “Эдгээр нь ирж буй юмсын сүүдэр нь юм” гэсэн бол, 1Коринт 10:11 дээр “Энэ бүхэн жишээ болон тэдэнд тохиолдсон бөгөөд үүнийг үеийн төгсгөл тохиож буй бидэнд сануулга болгон бичжээ” гэсэн байдаг. Ер нь Бичээс байнга Хуучин гэрээний үйл явдлыг алс ирээдүйд болох үйл явдлын хэлбэр, сүүдэр, дүрслэл болгодог. Надад үйлчил гэсэн үгийг анхаарна уу. Давидын хэлсэн шиг шал зүлгэдэг гэрийн үйлчлэгч байх нь нэг хэрэг бол, харин Бурханд үйлчлэх нь тэс өөр хэрэг билээ.

Би 1983 онд 8000 хүнтэй чуулганаас бүтэн цагийн үйлчлэлийн гараагаа эхлэж байлаа. Тэр чуулган манай хотод төдийгүй, дэлхийд нэртэй чуулган байв. Нэг хэсэг бүр 450 ажилтантай ч байлаа. Би пасторынхаа гэр бүлд туслах ажилтай байв. Тэдэнд үйлчилнэ гэдэг нэр төрийн хэрэг байсан юм. Миний ажлын өрөө тэдний ажлын өрөөтэй зэрэгцэж, пасторынхаа гэрээр байнга орж гарч, дэлхийн аугаа үйлчлэгч нартай барих зоогт нь оролцдог байсан учраас би бусад бүх ажилчдаас илүү завшаантай хүн байв. Заримдаа аймаар ч юм шиг. Тийм мундаг удирдагч нартай ийм ойр дотно байдаг, яасан хувьтай хүн бэ гэж өөрийгөө бодохоор хамар шархирдаг байлаа.

Би бусад ажилчдын сонсоогүй цэц ухаан, бодол, санааг сонсдог байв. Намайг өнөөдөр өдий зэрэгтэй амьдруулж буй ухаарал, гэгээрлийг би тэр үед л олж авсан юм. Тэр чуулганд миний ажил шиг хүслэн болсон ажил байсангүй. Манайхан надад: “Чи ийм ажил хийдэг ёстой азтай хүн” гэж байнга хэлнэ. Зарим нь атаархангуй: “Чи яаж байж ийм байр сууринд хүрсэн бэ?” гэж асууна. Үлдсэн нь намайг явсны дараа тэр байр сууринд хэн очих талаар хэлэлцэнэ. Гэхдээ яахын аргагүй тэдний зөв байлаа - би үнэхээр шилдэг байр сууринд байсан юм.

Тэгвэл Бурханаас ийм байр суурь хүртэх ямар байхыг төсөөлж байна уу? Ажлаа сайн хийдэг, уралдаанаа дуустал гүйдэг, мятрашгүй итгэгчид хожим Бурхантай ийм ойр дотно байна. Тэд Бурханы хүндэтгэлийн суудалд заларна. Езекиел 44:28 дээр Бурхан “Өвтэй хамаатай нь энэ билээ. Би өв нь юм. Та нар тэдэнд Израильд ямар ч эзэмшлийг өгөх ёсгүй. Би эзэмшил нь юм” хэмээн айлджээ.

Биширмээр! Үүнээс илүү шагнал гэж байх уу? Үнэхээр эцсээ хүртэл хичээнгүй бөгөөд итгэмжтэй байсан хүмүүс л Бурханы санаа, алсын хараа, гэгээрлийг сонсож, ирээдүйг төлөвлөж, удирдахад нь туслана. Тэд Бурхантай хамт мөнхөд сууж, захирч, ойроос үйлчилнэ. Юутай гайхамшигтай амлалт вэ!

Тиймээс Паулын ятгалгыг дахин сонс:

Тэмцээнд өрсөлдөгч бүр бүх талаар биеэ захирах чадварт өөрийгөө дасгалжуулдаг аж. Тэд муудах титэм хүртэхийн

төлөө бол, харин бид үл муудах титмийн төлөө юм. Тиймээс би зорилгогүй мэт гүйдэггүй, хий агаар цохих мэт нударгалдаггүй... (1Коринт 9:25-26)

Мэргэжлийн тамирчид Супер цом, Мастерсын ногоон хүрэм, Стэнли цом, олимпийн алтан медалийн төлөө үхэн хатан бэлтгэдэг. Гэхдээ эдгээр шагнал нь бидний хүртэх шагналын дэргэд юу ч биш юм. Тиймээс л Еврей 12:1 дээр биднийг “Тиймээс бид өөрсдийг минь хүрээлэн буй үүл мэт үлэмж их гэрч нартай тул аливаа саад тотгор ба амархан урхиддаг нүглийг хажуу тийш нь тавьж, өмнөө тавигдсан уралдаанд тэвчээртэйгээр гүйцгээе” хэмээн ятгажээ.

Одоо өөрөөсөө: “Намайг ямар шагнал хүлээж байгааг мэддэг болсон болохоор одоо би үүнд илүү нухацтай хандаж байна уу?” гэж асуу.

Хариултыг нь та өөрөө мэдэж байгаа байх аа.

ХЭЗЭЭ Ч БҮҮ БУУЖ ӨГ!

Миний нэрээс болж бүгд та нарыг үзэн ядна. Харин эцсээ хүртэл тэссэн нь аврагдах болно.

Матай 10:22

Миний нэрээс болж бүгд та нарыг үзэн ядна. Харин эцсээ хүртэл тэссэн нь аврагдах болно.

Бууж өгөх шийдвэрийг хэн ч танаар гаргуулж чадахгүй. Та үүнийг өөрөө л шийднэ. Тиймээс бууж өгөх шийдвэрийг хэзээ ч бүү гарга.

Одоо нүүрлэж байгаа бэрхшээл чинь энэ амьдралдаа бас дараагийн амьдралдаа хүлээж авах шагналын дэргэд юу ч биш юм. Есүс “Эцсээ хүртэл тэвчих нь талаар болохгүй” хэмээн айлдсан.

Гэхдээ эцсийн өдрүүдэд ийм харамсалтай явдал болно гэдгийг Аврагч маань урьдаас хэлжээ. “Олон хүн бууж өгнө” гэдгийг Матай 24:10 дээр Есүс хэлсэн байдаг. Тэрбээр энэ тухай хэлэхдээ элэг зүрхнээсээ шаналсан байх. Эрх чөлөөтэй, амжилттай болгохын төлөө амиараа худалдаж авсан, хайртай хүмүүс нь Түүнээс нүүр буруулж, итгэлийнхээ замаас бууж өгөх ажээ.

Гэхдээ уг нь тэд бууж өгөх ямар ч шаардлагагүй нь бүр ч харамсалтай юм. Бурхан биднийг бэрхшээлийг салгалаад ч болтугай даваад гараасай гэсэндээ биш, харин бэрхшээлээс

улам хүчтэй, ухаантай, үр жимстэй болоод гараасай гэсэндээ нигүүлслээ хайрласан юм. Олон хүн зөв үзэл бодолгүй учраас бууж өгдөг. Тэд зэвсэглээгүй байдаг.

Хүн олон янзаар бууж өгдөг. Дийлэнхдээ нөхцөл байдалтайгаа эвлэрснээс болж бууж өгдөг бөгөөд харин энэ нь мятрашгүй чанарын эсрэг зан чанар юм. Урсгал сөрөн сэлүүрдсэн нөгөө хүнийг санаж байна уу? Бид түүнийг даган дууриах ёстой. Бурхантай алхаж, хаанчлалыг нь харуулж, Бурханы төлөө өөрийгөө онцгойруулахад дэлхийн системийг сөрж алхах л ёстой болно.

Бид мятрашгүйгээр Бурханы цэц ухааныг сахих ёстой. Бид энэ дэлхийтэй эвлэрэх талаар санах ч ёсгүй.

ХРИСТЭД ИТГЭХ ХЭЦҮҮ

Паул алуулахаасаа өмнө ямар хэцүү өдрүүд айсууг харжээ: “Эцсийн өдрүүдэд хэцүү цаг ирнэ гэдгийг мэдэж ав” (2Тимот 3:1) Паул янз бүрийн тохиолдлоор 39 удаа ташуурдуулж, саваагаар жанчуулж, үхэнгээ алдталаа чулуугаар шидүүлж, олон жил шоронд зовсон. Тэрбээр явсан газар бүрийдээ дайсагнал, хавчлага үзсэн. Тийм атал Паул бидний энэ үед Бурханы төлөө амьдрах хавьгүй хэцүү болно гэж хэлжээ! Тийм зовлон үзсэн хүн яаж ингэж хэлэв ээ? Гэхдээ Паул үүнийгээ ингэж тайлбарлажээ:

Учир нь хүмүүс аминч, мөнгөнд дурлагч, сагсуу, их зантай, доромжлогч, эцэг эхдээ дуулгаваргүй, үл талархагч, ариун бус, үл хайрлагч, үл эвлэрэгч, гүтгэгч, биеэ хянадаггүй, хэрцгий, сайныг үзэн ядагч, тэрслэгч, бодлогогүй, биеэ тоодог, Бурханыг хайрлагч байхаас илүү зугаа цэнгэлийг хайрлагч болох болно. (2Тимот 3:2-4)

Эхлээд бид: “Паул юу хэлэх гэсэн юм бол? Эдгээр зан үйлдэл нь Паулын үеийнхээс юугаараа ялгаатай гэж?” гэж хэлж магадгүй. Тийм ээ, үнэхээр ийм зан авир Паулын нийгэмд ч байсан. Тэртээ Паулын үед ч хүмүүс амиа, мөнгөө хайрлаж, ариун бус, өширхүү зэрэг дээрх зан авирыг бүгдийг

нь гаргадаг байсан. Тэр бүү хэл Пентекост өдөр Петр “Энэхүү гажууд үеийнхнээс аврагдагтун” (Үйлс 2:40) гэж хэлсэн буй.

Тэгвэл Паул яагаад бидний үеийг олноос онцлох болов? Яагаад манай энэ цаг үеийг Бурхантай алхахад хамгийн хэцүү түүхэн үе хэмээв? Үүнд удаах ишлэл хариулжээ: “Тэд итгэл сүсэгт дүртэй ч хүчийг нь үгүйсгэдэг. Чи тэднээс хол бай” (2Тимот 3:5).

Хамгийн том асуудал үнэнийг хөсөрдүүлдэг “итгэгч” нараас үүсдгийг Паул хэлжээ. Манай энэ үед “дахин төрсөн Христэд итгэгч” нэртэй үй олон хүн Бурханы нигүүлсэл дотор зогсохоо болино гэдгийг Паул Шинэ гэрээний бусад бичээч нарын нэгэн адил хэлжээ. Тэд нигүүлслээр аврагдсан гэдэг баримтаасаа гогдовч, өөрсдийг нь хаанчлалын мятрашгүй дайчид болгон тусгаарладаг нигүүлсийн хүчийг үгүйсгэдэг юм.

Тэд бол сэлүүрээ тавьсан хүмүүс. Тэд урсгал өөд харчихсан чигээрээ энэ дэлхийн системд туугдаж яваа хүмүүс. Гэхдээ миний үзсэн үзэгдэлд тэр завинд дүүрэн хүмүүс байсан нь бүр ч аймшигтай. Тэд олуулаа нийлэхдээ энэ худал хуурмаг байдлаа улам л үнэмшилтэй болгон зузаатгажээ. Тэд өөрсдөө мэхлэгдээд зогсохгүй, үй олон гэнэн цайлган хүмүүсийг төөрөлдүүлэн бүдрэхэд хүргэдэг. Паул яг энэ талаар л хэлсэн юм.

Түүхийг сөхөж харвал, анхан үеийн чуулганы эцгүүдийн хамгийн том тулаан нь хуульчлал байжээ. Хуульчлал нь шинэ итгэгчдэд Бурханы нигүүлслээр аврагдахын оронд хуулийг сахиснаар аврагдах арга замыг санал болгодог байсан.

Харин эцсийн өдрүүдэд аж төрж байгаа та бид өнөөдөр тэс өөр тулаан хийж байна. Бид хууль ёсгүй байдалтай үзэлцэж байна. Хууль ёсгүй байдал нь амьдралаа өөрчлөлгүйгээр аврагдах арга замыг санал болгодог. Тийнхүү Христэд итгэгч болсон тэдгээр хүмүүс тодорхой клубтэй, шошготой, хэлтэй болсон ч, амьдрал нь бахь байдгаараа, завь нь ч урсгалд туугдан хөвсөөр явдаг. Тэд Бурханд мятрашгүйгээр найддаг ч үгүй, дуулгавартай дагадаг ч үгүй.

Есүс хожмын өдрүүдэд “Ёс бус явдал өссөнөөс болж олонхын хайр хөрнө. Харин эцсийг хүртэл тэвчсэн нь аврагдах болно. Хаанчлалын энэхүү сайнмэдээ дэлхий даяар тунхаглагдаж,

бүх үндэстэнд гэрчлэл болно. Тэгэхэд л төгсгөл ирнэ” хэмээн айлдсан (Матай 24:12-13). Гэхдээ байзаарай. Есүсийн аж төрж байсан нийгэм ч яг л ийм байсан шүү дээ. Тэгвэл өнөөгийн нийгэм юугаараа ялгаатай гэж? Есүс яг үнэндээ нийт хүмүүсийн талаар яриагүй, харин Өөрийг нь дагадаг нэртэй хүмүүсийн тухай ярьжээ. Дээрх нүгэл нь өнөөдөр Христэд итгэгчдийн дунд газар авахыг Есүс гэрчилсэн байна. Эс бөгөөс Есүс юу гэж “эцсээ хүртэл тэвчсэн нь аврагдах болно” гэж хэлэх билээ? Тэрбээр итгэгч бус хүнд “эцсээ хүртэл тэвчсэн нь аврагдана” гэж хэлэхгүй байсан. Учир нь итгэгч бус хүн уралдаанд оролцоогүй. Зөвхөн хэдийнээ итгэл дотор байгаа, хэдийнээ уралдаанд гарсан хүнд л “эцсээ хүртэл тэвчсэн нь аврагдана” гэж хэлнэ.

Есүсийн хэлсэн түлхүүр үг нь тэсч гарах юм. Тэсч гарах гэдэг нь үнэнийг сахин хамгаалахад эсэргүүцэл, сөргөлдөөн, бэрхшээл байна гэсэн үг. Бид сайн дуусгахын төлөө мятрашгүй тэмцэх ёстой.

ЦАГ ИРЛЭЭ

Тиймээс Тимотод бичсэн Паулын захидалд илүү анхаарах хэрэгтэй. Паул бэрхшээлийн талаар яриад дараа нь шийдлийг нь зааж өгчээ: “Харин чи юу сурсан, юунд итгэсэндээ бай” (2Тимот 3:13-14).

Үнэн бол онц сонирхолтой зүйл биш. Үнэн хэзээд үнэнээрээ байдаг бөгөөд санал соёлын нөлөөгөөр хувьсан өөрчлөгдөхгүй. Паул дагалдагчдаа “сурсан, итгэсэндээ бай” хэмээн сэнхрүүлжээ. Харин сурсан, итгэсэндээ байх цорын ганц арга зам нь тэвчээр юм.

Дэлхийн чиг хандлага нь сэтгэл урхидмаар байдаг ч, энэ нь худал хуурмаг руу л хөтлөнө. Иймээс л Паул:

Христ Есүс дэх итгэлээр авралд чамайг мэргэн болгох чадалтай ариун судар бичгүүдийг чи хүүхэд байхаасаа мэдсэн. Бичвэр бүр Бурханы амьсгалснаар бөгөөд заахуй, зэмлэхүй, залруулахуй, зөвд чиглүүлэхүйд тустай. Энэ нь

Бурханы хүн чадамгай, аливаа сайн үйлд бүрэн бэлтгэгдсэн байхын тулд юм. (2Тимот 3:15-17)

Би дээрх хэсэгт “Ариун Бичээс”, “хүүхэд наснаас” гэсэн хоёр хэсгийг тодруулсан байгаа. Бурхан бүх Бичээсийг бичсэн. Бурханы үнэн үг цаг хугацаа, соёлын хувьслаас дээр оршдог. Бурханы үг бол бидний амьдралын суурь юм. Бурхан үг биднийг бүх талаараа Бурханд таалагдах мэдлэг, хүчтэй болгон боловсруулдаг.

2Тимотын 3-р бүлгийн төгсгөлийн үгс нь Паул яг ийм үгээр санаагаа дуусгаж байгаа мэт санагдуулж байж болох юм. Гэхдээ Библийн бүлэг, шүлгийн зүйчлэл нь МЭ 1227 онд л бий болсон зүйл бөгөөд “2Тимот” нь үнэндээ Паулын нэг л цул захидал юм. Тэгэхээр Паул бодлоо төгсгөөгүй, цааш нь шууд үргэлжлүүлсэн нь тодорхой байна:

Би, Бурханы болон амьд ба үхэгсдийг үзэгдэлт ба хаанчлалдаа шүүх Христ Есүсийн өмнө чамд чухалчлан захья. Үгийг тунхагла. Цагаа олсон ч, олоогүй ч бэлэн бай. Уужим сэтгэлээр, сургаалаар сэнхрүүл зэмлэ, урамшуул. Цаг нь ирэхэд хүмүүс эрүүл сургаалыг тэвчихгүй болж, харин хүслийнхээ дагуу, чихийг нь гижигдсэн багш нарыг өөрсдөдөө цуглуулах бөгөөд чих нь үнэнээс эргэж, үлгэр домгуудад хандах болно. (2Тимот 4:1-4)

“Бурханы болон Христ Есүсийн өмнө чамд хариуцлага ноогдуулъя.” Тэр хариуцлага нь юу вэ? Бурханы үгийг тунхаглан заах. Аль нэг гүн ухаан, нийгмийн удирдлагын зарчим, амьдрал дасгалжуулах арга техник юмуу тодорхой нэг үед дэлгэрч байгаа материалуудыг заах биш, харин цаг хугацаанд баригдашгүй Бичээсийг заах хариуцлага юм.

Паул дөнгөж сая бүх Бичээс нь Бурханы амьсгалснаар бөгөөд бидний амьдралыг чиглүүлдэг гэж хэлээд, үүнийг тунхаглан заах үүрэг хариуцлагыг Тимотод ноогдуулжээ. Яагаад? Яагаад гэвэл мэхлэж, мэхлэгдсэн хүмүүс нь эрүүл доктриныг тэвчихээ болих цаг ирнэ (миний бодлоор хэдийн ирсэн). Доктрин гэж юу вэ? Доктрин гэдэг нь зөвхөн сургаалыг хэлэхгүй, харин

Бичээсийн сургаалын суурь буюу ясан мод юм. Доктрин нь бүх сургаалыг хооронд нь холбодог үндсэн сургааль мөн.

Харамсалтай нь бидний сүнслэг суурь (бичээсийн суурь) цаг хугацаа хийгээд чиг хандлагатай ураг барилдаж, сүүлдээ бүр том чуулганы үйлчлэгч нар гишүүдийнхээ өмнө өөрийгөө ижил хүйстэн гэдгээ зарлаад, олон нийтийн сайшаал талархлыг хүлээхдээ тултлаа задгайран хэрээс хэтэрч, хяналтаас гарчээ. Өөр нэгэн номлогч “Бурхан одоо эдгээхээ больсон” гэж тунхаглахад нь гишүүд нь Бурханы Үгд биш, номлогчийнхоо үгд итгэж байх. Бас нэгэн номлогч “Хүн төрөлхтөн бүхлээрээ тэнгэрт орно. Нэг ч хүн мөнхийн тамд шатахгүй” гэсэн ном бичээд, Христийнхэний дунд “рок од” болон гялалзаж байх. Өөр нэгэн удирдагч Есүс Христийг онгон охиноос төрсөн эсэх, эргэж ирэх эсэхэд нь эргэлзсэн ч, Христийнхэний хүндэтгэлийг хүлээсэн хэвээр л байна. Энэ мэтчилэн харуусмаар үйл явдлууд “Христэд итгэгч” нэртэй хүмүүсийн дунд өдөр бүр өрнөсөөр байна.

Яагаад ийм хөгийн хувьсал газар авч байгааг сүүлийн үеийн зарим нэг судалгаа тайлбарлаж өгдөг. Улс даяар явуулсан нэгэн судалгаагаар “дахин төрсөн Христэд итгэгчдийн” 46-хан хувь нь л ёс суртахууны туйлын үнэнд итгэдэг гэжээ. “Евангелийн Христэд итгэгчдийн” 50-иас илүү хувь нь “хүмүүс Есүс Христийн тахилаас өөр арга замаар тэнгэрт орж болно” гэдэгт итгэдэг бол, “дахин төрсөн Христэд итгэгчдийн” 40 хувь нь л Сатаныг бодитой аюул занал гэдэгт итгэдэг ажээ.

Яаж ийм юм байж болох вэ? Үүний хариултыг Тимотод бичсэн Паулын захидлаас олж болно: “Тэд эрүүл саруул доктриныг тэвчихгүй.” Өөрөөр хэлбэл бид үнэнийг мятрашгүйгээр сахин хамгаалахаа болино.

Бид ямар ч амьгүй сайн мэдээнд татагдаж, үүнийгээ тунхагладаг болсон. Тэгээд “Есүс биднийг тэнгэрт оруулахын төлөө үхсэн нь үнэн. Гэхдээ бид хүн учраас бэлгийн янз янзын чиг хандлагатай байдгийг Бурхан ойлгодог” гэх ухааны юм заадаг болсон. Тухайлбал сүүлийн үед “нүглээ гэмших шаардлагагүй болсон” гэдэг сургаал газар авч байна. Маш олон итгэгчид “Нигүүлсэл бидний бүх нүглийг хэдийнээ цагаатгасан учраас Бурханд дуулгаваргүй загнаснаа заавал Бурханы өмнө улайж, гэмших хэрэггүй” хэмээн

хэнэг ч үгүй хэлдэг. Ийм итгэлтэй хүмүүс “сайн мэдээ бол маш энгийн, шинэлэг, чөлөөт зүйл” хэмээн мэдэмхийрч байхыг би сонссон. Гэхдээ энгийн, шинэлэг, эрх чөлөө нь жинхэнэ үнэний тодорхойлогч л юм бол, махан биеийг хангадаг доктрин болгон нь үнэн байх учиртай! Христэд итгэгчид гэмших шаардлагагүй болсон гэдэг сургаал нь үнэн л юм бол, Есүс Христ Илчлэл номд долоон чуулганы тавд нь “гэмш” хэмээн айлдсан нь ямар учиртай вэ? (Илчлэл 2:5, 16, 21, 22, 3:3,19).

Үнэн нь нүгэлд дуртай хүмүүсийн дур хүслээр хувьсан өөрчлөгдөхгүй. Үнэн нь хүний хүсэл, тав тухт нийцэх гэж эсвэл “улс төрийн хувьд зөв болох” гэж буулт хийдэггүй. Харин ч эсрэгээр Бурханы Хүү Өөрөө “Амь өөд хөтөлдөг хаалга нь хавчиг, зам нь нарийн юм. Цөөнх нь түүнийг олдог” (Матай 7:14) гэж мэдэгдсэн юм шүү.

Өдгөө бид эрүүл саруул доктриноос хадуурсан багш нарыг сонсдог болжээ. Хүний ухаан санааг урхидах чадвартай, тэдгээр заль мэхтнүүд нь орчин цагийн соёлын ёс суртахууны хэм хэмжээтэй эвлэлдэн зохицдог Сайн мэдээг зохион бүтээжээ. Итгэгч хүн амьдралаа үнэнээр цогцлоохоо больж, үнэнийг соёлынхоо чиг хандлагаар гуйвуулан хөрвүүлдэг болжээ. Яагаад? Яагаад гэвэл бидний чихийг “Тиймээс тэдний дундаас гарч тусгаар бай” (2Коринт 6:17) гэсэн Эзэний үг биш, харин дэлхийтэй орон дээрээ дэвхрэхэд хүргэдэг үг гижигддэг болжээ.

Олон итгэгчид анх дэлхийтэй сээтэгнэж эхлэхдээ, Ариун Сүнсний дохиог мэдэрдэг. Тийм боловч том завин дээр бөөн бөөнөөрөө суугаад, урсгалд туугдаж яваа хүмүүсийг харахдаа, чихээ бөглөж Ариун Сүнсний амыг тагладаг учраас сүүлдээ үнэний дуу хоолойг сонсох чадваргүй болдог.

АВАРГА ҮЕИЙНХЭН

Христ Есүсийн сайн цэрэг адил надтай хамт зов (2Тимот 2:3).

Нөгөөтэйгүүр яг энэ үеэр аварга үеийнхэн мэндлэх ажээ. Тэдний дунд эрэгтэй эмэгтэй, хөгшин залуу янз бүрийн хүмүүс байна (Үйлс 2:17-18). Эдгээр баатруудыг эртний эш үзүүлэгч, элч нар “үнэн доторх мятрашгүй дайчид” гэдэг.

Харанхуйн дайсагнал, худал хуурмаг нь эдгээр дайчдад тайз засч өгдөг байх нь. Тэд ухрах нь бүү хэл, дүрэлзсэн итгэл, үйлдлээрээ Бурханы хаанчлалын төлөө давшдаг. Тэд өөрсдийгөө харанхуйг гийгүүлэгч хурц гэрэл болгон онцгойруулна. Тэд буулт хийлгүйгээр, Даниел шиг бурханлаг эмээхүй, хүчирхэгжүүлэгч нигүүлслээр л ирдэг цэц ухаанаар амьдралынхаа талбар бүр дээр онцсайн болдог.

Эрхэм уншигч аа, би таныг тэдний нэг байгаасай гэж хүсч байна. Таныг хууль ёсоо сахин хамгаалж, зөвт байдлын цээживчээр хуягласнаараа аугаа чанараа бэхжүүлэхийн төлөө би залбирч байна. Таныг итгэлийн бамбайгаа барин, уралдаандаа цуцалгүй гүйж, ямар ч эсэргүүцэлтэй эцсээ хүртэл үзэлцэнэ гэдэгт найдаж байна. Та бол ялагч. Энэ дэлхий дээр байж болох хамгийн том дайсагналыг ялаад гарсан Нэгэний үр таны дотор бий. Түүний хүч танд бий! Түүний мөн чанар танд бий! Та бууж өгч, ухарч, найр тавьж, буулт хийж, эвлэрэхээр бүтээгдээгүй. Танд Бурханы гайхамшигт нигүүлсэл бий!

Танд ямар ч дайсагнал ирсэн бай, үүнийг захиргааны дараагийн төвшин рүү ахих гишгүүр гэж үз. Паул шиг дайсагналаас суралц:

Ах дүү нар аа, Азид байхад бидэнд учирсан зовлонг, хүч чадлаасаа хэтэрсэн хүнд дарамтад байснаас амьд үлдэх горьдлого тасарсныг ч та нар эс мэдэхийг бид хүсэхгүй байна. Гэхдээ бид өөрсдөө үхлийн ял дор байсан нь өөрсдөдөө бус, харин үхэгсдийг амилуулдаг Бурханд найдахын тулд билээ. Тэр биднийг тийм сүрхий үхлээс аварсан, аврах ч болно. Тэр биднийг аврах ч болно гэдэгт бид Түүнд найддаг. (2Коринт 1:8-10)

Паул болон түүний багийнхан тэсэхүйеэ аймшигтай зовлон туулсан атал тэрбээр: “Бидэнд тохиолдсон бүхэн дундаас үүн шиг сайхан юм байсангүй” гэж хэлжээ. Паул эсэргүүцэл дээр дөрөөлөн илүү том эрх мэдэл, хүч рүү ахижээ. Бурханы нигүүлсэл (хүч) хэзээд хангалттай байдаг. Бурхан биднийг хэзээд аваад л гардаг.

Гагцхүү бид итгэлээсээ тас зуурах ёстой. Учир нь нөгөө талд биднийг аугаа их ялалт, хангамж, биелэл хүлээж байгаа. Иаков “Сорилтыг тэсвэрлэдэг хүн ерөөлтэй еэ! Учир нь тэр шалгуулчихаад, Өөрийг нь хайрлагсдад Эзэний амласан амийн титмийг хүлээн авна” (Иаков 1:12) гэдэг.

Таны дотор Бурханы хүчирхэгжүүлэгч нигүүлсэл, мөн чанар, үндсэн зан чанар, бүрэн дүүрэн байдал суулгагдсан. Та Христийн бие учраас Христтэй хамт байгаа. Бидний тэргүүн болох Есүс хэзээ ч бүтэлгүйтээгүй учраас, бие нь ч бүтэлгүйтэх ёсгүй. Паул: “Бид бүх талаар дарамтлагдавч няцардаггүй, сандардаг ч цөхөрдөггүй” (2Коринт 4:8) гэжээ.

Бид Христийн бие. Тиймээс хэзээ ч бүү бууж өг, бүү зогс! Паул энэ үгээ ахин дахин хэлсэн: “Тиймд... бид зүрх алдахгүй” (2Коринт 4:1), “Тиймээс бид зүрх алддаггүй” (2Коринт 4:16). Та сайн дуусгахаар бүтээгдсэн.

Бурхан таныг хөсөрдүүлнэ гэж хэзээ ч бүү сана. Тэр хэзээ ч ийм юм хийхгүй. Түүний хэзээ ч үгүйрэхгүй амлалтыг үз: “Өөрийн Хүү, бидний Эзэн Есүс Христийн нөхөрлөлд та нарыг дуудсан Бурхан итгэмжит юм” (1Коринт 1:9).

Үүнээс илүү гайхамшиг байх уу? Бурхан таныг хэзээ ч хөсөрдүүлэхгүй. Бурхан бол мятрашгүй дайчин. Бурхан танд итгэл алдраагүй байхад, та өөртөө итгэл алдарч болохгүй. Мятрашгүй бай.

Мятрашгүй байсны шагнал юу вэ? Эзэн Өөрөө ингэж айлджээ:

Ялагч ба үйлсийг минь эцэс хүртэл хамгаалагсдад Би үндэстнүүдийн дээгүүрх эрх мэдэл өгнө. (Илчлэл 2:26)

Ямар аугаа шагнал вэ! Паул ч Есүсийн амлалтыг батласан: “Хэрэв бид тэвчвэл Түүнтэй хамт мөн хаанчилна” (2Тимот 2:12). Хамгийн гол нь энэ нь зөвхөн ирээдүйд болох үйл явдал биш, харин яг одоо энэ амьдралд болох зүйл юм. “Ганц хүний алдаа зөрчлөөс болж ганц хүнээр дамжин үхэл нь ноёрхсон юм бол, тэгэх тусмаа нигүүлслийн баялгийг болон зөвт байдлын бэлгийн дүүрэн хүртэгсэд нь Есүс Христ гэгч ганц Хүнээр дамжин амь дор ноёрхоно” (Ром 5:17).

Тиймээс Христийн доторх эрхэм хүндэт ахан дүү минь, танд мятрашгүй хүч бий. Танд сайн дуусгахад шаардлагатай бүхэн бий: таныг хэзээ ч хөсөрдүүлэхгүй Бурханы нигүүлсэл танд байна. Тиймээс шагналынхаа төлөө итгэлтэйгээр гүй. Тэнгэрийн даалгаврын төлөө байна уу, гол байр суурийн төлөө байна уу, хаанчлалын харилцааны төлөө байна уу, урт хугацааны төлөө байна уу, насан туршийнхаа төлөө байна уу - та байлдан дагуулж, хаанчлах хувьтай хүн. Мятрашгүй байсныхаа ачаар та бүрэн дүүрэн амьдралыг эдлэж, захирах завшаантай хүн. Та Хааныхаа алдрын төлөө онцгойрно. Үүнээс илүү шагнал байх уу даа?

ЭЗЭНийг хүсэн хүлээгтүн! Тууштай байж, зүрхээ зоригжуулагтун! Тийм ээ, ЭЗЭНийг хүсэн хүлээгтүн! (Дуулал 27:14) гэдэг үгийг бүү мартаарай.

БУРХАНЫ ХҮҮХЭД БОЛОХ ЗАЛБИРАЛ

Яаж Бурханы хүүхэд болох вэ? Нэн түрүүнд - үүнд таны гавъяа байхгүй, гагцхүү Есүс Христийн гавъяа оршино гэдгийг хэлэх хэрэгтэй. Есүс Өөрөө Хаан бөгөөд ширхэг ч нүгэлгүй төгс төгөлдөр Нэгэн боловч, таныг Бүтээгч Бурхан Аав дээр тань авчрахын төлөө таны нүглийг цагаатган амиа өгсөн юм. Есүс загалмайн үхлээрээ танд мөнхийн амийг худалдаж авч өгсөн.

Та ямар ч үндэс угсаа, нийгмийн гарал үүсэл, шашин шүтлэгтэй байсан ч, Бурханы хүүхэд болох боломжтой. Есүс таныг Өөрийн болгохыг хүсдэг. Үүний тулд та зүгээр л Түүнээс тусдаа дур мэдэн амьдарсан гэм буруугаа хүлээн, амьдралаа Есүс Христийн Эзэний эрх мэдэлд бүрэн өргөхөд л болно. Үүнийг хийсэн хүн жинхэнээсээ дахин төрдөг. Та цаашид харанхуйн боол байхаа больж, Бурханы дахин төрсөн хүү, охин болно.

Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл,

аврагдах болно. Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрч авралд хүрнэ (Ром 10:9-10).

Хэрэв та Есүс Христ таны төлөө амиа өгсөн гэдэгт итгэн, цаашид өөрийнхөө төлөө амьдрахаа больж, Түүнд амьдралаа өгөхийг хүсбэл, дараах залбирлыг чин зүрхнээсээ хэлэхэд л Бурханы хүүхэд болно:

“Тэнгэрийн Бурхан минь, би Таны зөвт байдлын жишигт хүрэхгүй гэмтэй хүн. Би хийсэн нүглийнхээ төлөө мөнхөд шийтгүүлэх ялтай хүн. Гэхдээ Та намайг энэ хэвээр минь орхиогчид баярлалаа. Учир нь Өөрийнхөө цорын ганц Хүү Есүс Христийг миний төлөө үхүүлэхээр энэ дэлхий рүү илгээн, онгон Мариагаас төрүүлсэн гэдэгт би итгэж байна. Есүс үхсэн боловч, гурав дахь өдрөө үхлээс амилуулагдаж, одоо Таны баруун гар талд миний Эзэн бөгөөд Аврагч болон сууж байгаа гэдэгт би бас итгэж байна. Тиймээс ... оны ... сарын ... ний энэ өдөр би Есүсийн Эзэний эрх мэдэлд амьдралаа бүхлээр нь өргөж байна.

Есүс ээ, одоо Та миний Эзэн, Аврагч, Хаан боллоо. Ариун Сүнсээрээ амьдралд маань ирж, намайг Бурханы хүүхэд болгон өөрчлөөч. Өнөөдрөөс бид урьд нь холбоотой байсан бүх харанхуйн явдлаасаа салж, өөрийнхөө төлөө биш, харин намайг амьтай болгох гэж амиа өгсөн Таны төлөө амьдрах болно.

Баярлалаа Эзэн минь. Одоо миний амьдрал бүхлээрээ Таны гарт байгаа. Та намайг хэзээ ч ичгүүрт оруулахгүй гэж амласан.”

Ийнхүү та аврагдаж, Бурханы хүүхэд боллоо. Яг одоо тэнгэр тэр аяараа баярлаж байна! Бурханы гэр бүлд тавтай морилно уу! Харин одоо би танд дараах гурван алхмыг аль болох түргэн хийхийг зөвлөе:

1. Саяын хийсэн зүйлээ хэн нэг итгэгч хүнтэй хуваалц.

Бичээс биднийг харанхуйг гэрчлэлийн үгээр ялан дийлнэ

гэсэн (Илчлэл 12:11). Та www.messengerinternational.org хаягаар манай Мессенжер Интернэйшнэл байгууллагатай холбогдож ч болно.

2. Бурханы Үгийг заадаг чуулганд хамрагд. Тэр чуулганы гишүүн болж, үйл ажиллагаанд нь оролц. Дөнгөж мэндэлсэн нярайг гудманд орхиод “Өөрөө хүн болоорой” гэж хэлдэггүй. Одоо та Христийн дотор нярай хүүхэд болсон бөгөөд Бурхан Аав тань танд хүн болох гэр бүл өгчээ. Тэр гэр бүлийг чинь “Шинэ Гэрээний чуулган” гэдэг.
3. Усан баптисм хийлгэ. Та хэдийнээ Бурханы хүүхэд болсон. Гэхдээ усан баптисм хийлгэх нь та өөрийгөө Есүс Христээр дамжин Бурханы болсноо сүнслэг болоод бодит ертөнцөд зарлан тунхаглаж буй явдал юм. Мөн энэ нь Бурханы үгийг дуулгавартай дагаж буй үйлдэл мөн. Учир нь Есүс бидэнд “...Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээ” (Матай 28:19) гэж тушаасан.

Христ доторх шинэ амьдралд чинь томоос том амжилт хүсье. Манай үйлчлэл таны төлөө тогтмол залбирна. Одооноос эхлээд үнэн дотор мятрашгүй амьдраарай!

БИ ЯАГААД ОЛОН ЯНЗЫН ОРЧУУЛГА ХЭРЭГЛЭДЭГ ВЭ?

Хүмүүс намайг яагаад олон янзын орчуулга хэрэглэдгийг бас яагаад ишлэлийг хагаслаж бичдэгийг асуудаг. Би үүнд хариулья.

1. Библи анх 11,000 Еврей, Арамей, Грек үгээр бичигдсэн байдаг. Гэтэл Англи хэл дээр хөрвүүлсэн Библид дунджаар 6,000 үг л хэрэглэсэн байдаг. Тэгэхээр орчуулгын явцад янз бүрийн утга мулт үсрээд, алдагдсан байх боломжтой гэдэг нь тодорхой байна. Тийнхүү хэд хэдэн Англи бичвэрийг харьцуулж ишлэснээр Бурханы хэлэх гэсэн санааг бүрэн бүтнээр нь гаргаж авах боломжтой юм.

2. Ганц орчуулгыг барих үед уншигч хүн тухайн ишлэлтэй танил учраас гүйлгээд өнгөрөх нь элбэг тохиолддог. Тиймээс янз бүрийн орчуулга хэрэглэснээр ийм явдлаас сэргийлж, уншигчийг Бичээс дээр төвлөрөхөд нь тусладаг.

3. Миний бие аль нэг Бичээсийг дор хаяж 5-8 орчуулгаас нягтлан уншиж байж, санааг маань хамгийн сайн гаргаж байгаа хувилбарыг сонгодог. Түүнчлэн тухайн ишлэлийг утгачлан буулгаж байгаа бол, тухайн утгаа Библийн хамгийн нэрд гарсан орчуулгаар хянан баталгаажуулдаг.

4. Харин бичээсийг бүтнээр нь биш, хагаслан ишлэдгийн учир гэвэл - Библийг бүлэг, шүлгээр зүйчлэх ажлыг МЭ 1227 онд хийсэн байдаг. Библи нь анх зүгээр л үргэлжилсэн хэлбэрээр бичигдсэн байжээ. Сайн мэдээнд Есүс ч Хуучин гэрээний шүлгээс хэсэгчлэн иш татсан байдаг билээ.

ДЭЛГЭРҮҮЛЖ БОДОХ, ЯРИЛЦАХ АСУУЛТ

1. Амьдралаа яаж дуусгах нь яаж эхлүүлэхээсээ чухал гэдэгтэй та санал нийлэх үү? Хариултаа тайлбарлана уу.
2. “Мятрашгүй сүнс” гэдгийг тодорхойлно уу.
3. Бурханы нигүүлсэл гэж юу вэ? Энэ номыг уншсанаар нигүүлслийн талаарх ойлголт чинь сайжирсан уу?
4. Христэд итгэгчид “амьдралд захирах” (Ром 5:17) ёстой гэдэг ойлголтыг та амьдрал дээр яг яаж хэрэгжүүлэх вэ? Энэ үнэн танай гэр бүл, амьдрал, амьдралын саад бэрхшээлд хандах хандлагад чинь яаж нөлөөлж байна?
5. Олон итгэгчид амьдралд захирч чаддаггүй. Яагаад тэр вэ?
6. Итгэгч хүнийг амьдралын бэрхшээлд захирагч байх боломж олгодог үндсэн хандлага, үйлдлээс нэрлэнэ үү?
7. Сатан таны амьдралд ямар төлөвлөгөөгөөр ажилладаг вэ (Иохан 10:10)? Сатан энэ “хулгайлж, алж, устгах” төлөвлөгөөгөө сүүлийн үед таны амьдралд хэрэгжүүлсэн үү? Тэр яаж ажилласан бэ?
8. Есүс биднийг энэ дэлхийд зовно гэсэн. Гэхдээ Есүс бас Өөрийгөө “дэлхийг ялсан” гэсэн (Иохан 16:33). Чухам юу биднийг ялагч, байлдан дагуулагч болгодог вэ?

9. Бардам хүний шинж юу вэ? Даруу хүний шинж юу вэ?
10. Элч Петр Есүсийн дагалдагч нарыг “даруу байдлаар хувцасла” гэж сэнхрүүлсэн (1Петр 5:5). Жирийн амьдрал дээр энэ ямар утгатай вэ?
11. Дяволыг эсэргүүцэх зарим нэг аргаас нэрлэнэ үү?
12. Христэд итгэгч хүний амьдралд яагаад бэрхшээл амин чухал байдаг вэ?
13. Мятрашгүй итгэгчийн амьдралд залбирал ямар үүрэгтэй вэ?
14. “Чин сэтгэлийн залбирал” гэдгийг та юу гэж тайлбарлах вэ?
15. Тэнгэрт яагаад янз бүрийн төрөл, төвшний шагнал байдаг вэ?
16. Энэ номыг уншаад эргэцүүлж байхад, таны “мятрашгүй сүнснийг” бэхжүүлэхэд амьдралын чинь аль хэсэг дээр Ариун Сүнсний тусламж хэрэгтэй байна вэ?

ЖОН БИВЭР сонсдог жүжиг толилуулж байна

АФФАБЕЛ

ӨНӨ МӨНХ РҮҮ ӨНГИЙХ ЦОНХ

СОНСДОГ ЖҮЖИГ

ЖОН БИВЭРИЙН бичсэн **АФФАБЕЛ** нэртэй сонсдог жүжиг Монгол хэлнээ бэлэн боллоо! Та энэхүү жүжгийг YouTube.com руу ороод “Аффабел” гэж хайвал 5 цуврал жүжгийг сонсох боломжтой. Мөн www.cloudlibrary.org руу ороод Монгол хэлийг сонгож “Аудио” гэсэн товчийг дарвал Аффабел болон Жон Бивэрийн бусад сонсдог ном, сургаалуудыг Монгол хэлнээ сонсох боломжтой. Сонсдог зохиол, номоо таалан сууж тухлан сонсоорой.



ЖОН БА ЛИЗА БИВЭРИЙН АЛБАН ЁСНЫ
МОНГОЛ ФЭЙСБҮҮК ХУУДАСТ
ТАВТАЙ МОРИЛНО УУ!

<https://www.facebook.com/JohnBevereMongolia/>



Та дээрх хуудсанд айлчилж ЛАЙК дарснаар
энэхүү албан ёсны хуудсанд тавигдах сүүлийн үеийн бүх мэдээллийг цаг
алдалгүй хүлээн авах боломжтой болох юм.

МӨН

Монгол хэл дээрх Жон ба Лиза Бивэрийн цахим ном, видео, аудио
хичээл болон сонсдог номыг үнэ төлбөргүйгээр татаж авах боломжтой.

Үүний тулд та дараах цахим хаягаар ороод, Монгол хэлээ сонгоход л
хангалттай! Таны итгэлийн амьдралд хүч, урам, ухаан өгөх хүчирхэг эх
сурвалжуудтайгаа холбоорой!

Энэ бол танд өгч буй бэлэг юм шүү!



www.CloudLibrary.org

ЭДГЭЭР СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРҮҮД МОНГОЛ ХЭЛЭЭР БЭЛЭН БОЛСОН



Эдгээр материалуудыг чөлөөтэй хуулж, бусдад дамжуулж, суралцах боломжтой юм. Анхааралтай нягтлан судалсанаар итгэлийн амьдрал тань хүчирхэг суурьтай болно!

Сайныг уу, Бурханыг уу? сургалтын хөтөлбөрийн хувьд:

- DVD нь зөвхөн компьютерт уншигдахыг анхаарна уу. Энэ DVD дотор видео, аудио, цахим ном зэрэг төрөл бүрийн форматтай материал байгаа тул зөвхөн компьютероор уншуулна уу.
- MP4 видео сургаалыг өөрийн хүссэн цахим төхөөрөмжинд хуулж үзэх боломжтой.
- MP3 аудио файлыг утас, таблет, компьютертээ хуулан авч сонсох боломжтой.
- PDF формат дээр цахим номууд байгаа ба түүнийг ухаалаг утас, таблет, компьютертээ суулгах, эсвэл хэвлэн авч унших боломжтой.

Илүү дэлгэрэнгүйг, өөр олон хэлээр дараах цахим хуудаснаас:



www.CloudLibrary.org

МЯТРАШГҮЙ

сургалтын хөтөлбөр



Гарт тань Жон Бивэрийн, “МЯТРАШГҮЙ” нэртэй ном, сургалтын хөтөлбөр атгаастай байна. Амьдрал өөрчлөх хүчирхэг сургаалыг тал бүрээс нь нухацтай судлахад тань энэ ном болон DVD-д багтсан туслах материал мөн CloudLibrary.org цахим хуудаснаас татаж авах материалууд багтай тусална хэмээн найдаж байна. Үр дүнтэй итгэгч байж Эзэний төлөө аугаа ихийг бүтээгээрэй! Энэхүү сургалтын хөтөлбөрт дараах материал багтсан байгаа болно.

МЯТРАШГҮЙ ном
Сургалтын хөтөлбөрийн цорын

ганц хэвлэмэл бол энэ ном юм. Харин бусад материал нь DVD-д багтсан байгаа.

МЯТРАШГҮЙ НОМЫН МАТЕРИАЛЫГ АГУУЛСАН DVD
Цахим хэлбэрээр DVD дотор бусад хэрэгтэй материалыг хуулсан бөгөөд зөвхөн компьютерээр уншихыг анхаарна уу. DVD доторх материалуудыг хуулж, тарааж болно.

МЯТРАШГҮЙ сонсдог ном
Номын 18 бүлэг Монгол хэл дээр .mp3 форматаар DVD дотор байгаа.

МЯТРАШГҮЙ видео хичээл
Нийт 12 видео хичээл .mp4 форматаар DVD дотор байгаа.

МЯТРАШГҮЙ аудио хичээл
Нийт 12 аудио хичээл .mp3 форматаар DVD дотор байгаа.

Нэмэлт материал
Жон ба Лиза Бивэрийн бусад цахим ном DVD-д байгаа болно.

МЯТРАШГҮЙ НОМЫН МАТЕРИАЛ



Энд байгаа болон бусад материалуудыг дараах цахим хуудаснаас аваарай.
www.CloudLibrary.org

Зөвхөн компьютерт зориулсан

ХЭЗЭЭ Ч БУУЖ ӨГӨХГҮЙ БАЙХ ХҮЧ

МЯТРАШГҮЙ

ЖОН БИВЭР



Энэхүү DVD доторх материалууд нь Жон Бивэрээс танд өгч буй бэлэг юм. Илүү гүн гүнзгий Эзэний Үгийг судалж итгэлээ батжуулан бэхжүүлэхэд тань өгч байгаа билээ. DVD доторх материалуудыг ямар ч хэлбэрээр ашгийн бүс замаар хувилж тарааж болно. Итгэгчдэд хэрэгтэй энэ бүх материал, судлал нь таны болон анд нөхдийн тань итгэлийг өсгөх болтугай!

Жон болон Лиза Бивэрийн эдгээр болон бусад материалуудыг МОНГОЛ хэлээр дараах цахим хуудаснаас үнэ төлбөргүй татаж авах боломжтой.

www.CloudLibrary.org
www.MessengerInternational.org

Бусад өөр хэл дээрх нэмэлт материалуудыг YouTube.com, Yuku.com болон бусад медиа цахим хуудаснаас олж авах боломжтойг дуулгахад таатай байна.

*“Бурхан зовлонгийн зохиогч биш боловч,
зовлонгоор биднийг илүү том үйл хэрэгт
бэхжүүлдэг. Бурхан бидэнд даван туулах хүчийг
нь өгөлгүйгээр хэзээ ч шуурганд оруулдаггүй.”*

- ЖОН БИВЭР, Мятрашгүй

Танд сайн дуусгах бүх хүчин зүйлс нь байгаа!

Христэд итгэгчид “амьсгаатай л байхын” тулд амьдраагүй. Та дайсагналын өөдөөс босоод, бэрхшээлийг залгиж амьдрахаар бүтээгдсэн! Энэ номд зохиолч Жон Бивэр амьдралаа хэрхэн сайн дуусгахыг заажээ. “Мятрашгүй” ном нь бидэнд амьд үлдэх стратегийг зааж өгөөд зогсохгүй, үүнээс чухал нь элч Паулын “би зовлонд баярладаг” хэмээн мэдэгдсэн шиг цоо шинэ сэтгэлгээтэй болгоно. Түүнчлэн библийн ул суурьтай үнэн нь таныг амьдралын аль ч улиралд цэцэглэн хөгжүүлнэ.

Мятрашгүй байгаарай!



Бестселлер зохиолч, нэрд гарсан номлогч Жон Бивэр нь бестселлер зохиолч - гэргий Лизагийнхаа хамт 1990 онд үйлчлэлээ эхлүүлсэн болно. Өдгөө үйлчлэл нь дэлхийн 214 оронд цацагддаг “Мессенжер” долоо хоног тутмын телевизийн нэвтрүүлэгтэй олон улсын үйлчлэл болон хөгжжээ. Жон Бивэр “Айдсыг ялахуй”, “Сатаны Урхи”, “Сайныг уу, Бурханыг уу” зэрэг олон номыг зохиосон билээ.

DVD ДОТОР ДАРААХ МАТЕРИАЛУУД БИЙ



ДАРААХ ХУУДАСНААС ТАТАЖ АВАХ БОЛОМЖТОЙ
www.CloudLibrary.org
www.MessengerInternational.org



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org

Энэ номыг зохиогч БЭЛЭГЛЭЖ байгаа
бөгөөд ХУДАЛДАХЫГ ХОРИГЛОНО.

